



ФАТФ-ын тайлан

**АШГИЙН (ТӨЛӨӨ) БУС БАЙГУУЛЛАГЫГ
ТЕРРОРИЗМЫН ЗОРИЛГООР ХУУЛЬ
БУСААР АШИГЛАХ ЭРСДЭЛ**

2014 оны 6 дугаар сар



АГУУЛГА

Тайлангийн хураангуй	5
Эрсдэлийн ойлголт	6
Тайлангийн хамрах хүрээ	7
Аюул заналын мөн чанар	8
Эрсдэлийг бууруулах	9
Эрсдэлийн ангилал	10
Илрүүлэх, таслан зогсоох	12
Шалгуур үзүүлэлт.....	13
Цаашдын арга хэмжээ.....	13
Бүлэг 1. Удиртгал	15
Оршил	15
Судалгааны зорилго, хамрах хүрээ	17
Терроризмын дэмжлэгийн континуум	19
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааны харьцуулалт: аргачлал ба эрсдэл.....	21
Мэдээлэл цуглуулах, эх сурвалжийг ашиглах	23
Кейс тохиолдлын судалгааг цуглуулах	23
Улс орнуудын нөхцөл байдлын ерөнхий мэдээллийг цуглуулах	25
Ашгийн бус салбарын асуумж авах, салбарын төлөөлөгчидтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	25
Нээлттэй эх сурвалжийн мэдээллийг судлах	27
Бүлэг 2. Ашгийн бус байгууллагын салбар, түүнийг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах эрсдэл.....	28
Дэлхий дахины өнөөгийн нөхцөл байдал	28
Ашгийн бус байгууллагын салбар	30
Ашгийн бус салбарын үйл ажиллагаа, түүний эмзэг байдал	35
Терроризмын аюул заналын өнөөгийн үндсэн шинж	39
Террористууд хууль бусаар ашиглах, ашгийн бус байгууллагад учруулах эрсдэл.....	42
Стратегийн асуудлууд	42
Асуудал 1- Онцгой шаардлагаар үүссэн сөргөлдөөнт нөхцөл байдал	47
Асуудал 2 - Олон улсын стандарт, хэм хэмжээг улс орнууд хэрэглэх нь.....	48
Дүгнэлт	49
Бүлэг 3. Хууль бусаар ашиглах эрсдэл ба түүний арга, аргачлал	51
Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх	53
Ашгийн бус байгууллагад хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчлөх	53

Ашгийн бус байгууллагад хамааралгүй этгээд хөрөнгийг зориулалтыг өөрчлөх	57
Террорист байгууллагатай холбоотой байх	59
Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах	62
Элсүүлэхэд дэмжлэг үзүүлэх	64
Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч буюу халхавч ашгийн бус байгууллага.....	66
Бүлэг 4. Илрүүлэх арга, аргачлал	68
Ашгийн бус байгууллагын хяналтын байгууллагын мэдээлэл.....	70
Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл	72
Санхүүгийн мэдээллийн алба болон бусад санхүүгийн мэдээлэл	73
Үндэсний аюулгүй байдлын мэдээлэл	74
Хууль сахиулах байгууллагын мэдээлэл	75
Олон улсын хамтын ажиллагаа, гадаадаас авсан мэдээлэл	76
Дүгнэлт	77
Бүлэг 5. Таслан зогсоох арга, аргачлал.....	79
Салбарын мэдээлэл, соён гэгээрүүлэх ажил, өөрийн хяналт шалгалт.....	81
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	81
Захиргааны арга хэмжээ, торгууль, зорилтот хориг арга хэмжээ	83
Дүгнэлт	87
Бүлэг 6. Террорист байгууллагууд ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт, эрсдэлийн шалгуур үзүүлэлт.....	89
Шалгуур үзүүлэлтийн үндсэн шинж	89
Шалгуур үзүүлэлтийн ангилал.....	93
Ангилал 1: Мэдэгдэж буй эсхүл сэжиглэгдэж буй террорист байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	93
Ангилал 2: Мэдэгдэж буй эсхүл сэжиглэгдэж буй террорист байгууллагад материаллаг дэмжлэг үзүүлэх.....	94
Ангилал 3: Жагсаалтад орсон террорист байгууллагад санхүү, материаллаг эсхүл зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх	95
Ангилал 4: Терроризмын аюул заналхийлэл идэвхтэй газар нутагт үйл ажиллагаа явуулах	96
Ангилал 5: Ерөнхий үйл ажиллагаа, удирдлага	97
Ангилал 6: Элсүүлэхэд дэмжлэг үзүүлэх	98
Ангилал 7: Бусад гэмт хэргийн үйл ажиллагаа	99
Бүлэг 7. Дүгнэлт.....	101
Стратегийн асуудлууд	102
Судалгаа дүн шинжилгээний үр дүн.....	103
Цаашдын ажил	109

Ном зүй.....	110
Хавсралт А-Кейс тохиолдлыг шинжлэн судалсан нь	118

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

1. 2001 оны 10 дугаар сард Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг (ФАТФ)-ийн зүгээс мөн оны 9 дүгээр сарын 11-ны өдөр болсон халдлагад хүргэсэн аюул заналын өөрчлөгдөж буй нөхцөл байдалтай холбогдуулан терроризмын санхүүжилтэд хамаарах найман зүйл тусгай зөвлөмжийг боловсруулсан.

Эхэндээ Тусгай зөвлөмж 8 гэж нэрлэгдэж байсан (SR VIII) одоогийн Зөвлөмж 8-д дараах зүйлийг тэмдэглэсэн. Үүнд:

Улс орнууд терроризмыг санхүүжүүлэхэд ашиглаж болзошгүй байгууллагуудтай холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хянаж үзэх шаардлагатай. Нэн ялангуяа ашгийн бус байгууллагуудын эмзэг байдлыг хууль бусаар ашигладаг болохыг улс орнууд анхаарах ёстой:

(а) хууль ёсны байгууллага гэж халхавчилсан террорист байгууллагууд;

(б) хууль ёсны байгууллагыг терроризмын санхүүжилтэд болон хөрөнгийг царцаах арга хэмжээнээс зайлсхийх зорилгоор ашиглах;

(в) хууль ёсны үйл ажиллагаанд зориулагдсан хөрөнгийг нууж эсхүл будилуулж террорист байгууллагад шилжүүлэх.

2. Хэдийгээр ашгийн бус байгууллагууд нь ашгийн төлөөх байгууллагуудын адил мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой олон эрсдэлтэй тулгарч байгаа ч SR VIII нь терроризмын санхүүжилттэй холбоотой ашгийн бус байгууллагуудын (Ашгийн төлөө бус хуулийн этгээд) хувьд тулгарч буй онцлог эмзэг байдал, аюул заналхийллийг шийдвэрлэх зорилгоор гаргасан зөвлөмж юм. 2012 онд 40 зүйл заалт бүхий зөвлөмжийг шинэчлэн батлахад ФАТФ нь терроризмыг санхүүжүүлэх тухай Тусгай зөвлөмжийн ихэнхи хэсгийг нь мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг хамарсан ерөнхий зөвлөмж болгон нэгтгэсэн. Түүнчлэн ФАТФ-ын гурван Зөвлөмж терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой тусгай зүйл гэдгийг хэвээр нь үлдээж, тэдгээрийг Зөвлөмжийн С хэсэгт нэгтгэж; өмнөх SRVIII буюу одоогийн Зөвлөмж 8 (Ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ) нь эдгээр гурван зөвлөмжийн нэг юм. Энэхүү типологийн тайлан нь ашгийн бус салбарт учруулах терроризмын аюул заналын тухай ойлголтыг урагшлуулахад ихээхэн түлхэц болох юм. ФАТФ-ын гишүүн орнуудаас ирүүлсэн болон нээлттэй эх сурвалж, аюул заналын нөхцөл байдлын талаарх өнөөгийн судалгааны хүрээнд эмхэтгэсэн 102 кейс тохиолдлыг шинжлэн судалснаар хэд хэдэн чухал үр дүнд хүрсэн. Эдгээрийг нэгтгэн дүгнэхэд:

Судалгааны үндсэн үр дүн 1: Ашгийн бус салбар нь өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой эмзэг талуудтай бөгөөд террорист байгууллагууд эдгээрээс нэг бусыг нь ашиглахыг хичээдэг байна. Энэхүү

төслийн хүрээнд шинжлэн судалсан кейс тохиолдолд ашгийн бус байгууллагын хөрөнгийн зориулалтыг өөрчилж ашиглах нь террорист байгууллагуудын гол арга байв. Түүнчлэн үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах, террорист этгээдүүдийг элсүүлэхэд ашиглах зэрэг санхүүгийн бус зорилгоор ашиглах явдал нилээдгүй гарлаа.

Судалгааны үндсэн үр дүн 2: Терроризмын аюул занал бүхий бүс нутгийн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг, гол төлөв "Үйлчилгээ" үзүүлдэг ашгийн бус байгууллагууд эрсдэлд өртөх магадлал хамгийн ихтэй байна. Энэ нь терроризмын аюул заналхийлэл бүхий зөрчил мөргөлдөөнтэй газар нутагт үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагад хамаатай байж болно. Түүнчлэн дотооддоо үйл ажиллагаа явуулдаг хэдий ч террорист байгууллагад дэмжлэг авах, халхавчлах зорилгоор хүн амын дотор идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд байж болно. Энэ хоёр нөхцөлд эрсдэлийн гол хувьсагч нь газарзүйн байршил бус харин аюул заналд хэр ойр байхаас шалтгаална.

Судалгааны үндсэн үр дүн 3: Аюул заналын мөн чанар, түүнд улс орнуудын зүгээс авах хариу арга хэмжээнээс шалтгаалан ихээхэн эрсдэл бүхий кейс тохиолдлууд нь типологийн тайлангийн дүн шинжилгээнд мэдээллийн чухал эх сурвалж болж байна.

Судалгааны үндсэн үр дүн 4: Олон байгууллагын мэдэлд байх олон талт мэдээллийг нэгтгэснээр хууль бусаар ашигласан хэргийг илрүүлэх, ноцтой эрсдэлийг тодорхойлох чухал хүчин зүйл болдог.

Судалгааны үндсэн үр дүн 5: Хууль бусаар ашиглах явдлыг таслан зогсоох, ноцтой эрсдэлийг бууруулахын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хязгаарлагдахгүйгээр бусад олон төрлийн аргаар арга хэмжээ авсан байна. Захиргааны албадлага, санхүүгийн шийтгэл болон санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ нь хууль ашиглах тохиолдлыг таслан зогсоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

ЭРСДЭЛИЙН ОЙЛГОЛТ

3. ФАТФ-ын үнэлгээний гуравдугаар шатанд 40 Зөвлөмжид шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагууд бодлого, үйл ажиллагаандаа хэрхэн нийцүүлж байгаад хийсэн үнэлгээ дүгнэлтээс харахад үнэлгээнд хамрагдсан улс орнуудын 57 хувь нь одоогийн Зөвлөмж 8-ийг дагаж мөрдөөгүй эсхүл зөвхөн хэсэгчлэн нийцүүлсэн байсан бөгөөд улс орнуудын ердөө 5 хувь нь Зөвлөмжийг бүрэн буюу ихэнхийг нь нийцүүлсэн байна. Саяхан Терроризмтой тэмцэх дэлхийн хамтын ажиллагааны төв болон НҮБ-ын Терроризмтой тэмцэх хорооны Гүйцэтгэх албанаас явуулсан судалгааны дүнгээр ашгийн бус салбарын эрсдэлийн талаарх ойлголтын түвшин дэлхийн хэмжээнд тэгш бус байгааг тогтоожээ.¹ Түүнчлэн судалгаанд аюул заналыг

¹ Терроризмтой тэмцэх дэлхийн хамтын ажиллагааны төв, болон бусад (2013), p.v.

болон эрсдэлийг бууруулах шилдэг туршлагаудын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор террорист байгууллагууд ашгийн бус байгууллагуудад учруулж буй аюул заналыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байгааг тэмдэглэжээ.

4. Олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд ашгийн бус байгууллагуудын оруулж буй хувь нэмэр ач холбогдлыг үнэлж баршгүй юм. Олон сая хүмүүст тоолж баршгүй их үйлчилгээ үзүүлдэг, эрч хүчээр дүүрэн салбар юм. Гэсэн хэдий ч энэхүү типологийн төсөл террористууд болон террорист байгууллага (цаашид террорист этгээдүүд гэх)-ууд ашгийн бус байгууллагуудыг хууль бусаар ашиглаж эхэлснээс хойш даруй арав гаруй жилийн дараа албан ёсоор анхаарал хандуулсан ч, уг салбар террорист байгууллагуудад хууль бусаар ашиглагдан, ашиглуулсаар байгаа нь тус салбар терроризмын аюул заналд өртөмтгий, террорист байгууллагууд янз бүрийн аргаар ашиглах боломжтой болохыг олж тогтоожээ. Сайн санааны үйлсийн төлөө үйл ажиллагаа нь чиглэдэг тус салбарыг гэм зэмгүй хүмүүст хор уршиг учруулах зорилгоор ашиглаж байгаа нь урвуулан ашиглахын хамгийн жигшмээр хэлбэрийн нэг бөгөөд үүний улмаас олон нийт ашгийн бус салбарт итгэх итгэлийг ноцтойгоор алдагдуулахад хүргэж байна.

5. Ашгийн бус салбар нь эдгээр шаардлагын дагуу нилээдгүй их арга хэмжээг авч байгууллагын үйл ажиллагааны хариуцлага, ил тод байдлыг хангахад туслах зорилгоор хэд хэдэн стандарт, санаачилгыг боловсруулж гаргасан. Гэвч террорист этгээдүүд, ялангуяа зөрчил мөргөлдөөнтэй бүс нутгаас гадуурх үйл ажиллагаагаа нуун далдлахын тулд хууран мэхлэх аргыг ашиглах нь элбэг байдаг байна. Тайлангийн хүрээнд шинжлэн судалсан кейс тохиолдлууд сайтар төлөвлөсөн хууран мэхлэлтийг төрийн бус этгээдийн чадавхи нөөц бололцоонд тулгуурлан илрүүлэхэд хэцүү байх тул төрийн хяналтын тогтолцоо, түүний чадавхи нөөц бололцоо нь тус салбарын үйл ажиллагаанд учруулах хамгийн ноцтой аюул заналыг илрүүлэхэд мөн нэн чухал шаардлагатай хүчин зүйл гэдгийг харуулж байна.

6. Зөвлөмж 8-ийн төслийг анх боловсруулснаас хойшхи 12 жилийн хугацаанд аюул заналын орчин болон ашгийн бус салбар хувьсан өөрчлөгдсөөр ирсэн. Мөн улс орнууд болон ашгийн бус байгууллагууд Зөвлөмжийг хэрэгжүүлэн нилээдгүй хэдэн жилийн туршлагатай болсон. Энэ туршлагаас тус салбарыг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглуулахаас хэрхэн хамгийн оновчтой аргаар урьдчилан сэргийлж хамгаалах вэ гэдэг шинэ асуултыг гаргасан. Тайланд эдгээр асуултын хариу болгож, түүнчлэн цаашдын яриа хэлэлцээний асуудлыг тодорхойлох үүднээс ашгийн бус салбар болон дотоодын, олон улсын бодлого боловсруулагчдын өмнө тулгарч буй зарим чухал стратегийн асуудлыг тодорхойлж өгсөн.

ТАЙЛАНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

7. Энэхүү типологийн төсөл нь өнөөгийн бодлогыг үнэлэх бус *дүн шинжилгээ* хийх зорилготой байв. Тиймээс энэ тайлан нь бодлогын арга хэмжээг зөвлөмж болгох бус харин ашгийн бус салбарт террорист этгээдүүдийн учруулж болзошгүй аюул занал, түүнийг учруулж буй хүчин зүйлс, мөн энэ салбарын эмзэг байдал болон оролцогч

талуудын хариу үйлдэлд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судалж, тайлбарласан. Энэхүү типологийн тайлан нь ашгийн бус салбарыг хууль бусаар ашигласан үйлдлийг өргөн хүрээнд судалсан. Учир нь тус салбарын үйл ажиллагаа, тиймээс эмзэг байдал нь түүний санхүүгийн урсгалаас гадна материаллаг дэмжлэгийг хамардагтай холбоотой юм. Тиймээс тус салбарын санхүүгийн эмзэг байдлыг ойлгохын тулд бусад харилцан хамааралтай эмзэг байдлыг ойлгох шаардлагатай юм. Террористууд буюу террорист байгууллагуудын ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглах нь хүмүүнлэгийн² тусламж үзүүлэх, терроризмтой тэмцэх арга хэмжээ хоорондын сөргөлдөөн, мөн олон улсын стандартын дагуу дотооддоо хариу арга хэмжээ авах зэрэг хэд хэдэн стратегийн ээдрээтэй асуудлыг бий болгодог. Энэхүү тайлан нь эдгээр асуудлыг нарийвчлан хэлэлцэх эсхүл шийдлийг санал болгох бус харин эдгээр стратегийн асуудлыг тодорхойлох, цаашдын яриа хэлэлцээний аналитик үндэс суурийг хангахад чиглэж байна.

8. Типологийн тайланд шинжлэн судалсан 102 кейс тохиолдол нь багагүй тоо биш гэдгийг хэлэх нь зүйтэй юм. Гэхдээ кейс тохиолдлыг түүвэрлэн шинжилсэн нь хангалттай биш бөгөөд энэ нь ФАТФ-ын гишүүн орнууд болон түүний бүс нутгийн байгууллагууд (FSRBs)-аас ирүүлсэн сайн дурын мэдээллээр тодорхойлогдож байна. Типологийн тайланд олон улсын хэмжээнд хэрэглэгдэх дүгнэлтийг гаргахыг зорьсон бөгөөд үүнд тодорхой нэг улсын шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын онцлог шинж чанарыг тусгаагүй байж болох нь ойлгомжтой юм. Түүнчлэн кейс тохиолдлууд нь хууль сахиулах байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба (СМА), хянан шалгагч зэрэг, мөн тухайн улсын шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын зүгээс авч үздэг тодорхой эрсдэлүүд зэрэг тухайн эх сурвалж бүхий байгууллагын бүрэн эрхээс хамааран тодорхойлогдсон байх боломжтой юм.

АЮУЛ ЗАНАЛЫН МӨН ЧАНАР

9. Зөвлөмж 8 нь терроризмын санхүүжилттэй тэмцэх хүчин чармайлтад онцлог зөвлөмжүүдийн нэг гэдэг үүднээс мөн терроризмыг санхүүжүүлэх нь мөнгө угаахаас ялгаатай үйл ажиллагаа гэдтэй мэргэжилтнүүдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн зүйл тул терроризмын санхүүжилт, мөнгө угаах хоёрын ялгааг тодруулах шаардлагатай. Ялангуяа энэхүү ялгаатай байдал нь ашгийн бус салбарт хэрхэн нөлөөлж байгааг, тус салбарыг хууль бусаар ашигласан явдалд дүн шинжилгээ хийх, эцэст нь тус салбарыг хамгаалах хүчин чармайлтыг тодорхой болгохын тулд судлан шинжлэх шаардлагатай байв. Терроризм нь мөн чанарын хувьд урьдчилан сэргийлэх шаардлагатай нэн чухал эрсдэл бөгөөд ялангуяа ашгийн бус байгууллагын хувьд бодитой зүйл тул терроризмын санхүүжилт нь өргөн цар хүрээтэй аюул заналын нэг тал юм.

Террорист байгууллагад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлдэг терроризмын санхүүжүүлэгчид нь зохион байгуулалтын өргөн хүрээний хэрэгцээг хангах

² Хүмүүнлэгийн гэх нь хүний хангалуун байдлыг хөхиүлэн дэмжихийг хэлэх бөгөөд онц байдал эсхүл гамшгийн нөхцөл байдлын дараа авсан үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй юм

зорилгоор элсүүлэх, аялал болон зэвсэг олж авах зэргээр хязгаарлагдахгүйгээр хөрөнгийг ашигладаг болохыг ажиллагааны кейс тохиолдлууд харуулж байв. Зөвлөмж 8-ын тайлбарт үүнийг тэмдэглэж террористууд болон террорист байгууллагууд нь "Ашгийн бус салбарыг ашиглан хөрөнгө босгох, шилжүүлэх, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, терроризмд элсүүлэхийг дэмжих буюу террорист байгууллага, үйл ажиллагааг дэмжихэд ашигладаг" гэжээ.³ Мөн тайлбарт Зөвлөмжийн ерөнхий зарчмуудын нэг нь:

*Улс орнуудын террористууд болон террорист байгууллагыг дэмждэг эсхүл ашиглуулсан ашгийн бус байгууллагыг олж тогтоох, тэдгээрийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах нь терроризмын санхүүжилт болон терроризмыг дэмжих бусад хэлбэрээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол яллахад чиглэгдэх ёстой. Ашгийн бус байгууллага нь терроризмын санхүүжилт эсхүл терроризмыг дэмжих бусад хэлбэрт сэжиглэгдсэн эсхүл тогтоогдсон тохиолдолд улс орнууд нэн тэргүүнд тэдгээр терроризмын санхүүжилт эсхүл дэмжлэгийг шалгах, таслан зогсоох ёстой.*⁴

10. Терроризмын санхүүжилтийн мөрдөн шалгах ажиллагааны зорилго нь⁵ эдгээр аюул занал, эмзэг байдлыг эрсдэл бодит болохоос өмнө нь ойлгож урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад оршино. Террорист ажиллагааг үйлдсэн тохиолдолд энэ нь олон нийтэд онц хэрцгийгээр ямар ч ялгаварлалгүй хохирол учруулах тул эмзэг байдлыг ашиглахаас нь өмнө аюул заналыг ойлгож, таслан зогсоох ёстой. Тиймээс тодорхой гэмт хэрэгт чиглэсэн, хууль сахиулах зорилготой мөнгө угаах мөрдөн шалгах ажиллагаанаас ялгаатай терроризмын санхүүжилтийн мөрдөн шалгах ажиллагаа нь тагнуулын мэдээлэл олоход суурилдаг. Терроризмын санхүүжилтийн мөрдөн шалгах ажиллагаа нь тодорхой гэмт хэрэгт чиглэгддэггүй гэдгийг харгалзан үзвэл мөрдөгч эсхүл шинжээч нь терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг ойлгохын тулд илүү олон шалгуур үзүүлэлтэд тулгуурлах ёстой болно. Энэ нь ялангуяа мөрдөгч эсхүл шинжээч нь тухайн субъектийн санаа зорилго эсхүл оролцооны түвшинг ойлгоход чухал байх юм.

ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

11. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хэрэгт террорист халдлагаас урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарал хандуулдаг хэдий ч АББ-ыг хууль бусаар ашиглах эсхүл ашиглах эрсдэл байх тохиолдолд ихэвчлэн шүүхээр хянан шийдвэрлэхтэй холбоогүй арга хэмжээг ашигладаг. Эдгээр нь:

- Урьдчилан сэргийлэх сургалт, боловсролын арга хэмжээ,

³ ФАТФ-ын Зөвлөмж 8 (Төрийн бус байгууллага)-ын тайлбарт (2012а), х.54.

⁴ ФАТФ-ын Зөвлөмж 8 (Төрийн бус байгууллага)-ын тайлбарт (2012а), х.55.

⁵ Тайлангийн хүрээнд ашиглагдаж буй "мөрдөн шалгах ажиллагаа" гэдэг нэр томъёолол нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, захиргааны болон тагнуулын мөрдөн шалгах ажиллагааг ялгаж салгаагүй болно. Учир нь терроризмын хэрэгт оролцсон байгууллага, бүрэн эрхт байдлын хослол нь улс орнуудад харилцан адилгүй байдаг бөгөөд тухайн тохиолдлоос хамааран заримыг нь эсхүл бүгдийг нь хамарч болно.

- Тухайн салбарын өөрийгөө хянах арга хэмжээ
- Террорист байгууллага эсхүл тэдгээрийг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтыг гаргах, эсхүл
- Хууль сахиулах байгууллагаас авах арга хэмжээ.

Эдгээр арга хэмжээний ихэнхийг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнөх шатанд хэрэгжүүлсэн байдаг. Гадны байгууллагууд орон нутгийн ашгийн бус байгууллагыг хууль бус зорилгоор ашиглаж байгаа эсхүл ашиглаж болох тохиолдолд шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх нь хамгийн оновчтой сонголт биш бөгөөд ийм тохиолдолд гадны болон дотоодын байгууллагад чиглэсэн санхүүгийн хориг арга хэмжээ авах нь орон нутгийн АББ-ыг хамгаалах нэг хувилбар байх юм.⁶ Энэхүү тайланг бэлтгэх явцад шинжлэн судалсан кейс тохиолдлын 88 хувьд нь хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож захиргааны арга хэмжээ авч, байгууллага, хувь хүмүүсийг террорист буюу терроризмыг дэмждэг хүмүүсийн жагсаалтад оруулсан бол кейс тохиолдлын 25 хувьд нь хууль бус үйл ажиллагааг эрүүгийн хэрэг үүсгэн шүүхээр хэргийг хянан шийдвэрлэсэн байна.⁷ АББ-ын салбар дахь терроризмын санхүүжилтийн эрсдлийг аль болох эрт илрүүлж, бууруулах, түүнчлэн энэ салбарын эмзэг байдлыг бүрэн дүүрэн ойлгох шаардлагатай тул ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах эсхүл ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах эрсдэлтэй тохиолдлын аль алиныг нь шинжлэн судлах нь чухал юм.

12. Зөвлөмж 8-ын тайлбарт хэдийгээр ашгийн бус салбарыг хамгаалах нь нэн чухал боловч тус салбарыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ нь "хууль ёсны буяны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох эсхүл саад учруулах ёстойгүй" гэсэн. Энэхүү тайланг боловсруулах явцад шинжлэн судалсан кейс тохиолдолд АББ-ыг хууль бусаар ашигласан тохиолдлыг илрүүлэх, таслан зогсооход хэд хэдэн аргыг ашигласан бөгөөд үүнд эрсдэлийг бууруулах арга хэмжээ болон ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашигласан тохиолдлыг илрүүлэх арга хэмжээ багтасан болно. Ихэнхи тохиолдолд хууль бусаар ашигласан үйл ажиллагааг таслан зогсоох, эрсдлийг бууруулахад олон төрлийн эх сурвалжаас авсан мэдээлэл, АББ-ын төсөл хөтөлбөр, үйл ажиллагаанд тусгайлан хийсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэсэн хяналт шалгалтын зорилтот арга хэмжээг авсан. Хэдийгээр үйл ажиллагааг таслан зогсоох эдгээр арга хэмжээний тус салбарт үзүүлэх нөлөөллийг тоон утгаар үнэлэхэд хэцүү байх ч тодорхой нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээний үндсэн дээр авсан зорилтот арга хэмжээ нь тус салбарын хууль ёсны үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулдаг болохыг энэхүү судалгаа дүн шинжилгээ нь нотолж байна.

ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛ

⁶ ФАТФ-ын Зөвлөмж 6 "Терроризм болон терроризмын санхүүжилттэй холбогдох санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ"-ний дагуу хориг арга хэмжээ авах.

⁷ Тайлангийн 5-р бүлэгт дурдсанаар зарим кейс тохиолдолд нэгээс илүү таслан зогсоох үйл ажиллагаа явуулсан байх тул эдгээр хувиудын нийлбэр 100 хувьд хүрэхгүй юм.

13. Кейс тохиолдол болон бусад нийтлэлийг шинжлэн судалсны үр дүнд АББ-ыг хууль бусаар ашигласан эсхүл хууль бусаар ашиглах эрсдэлийн таван ангилалыг тодорхойлсон. Гэхдээ эдгээр нь харилцан холбоогүй ангилалууд биш бөгөөд тэдгээрийн олонхи нь энэхүү тайланд тусгагдсан олон янзын кейс тохиолдлын судалгаанд нэгэн зэрэг илэрч байв.

- *Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх* нь тус салбарын нилээдгүй их санхүүгийн хөрөнгө нөөцөд чиглэсэн ноцтой аргын нэг байв. Ашгийн бус байгууллагын дотор байх этгээд эсхүл гадаадын түнш зэрэг түүний гадна байх хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилдөг байна.
- Ашгийн бус байгууллага эсхүл түүнийг удирддаг эрх бүхий этгээд санаатайгаар эсхүл санамсаргүйгээр *террорист этгээдтэй хамааралтай* байх. Энэ тохиолдолд ашгийн бус байгууллагыг террорист байгууллагад ерөнхий зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх зэрэг хэд хэдэн зорилгоор ашигладаг байна.
- Хэд хэдэн тохиолдолд ашгийн бус байгууллагыг террорист этгээдүүдийн *элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэхэд* ашигласан байна.
- Ашгийн бус байгууллагуудыг мөн *хөтөлбөрийг нь хууль бусаар ашиглах* зорилгоор ашигласан байна. Энэ тохиолдолд санхүүгийн хөрөнгө нөөцийнх нь урсгал хууль ёсны байх ч ашгийн бус байгууллагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед терроризмыг дэмжих зорилгоор ашигладаг байна.
- Зарим террорист этгээдүүд *төөрөгдүүлсэн төлөөллөөр* ашгийн бус салбарыг ашигладаг. Энэ тохиолдолд террорист этгээдүүд өөрсдийгөө халхавчилсан хуурамч Ашгийн бус байгууллага байгуулах эсхүл донор хандивлагчдыг хуурч дэмжлэг авах зорилгоор өөрсдийгөө сайн үйлсийн буяны ажилтан мэт танилцуулдаг байна.

14. Зөвлөмж 8-ийн хамаар бүхий талуудад тулгарч буй чухал асуултын нэг нь ямар ашгийн бус байгууллагууд хууль бусаар ашиглагдах хамгийн их эрсдэлтэй гэдгийг хэрхэн үнэлэх тухай асуудал юм. Тайлангийн явцад хийсэн судалгаа дүн шинжилгээгээр ашгийн бус байгууллагын эрхэлж буй үйл ажиллагаа болон хууль бусаар ашиглах эрсдэлийн хооронд харилцан хамаарал байгааг харуулсан байна. Шинжлэн судалсан 102 кейс тохиолдлын ихэнх нь "үйлчилгээний чиглэлээр" үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага (орон сууц, нийгмийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ)-тай холбоотой байв.⁸ Эдгээр кейс тохиолдлын нэг нь ч "идэвхтэй төлөөллийн" үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага (спорт, амралт чөлөөт цаг, соёл урлаг, сонирхлын төлөөлөл эсхүл ухуулга сурталчилгаа)-тай холбоогүй байв.⁹ Түүнчлэн шинжлэн судалсан кейс

⁸ Лестер М. Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2013 он), х.5.

⁹ Мөн тэнд.

тохиолдлууд болон бусад судалгаагаар террорист байгууллагын дэмжлэг авах зорилготой хүн амын дотор үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд ашиглуулах өртөх өндөр эрсдэлтэй гэдгийг харуулж байна. Гэхдээ энэ нь газарзүйн зөрчил мөргөлдөөнтэй эсхүл сул засаглалтай орон нутагт байнга хамааралтай байдаггүй болохыг анхаарах нь зүйтэй. Террорист байгууллагууд үйл ажиллагаа явуулдаггүй эсхүл явуулж чаддаггүй сул засаглалтай эсхүл зөрчил мөргөлдөөнтэй газар нутагт ашгийн бус байгууллагууд терроризмын биш ч гэсэн авлига эсхүл гэмт хэрэгтэй холбоотой эрсдэлд өртөх боломжтой юм. Нөгөөтэйгүүр террорист байгууллагууд дэмжлэг авах үүднээс харьцангуй тогтвортой орчинд байх хүн амыг чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж болно. Тухайлбал, “Тамил-Илам (LTTE)-ын чөлөөлөх барууд” гэх байгууллага санхүүгийн болон бусад дэмжлэг авах зорилгоор Шри Ланк Улсын тогтвортой мужуудад байх хэд хэдэн суурин газрыг чиглэсэн үйл ажиллагаа явуулсан. Тиймээс эдгээр тогтвортой орчинд үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд өндөр эрсдэлд орох магадлалтай байдаг. Эцсийн дүнд ямар ашгийн бус байгууллагууд өндөр эрсдэлтэйг тодорхойлох үндсэн нөхцөл нь тэдгээрийн хөрөнгө нөөц бололцоо эсхүл үйл ажиллагаа нь террорист байгууллагуудад хир үнэ цэнэтэй байх, ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах чадавхи, зорилготой идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг террорист аюул заналтай хир ойр байхаас нь хамаарах юм.

ИЛРҮҮЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ

15. Төсөл нь мөн эрх баригчдыг хууль бусаар ашигласан, ихээхэн эрсдэл бүхий тохиолдлыг илрүүлэхэд ямар төрлийн мэдээлэлд үндэслэсэн, түүнчлэн дараа дараагийн мөрдөн шалгах ажиллагааны явцад ямар мэдээллийг ашигласан болохыг судалсан. Хамгийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй буюу хамгийн нарийвчилсан мэдээлэлтэй кейс тохиолдлууд нь гол төлөв эрх үүргийнхээ дагуу ашгийн бус салбарыг хянадаг хяналт шалгалтын байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэсэн байв. Гэсэн хэдий ч холбоо бүхий байгууллага нь донор хандивлагчид болон бусад ашгийн бус байгууллагыг төөрөгдүүлсэн тохиолдолд үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд тулгуурлаж энэхүү луйвар заль мэхийг илрүүлсэн нь тус салбарыг бүхэлд нь хамгаалахад чухал ач холбогдолтой байв.

16. Кейс тохиолдлыг шинжлэн судлахад хэргийн ноцтой байдлаас хамааран ашгийн бус салбарыг хууль бусаар ашигласан эсхүл ноцтой эрсдэлийг илрүүлэхэд түүнийг таслан зогсоох эсхүл нөлөөллийг нь багасгахад хүргэсэн хэд хэдэн аргыг хэрэглэсэн байв. Тухайн үйлдэл гэмт хэрэг гэдэг нь тодорхой болсон тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аргаар хэргийг таслан зогсоосон байна. Ашгийн бус салбарыг хамгаалах захиргааны болон санхүүгийн зорилтот хориг арга хэмжээнд тус салбарын үйл ажиллагааны томоохон хэсэгт нөлөөлөхгүйгээр зорилтот байгууллагуудын хууль ёсны байдал болон донор хандивлагчдын дэмжлэгийг алдахад хүргэх өргөн хүрээтэй өөр олон арга хэмжээ багтдаг. Захиргааны арга хэмжээнд зорилтот хориг арга хэмжээг оролцуулан ихэвчлэн захиргааны шийдвэр болон бусад захиргааны зохих ёсны үйл ажиллагааг сорьсон үйл ажиллагааг хамруулдаг. Энэхүү судалгаа дүн шинжилгээнээс үзэхэд тус салбарыг хууль бусаар ашиглахаас хамгаалах өргөн хүрээтэй боломжит

хувилбарууд байгааг тодорхойлж, бусад арга замаар шийдвэрлэх боломжгүй цөөн хэдэн хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ашигласан болохыг харуулж байна.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

17. Кейс тохиолдлыг шинжлэн судалж, холбогдох ном товхимолд хийсэн дүн шинжилгээгээр ашгийн бус салбар, төр засгийн газрын байгууллагуудын оролцогчид, санхүүгийн байгууллагууд болон нэр бүхий санхүүгийн бус бизнес эрхлэгчид эсхүл мэргэжилтнүүдэд (DNFBPs) ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашигласан тохиолдлыг илрүүлэх, тодорхойлоход туслах хоёр төрлийн шалгуур үзүүлэлтийг мөн гаргасан. Эхний шалгуур үзүүлэлт болох "эрсдэлийн шалгуур үзүүлэлт" гэдэг нь терроризмтой холбоотой эсхүл холбоогүй байж болох хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг үзүүлж байгаа бөгөөд хэдийгээр энэ нь эрсдэл бүхий байгууллагуудыг тодорхойлоход чухал ач холбогдолтой ч үүнийг бусад хууль бусаар ашигласан хэлбэрээр тайлбарлаж болно. Хоёрдахь шалгуур үзүүлэлт нь террорист байгууллагууд хууль бусаар ашиглах тохиолдолтой илүү хүчтэй хамааралтай үзүүлэлт юм. Эдгээр үзүүлэлтийг "терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлтүүд" гэж нэрлэсэн бөгөөд эдгээр нь терроризмын оролцоог илүү хүчтэй илэрхийлж, төр засгийн газрын байгууллагууд эсхүл ашгийн бус байгууллагыг удирдан чиглүүлдэг албан тушаалтнуудад анхааруулах үүргийг гүйцэтгэдэг байна.

ЦААШДЫН АРГА ХЭМЖЭЭ

18. Тайлан нь террорист байгууллагуудын ашгийн бус салбарт учруулж буй аюул заналын талаархи ойлголтыг ихээхэн нэмэгдүүлж өгсөн. Гэхдээ цаашид энэ ойлголтод тулгуурлаж судалгаа дүн шинжилгээ хийх шаардлагатай байна. Тухайлбал, ялангуяа террорист үйл ажиллагаанд өртөх өндөр эрсдэлтэй улс орнуудын шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын талаархи ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд улсын хэмжээнд хууль бусаар ашигласан тохиолдлыг судлах шаардлагатай юм. Энэ төрлийн судалгаа хийхийг ФАТФ-ын Зөвлөмж 1-д заасан байдаг бөгөөд зөвлөмжийн дагуу бүх гишүүн улс орнуудад үндэсний эрсдэлийн үнэлгээ хийхийг шаардлага болгосон. Эдгээр судалгаанд тулгуурлаж цаашдын харилцан хамаарлыг судлах, онцлог шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох боломжтой болох юм. Улсын хэмжээнд эрсдэлийн талаар илүү нарийвчилсан ойлголттой болох нь эрсдэлийг тодорхой бус үнэлснээс үүдэн ашгийн бус байгууллагад хэт хатуу хяналт тавьдаг гэх салбарын зарим асуудлыг даван туулахад тустай байх юм. Түүнчлэн ашгийн бус байгууллагын үйлчилгээнээс ашиг хүртэгч улс орнууд болон донор хандивлагч улс орнуудад тулгарах аюул заналын (эрсдэл болон эмзэг байдлын хувьд) ялгааг илүү сайн ойлгох шаардлагатай байна. Хэдийгээр тайланд хөрөнгийн зориулалтыг өөрчлөхөөс хамгаалж ашгийн бус байгууллагын хөрөнгийн зориулалтын талаар нарийвчилсан ойлголтыг өгч байгаа ч ашгийн бус байгууллагын хөрөнгө нөөц бололцоотой холбоотой аюул заналын талаар өнөөг болтол тодорхой сайн ойлголтгүй байна. Иймд цаашид терроризмын санхүүжилттэй холбоотой ашгийн бус байгууллагын хөрөнгө нөөцийн эх үүсвэртэй

холбоотой эрсдэл болон түүнийг хууль бусаар ашиглах тохиолдлын талаар судалгаа дүн шинжилгээ хийхэд анхаарах нь зүйтэй юм.

19. Террорист этгээдүүдээс ашгийн бус байгууллагуудад учруулах аюул заналын асуудлыг авч үзэхийн тулд ашгийн бус байгууллагын үйл ажиллагаа явуулдаг орчин, тухайн салбарын эмзэг байдал, террорист этгээдүүд эдгээр эмзэг байдлыг хэрхэн ашиглахаар эрэлхийлж буй болон тус салбарт учрах аюул заналыг хэрхэн илрүүлж, удирдан зохион байгуулах талаар ойлголттой болох шаардлагатай. Ашгийн бус салбарыг террористууд ашиглахаас хэрхэн оновчтой аргаар урьдчилан сэргийлэх, ялангуяа энэхүү тайланд онцлон тэмдэглэсэн стратегийн асуудлаар цаашид аливаа хэлэлцүүлэг хийхэд маш нарийн судалгаа дүн шинжилгээ бүхий суурь ойлголттой байх шаардлагатай юм. Зөвлөмж 8-т хамаарах ээдрээтэй асуудлуудыг чиглүүлэхэд хэцүү байсаар ирсэн бөгөөд цаашид ч хэцүү хэвээр байх болно. Гэхдээ эдгээр асуудлыг зохих ёсоор нь чиглүүлж байхгүй бол ашгийн бус салбарын бүрэн эрхт байдал эрсдэлд хэвээр байх юм. Энэхүү типологийн тайлан нь эдгээр ээдрээтэй асуудлыг залж чиглүүлэхэд нь туслах үүднээс дотоодын болон олон улсын бодлого боловсруулагчид, ашгийн бус салбарт шаардлагатай судалгаа дүн шинжилгээтэй суурийг бий болгох, улмаар ашгийн бус салбарын сайн үйлсийн ажил хэрэг нь хэрэгтэй хүмүүстээ ашиг тусаа үргэлжлүүлэн өгөх боломжоор хангах зорилготой юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ УДИРТГАЛ

ОРШИЛ

20. Ашгийн бус байгууллагууд (АББ) нь өнөөгийн дэлхий ертөнцийн идэвхтэй хөгжиж буй, салшгүй нэг хэсэг бөгөөд терроризмтой тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.¹⁰ Тэдгээрийн үйл ажиллагааны өргөн цар хүрээ, газарзүйн хамрах хүрээ, тэсвэртэй байх чадвар нь АББ-ыг олон улсын өвөрмөц субъект болгосон. Хэдийгээр өнөөгийн байдлаар дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ашгийн бус байгууллагын талаархи статистик мэдээлэл байхгүй ч 35 улсын үндэсний ашгийн бус байгууллагад хийсэн нэгэн судалгаагаар АББ-ын үйл ажиллагааны цар хүрээ, ач холбогдлын талаар зарим ойлголтыг өгсөн. 2003 онд Жон Хопкинсын Их сургуулийн Иргэний нийгмийн судалгааны төвөөс ашгийн бус салбарын харьцуулсан судалгааны ажлын хүрээнд гаргасан тайланг нийтлүүлсэн. Энэхүү тайланд дурдсанаар 1990-ээд оны эцэс гэхэд дэлхийн 35 улсын ашгийн бус байгууллагын салбарын нийт хэмжээ мөнгө дүнгээр 1.5 их наяд ам.долларт хүрсэн нь дэлхийн долоо дахь хамгийн том эдийн засагтай тэнцэж байсан бөгөөд эдгээр салбарт 39 сая гаруй хүн ажиллаж байсан байна.¹¹ 2013 онд 16 улсад хийсэн судалгааны дүнг нийтэлсэн шинэчилсэн тайланд бүрэн хэмжээний мэдээлэл авах боломжтой улс орнуудын хувьд дунджаар нийт ажиллах хүчний 7.4 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 4.5 хувийг ашгийн бус салбар эзэлж байгааг тэмдэглэсэн байна.¹² Ашгийн бус байгууллагын салбар нь мөн НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтууд зэрэг хамтын санаачилгыг хэрэгжүүлэхэд нийтийн (төрийн) салбарын салшгүй түнш нь юм. Ашгийн бус байгууллагын салбар нь олон нийтийн итгэлийг хүлээж ирсэн уламжлалтай бөгөөд энэ нь түүний амжилтын үндсэн шалтгаануудын нэг байсаар ирсэн. Олон нийтийн энэхүү итгэлийг дааж хадгалах нь ашгийн бус байгууллагын салбарын үйл ажиллагааны үр дүнг хангах чухал нөхцөл юм.

21. Гэсэн хэдий ч сайн үйлсийн ажил хийх тухай үзэл баримтлал нь сайн санааны зорилгогүй этгээдүүдийн зорилго байсаар ирсэн. Үүнээс хамгийн ноцтой аюул заналыг террорист үйл ажиллагаа явуулдаг этгээдүүд учруулдаг. Хэдийгээр ашгийн бус байгууллагуудын дийлэнхи олонхи нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүсийн ахуй амьдралыг сайжруулахын төлөө шаргуу ажиллаж байхад цөөн тооны байгууллага, хувь хүмүүс тэс ондоо зорилгоор буюу ашгийн бус салбарыг терроризмд оролцогчдыг дэмжихэд эсхүл террорист байгууллагыг дэмжих зорилгоор ашиглаж байна. Терроризмыг санхүүжүүлэх эсхүл материаллаг дэмжлэг үзүүлэхэд ашгийн бус байгууллагыг ашиглах нь магадлал багатай эрсдэл мэт санагдаж болох ч эдгээр үйл ажиллагааны нөлөөлөл нь терроризмын хохирогчид

¹⁰ НҮБ-ын *тайван замаар чуулах, эвлэлдэн нэгдэх эрхийн Тусгай илтгэгчийн тайлан*, A/HRC/23/39 (НҮБ-ын Ерөнхий Ассемблей, 2013 он) х.9. Тусгай илтгэгчийн тайланд "Ерөнхийдөө иргэний нийгмийн байгууллагууд терроризмтой тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж Тусгай илтгэгч үзсэн. Хүн амтай шууд харилцаж, ядуурлыг бууруулах, энхийг дэмжих, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хүний эрх, нийгмийн шударга ёс, тэр дундаа улс төрийн хүнд нөхцөлд терроризмын аюул заналтай тэмцэхэд иргэний нийгэм чухал үүрэг гүйцэтгэдэг" гэж илтгэлд тэмдэглэсэн.

¹¹ Лестер М. Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2013 он), х.13-15.

¹² Лестер М. Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2013 он), х.2-3.

болон ашгийн бус байгууллагын сайн үйлсийн үр шимийг хүртэх ёстой байсан хүмүүст маш ноцтой байх юм. Энэхүү шууд нөлөөллийг олон нийтийн ашгийн бус салбарт үзүүлэх итгэл алдагдахад түүнийг үржүүлсэнтэй тэнцэх юм.¹³ Ази, Номхон далайн Мөнгө угаахтай тэмцэх бүлгийн (АНБ) типологийн тайланд энэ асуудлыг бүс нутгийн үүднээс авч үзсэн бөгөөд 2003, 2007 оны ФАТФ-ын типологийн тайланд терроризмын зорилгоор ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах тухай тусгайлсан бүлгийг оруулсан.¹⁴ Дэлхийн банкны бодлогын томоохон тайланд ашгийн бус салбараар дамжуулан терроризмыг санхүүжүүлэх асуудлыг мөн авч үзсэн бөгөөд тэнцвэртэй хариу үйлдэл гэдэгт юуг хамруулах вэ? гэдэг асуултад тусгайлан анхаарлаа хандуулсан.¹⁵ Гэсэн хэдий ч 2001 оноос хойш террорист байгууллагуудын ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглах буюу ашиглах эрсдэлийг судалсан тусгайлсан типологийн тайлан гараагүй. Хэдийгээр АНБ-ийн тайлан болон өмнөх ФАТФ-ын типологийн тайланд энэ төрлийн судалгааг хийх эхний алхмыг гаргасан боловч ашгийн бус салбарт анхаарлаа хандуулсан тусгайлсан, өргөн цар хүрээтэй, илүү орчин цагийн олон улсын типологийн тайлангийн шаардлага байсаар байна. ашгийн бус байгууллагуудын асуудлыг тусгасан Зөвлөмжийг (одоогийн Зөвлөмж 8-ийг цаашид 3.8 гэх) ФАТФ-ын 2001 онд хийсэн өөрчлөлтөд тусгасны дараа аюул заналын орчинд гарсан өөрчлөлтүүдтэй холбоотой энэхүү хэрэгцээ шаардлага улам ноцтой болсон. Түүнчлэн олон улсын байгууллагууд, судалгааны байгууллагууд болон ашгийн бус салбарын зүгээс терроризмтой тэмцэх арга хэмжээ болон нэн ялангуяа ашгийн бус байгууллагын хүмүүнлэгийн үйл ажиллагааны үр дүнгийн тэнцвэртэй байдлын талаар санаа зовж байгаагаа илэрхийлсэн.¹⁶ Эцэст нь терроризмыг болон террорист байгууллагыг дэмжих зорилгоор ашгийн бус салбарыг ашиглахтай холбоотой хэд хэдэн үндсэн асуултуудыг төвийг сахисан бодлогын аргаар судлах олон улсын дүн шинжилгээний тайлангийн шаардлага хэрэгцээ байгаа юм. *Зураг 1.1-т* эдгээр үндсэн асуултуудыг харуулав.

Зураг 1.1: Судалгааны үндсэн асуултууд

ЯмарАББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд хамгийн ихээр өртдөг вэ?
Юу вэ террорист байгууллагын ашгийн бус салбарт учруулах аюул заналын үндсэн шинж?
ХэзээАББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд хамгийн ихээр өртдөг вэ?
ХаанаАББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд хамгийн ихээр өртдөг өндөр вэ?

¹³ ФАТФ-ын Зөвлөмж 8 (Төрийн бус байгууллага)-ын тайлбарт (2012а), х.54.

¹⁴ Ази, Номхон далайн Мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНБ) (2011 он), ФАТФ (2003 болон 2008 он). Евроазийн бүлгээс мөн ашгийн бус байгууллагын салбарыг мөнгө угаах зорилгоор ашиглах асуудлын талаарх типологийн тайланг боловсруулсан. (Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Евроазийн бүлэг [ЕАБ], 2012 он)

¹⁵ Эмили Ван дер Дос де Виллебойс (Van der Does de Willebois, Emile) (2010 он).

¹⁶ Кейт Макинтош (Mackintosh, Kate) болон Патрик Дуплат (Duplat, Patrick) (2013 он).

Яагаад АББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд өртдөг вэ?
Хэрхэн/Яаж АББ-ууд террорист үйл ажиллагаанд эмзэг болдог вэ? ...террорист байгууллагууд ашгийн бус салбарыг хууль бусаар ашигладаг вэ? ...АББ-ыг хууль бусаар ашигласан тохиолдлыг илрүүлж, таслан зогсоосон вэ?

22. Тайлан нь эдгээр үндсэн асуултыг хөндөж эхэлснээр эхэлнэ. Аливаа типологийн тайлангийн дийлэнхи хэсэг нь "хэрхэн" гэх асуултад анхаарах хэдий ч ашгийн бус салбарт тулгарах эрсдэл болон эрсдэлийг багасгахад хамаарах сорилтын талаар бүрэн дүн шинжилгээ хийхийн тулд боломжийн хүрээнд бусад үндсэн асуултуудыг авч үзэх шаардлагатай юм.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

23. Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмжид үнэ цэнэтэй хэдий ч эмзэг салбар болох ашгийн бус байгууллагатай холбоотой тусгай заалтыг оруулсан. Эдгээр заалтыг Зөвлөмж 8 (өмнө нь Тусгай Зөвлөмж VIII)-д оруулсан бөгөөд үүнд гишүүн орнууд АББ-ыг террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хууль бусаар ашиглуулахгүйн байх арга хэмжээг авах ёстой гэдгийг тэмдэглэсэн.¹⁷ Энэхүү Зөвлөмж нь 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын дараа 2001 оны 10 дугаар сард гаргасан 8 Тусгай Зөвлөмжийн¹⁸ нэг байсан. Энэхүү Зөвлөмжийг террорист байгууллагыг дэмжих зорилгоор АББ-ыг ашиглаж байсныг харуулсан хэд хэдэн хэргийг илрүүлсний дараа терроризмтой тэмцэх зорилгоор тусгайлан боловсруулсан.

24. Зөвлөмж 8 болон түүний тайлбар нь терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашгийн бус салбарыг ашиглахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх болон таслан зогсоох ФАТФ-ын арга хэмжээний үндэс суурь нь юм. ФАТФ-ын арга хэрэгсэлд энэхүү тайлангийн хамрах хүрээтэй холбоотой бусад Зөвлөмжүүдийг оруулсан бөгөөд тэдгээрийг 3.8-тай уялдуулан авч үзэх шаардлагатай. Зөвлөмж 1-д терроризмын санхүүжилттэй тэмцэхэд хор уршгийг бууруулах хүчин чармайлтыг тодорхойлсон эрсдэлтэй үр дүнтэй уялдуулахын тулд эрсдэлд суурилсан хандлагын ач холбогдлыг тусгасан.¹⁹ Ашгийн бус салбарыг судлахад 3.1-д хууль бусаар ашиглах болон ноцтой эрсдэлийг тодорхойлох нь чухал хүчин чармайлт гэдгийг тэмдэглэсэн.

25. Терроризмын санхүүжилтийг гэмт хэрэгт тооцохыг зөвлөмж болгосон Зөвлөмж 5-д гишүүн орнууд "террорист үйлдлийг санхүүжүүлэх төдийгүй террорист

¹⁷ ФАТФ-ын Зөвлөмж 8 (2012а), х.13.

¹⁸ Бэлэн мөнгө тээвэрлэгчдийн талаарх 9 дэх тусгай зөвлөмжийг сүүлд нэмж оруулсан. ФАТФ-ын Зөвлөмж 1 (2012а), х. 11.

¹⁹ ФАТФ-ын Зөвлөмж 1 (2012а), х.11.

байгууллага, террористуудыг санхүүжүүлэхийг тодорхой террорист ажиллагаа, үйлдэлтэй холбоогүй байсан ч гэмт хэрэгт тооцох ёстой” гэж тэмдэглэсэн.²⁰ 3.5-д террорист байгууллагад дэмжлэг үзүүлэхээ зогсоох нь элсүүлэх зэрэг цэргийн бус зорилгоор ашиглах санхүүжилтийг зогсоох асуудлыг оруулна гэсэн.

26. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах тухай Зөвлөмж 6-д хориг арга хэмжээ нь терроризмыг дэмжсэн хэргээр тэдгээрийн эсрэг хориг арга хэмжээ авсан олон улсын болон үндэсний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдэд “шууд болон шууд бусаар” “бэлэн мөнгө болон бусад хөрөнгийг” олгохгүй байхад баталгаа болох ёстой гэж заасан.²¹ Ашгийн бус байгууллагын хувьд Зөвлөмж 6-д бэлэн мөнгө нь террорист байгууллагад эд баялаг шилжүүлэх цорын ганц хэрэгсэл биш гэдгийг онцолсон. Террорист байгууллагад шууд бусаар шилжүүлсэн бэлэн бараа бүтээгдэхүүн нь шууд мөнгө шилжүүлсэнтэй адил үр дүнд хүргэж болно. АББ нь баялгийг зөвхөн бэлэн мөнгөөр шилжүүлэхээс гадна өөр олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг тул Зөвлөмжийн 6-ын уг заалт нь энэхүү судалгааны сэдвийн чухал бүрэлдэхүүн хэсэг хэвээр байх болно.

27. 24, 25-р Зөвлөмж нь хуулийн этгээдийн ил тод байдал, ашигтай өмчлөл болон зохицуулалттай холбоотой.²² Эдгээр зөвлөмжийн аль алинд нь хуулийн этгээдийн ашигтай өмчлөл болон хууль эрх зүйн зохицуулалтын "мэдээллийг хангалттай, үнэн зөв, цаг тухайд нь" хангах болон энэхүү мэдээллийг “эрх бүхий байгууллагаас цаг тухайд нь авах, нэвтрэх” боломжтой байх ёстой гэдгийг заасан.²³ 25, 24 дугаар Зөвлөмжид аливаа хуулийн этгээд түүний дотор АББ-уудад ил тод байдал болон сайн засаглалын ач холбогдлыг тэмдэглэсэн.

28. ФАТФ-ын стандартуудаас гадна улс орнууд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (22 дугаар зүйл) зэрэг нөхөрлөл холбоо байгуулах эрх чөлөөг хамгаалсан олон улсын хүний эрхийн стандартуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

29. Энэхүү типологийн тайланд шинжлэн судалсан кейс тохиолдолд эдгээр олон талын аргыг ашигласан. Үүнтэй холбогдуулан Зөвлөмж 8-ын заалтууд нь терроризмын санхүүжилтийн тухай хязгаарлагдмал ойлголтоор хязгаарлагдахгүйгээр, мөн материаллаг дэмжлэгтэй холбоотой бүх зүйлийг хамарна (ФАТФ-ын "бэлэн мөнгө болон бусад хөрөнгө"-ийн тухай тодорхойлолтод нийцүүлэн), үүнд "санхүүгийн хөрөнгө, эдийн засгийн нөөц болон бүх төрлийн эд хөрөнгө багтана".

30. Энэхүү баримт бичгийн гарчихаас харахад энэхүү типологийн судалгааны зорилго нь ашгийн бус байгууллагын салбарыг терроризмын зорилгоор ашиглах эрсдлийг судалж, дүн шинжилгээ хийх явдал юм. Харилцан үнэлгээний 3 дахь шатны дүнг судлан шинжлэхэд улс орнууд Зөвлөмж 8-ын шаардлагыг дагаж

²⁰ Мөн тэнд. х.13.

²¹ ФАТФ-ын Зөвлөмж 6 (2012а), х.13.

²² ФАТФ-ын Зөвлөмж 24, 25 (2012а), х.22.

²³ Мөн тэнд.

мөрдөхөд бэрхшээлтэй тулгарсаар байгааг харуулсан. Хэдийгээр энэхүү тайлан нь Зөвлөмж 8-д заасан зарим асуудлын талаархи мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд туслах зорилготой ч Зөвлөмж 8-ын талаар тайлбар өгөхгүй бөгөөд энэхүү Зөвлөмжид тусгагдсан асуудлаар хязгаарлагдахгүй болно. Түүнчлэн тайланд улс төр, бодлогын ямар нэгэн зөвлөмжийг агуулаагүй болно. Энэхүү тайлангийн зорилго нь үндэсний болон олон улсын түвшинд бодлогын асуудлыг цаашид авч хэлэлцэх, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх явдал юм.

31. ФАТФ-ын бусад типологийн тайлангын нэгэн адил энэхүү тайлангийн зорилтыг хэлэлцэж буй салбартай холбогдуулан Зураг 1.1-д тусгасан судалгааны үндсэн асуултуудаар тодорхойлсон. Эдгээр зорилтуудыг дараахь байдлаар тодорхойлов:

Зорилт 1: Орчин цагийн терроризмын аюул заналын үндсэн шинж, түүний ашгийн бус байгууллагын салбар дахь нөлөөллийг судлах.

Зорилт 2: Террорист байгууллагууд хууль бусаар ашиглахад АББ-ууд байгууллагын түвшинд болон салбарын түвшинд хэрхэн, хаана эмзэг болдог талаар дүн шинжилгээ хийх. Ийм дүн шинжилгээ нь ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашигласан жишээн дээр болон ашиглах бодит эрсдлийн талаар хууль сахиулах байгууллага болон төрийн бусад байгууллагаас өгсөн мэдээлэлд үндэслэдэг.

Зорилт 3: Террорист байгууллагын ашгийн бус байгууллагын салбарт учруулах аюул заналын талаарх ойлголтыг өргөжүүлэх, ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах үйл ажиллагааны типологи, чиг хандлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, бодлого боловсруулах зорилгоор цаашид хэлэлцэх стратегийн чухал асуудлуудыг тодорхойлох.

32. Эдгээр зорилтууд нь харилцан хамааралгүй биш бөгөөд харин бие биенээ харилцан нөхдөг болно. Үйл ажиллагааны түвшинд АББ-ыг хууль бусаар хэрхэн ашигладаг болохыг шинжлэн судлах нь Зураг 1.1-т тусгасан “хэрхэн” гэдэг асуултад хариулахад чухал ач холбогдолтой юм. Гэхдээ үйл ажиллагааны түвшинд хийсэн судалгаа дүн шинжилгээ нь яагаад гэх хэд хэдэн ерөнхий асуултад болон ямар нөхцөл байдалд террорист байгууллагууд ашгийн бус байгууллагын салбарыг өөрсдийн ашиг сонирхолд ашиглахыг эрмэлздэг гэдэгт хангалттай хариултыг өгдөггүй байна. Эдгээр асуултад хариулахын тулд террорист аюул заналын тухай болон ашгийн бус байгууллагын салбарын талаар стратегийн түвшинд дүн шинжилгээ хийх шаардлагатай юм. Энэхүү типологийн тайланд эдгээр асуултын хариултыг олохын тулд үйл ажиллагааны болон стратегийн дүн шинжилгээний аль алиныг нь авч үзсэн бөгөөд өнөөгийн байдлаар АББ-ыг хууль бусаар ашиглах асуудлыг аль болох гүн гүнзгий ойлгохыг хичээсэн болно.

ТЕРРОРИЗМЫН ДЭМЖЛЭГИЙН КОНТИНУУМ

33. Аливаа террорист халдлага болгоны цаана элсүүлэхээс эхлээд материаллаг дэмжлэг үзүүлэх хүртэл олон янзын хүчин зүйлсийг багтаасан зохион байгуулалтын сүлжээ байдаг. Эдгээр хүчин зүйлс нь ижилхэн түвшинд аюул занал учруулах

албагүй тул олон улс орны зүгээс эдгээр асуудлыг тус бүрт нь шийдвэрлэхэд өөр өөрөөр ханддаг. Үүнийг Зураг 1.2-т үзүүлсний дагуу тасралтгүй үргэлжлэх үйл явц буюу терроризмыг дэмжих континуум хэлбэрээр төсөөлж болно. Амстердамын Их сургуулийн доктор Тимоти Виттиг (Timothy Wittig) хэлэхдээ, терроризмын санхүүжилт нь (мөн террорист хөдөлгөөнийг илүү өргөн хүрээнд дэмжих нь) түүний нийгэм, улс төрийн үндэстэй салшгүй холбоотой тул үүнийг "континуум" хэлбэрээр авч үзэх ёстой гэсэн.²⁴


34. Доор танилцуулсан дээрх континуумын диаграммд (үйл ажиллагаа болон сөрөх арга хэмжээг тусгасан) терроризмыг дэмжих чиглэлээр "элсүүлэх", "хөрөнгө босгох", "төлөвлөлт, сургалт зохион байгуулах", "материаллаг дэмжлэг үзүүлэх" гэх зэрэг хэд хэдэн үйл ажиллагаа нь террорист халдлага үйлдэхэд хувь нэмэр оруулдаг. Энэхүү тасралтгүй үргэлжлэх континуумын дагуу терроризмыг дэмжих үйл ажиллагаа нь чадавхыг нэмэгдүүлж, зорилгодоо хүрэхэд хувь нэмэр оруулах хирээр терроризмыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоход олон янзын субъектууд оролцдог байна. Салбарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь бага байх континуумын доод цэгт энэхүү үйл ажиллагааг эсэргүүцэж буй гол хүчин зүйл нь АББ-ууд өөрсдөө, мөн хандивлагчид, хууль ёсны дэмжлэгийг хүртэгчид болон тус салбарт хяналт тавьдаг зохицуулалт, хяналт шалгалтын байгууллагууд байна. Салбарын хянан магадлагааны хэрэгжилт, аюулгүй байдлын хатуу арга хэмжээг авснаар салбарт учрах эрдслийн ихэнхи хэсэг нь континуумын уг цэгт буурах юм. Гэхдээ ашгийн бус байгууллагууд төдийгүй хяналтын байгууллагууд тогтоож, илрүүлэхэд бэрхшээлтэй, хууран мэхлэх аргыг ашигласан зарим аюул занал континуумын туршид байсаар байх болно. Эдгээр тохиолдолд тус салбарт хийгдэх хянан магадлагааны хэрэгжилтын арга хэмжээ болон хяналтын байгууллагын мөрдөн шалгах ажиллагаа нь тус салбарыг хууль бусаар ашиглах гэсэн илүү нарийн төвөгтэй оролдлогыг тогтоож, илрүүлэх чадвартай санхүүгийн мэдээллийн алба (СМА) болон бусад тагнуулын байгууллагын дэмжлэгтэйгээр хүч нэмэгдүүлдэг. Салбарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дээд цэгтээ хүрсэн континуумын цэгт салбарт учруулах эрсдлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон хууль бус үйлдлийг илрүүлэх тагнуулын байгууллагын хүчин чармайлт нь хууль сахиулах байгууллагын болон шүүхийн тогтолцооны хууль сахиулах, шүүхийн яллах эрх мэдлээр бататгаж өгдөг. Эдгээр эрх мэдэл нь тус салбарыг хууль бусаар ашигласан үйлдлийг шийтгэхэд ашиглагддаг бөгөөд ийм хэрэг дахин гарахаас урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай байдаг.

35. Терроризмын дэмжлэгийн континуум шугаман хэмжээстэй байгаа нь зөвхөн тодорхой, ойлгомжтой байлгах үүднээс ийнхүү дүрсэлсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Бодит байдалд террорист үйл ажиллагаа, түүнийг таслан зогсоох гэсэн хүчин чармайлтын аль аль нь шулуун шугамаар жигд, эмх цэгцтэй явагддаггүй. Терроризмыг дэмжих үйл ажиллагаа нь Зураг 1.2-т харуулсан дарааллын дагуу үргэлж явагдахгүй бөгөөд нэгэн зэрэг хэд хэдэн цэгт зэрэгцэн тохиолдох магадлалтай. Тиймээс мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон эрсдлийг

²⁴ Тимоти Виттиг (Wittig, Timothy), (2011 он), х.141-58.

бууруулах субъектын оролцоо нь зурагт харуулсан шиг шулуун бус харин ихэнхдээ зэрэгцээ явагдах болно. Практикт энэхүү тайланг боловсруулах зорилгоор шинжлэн судалсан кейс тохиолдлоос харахад хэд хэдэн субъектын харилцан уялдаатай үйл ажиллагааны дүнд АББ-ыг хууль бусаар ашиглах эрсдлийг бууруулж чаддаг байна.

Зураг 1.2: **Терроризмын дэмжлэгийн континуум**



36. Терроризмыг дэмжих үйл ажиллагаа, түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг таслан зогсоох нь ихэнхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахаас өмнө олон янзын арга хэмжээг нэгэн зэрэг ашигласны үр дүнд болсон байдгийг терроризмыг дэмжих континуумын диаграммаас харж болно. Үүнийг анхааралдаа авч тус салбарт тулгарч болох эрсдлийн талаар тодорхой, бүрэн гүйцэд ойлголттой болохын тулд АББ-ыг хууль бусаар ашигласан талаарх судалгаа нь континуумын зөвхөн эцсийн цэгт бус харин бүх цэгт тохиолдох хэргийг судлахад үндэслэгдсэн байх ёстой.

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦУУЛАЛТ: АРГАЧЛАЛ БА ЭРСДЭЛ

37. Терроризмыг дэмжих континуумын диаграмм нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх хоорондын нарийн, гэхдээ чухал ялгааг харуулж байгаа бөгөөд энэ нь энэхүү типологийн судалгааг ойлгоход чухал ач холбогдолтой юм. ФАТФ-ын *Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах гарын авлагад* хэдийгээр терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах нь ихэнхи тохиолдолд хамтдаа байдаг ч эдгээр гэмт хэрэг нь тэдгээрийг үйлдсэн байдал, мөрдөн шалгах ажиллагааны шинж

чанараараа ялгаатай юм. Уг Гарын авлагад “Мөнгө угаах” гэдэг нь “бохир” мөнгийг “цэвэр” болгох үйл явцыг хэлдэг бол терроризмыг санхүүжүүлэх нь “цэвэр” мөнгийг ихэвчлэн харгис зорилгоор ашиглахыг хэлнэ” гэжээ.²⁵ Товчхондоо мөнгө угаах гэдэг нь ноцтой гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хууль ёсны болгох буюу гэмт хэргийн улмаас болдог байна. Нөгөө талаар терроризмыг санхүүжүүлэх нь, хэдийгээр энэ нь өөрөө гэмт хэрэг боловч ноцтой гэмт хэрэг үйлдэх боломжийг олгодог бөгөөд терроризмын санхүүжилтийг таслан зогсоох хүчин чармайлт нь цаашдын террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Гэхдээ энэ нь терроризмыг санхүүжүүлэх болон санхүүгийн бусад төрлийн гэмт хэрэг, тэр дундаа мөнгө угаахтай ямарч холбоогүй гэсэн үг биш юм. Эсрэгээрээ ФАТФ-ын типологийн судалгаа болон террорист хөдөлгөөний хөрөнгийн эх үүсвэрийг судалсан бусад судалгаанд терроризм болон гэмт хэрэг хоорондын уялдаа холбоог онцолж байв.²⁶ Гэхдээ мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааг ихэнхдээ хууль сахиулах байгууллагууд явуулдаг бөгөөд голдуу хэдийнээ үйлдсэн гэмт хэрэгтэй холбогдуулан нотлох баримт цуглуулах зорилгоор гэмт хэрэгтэнд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад оршдог. Нөгөө талаас, аюул заналын шинж чанараас хамааран терроризмын санхүүжилтийн мөрдөн шалгах ажиллагаа нь аюул заналаас урьдчилан сэргийлэхэд илүү төвлөрч, ном журмын дагуу тагнуулын байгууллага явуулдаг.

38. Нэгэнт хөрөнгө²⁷ террорист байгууллагуудын гарт орсон байхад тэдгээрийг эцсийн байдлаар ашиглах явдлыг тасалдуулан зогсоох нь илүү хэцүү болдог. Терроризмын санхүүжилт нь магадлал багатай хэрэг хэдий ч энэ нь террорист халдлагыг боломжтой болгох тохиолдолд олон нийтэд өндөр нөлөөлөл үзүүлдэг. Стратегийн хувьд мөнгө угаах нь мөн цаг хугацааны явцад нийгэмд өндөр нөлөөлөл үзүүлдэг боловч террорист үйл ажиллагааны шууд нөлөөлөл (ялангуяа хүний амь настай холбоотой хамгийн тодорхой өртөг) нь олон нийтийн аюул заналын ондоо тооцооллыг гаргадаг. Тиймээс мөнгө угаахтай харьцуулахад түүний олон нийтэд учруулах шууд нөлөөлөл нь харьцангуй өндөр байх тул олон улс орон терроризмын санхүүжилтийн эрсдэлийг илүү эртнээс бууруулах шаардлагатай байдаг.

39. Эцсийн бүлэгт терроризмын санхүүжилтийн мөрдөн шалгах ажиллагааны зорилго нь эрсдэл бодит байдал болохоос өмнө аюул занал болон эмзэг байдлыг ойлгох тухай юм. Малколм Спарроу өөрийн "Зохицуулалтын урлаг" хэмээх номондоо урьдчилан сэргийлэх нь эрсдэлийг бууруулах гол бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлсон.²⁸ Аюул заналыг эмзэг байдлыг ашиглахаас нь өмнө тодорхойлж, ойлгох шаардлагатай. Тиймээс эрсдэлийн тохиолдлууд болон хууль бусаар ашигласан тохиолдлуудыг шинжлэн судлах шаардлагатай. Иймд хууль бусаар ашигласан тохиолдлыг болон хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэлийн аль алиныг нь харуулсан кейс тохиолдлыг шинжлэн судалж энэхүү тайланд тусгалаа.

²⁵ ФАТФ (2012b), х.15.

²⁶ ФАТФ (2008).

²⁷ Хууль ёсны эсхүл хууль бус үйл ажиллагаанаас олсон хөрөнгийг хэлж буй.

²⁸ Sparrow, Malcolm K (2000), х.265-69.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ЭХ СУРВАЛЖИЙГ АШИГЛАХ

40. Энэхүү типологийн тайлангийн судалгааг олон талын аргаар хийсэн. Судалгааны ажлын цөм нь гол төлөв ФАТФ-ын гишүүн орнуудын боловсруулсан кейс тохиолдлын мэдээллийг цуглуулан, шинжлэн судлахын зэрэгцээ нээлттэй эх сурвалжийн мэдээллийг давхар судаллаа. Мөрдөн шалгах ажиллагааны томоохон чиг хандлагын талаархи мэдээллийг болон илрүүлэх арга зам, агентлаг хоорондын хамтын ажиллагааны талаархи мэдээллийг мөн ФАТФ-ын гишүүн орнуудаас цуглуулсан.

41. Энэхүү типологийн төслийн гол зорилтуудын нэг нь судалгааны ажлын явцад ашгийн бус салбарыг оролцуулах явдал байв. Энэ хүрээнд ашгийн бус салбарын байгууллагуудтай олон талын оролцогч талуудыг хамруулсан асуумж, зөвлөлдөх уулзалтын хүрээнд албан ёсоор зөвлөлдсөн. Асуумж болон зөвлөлдөх уулзалтыг салбарын үйл ажиллагаа, террорист байгууллагууд хууль бусаар ашиглаж болох эмзэг байдал, мөн АББ-ууд өөрсдөө террорист үйл ажиллагааны эрсдэлийг хэрхэн үзэж байгаа талаар илүү сайн ойлголттой болох зорилгоор төлөвлөсөн байв.

42. Аливаа аналитик бүтээлийн нэгэн адил илрүүлсэн баримтыг тэдгээрийг цуглуулахад ашигласан арга, аргачлалыг харгалзан авч үзэх шаардлагатай байдаг. Энэхүү типологийн тайланд голчлон олон улсын түвшинд илрүүлсэн баримтуудыг танилцуулсан. Үүнд ФАТФ-ын гишүүн орнууд болон ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагаас 102 кейс тохиолдлын судалгааг ирүүлсэн бөгөөд энэ нь типологийн тайлангийн хувьд нилээд их (гэхдээ бүрэн гүйцэд биш) тоо юм. Түүнчлэн ФАТФ болон ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагын гишүүн орнуудаас ирүүлсэн сайн дурын мэдээлэл нь энэхүү типологийн тайлангийн кейс тохиолдлын судалгааны хүрээг тодорхойлж өгсөн. Эдгээр типологийн судалгаа нь тэдгээрийг ирүүлсэн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг болон холбогдох улсын тодорхой эрсдлээр тодорхойлогдсон байх боломжтой.

КЕЙС ТОХИОЛДЛЫН СУДАЛГААГ ЦУГЛУУЛАХ

43. Кейс тохиолдлын судалгааг ирүүлэх тухай хүсэлтийг ФАТФ-ын гишүүн орнууд болон ФАТФ-ын бүс нутгийн байгууллагуудад (FSRBs) ФАТФ-ын нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан явуулсан. Уг хүсэлтэд терроризмын дэмжлэгийн континуумын талаар тоймлон тайлбарлаж, судалгаанд оролцогсдод кейс тохиолдлын судалгаанаас эмзэг нууц мэдээллийг сонгох, боловсруулах, устгахад нь туслах зорилгоор жишиг кейс тохиолдлыг тусгасан байв. Асуулгын хариуд 14 улсаас хариу өгч, нийт 102 кейс тохиолдлын судалгааг төслийн багт ирүүлсэн. Ирүүлсэн кейс тохиолдлын судалгаа нь газарзүйн хувьд Европ, Хойд Америк, Ойрхи Дорнод, Зүүн Өмнөд Ази, Далайн орнуудыг хамарч байна. Тодорхой илгээгчдийн хувьд кейс тохиолдлын судалгааг хууль сахиулах, тагнуул, хяналт шалгалтын байгууллага зэрэг янз бүрийн байгууллагаас явуулсан.

44. Энэхүү тайланд нууц мэдээлэл агуулсан болон агуулаагүй кейс тохиолдлын судалгааны аль алиныг нь оруулсан. Энэ нь эдгээр хоёр аргын аль алиных нь давуу

талыг ашиглах үүднээс ийнхүү оруулсан. ФАТФ-ын гишүүн орнууд болон ФАТФ-ын бүс нутгийн байгууллагаас ирүүлсэн ихэнхи кейс тохиолдлын судалгаанаас, төслийн багт танилцуулахаас нь өмнө дараахь шалтгаанаар нууц мэдээллийг устгасан. Эдгээр нь:

1. **АББ-ын нэр хүндийг хамгаалах:** Ихэнхи тохиолдолд хууль бусаар ашиглуулах хэрэгт холбогдсон хууль ёсны АББ-ууд нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж, үнэтэй үйлчилгээ үзүүлсэн хэвээр байна. Эдгээр АББ-уудыг тодорхойлж тогтоох нь гэмт хэргийн хохирогчийг тогтоохтой адил урьдчилан тооцоогүй хор уршигтай үр дагаварыг дагуулж болзошгүй юм.

2. **Ямар байгууллагыг террорист гэж тооцдог талаар санал зөрөлддөг:** Террорист үйл ажиллагаа гэж юуг хэлэх талаар өндөр түвшинд ойлголттой болж харьцангуй зөвшилцөлд хүрсэн байгаа хэдий ч зарим хөдөлгөөн эсхүл этгээдүүдийг “террорист” гэж нэрлэх нь зүйтэй эсэх нь маргаан дагуулж зөвшилцөлд хүрээгүй байна. Ихэнхдээ эдгээр маргаан нь өөр өөр үзэл бодлын улмаас болон дотоодын аюул заналын орчныг өөр өөрөөр тайлбарлаж байгаагаас болдог. Эдгээр маргаан мэтгэлцээн хэдий чухал боловч террорист байгууллагууд ашгийн бус салбарыг хүчирхийллийн зорилгоор хэрхэн, яагаад ашигладаг болохыг ойлгох гэсэн ерөнхий зорилгоос ухраах ёсгүй юм.

3. **Дуусаагүй хэргүүд:** Терроризмын санхүүжилтийг мөрдөн шалгах ажиллагаа болон ял оногдуулах нь ихэвчлэн урт удаан үргэлжилсэн үйл явц байдаг. Өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх үүднээс одоо шалгагдаж байгаа хэргийн талаар мэдээлэхдээ улс орнууд сэтгэл хангалуун байна гэдэгт төслийн баг итгэлтэй байх шаардлагатай байв. Хэрэг мөрдөн шалгах шатанд байх тохиолдолд гүйцэтгэх ажиллагааны эх сурвалж, арга хэмжээг эрсдэлд оруулахгүй байх үүднээс тэдгээр шалгалтын халдашгүй байдлыг хамгаалах шаардлагатай юм. Хэрэг шүүхийн шатанд байгаа тохиолдолд хуулиараа нэр холбогдсон хүмүүс эсхүл байгууллагын хувийн мэдээллийг хамгаалах шаардлагатай.

4. **Захиргааны арга хэмжээгээр үйл ажиллагааг таслан зогсоосон:** Эрсдэлийг бууруулах шаардлагыг харгалзан ашгийн бус салбарыг терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашигласан олон тохиолдлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аргаар бус харин захиргааны арга хэмжээгээр шийдвэрлэсэн байдаг. Өмнө дурдсанчлан, хамгийн найдвартай судалгаа дүн шинжилгээ хийхийн тулд эдгээр хэргийг авч үзэх шаардлагатай юм. Гэхдээ захиргааны арга хэмжээгээр шийдвэрлэсэн хэргийг голдуу терроризмтой холбоотой гэж тодорхойлдоггүй. Цаашдаа эдгээр хэргийг терроризмтой холбоотой гэж тодорхойлох нь захиргааны үйл явц нь эрсдэлийг бууруулах үр дүнтэй хэрэгсэл гэдгийг дордуулж болзошгүй юм.

5. **Үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг ашигласан:** Терроризмтой холбоотой хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог шинж

чанараас нь шалтгаалан бүх улс орнууд хамгаалах сонирхолтой тагнуулын нууц мэдээллийг ихэвчлэн ашигласан байдаг. Зарим тохиолдолд мэдээллийн эх сурвалж, мөрдөн шалгах ажиллагааны арга барилыг ил болгох нь хувь хүн болон байгууллагыг аюул оруулж болзошгүй байдаг. Улс орнууд өргөн хүрээг хамарсан кейс тохиолдлын судалгааг танилцуулахад санаа зовохгүй байх үүднээс мөрдөн шалгах ажиллагааны чадавхи, арга барил, эх сурвалжийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг нууцлах шаардлагатай байв.

45. Нууц мэдээллийг хассан кейс тохиолдлын судалгаанаас гадна нууц мэдээлэл агуулаагүй кейс тохиолдлын судалгаа нь асуудлын талаар илүү гүнзгий ойлголттой болох боломжоор хангадаг. Учир нь тэдгээрт АББ-ыг хууль бусаар ашигласан жишээг оруулсан байдаг тул ойлгоход илүү хялбар байдаг. Нууц мэдээлэл агуулаагүй кейс тохиолдлын судалгаа нь нээлттэй эх сурвалжийн нэмэлт мэдээллийг ашиглах боломжийг олгодог. Тухайлбал, шүүхийн баримт бичиг, судалгааны тайлан, засгийн газрын албан ёсны хэвлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл. Үүнтэй холбогдуулан энэхүү тайланд мөн шүүхийн шийдвэр гарсан, нууц мэдээлэл агуулаагүй хэргүүд эсхүл хэдийнээ олон нийтэд мэдээлэл нь нээлттэй ил болсон хэргүүдийг оруулсан.

УЛС ОРНУУДЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ

46. ФАТФ-ийн гишүүн орнууд болон бүс нутгийн байгууллагуудад хүргүүлсэн шинжлэн судлах кейс тохиолдлыг ирүүлэх тухай хүсэлтэд терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь тэдгээр улсын ашгийн бус салбарт учрах эрсдэлийн талаар энэхүү судалгаа дүн шинжилгээнд оролцогчдоос хэд хэдэн ерөнхий асуултыг асуусан. Тэдгээр асуултууд нь дараахь мэдээллийг олж авах зорилготой байв:

- Ашгийн бус салбарын үнэлгээ дүгнэлтээр цуглуулсан статистик мэдээлэл, нэн ялангуяа ямар төрлийн АББ-ууд хамгийн их эрсдэлтэй байдаг тухай мэдээлэл
- Ашгийн бус салбарыг хамруулсан үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн, дүгнэлт
- Санхүүгийн гүйлгээний тайлангийн субъект болох АББ-тай холбоотой мэдээлэл

47. Энэхүү мэдээллийг АББ-ын орчин, хууль бусаар ашиглах арга аргачлал болон илрүүлэх арга замын асуудлыг хөндсөн типологийн тайлангийн холбогдох бүлгүүдэд тусгасан.

АШГИЙН БУС САЛБАРЫН АСУУМЖ АВАХ, САЛБАРЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

48. Өмнө дурьдсанчлан ашгийн бус салбарыг судалгаанд тогтмол оролцуулах нь төслийн багийн хувьд чухал байсан. Ашгийн бус салбарын байгууллагуудад хэд хэдэн чухал асуудлаар салбарын хувь нэмрийг оруулахыг нь хүсэлт болгосон асуумжийг хүргүүлсэн. Эдгээр нь:

- Судалгаанд оролцогчид террорист үйл ажиллагаанаас тэдгээрийн байгууллага(уудад) учрах эрсдэлийг хэрхэн үзэж байна вэ;
- Судалгаанд оролцогчид өөрсдийн байгууллага(уудыг) террорист байгууллагын хууль бусаар ашиглах үйлдэлд эмзэг өртөмтгий гэж үзэж байгаа эсэх, хэрэв тийм бол ямар эмзэг байдлыг ашиглаж;
- Судалгаанд оролцогчид ашгийн бус салбарыг террорист байгууллагууд ашигласан тохиолдлуудад оролцсон эсэх эсхүл мэдэж байгаа эсэх;
- Байгууллага эсхүл ашгийн бус салбарын хүрээнд хамтран боловсруулсан эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлох.

49. Түүнчлэн үүнтэй зэрэгцэн ашгийн бус салбарын төлөөлөгчид АББ-ын талаарх өөрсдийн судалгааг оруулсан үнэлгээ дүгнэлтийг хийсэн.

50. Ашгийн бус байгууллагын салбарт ордог байгууллагуудтай (Нью-Йорк, Брюссель хотноо) хоёр удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Эдгээр зөвлөлдөх уулзалтыг “The Charity and Security Network” (Буяны, аюулгүй байдлын сүлжээ) болон “European Foundation Centre” (Хандивын сангийн үйл ажиллагааг дэмжих Европын төв)-тэй хамтран зохион байгуулсан. Эдгээр зөвлөдөх уулзалтын зорилго нь үндэсний болон олон улсын засгийн газрын байгууллагууд болон ашгийн бус байгууллагын салбар хооронд энэхүү типологийн тайлантай холбоотой хэд хэдэн асуудлаар өргөн хүрээний, байнгын яриа хэлэлцээг дэмжихэд чиглэж байв. Үүнд:

- Үйл ажиллагааны хараат бус байдал, үр ашгийн хувьд АББ-ын салбарын төлөөлөгчдийн анхаарал хандуулсан асуудлууд;
- Зөвлөмж 8-ын шаардлагыг хэрэгжүүлэх талаар зарим улс орноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбогдуулан АББ-ын салбарын төлөөлөгчдийн анхаарал хандуулсан асуудлууд;
- Илүү өргөн хянан магадлагааны нийцүүлэлт болон хяналт шалгалтын шаардлагын хүрээнд терроризмтой тэмцэх арга хэмжээний нөлөөлөл

51. Эдгээр асуудлын ихэнхи нь бодлогын өргөн хүрээний хэлэлцүүлгийн хэсэг байдаг тул типологийн тайлангийн хамрах асуудлын хүрээнд аливаа нэг дүгнэлт хийгдэх учиргүй юм. Гэхдээ зөвлөлдөх уулзалтууд нь типологийн тайланд онцлох шаардлагатай байсан стратегийн томоохон асуудлуудыг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой байв. ФАТФ-аас явуулсан асуумж, салбарын төлөөлөгчдийн хийсэн

үнэлгээ дүгнэлт болон зөвлөлдөх уулзалтын хүрээнд олж авсан мэдээллийг салбарын эмзэг байдал, эрсдэлийг бууруулах арга хэмжээний тухай Хоёрдугаар бүлэгт тусгайлан нэгтгэн орууллаа.

НЭЭЛТТЭЙ ЭХ СУРВАЛЖИЙН МЭДЭЭЛЛИЙГ СУДЛАХ

52. Нээлттэй эх сурвалжийн материалыг нарийвчлан судалсан нь судалгааны ажлын явцад гарсан бүхий л асуудлыг тодруулахад чухал ач холбогдолтой байв. Нууц мэдээлэл агуулаагүй кейс тохиолдлын судалгааг нэгтгэхэд нээлттэй эх сурвалжийн материалыг судлахаас гадна АББ-ын салбарын чиг хандлага, терроризмын аюул заналыг үнэлэхэд эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээний хүрээлэн, төр засгийн газрын байгууллагаас хэвлэн нийтэлсэн материалыг ашигласан. Бүх тохиолдолд нээлттэй эх сурвалжаас авсан мэдээллийг тайлангийн эцсийн хувилбарыг боловсруулахад эх сурвалж болгон ашиглахаас өмнө төслийн багаас түүний үнэн зөв баттай, нарийвчлалтай байдлыг сайтар үнэлж, шалгасан.

53. Ерөнхийдөө дээр дурьдсан дүн шинжилгээний үйл явц дахь зарим нэг хязгаарлагдмал байдлыг үл харгалзан энэхүү типологийн тайланд тусгасан үндсэн мэдээлэл, дүн шинжилгээ, тодорхойлсон баримтууд нь АББ-ын салбарт учруулах террорист үйл ажиллагааны эрсдэлийг ойлгоход чиглэсэн томоохон алхам болж байна. Энэ нь АББ-ын салбарыг террорист байгууллагууд хууль бусаар ашиглахаас хамгийн оновчтой байдлаар хамгаалах арга замыг олоход болон цаашдын яриа хэлэлцүүлэгт дэмжлэг болох учиртай юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН САЛБАР, ТҮҮНИЙГ ТЕРРОРИЗМЫН ЗОРИЛГООР ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ЭРСДЭЛ

ДЭЛХИЙ ДАХИНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

54. Даяаршил нь хууль ёсны болон хууль бус олон улсын этгээдийн аль аль нь оршиж, үйл ажиллагаа явуулдаг гадаад орчны тодорхойгүй байдлыг улам бүр нэмэгдүүлж, тэдэнд ихээхэн боломжийг олгохын зэрэгцээ ихээхэн эрсдлийг авчирсан.²⁹ Ашгийн бус байгууллагуудын хувьд шинэ технологийн хөгжил дэвшил нь хөрөнгө босгох, мэдээлэл түгээх тэдгээрийн чадавхийг өргөжүүлж өгснөөс гадна төсөл хөтөлбөрийн зохицуулалтын асуудлыг хялбаршуулж өгсөн. Харилцан уялдаатай хөгжсөн санхүүгийн болон тээврийн сүлжээ нь дэлхийн даяарх салбар нэгж, түнш байгууллагууд эсхүл тусламжийг хүлээн авагчдад санхүү хөрөнгө шилжүүлэх, бараа бүтээгдэхүүнийг хүргэх ажлыг хялбаршуулж өгсөн. Үүний зэрэгцээ даяаршил нь АББ-ын үйлчилгээ, ялангуяа хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааны бүрэн бүтэн байдал эрсдэлд орох чиглэлд ажиллахыг хүчлэх, эсхүл орон нутгийн хэмжээнд эрсдлийг өөрчлөхөд хүргэдэг байна.

55. Олон улсын хууль ёсны этгээдийн хувьд АББ-ууд тэдгээрийн үйл ажиллагаанд даяаршлын олгож буй шинэ боломжуудыг хялбархан ашиглах боломжтой юм, үүнд:

- Илүү хөдөлгөөнтэй, хувирах чадвартай болох;
- Дэд бүтцийн сүлжээ хоорондын харилцаа холбоо
- Зөрчил мөргөлдөөнтэй эсхүл тогтворгүй (сул засаглалтай) бүс нутагт нэвтрэх илүү өргөн боломж;
- Санхүүгийн үйлчилгээ болон зохион байгуулалтын өргөн сүлжээ;
- Төвлөрсөн бус харилцаа холбоо, удирдлага;
- Олон нийттэй харилцах өргөн боломж.

56. Харамсалтай нь террористууд эдгээр давуу талуудыг далд байдлаар олж авахыг хичээдэг. Тухайлбал, Аль-Кайда сүлжээний тэсвэртэй байгаа байдал нь түүний харилцаа холбоо, менежментийн төвлөрсөн удирдлагыг сааруулах, логистик, санхүүгийн болон элсүүлэх сүлжээгээ төрөлжүүлэх чадвартай нь холбоотой юм.

²⁹ Дэлхийн голлох чиг хандлагын тухайд, Үндэсний тагнуулын зөвлөлийг үзнэ үү (2012); Хөгжил, үзэл баримтлал, номнолын төв (2013).

Үүнтэй нэгэн адил Тамил Илам (LTTE)-ын чөлөөлөх барууд байгууллага нь олон тооны харъяа АББ, хандивын байгууллагаараа дамжуулан өөрийн дэлхий даяарх логистикийн сүлжээгээ ажиллуулж байсан. Энэхүү хүмүүнлэгийн гэж харагдах байгууллагуудын даяаршсан сүлжээ нь маш бат бөх байсан тул энэ нь эцэстээ LTTE-ийн цэргийн жигүүрээс нь илүү удаан оршсон байна. АББ-ын үйл ажиллагааны хууль ёсны байдал, өргөн цар хүрээ нь түүний үйл ажиллагааны шаардлагын энэхүү давхцалтай нэгдэж, даяаршсан орчингийн өвөрмөц давуу талуудыг ашиглахыг зорьж буй террористуудын анхаарлыг татсан бай болж байна. Эцсийн дүнд, хэдийгээр тэдний зорилго ялгаатай ч террорист сүлжээ болон АББ-ууд нь дэлхийн ертөнцийн ижил орчинд оршиж ихэнхи тохиолдолд хүн амын ижил бүлэгт зорьж хүрэхийг оролддог байна. Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АББ-ууд нь сайн үйлсийн ажлын төлөө голдуу орон нутгийн эсхүл гадны зөрчил мөргөлдөөнд боогдсон хүн ам руу нэвтрэх боломжийг эрэлхийлдэг бол террорист хөдөлгөөнүүд зөрчил мөргөлдөөний хүчийг улам хурцатгах эсхүл өрөвдүүлэх халхавч олох зорилгоор эдгээр хүн амд хүрэх боломжийг эрэлхийлдэг байна. Эдгээр хүн амд хүрэх гэсэн зэрэгцээ оролдлогууд нь эцсийн бүлэгт АББ-уудыг террорист аюул заналд улам бүр ойртуулдаг бөгөөд нэг тохиолдолд АББ-ын ажилтан хулгайлагдаж, золиосны мөнгөнд барьцаалагдаж байсан.³⁰

57. Терроризмын үйл ажиллагааг санхүүжүүлэх эсхүл өөр зорилгоор дэмжих зорилгоор Ашгийн бус салбарыг ашиглах нь эцсийн дүнд аюул занал учруулах этгээд эмзэг байдлыг амжилттай ашигласны үр дагавар юм. ФАТФ нь **аюул заналыг** “хохирол учруулах чадамжтай хувь хүн эсхүл бүлэг хүмүүс, биет зүйл эсхүл үйл ажиллагаа” гэж тодорхойлсон.³¹ Түүнчлэн энэ тохиолдолд аюул занал нь Ашгийн бус салбарт хохирол учруулах *чадавхи, зорилгын* аль алиныг нь эзэмшсэн этгээдүүдээс хамааралтай байдаг.³² Террорист байгууллага нь АББ-ыг ашиглах чадавхитай байж болно, тухайлбал АББ үйл ажиллагаа явуулдаг газарзүйн орон нутгийг хянах замаар байж болох ч стратегийн учир шалтгааны улмаас хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд руу чиглэхгүй байхаар шийдсэн байж болно. Эсрэгээр нь террорист байгууллага нь Ашгийн бус салбарыг урвуулан ашиглах зорилготой байж болно, тухайлбал хөрөнгө босгох зорилгоор хууль бус АББ-ыг байгуулах боловч уг АББ-ын үйл ажиллагааг явуулах хангалттай боловсон хүчин байхгүй тул түүнийг хэрэгцээтэй чадавхигүй орхидог. Дээрх хоёр тохиолдлын аль аль нь АББ-ын салбарт **эрсдэл**³³ учруулах бөгөөд байнгын хяналтыг шаардах юм. Гэхдээ энэ нь зөвхөн зорилго, чадавхи дараалан хэрэгжсэний дараа идэвхтэй аюул занал бий болох юм.

58. **Эмзэг байдал** гэдэг нь байгууллагын түвшинд эсхүл салбарын түвшинд байж болох бөгөөд үүнийг ФАТФ-аас “аюул заналын ашиглах эсхүл үйл ажиллагааг нь дэмжих эсхүл түлхэц болох боломжтой зүйлүүд” гэж тодорхойлсон.³⁴ Байгууллагын

³⁰ Тухайлбал, SwissInfo (2014)-г үзнэ үү.

³¹ ФАТФ (2013а), х.7.


³² Аюул заналын бүрэлдэхүүн хэсгийн тухай, Смит, Клифтон, Брукс, Дэвид Ж (2013)-г үзнэ үү, х. 64.

³³ ФАТФ-аас эрсдэлийг "аюул занал, эмзэг байдал, үр дагавар гэсэн гурван хүчин зүйлийн үйлдэл" гэж тодорхойлсон. ФАТФ (2013а), 7 дугаар хуудсыг үзнэ үү.

³⁴ ФАТФ (2013), х.7.

эмзэг байдал нь хууль ёсны АББ-ууд гадны оролцогчдод ашиглуулах эсхүл дотоодын оролцогчдод хууртагдах тохиолдолд ажиглагддаг. Салбарын эмзэг байдал нь хууль бус байгууллагууд (голдуу "хуурамч" АББ-ууд гэдэг)-ыг салбартаа оруулж түүний ашигтай талуудыг завших боломжийг олгосон тохиолдлуудад ажиглагддаг. *Зураг 2.1* нь Ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглах, аюул занал, эмзэг байдал хоорондын харилцаа холбоог харуулав.

Зураг 2.1: Аюул занал, эмзэг байдал



59. Тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлууд нь ашгийн бус салбарын үйл ажиллагааг хууль бусаар ашиглах буюу ашиглах ноцтой эрсдэл байгааг харуулсан. Гэхдээ хууль бусаар ашиглах байдал хэрхэн гарч байгааг сайн ойлгохын тулд ашгийн бус салбарын эмзэг байдал болон терроризмын аюул заналын чиг хандлагыг стратегийн түвшинд үнэлэх шаардлагатай. Терроризмын аюул занал, ашгийн бус салбар, дотоодын болон олон улсын засаглалыг бүхэлд нь авч үзэхэд улс төрчдөд хандсан хэд хэдэн чухал асуултууд гарч ирдэг. Эдгээр асуултыг судлахдаа тайланг боловсруулагчид улс төрийн аливаа нэг зөвлөмжийг өгөөгүй. Харин эсрэгээр нь тайланд цаашид улс төрийн асуудлыг дотоодын болон олон улсын түвшинд авч үзэх судалгаа дүн шинжилгээтэй үндэслэлийг гаргаж өгөхийг хичээсэн болно.

АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН САЛБАР

60. Ашгийн бус салбарыг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах эрсдэлийг үнэлэхэд тулгардаг салшгүй сорилтуудын нэг нь ашгийн бус байгууллага гэж юу болохыг тодорхойлох тухай бөгөөд хамгийн чухал нь эдгээр байгууллагуудын аль нь хамгийн их эрсдэлд өртдөг болохыг тодорхойлох явдал юм. ФАТФ-ын Зөвлөмж 8-ийн тайлбарт ашгийн бус байгууллагыг "хандив буяны үйл, шашны, соёлын, боловсролын, нийгмийн эсхүл ахан дүүсийн зорилгоор хөрөнгө босгох эсхүл зарцуулах үйл ажиллагаа эсхүл бусад төрлийн сайн үйлсийн ажил эрхэлдэг хуулийн

этгээд эсхүл арга хэмжээ эсхүл байгууллага” гэж тодорхойлсон.³⁵ Түүнчлэн ФАТФ-ын 3.8-ийн Шилдэг туршлагын зааварчилгаанд шгийн бус салбарт терроризмын санхүүжилтийн үйл ажиллагаатай тэмцэх арга хэмжээ нь "1) салбарын хяналтад байдаг санхүүгийн эх үүсвэрийн ихээхэн хэсгийг болон 2) салбарын олон улсын үйл ажиллагааны ихээхэн хувийг эзэлдэг АББ-уудад хамаарна" гэж тэмдэглэсэн.³⁶ Гэсэн хэдий ч эрсдэлийг бууруулах хүчин чармайлтын хамгийн оновчтой зорилтот бүлгийн талаар Ашгийн бус салбарт тодорхойгүй байдал байсаар байна.³⁷

61. Тайланд улс орнуудаас ирүүлсэн болон нээлттэй эх сурвалжаас ашиглах боломжтой шинжлэн судалсан кейс тохиолдлуудын аль аль нь терроризмын санхүүжилтэд ашиглуулах эрсдэлд хамгийн их өртөх боломжтой АББ-ууд нь тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гэдгийг тодорхойлсон. Жон Хопкинсийн Их сургуулийн Иргэний нийгмийн судалгааны төвөөс хийсэн нэгэн томоохон судалгаанд эрсдэлд хамгийн их өртөж болзошгүй байгууллагуудыг нарийвчилж үзэхэд туслах АББ-уудын үйл ажиллагаанд хэрэгтэй ангилалыг гаргасан байна. Тайланд АББ-уудын явуулдаг найман төрлийн үйл ажиллагааны жагсаалтыг гаргаж тэдгээрийг хоёр ерөнхий ангилалд хуваасан.³⁸ Зураг 2.2-д найман үйл ажиллагааны төрлийг болон хоёр ерөнхий ангиллыг харуулав.

Зураг 2.2 АББ-ын үйл ажиллагааны төрөл

Үйлчигээний үйл ажиллагаа	Идэвхтэй төлөөллийн үйл ажиллагаа
Орон сууцаар хангах	Спорт, биеийн тамир
Нийгмийн халамж	Урлаг, соёл
Боловсрол	Сонирхолын төлөөлөл
Эрүүл мэнд	Өмгөөлөл

Эх сурвалж: Лестер М.Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2013 он), х.5.

³⁵ ФАТФ-ын Зөвлөмж 8-ийн тайлбарт (2012а), х.58.

³⁶ ФАТФ (2013b), х.4.

³⁷ Ашгийн бус салбарын хамтран ажилладаг байгууллагуудын ФАТФ-ын ашгийн бус салбарын асуумжид өгсөн хариулт, 2014 оны 2 дугаар сар.

³⁸ Лестер М.Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2013он), х.5. Эдгээр үйл ажиллагааны төрлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл “Ашгийн бус байгууллагын олон улсын ангилал” хэмээх баримтад хандахыг зөвлөж байна.

62. Зураг 2.3-т энэхүү тайланд шинжлэн судлуулахаар ирүүлсэн кейс тохиолдлын үйлчилгээ болон идэвхтэй төлөөллийн үйл ажиллагааг АББ-ын үндсэн үйл ажиллагаа гэж хэдэн удаа тодорхойлсныг харуулав. Гэхдээ олонхи ирүүлсэн мэдээлэлд үйл ажиллагааны төрлийг ялгахад АББ-ын үйл ажиллагааг хангалттай нарийвчлан тогтоож өгөөгүй болно.

Эдгээр үйл ажиллагааны төрлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл “Ашгийн бус байгууллагын олон улсын ангилал” хэмээх баримтад хандахыг зөвлөж байна.

Зураг 2.3: Шинжлэн судалсан кейс тохиолдолд ажиглагдсан АББ-ын үйл ажиллагааны ангилал¹

Хэдэн удаа АББ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлээр үйлчилгээний үйл ажиллагаа тогтоогдсон болох	Хэдэн удаа АББ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлээр идэвхтэй төлөөллийн үйл ажиллагаа тогтоогдсон болох	Хэдэн удаа АББ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох боломжгүй байсан болох
64 ²	0	38

Тэмдэглэл:

1. Дээрх тоо нь кейс тохиолдлын нийт тоонд нэмэгдэхгүй. Учир нь: 1) дийлэнх олонхи кейс тохиолдолд АББ-ын үндсэн үйл ажиллагааг хангалттай нарийвчлан тогтоогоогүй, 2) Мөн олонхи кейс тохиолдолд АББ тус бүр дээр нэгээс илүү үндсэн үйл ажиллагааны төрлийг тодорхойлсон эсхүл кейс тохиолдол бүрт нэгээс илүү АББ оролцсон байв.

2. Хэдийгээр шашны АББ-ыг идэвхтэй төлөөллийн гэж үзэж болох боловч шашны байгууллагуудын явуулдаг зарим тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа нь голдуу үйлчилгээнд чиглэсэн байдаг. Тиймээс олонхи кейс тохиолдол нь шашны байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой байв.

63. Дээрх судалгаа нь үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АББ-ууд нь судалгаанд хамрагдсан 14 улсын хэмжээнд³⁹ Ашгийн бус салбарын гаргасан нийт нэмэгдсэн өртгийн дунджаар 73 хувийг эзэлж байсан бөгөөд энэ нь үйлчилгээний үйл ажиллагаа ФАТФ-ын 3.8-ийн Шилдэг туршлагын зааварчилгаанд дурдсан ашгийн бус салбарын эзлэх хувь, хамрах хүрээг хамарч байгааг харуулж байна. Тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлуудад хамрагдсан бүх АББ-ууд нь үндсэндээ хүмүүнлэгийн тусламжийн орон сууцаар хангах, нийгмийн үйлчилгээ, соёлын үйлчилгээ,⁴⁰ боловсрол, эрүүл мэнд гэх мэт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд тэдний нэг нь ч сонирхолын илэрхийлэл, өмгөөлөл зэрэг идэвхтэй төлөөллийн үйл ажиллагаа явуулахад чиглээгүй байв. Иймд, байгаа

³⁹ Энэ хувь нь судалгаанд хамрагдсан 14 улсын ашгийн бус салбарын үйлчилгээ, идэвхтэй төлөөллийн үйл ажиллагааг харьцуулсан задаргаанд үндэслэсэн. Судалгаанд хамрагдсан 14 улс нь Австрали, Бельги, Бразил, Канад, Чех, Франц, Израиль, Япон, Кыргызстан, Мозамбик, Шинэ Зеланд, Норвеги, Португал, Тайланд улсууд байв.

⁴⁰ "Соёлын үйлчилгээ" гэдэг нь соёлын төвийг засварлах гэх мэт үйл ажиллагааг хэлнэ.

мэдээлэлдээ үндэслэн, "үйлчилгээний АББ-ууд"-ыг террорист хөдөлгөөнүүд хамгийн ихээр ашигладаг гэсэн дүгнэлт гарч байна.

64. Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа эрхэлдэг АББ-уудын хувьд даяаршил нь өөр хоорондоо зөрчилдөөтэй хоёр төрлийн өсөлтийг авчирсан. Хүйтэн дайны төгсгөл 50 жилийн туршид үргэлжилсэн хоёр туйлт хүчний тэнцвэрийг үгүй болгож олон хурцадмал байдлыг чөлөөлсний улмаас шинэ зөрчил мөргөлдөөнийг бий болгосон. Үүний зэрэгцээ, төр засгийн оролцогчдод үүссэн шинэ нөхцөл байдалд дасан зохицохтой хамт эдгээр зөрчилдөөнийг болон түүний үр дүнд бий болсон хүмүүнлэгийн шаардлагыг уламжлалт аргаар шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээлтэй болсон.⁴¹ Ерөнхийдөө төр засгийн газрын байгууллагуудаас үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн мөнгөнд учруулах дарамтыг бууруулах хүчин чармайлтын үүднээс хувийн хэвшлийн салбарт түүний дотор ашгийн бус салбарт олон үйлчилгээг шилжүүлсэн. Эдгээр үйл явдлууд нь ашгийн бус салбарт тавигдах шаардлагыг нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ, дэлхий дахины нөхцөл байдлын ээдрээтэй байдал террорист бүлэглэлүүд, ноцтой зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ, босогчид засаглалын тогтолцоогоо шинэчлэх эсхүл шинээр бий болгохоор тэмцэж буй газар нутагт шинэ боломжуудийг олсноор салбарын үйл ажиллагаанд тулгарах *эрсдэлийг нэмэгдүүлсэн*.

65. Үүнтэй ижил төстэй хүчин зүйлсийн улмаас үйл ажиллагааныхаа халдашгүй байдлыг хамгаалах нь олон улсад үйл ажиллагаа явуулдаг ихэнх салбарын хувьд гол шаардлага болжээ. Хэд хэдэн улсад авлигын эсрэг хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагууд нь бизнесийн салбарт илүү боловсронгуй хянан магадлах ажиллагаанд хөрөнгө оруулалтыг татсан.⁴² Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болон түүнтэй холбоотой мөнгө угаах эсхүл хуурамчаар үйлдэх ажиллагаа нэмэгдсэний улмаас санхүүгийн салбарт тавигдах ижил төстэй шаардлагууд мөн нэмэгдсэн. Хүний эрхийн хэм хэмжээ зэрэг олон улсын дэглэмийн хөгжил дэвшилтэй холбогдуулан нийтийн албаны өсөн нэмэгдэж буй үйл ажиллагаанд хянан магадлагааны нийцүүлэлт мөн чухал ач холбогдолтой байх юм.⁴³ Нийцүүлэлтийн шинэ шаардлага нь янз бүрийн салбарт янз бүрийн шалтгааны улмаас үүссэн боловч цогцоороо дэлхий дахины нөхцөл байдлын улам бүр нэмэгдэж буй ээдрээтэй байдал олон улсын бүх хууль усны оролцогчдод үйл ажиллагааныхаа халдашгүй, хариуцлагатай байдлыг хамгаалах шинэ шаардлагыг тавьсан.

66. АББ-ын салбар эдгээр шаардлагын дагуу нилээд их арга хэмжээ авч байгууллагын үйл ажиллагааны хариуцлага, ил тод байдлыг хангахад туслах зорилгоор хэд хэдэн ялгаатай стандарт, санаачилгыг боловсруулсан. *Зураг 2.4-т*

⁴¹ Эдгээр чиг хандлагын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Алан Мунро (Munro, Alan) (1999он)-ын ажлаас үзнэ үү.

⁴² Тоби Жей Ф. Бишоп (Bishop, Toby J.F.) болон Фрэнк Е.Хайдоски (Hydoski, Frank E.) (2009 он).

⁴³ Оливер Де Шуттер (De Schutter, Olivier) болон бусад (2012 он).

зарим стандарт, санаачилгын жагсаалтыг тэдгээрийг боловсруулах эсхүл хянах үүрэгтэй байгууллагуудын нэрсийн хамт оруулав.

Зураг 2.4: Ашгийн бус байгууллагын салбараас боловсруулсан ил тод байдлын стандарт, санаачилга

Стандарт, санаачилга	Боловсруулсан байгууллага(ууд)
Онцгой байдлын үед авах арга хэмжээний төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны зарчим	Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг
«Хохирол учруулахгүй байх» гарын авлага: Зөрчлийг шийдвэрлэхэд үзүүлэх тусламжийн нөлөөллийг шинжлэн судлах үндэслэл	“Collaborative for Development Action, Inc.” байгууллага; тус байгууллагын хамтарсан боловсролын төсөл хөтөлбөрүүд
Хувийн сайн дурын байгууллагуудын стандарт	«InterAction» байгууллага
«Humanitarian Accountability Partnership» байгууллагын стандарт	«Humanitarian Accountability Partnership» байгууллага
Хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулахад авлигаас урьдчилан сэргийлэх шилдэг туршлагын гарын авлага	«Transparency International» байгууллага
Хүмүүнлэгийн үйл ажиллагааны дүрэм болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх стандартын доод хэмжээ	«The Sphere Project » байгууллага
Үнэлгээ, сургалтын үйл ажиллагаа	Хүмүүнлэгийн үйл ажиллагааны хариуцлага, зан үйлийн сургалтын сүлжээ
Багийн сургалтын мөчлөг	“URD” бүлэг
Онцгой байдлын үед чадавхийг бэхжүүлэх төсөл	Онцгой байдлын үед чадавхийг бэхжүүлэх байгууллага хоорондын ажлын хэсэг
“People in Aid” байгууллагын ёс зүйн дүрэм	“People in Aid” байгууллага
Мусульман шашны буяны форум	“Human Appeal International”, “Human Relief Foundation”, “Islamic Relief”, “Muslim Aid”, “Muslim Hands” байгууллагууд

Онцгой байдлын үе дэх боловсрол сургалтын олон улсын сүлжээний баримтлах стандартын доод хэмжээний гарын авлага	Онцгой байдлын үе дэх боловсрол сургалтын олон улсын сүлжээ
Хүмүүнлэгийн тусламжийн асуудлыг нарийвчлан судлах	“Save the Children” (Их Британи), “Institute Bioforce”, “RedR”, “FrontlineSMS” байгууллагууд
Үнэлгээ, хяналтын үйл ажиллагаа	Хөрөнгө босгох товчоо
Энхтайвныг бэхжүүлэх үнэлгээний систем	Энхтайвныг бэхжүүлэх холбоо

Тэмдэглэл: ФАТФ-ын *Ашгийн бус салбараас авсан асуумжид* өгсөн хариултаас ашиглав, 2014 оны 2 дугаар сар.

67. АББ-ын салбараас эдгээр стандарт, санаачилгуудыг боловсруулсан нь салбарын үйл ажиллагааны халдашгүй байдлыг хангах чухал алхам юм. Гэсэн хэдий ч террористууд, нэн ялангуяа зөрчил мөргөлдөөнтэй газар нутгийн гадна байх өөрсдийн үйл ажиллагаагаа нуун далдлахын тулд ихэвчлэн хууран мэхлэх аргыг ашигладаг байна. Тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлууд нь төрийн бус оролцогчдийн боломжит нөөц бололцоогоор сайтар төлөвлөсөн луйврын үлдлийг илрүүлэхэд хэцүү гэдгийг илтгэх тул төр төвтэй хяналт болон төрийн чадавхи нь салбарын үйл ажиллагаанд учруулах хамгийн ноцтой аюул заналыг илрүүлэхэд нэн шаардлагатай хүчин зүйл болж байна. Үүнийг хууль бусаар ашигласан хэргийг хэрхэн илрүүлэх тухай судалсан Дөрөвдүгээр бүлэгт илүү нарийвчлан тусгалаа.

АШГИЙН БУС САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЭМЗЭГ БАЙДАЛ

68. Ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглах тохиолдол хэрхэн илэрч болохыг тодорхойлохын өмнө нийтэд хэрэглэгдэх, ялангуяа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад хэрэглэж болох ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны загвартай байх шаардлагатай юм. Тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлууд болон ашгийн бус байгууллагын тухай ном товхимолд ашгийн бус байгууллагын үйл ажиллагааг таван ерөнхий зүйлд нэгтгэж болохыг харуулж байна (Зураг 2.5-ыг үзнэ үү).

1. *Хөрөнгө цуглуулах* гэдэг нь Ашгийн бус байгууллага шууд эсхүл сайн дурынхан зэрэг гуравдагч этгээдээр дамжуулан хөрөнгө олж авах аливаа үйл ажиллагааг хэлнэ.

2. *Хөрөнгийг хадгалах* гэдэг нь Ашгийн бус байгууллага хөрөнгийг хураах эсхүл хамгаалахыг хэлнэ. Хадгалалт нь банкны данс хоорондын хөрөнгөний үйлчилгээнээс үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламжийн менежментийн үйл ажиллагаа зэргийг хамруулна.

3. *Хөрөнгийг шилжүүлэх* гэдэг нь Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны явцад хэд хэдэн удаа тохиолдох боломжтой бөгөөд Ашгийн бус байгууллагын хөрөнгийг өөр өөр оролцогчдийн хооронд шилжүүлэх аль нэг мөчийг хэлнэ.

4. *Хөрөнгө зарцуулах* гэдэг нь Ашгийн бус байгууллагын хөрөнгийг бараа, үйлчилгээний төлбөрт солилцох аль нэг мөчийг хэлнэ.

5. *Үйл ажиллагааг хэрэгжүүлэх* гэдэг нь Ашгийн бус байгууллага хөтөлбөрийн үйл ажиллагаагаа явуулах мөчийг хэлнэ. Үүнд тусламжийг тараах, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө босгох арга хэмжээ зохион байгуулах болон зочин илтгэгчийг хүлээж авах зэрэг үйл ажиллагааг оруулж болно.

Зураг 2.5: Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны ерөнхий загвар



69. Хөрөнгө гэсэн нэр томъёоллыг хандив хэлбэрээр өгсөн бараа, үйлчилгээ эсхүл үнэ бүхий (үл хөдлөх гэх мэт) санхүүгийн бус эх үүсвэрүүдийг хамруулах зорилгоор ашигласан. Түүнчлэн эдгээр бүх өгөгдөл нь ашгийн бус байгууллагын хөтөлбөрт үргэлж багтдаггүй тул эдгээрийг шулуун шугаман байдлаар танилцуулаагүй болно. Тухайлбал, хэрвээ ашгийн бус байгууллагын хөтөлбөрийг тухайн байгууллагын ажилтнууд өөрсдөө удирдан зохион байгуулдаг бол хөрөнгө шилжүүлдэггүй байна. Ялангуяа нэгээс олон ашгийн бус байгууллага холбогдсон тохиолдолд эдгээр ялгаатай өгөгдлүүд нь бие биенээсээ хамааралгүй гэсэн үг биш юм.

70. Эдгээр өгөгдөл нь ашгийн бус салбарын онцлог шинж байх тул энэ нь террористуудад ашиглуулах эмзэг байдлыг бий болгодог байна. Гэхдээ эдгээр нь нөгөө талаас тус салбарыг олон улсын өвөрмөц бөгөөд үр дүнтэй оролцогчид

болгодог шинж чанарууд юм. Эмзэг байдлыг дөрвөн үндсэн ангилалд хувааж болох юм:

1. Зохион байгуулалтын өргөн сүлжээ

Зохион байгуулалтын сүлжээ нь ашгийн бус байгууллага үйл ажиллагааныхаа хөрөнгийг цуглуулах, хадгалах, шилжүүлэх, зарцуулах холбоос болдог. **Өргөтгөсөн зохион байгуулалтын сүлжээ** нь ашгийн бус салбарт илүү өргөн хүрээг хамрах боломжийг өгдөг бөгөөд энэ нь ашгийн бус байгууллагуудад олон түншээр дамжуулан олон газарт хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжийг олгодог. Нөгөө талаас тэдгээрийн өргөн цар хүрээг хамарсан байдлаас өргөтгөсөн зохион байгуулалтын сүлжээ нь эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Илүү олон хүнтэй, өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа болон газарзүйн ихээхэн орон зайг хамруулах нь хөрөнгийн зохистой хяналтыг хангахад хүндрэл бэрхшээлтэй байх юм. Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагын хувьд зохион байгуулалтын сүлжээ нь ихэвчлэн зөрчил мөргөлдөөнтэй эсхүл засаглал султай газарзүйн бүс нутгаар дамждаг. Түүнчлэн арай зөөлөн засаглалтай байж болох бусад салбараар дамжин (тухайлбал, зохицуулалтгүй мөнгөний бизнес) хөрөнгө урсах эрсдэл нэмэгддэг байна. Эдгээр хоёр нөхцөл байдал нь хөрөнгийн зориулалтыг өөрчлөх эсхүл хөтөлбөрийг хууль бусаар ашиглах эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

2. Олон тооны хугацаат ажиллах хүчин

Ашгийн бус салбар нь **олон тооны хугацаат ажиллах хүчнээс** ихээхэн хамаардаг. Сайн дурын ажилтнууд энэхүү ажиллах хүчний ач холбогдолтой бөгөөд чухал хэсгийг бүрдүүлдэг. 22 улсад хийсэн томоохон харьцуулсан судалгаагаар Ашгийн бус байгууллагын үйл ажиллагаанд ойролцоогоор 19 сая орон тооны ажилтан ажиллаж байна. Үүн дээр сайн дурын ажилтнуудыг нэмж оролцуулбал уг тоо ойролцоогоор 29 саяд хүрнэ.⁴⁴ Гэхдээ ашгийн бус салбарт ажиллах хүчний шинж чанараас шалтгаалан ажилтнууд, ялангуяа сайн дурын ажилтнууд, гадаад түншийг шалгах хэцүү байдаг.⁴⁵ Түүнчлэн жижиг, дунд ашгийн бус байгууллагад энэ төрлийн ажиллах хүчний эрсдэлийн үнэлгээ, хянан нийцүүлэлт, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн ажилтныг татах, үлдээх нь хүндрэлтэй байдаг. Эдгээр ажилтны дарамт ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны хянан магадлагааны нийцүүлэлт, аюулгүй байдлыг хангаж чадахгүй байдгаас хууль бусаар ашиглуулах эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

3. Үйл ажиллагааны чадавхи

⁴⁴ Лестер М.Саламон (Salamon, Lester M.) болон бусад (1999 он), 9-10 дугаар хуудас.

⁴⁵ Ажилтнуудыг шалгах гэдэг нь өргөн хүрээнд ил тод байдал, хариуцлагын арга хэмжээг дэмжих үүднээс, түүний дотор терроризмтой тэмцэх зорилгоор ажилтнуудад хянан магадлагаа явуулахыг хэлнэ.

Түүнчлэн ашгийн бус салбар нь **үйл ажиллагааны өндөр хүчин чадавхитай**.⁴⁶ ФАТФ-аас ашгийн бус байгууллага нь эмзэг байж болно учир нь “их хэмжээний хөрөнгийн эх үүсвэрт хүрэх боломжтой бөгөөд ихэвчлэн хөрөнгөнд тулгуурласан байдаг гэдгийг тэмдэглэсэн. Түүнчлэн зарим АББ нь голдуу террорист үйл ажиллагаанд хамгийн их өртөх боломжтой бүс нутаг эсхүл түүний ойролцоо байх орон нутгийн болон олон улсын үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээг хамарсан олон улсын төлөөлөлтэй байдаг”.⁴⁷ Энэ дүгнэлтийг шинжлэн судалсан кейс тохиолдлуудад ашгийн бус байгууллагыг ашигласан болон холбогдох ном товхимолуудаас харагдаж, тогтоогдож байна. Ашгийн бус салбар нь хөрөнгө нөөцөнд ихээхэн тулгуурласан, үндэстэн дамнасан шинж чанартай. Эдгээр хөрөнгө нөөц болон холбогдох зохион байгуулалтын сүлжээг ашиглах боломжтой тохиолдолд энэ нь террорист хөдөлгөөнүүдэд чухал байх юм. Түүнчлэн АББ нь хүн амд хүрэх онцгой чадвартай, ялангуяа зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт болон үндэсний цөөнхи иргэдэд. Эдгээр онцгой шинж чанарыг ашиглах нь террорист хөдөлгөөнүүдэд АББ-ын хөрөнгө нөөц, хөтөлбөрийг хууль бусаар ашиглаж өөрсдийн хөдөлгөөндөө элсүүлэх боломжийг олгодог байна.

АББ-уудын үйл ажиллагааны чадавхийн бас нэгэн чухал зүйл нь олон нийтийн тус салбарт үзүүлэх итгэх итгэл юм. Ерөнхийдөө тус салбар нь олон нийтийн итгэлийг ихээхэн хүлээдэг тул АББ-ын үйл ажиллагааны шалгалт нь бусад салбартай харьцуулахад харьцангуй тогтмол бус, зөөлөн байв. Өөрсдийн үйл ажиллагаа болон зохион байгуулалтын сүлжээний эрсдэлийг багасгахыг эрэлхийлж буй террорист этгээдүүдийн хувьд хууль ёсны АББ-уудыг дүр эсгэж дуурайх нь анхаарал татахуйц татсан шийдэл байв.

4. Байгууллагын соёл

Эцэст нь авч үзэхэд эмзэг байдал **байгууллагын соёлтой** шууд холбоотой юм. Энэ талыг ашгийн бус салбараас авсан асуумжид өгсөн хариулттай холбогдуулан тайлбарласан бөгөөд судалгаанд оролцогчид зарим АББ-уудын ямар үнэт зүйлд ач холбогдол өгч байгаагаас нь шалтгаалан энэ нь муу шийдвэр гаргах, эрсдэлийн менежмент тааруу байхад нөлөөлж болохыг тэмдэглэсэн байв.⁴⁸ Судалгаа дүн шинжилгээгээр ашгийн бус байгууллагууд дахь үнэт зүйлийн ач холбогдлыг судалж үзсэн бөгөөд зарим байгууллагуудын хувьд үнэт зүйлийн хэмжүүр нь “хамгийн чухал зүйл” болохыг тогтоосон.⁴⁹ Хэдийгээр энэ нь байнгын эмзэг байдал биш боловч

⁴⁶ Энэ нь бүхэлдээ тус салбарын хувьд болон нэн ялангуяа томоохон байгууллагуудын хувьд үнэн юм. Жижиг АББ-ын хувьд, хэдийгээр ерөнхийдөө арай бага чадавхитай байх ч холбоо сүлжээ, үйл ажиллагааны шинэлэг арга барилыг ашиглах замаар өөрийн хэмжээнээсээ илүү их чадавхитай байж болно.

⁴⁷ ФАТФ-ын Зөвлөмж 8-ийн (Ашгийн бус байгууллага) тайлбарт (2012a), х.54.

⁴⁸ *Ашгий бус салбарын асуумжид* өгсөн хариулт, 2013 оны 12 дугаар сар.

⁴⁹ Байгууллагын соёл, ес зүйн үнэт зүйлийн гүйцэтгэх үүргийн талаарх мэдээллийг Ф.Тонкис (Tonkiss, F.) болон А.Пейси (Pasey, A) (1999 он), хуудас 257-74; түүнчлэн Гельмут К.Анхейер (Anheier, Helmut K.) (200 он)-ын ажлаас үзнэ үү.

хамааралгүй болон хамааралтай этгээдэд итгэх хандлага нь зарим АББ-ыг хууль бусаар ашиглахад өртөмтгий болгодог байна.

ТЕРРОРИЗМЫН АЮУЛ ЗАНАЛЫН ӨНӨӨГИЙН ҮНДСЭН ШИНЖ

71. Ихэнхи аюул заналын нэгэн адил терроризм нь хөдөлгөөнгүй зүйл биш юм. Ашгийн бус салбарт учрах аюул заналыг зохих хэмжээнд үнэлэхийн тулд терроризмын өнөөгийн чиг хандлагыг судлах, террорист байгууллагууд Ашгийн бус салбартай хэрхэн, хэзээ харилцаж болохыг ойлгох шаардлагатай юм. Террорист этгээдэд өөрсдийн сүлжээ, стратегиа өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицуулдаг. Тухайлбал, аюулгүй газар байсан Афганистаныг алдсан нь Аль Кайдаг (AQ) төвлөрсөн удирдлагаа сааруулах, бүс нутгийн харьяа байгууллагууд болон энд тэнд тарж бутарсан удирдлагын сүлжээндээ илүү түшиглэхэд хүргэсэн.⁵⁰ Аль Кайда, Тамил Иламын чөлөөлөх барууд (LTTE) зэрэг томоохон бүлгүүдийн төвлөрсөн удирдлагыг сааруулах, тарж хуваагдах явдал нь аюул заналын орчинд терроризмын сүлжээг нарийн төвөгтэй болгосон. Гэхдээ террорист аюул заналхийллийн хамгийн их сорилт дагуулсан хувьсал өөрчлөлт нь өөрсдийн санаачилгаар террорист үйл ажиллагаанд татагддаг орон нутгийн бичил нэгж буюу хувь хүмүүст стратегийн ач холбогдол өгсөн явдал юм.⁵¹

72. Эдүгээ хялбар танигдахуйц шаталсан удирдлагатай байгууллагууд харьцангуй бага төвлөрсөн удирдлагатай болсон нь терроризмыг дэмжих санхүүгийн эсхүл холбогдох эд материалын хандив өргөх уриалгыг цахим сүлжээгээр олон нийтэд түгээх боломжтой болсон. Террорист хөдөлгөөнүүд терроризм эсхүл террорист байгууллагуудыг дэмжих зорилгоор хөрөнгө босгох, элсүүлэх зэрэг өөрсдийн үйл ажиллагааны олон талыг дэмжих үүднээс цахим орчинг өргөнөөр ашигладаг болсон.⁵²

73. Террорист хөдөлгөөний тодорхой удирдлагын шатлалгүйгээр, шууд бусаар хувь хүний сонирхолыг өдөөн хатгах чадвар улам нэмэгдэхтэй холбогдуулан **орон нутгийн террорист этгээдийн** аажим боловч мэдэгдэхүйц өсөлтөд хүргэсэн.⁵³ Энэ нэр томъёо нь өөрсдийн төрөлх эх орноосоо эсхүл эх орондоо, заримдаа гадны оролцогчдын нөлөөнд автан террорист үйл ажиллагаанд татагдан оролцдог тухайн улсын иргэд эсхүл хууль ёсны оршин суугчдад хамаарна. Түүнчлэн энэ нь террорист байгууллагын нөлөөгөөр элсүүлээгүй бөгөөд террорист үйл хэргийг урагшлуулах зорилгоор өөрийн санаачилгаар террорист үйл ажиллагаанд оролцдог хувь хүн

⁵⁰ AQ хөдөлгөөний бүс нутгийн харьяа байгууллагуудад Араб Улсын хойг дахь Аль-Каида (AQAP), үндсэндээ Йемен Улсаас үйл ажиллагаа явуулдаг, Зүүн Африк дахь Аль Шабаб, Хойд болон Баруун Африк дахь Исламын Магреб (AQIM) дахь Аль Кайда багтана.

⁵¹ Аль Шабаб зэрэг AQ болон түүний харьяа байгууллагууд дотооддоо болон хувиараа эхэлсэн хүмүүсийг ашиглах гэж удаа дараа оролдож байсан. Тухайлбал, SITE Хяналтын үйлчилгээ (2014) -г үзнэ үү.

⁵² НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар (2012 он), хуудас 3-12; Инес вон Бер (Von Behr, Ines); Анаис Рединг (Reding, Anais); Чарли Эдвардс (Edwards, Charlie) болон Люк Гриббон (Gibbon, Luke) (2013 он).

⁵³Брайан Майкл Женкинс (Jenkins, Brian Michael) (2011 он); Томас Прехт (Precht, Tomas) (2007 он)-ыг үзнэ үү.

эсхүл жижиг бүлгүүдэд хамаарна.⁵⁴ Энэ хандлагын чухал тал нь элсүүлэх, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх (санхүүжилтийг оролцуулан) болон халдлагыг албан ёсны байгууллагатай маш бага, шууд бус харилцан орон нутагт тохиолдож болдог байна.

Орон нутгийн террорист этгээдүүд гэдэг нь:

i) өөрсдийн төрөлх эх орондоо эсхүл эх орноосоо, заримдаа гадны оролцогчдын нөлөөнд автан (албан ёсныхоос сэтгэл хөөрөл хүртэл) террорист үйл ажиллагаанд татагдан оролцдог тухайн улсын иргэд эсхүл хууль ёсны оршин суугчид

ii) террорист байгууллагын нөлөөгөөр элсүүлээгүй бөгөөд террорист үйл хэргийг урагшлуулах зорилгоор өөрийн санаачилгаар террорист үйл ажиллагаанд оролцдог хувь хүн эсхүл жижиг бүлгүүд

Орон нутгийн террорист этгээдүүдийн оролцсон террорист үйлдлүүдийн жишээг дурдвал:

■ Нидерланд Улсын Хофстад Сүлжээний 2003-2005 оны хооронд хийсэн янз бүрийн ажиллагаа, үйлдлүүд.

■ 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Лондон хотод болсон амиа золиослогчдын тавьсан бөмбөгдөлтүүд.

74. Террорист хөдөлгөөний стратегийн ерөнхий байршлыг функц хэлбэрээр нь авч үзвэл орон нутгийн террорист этгээдүүд нь аюул заналын орчны чухал бөгөөд нөлөө бүхий талыг төлөөлж байна. Тухайлбал, "удирдагчгүй эсэргүүцэл" гэсэн ойлголтыг "Аль-Каида"-ийн олон нийтийн хэвлэл мэдээллийн гол хэрэгсэл болох "Тэмүүлэл" онлайн нийтлэлд байнга гардаг.⁵⁵ Түүнчлэн орон нутгийн, өөрөө сонголтоо хийсэн, ерөнхийдөө бие даасан этгээдүүдийг олж илрүүлэхэд хүндрэлтэй байдаг тул эдгээр ажиллагааны гадна байх этгээдүүд үйл ажиллагаа явуулахад хэцүү байсан улс орнуудад хэд хэдэн халдлагыг сайтар зохион байгуулахад хүргэсэн байдаг.⁵⁶

75. Хэдийгээр сүлжээний төвлөрсөн удирдлагыг сааруулах, орон нутгийн этгээдүүдэд түшиглэх нь шинэ ач холбогдлыг өгсөн ч илүү олон албан ёсны

⁵⁴ Марк Сагемен (Sagemen, Marc) (2008 он); Жорж Майкл (Michael, George) (2012 он).

⁵⁵ Тухайлбал, Абу Мусаба Аль-Сури (Abu Musa'ab al Suri)-ийн ач холбогдлыг харна уу. Бриньяр Лиа (Lia, Brynjar) (2008 он), Дэвид Самюелс (Samuels, David) (2012 он), Стивен Сталински (Stalinsky, Steven) (2011 он).

⁵⁶ Хэд хэдэн иймэрхүү "дотоддын гаралтай" төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлсэн. Үүнд: 2013 онд Бостоны марафоны үеэр болсон дэлбэрэлт; 2013 онд Лондон хотын Вулвич хотод Английн цэргийн албан хаагчийн амь насыг хороосон; 2011 онд Норвегийн Осло хотод болон Утоя аралд Андерс Брейвикийн хийсэн террорист халдлага; 2009 онд "Форт-Худ" цэргийн баазад болсон аллага; 2005 оны 7 дугаар сарын 7-нд Лондон хотноо болсон дэлбэрэлт; 2004 онд Нидерландад Тео Ван Гогийн амь насыг хороосон хэрэг зэрэг болно.

байгууллагаас учруулах олон улсын аюул заналхийлэл одоо ч гэсэн маш их хамаатай бөгөөд ихэвчлэн тухайн орон нутгийн террорист этгээдүүдийн хүсэл зориг тэмүүлэл нь болдог. Сүүлийн үеийн үйл ажиллагаа нь террорист байгууллагууд уламжлалт хагас цэрэгжсэн чадавхийг санхүүжүүлэх, хөрөнгө нөөц бололцоогоор хангахыг эрэлхийлдэг болохыг илтгэж байна.⁵⁷ Тухайн орон нутгийн террорист этгээдүүд эсхүл сүлжээ, уламжлалт террорист байгууллагуудад ижил ач холбогдол өгч байгааг харгалзан террорист аюул заналхийллийн шинж чанар нэгээс нөгөөд шилжсэнгүй, харин илүү олон янз болсон. “Гадны байлдагчид”⁵⁸ гэх үзэгдэл нь энэхүү өөрчлөлтийн тусгал юм. Уламжлалт террорист байгууллагууд гадаад улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ч томоохон аюул занал хэвээр байна.⁵⁹ Үүний зэрэгцээ, дотооддоо бий болсон хэт даврагчид эдгээр байгууллагуудад сайн дурынхан нэрээр нэгдэж гадаад улсад террорист халдлагад оролцож байна.⁶⁰ Энэ нь аюул заналхийлж буй орон нутгийн болон олон улсын этгээдийн хооронд илүү “харилцан ашигтай” харилцаа тогтож байгааг харуулж байна. Зураг 2.6-д эдгээр харилцааны заримыг нь дүрслэн харуулахыг оролдов. Террорист сүлжээ, АББ нь эрс тэс ялгаатай зорилгын төлөө явдаг ч орон нутгийн эсхүл гадны үйл ажиллагаатай уялдсан, ихэвчлэн ижил төстэй зохион байгуулалтын чадавхид тулгуурладаг болохыг Зураг 2.6-д “ашиглах аргууд”-аас харагдаж байна. Хөрөнгө, мөнгө, материал, хүн хүч, олон нийтэд нөлөөлөх⁶¹ нь АББ-ын гол нөөц бололцоо хэдий ч үүнийг мөн орон нутгийн болон гадны террорист байгууллагууд эрэлхийлдэг байна. Ижил төрлийн хөрөнгө эх үүсвэрийн хэрэгцээ шаардлагаас үүдэн хууль ёсны болон хууль бус этгээдүүд өөр хоорондоо харшилдахад хүргэж болзошгүй бөгөөд энэ нь олон улсын үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй юм.

⁵⁷ Тухайлбал, Найроби дахь “Вестгейт” худалдааны төвд Аль-Шабааб”-ын дайчдын хийсэн халдлага, “Имарат Кавказ” байгууллагатай холбоотой амиа золиослогч-дайчдын үйлдсэн Волгоград хотод болсон дэлбэрэлт, 2013 онд Алжир дахь “Тигантурин” газрын тос, байгалийн хийн цогцолборт “Исламын Магребын орнууд дахь Аль-Каида” бүлэглэлийн дайчдын үйлдсэн халдлага, “Хизболла”-гийн Сирийн мөргөлдөөнд байнга оролцдог зэрэг нь илүү төвлөрсөн террорист байгууллагуудын үйл ажиллагааны жишээ юм.

⁵⁸ Ихэвчлэн үзэл суртлаас шалтгаалан зөрчил мөргөлдөөнд оролцохоор гадаад руу явж байгаа этгээд (өөрөөр хэлбэл тэдгээр нь зөрчилдөөний “гадаадын” оролцогчид байдаг).

⁵⁹ Аршам Мохаммед (Mohammed, Arsham) болон Табассум Захария (Zakaria, Tabassum) (2013 он).

⁶⁰ Томас Неггхаммер (Hegghammer, Thomas) (2013 он), Аарон Е.Зелин (Zelin, Aaron Y.) (2013 он).

⁶¹ Энэ утгаараа “олон нийтийн үзэл бодолд нөлөөлөх” гэдэг нь хүн амын тодорхой хэсэгт нэвтрэх, нөлөөлөх, биеэрээ буюу үйл ажиллагаа явуулах замаар эсхүл холбогдох мэдээллийг дамжуулах замаар хүрэх чадварыг хэлнэ.

Зураг 2.6: АББ-д учруулах террорист аюул занал



ТЕРРОРИСТУУД ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ, АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГАД УЧРУУЛАХ ЭРСДЭЛ

Стратегийн асуудлууд

76. Терроризмын аюул заналын орчны чиг хандлага террористууд хэрхэн хууль бус зорилгоор ашигладаг, терроризмын санхүүжилт (ТС) зэрэг зарим тодорхой хүчирхийллийн хэлбэрүүд хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгаа болон энэ нь Ашгийн бус салбарт хэрхэн нөлөөлж байна вэ гэдэг асуултыг гаргадаг. Тухайлбал, 9/11-нээс хойш терроризмын асуудалд ихээхэн анхаарал хандуулж ирсэн нь терроризмын санхүүжилт зэрэг зарим үйл ажиллагааг нь улам далд хэлбэрт оруулсан нь АББ зэрэг хууль ёсны байгууллагуудын халхавч нь террорист байгууллагуудыг илүү татах боломжийг нэмэгдүүлэн өгч байна. Терроризмыг дэмжих үйл ажиллагааны ил тод бус байдал, терроризмтой тэмцэх хүчин чармайлтын урьдчилан сэргийлэх шинж чанараас шалтгааж статистикийн найдвартай мэдээллийг олж авахад ихээхэн хүндрэлтэй байдаг.⁶² Нөхцөл байдал ийм байгаа ч терроризмын санхүүжилттэй холбоотой зарим өргөн чиг хандлагын талаар хэлэлцэж болох юм.

⁶² Терроризмыг санхүүжүүлэх бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй холбогдуулан, тухайлбал мөнгө хуурамчаар үйлдэх зэрэг үүнтэй төстэй хүндрэл бэрхшээлтэй учирсан талаар тэмдэглэсэн. Рональд К.Ноубл (Ronald K. Noble) (2003 он) -ийг үзнэ үү.

77. Терроризмыг санхүүжүүлэх арга, техник, чиг хандлагыг судалсан ФАТФ-ын 2008 оны тайланд террорист үйл ажиллагаа ихэнх тохиолдолд олон төрлийн аргаар тухайн орон нутагтаа өөрийгөө санхүүжүүлэх боломжтой болохыг тогтоожээ.⁶³ Орчин цагийн ТС чиг хандлагын талаарх бусад судалгаагаар террорист байгууллагын төвлөрсөн удирдлагагүй байдал, тухайн орон нутаг дахь террорист этгээдүүдийг дэмжих чиг хандлага зэрэг нь тухайн орон газар дахь боломжуудыг ашиглан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх стратегийг илүү хэрэглэхэд хүргэж байна.⁶⁴ Тухайн орон нутгийн ТС нь хэд хэдэн чухал учир шалтгааны улмаас өмнө дурдсан үйл ажиллагааны стратегитай холбоотой юм:

1) Өнөөгийн терроризмын стратеги нь 9/11 гэх мэт дуулиантай томоохон халдлагуудыг ихээхэн онцолж байгаа нь харьцангуй жижиг хэмжээний халдлагуудыг илүү өндөр түвшинд авч үзэхэд нааштай болсон. Энэ нь тухайн орон нутаг дахь ТС-ийг илүү бодитой стратеги болгосон.⁶⁵

2) Терроризмтой тэмцэх арга хэмжээ нь олон улсын ТС үйл ажиллагааг илрүүлэх эрсдэлийг нэмэгдүүлсэн. Террорист байгууллагуудын олон улсын зохион байгуулалтын сүлжээ нь бүлэглэлүүд хамгаалахыг хичээдэг өндөр үнэ цэнэтэй хөрөнгө юм. Орон нутгийн ТС нь террорист бүлгүүдэд үйл ажиллагааныхаа сүлжээнээс зохион байгуулалтын үндсэн сүлжээгээ тусгаарлах боломжийг олгодог.⁶⁶

3) Орон нутгийн ТС нь терроризмыг дэмжигчдэд тухайн орон нутгийн боломжуудыг ашиглах боломжийг олгодог. Дэмжигчдийн сүлжээ нь залилан, хулгай, мансууруулах бодисын худалдаа, тэр ч байтугай хууль ёсны бизнесээс санхүүжих боломжтой эх үүсвэр нь болдог.⁶⁷

78. Сүүлийн үеийн террорист халдлага, террорист халдлага үйлдэх гэсэн оролдлогын талаарх мэдээлэл нь орон нутгийн терроризмын санхүүжилт, ялангуяа террорист хөдөлгөөний төвлөрсөн удирдлага саарахтай холбогдуулан улам бүр чухал ач холбогдолтой болж байгаа гэсэн таамаглалыг нотолж байна.⁶⁸ Тухайлбал, 2004 онд Мадрид хотод болсон халдлагын үеэрх дэлбэрэлтүүдийг тодорхой сүлжээгээр дамжуулан хар тамхи худалдалаах замаар санхүүжүүлсэн байсан бөгөөд халдлага үйлдэгчдийн нэг нь уг сүлжээнд нэвтэрсэн байжээ.⁶⁹ 2005 онд Лондон хотын метронд бөмбөг дэлбэлсэн амиа золиослогч террористууд уг халдлагыг санхүүжүүлэх зорилгоор өөрсдийн банкны зээл, зээлийн карт,

⁶³ ФАТФ (2008 он), х.14.

⁶⁴ Лоретта Наполеони (Napoleoni, Loretta) (2013 он), хуудас 13-26; Захари А.Поллингер (Pollinger, Zachary A.) (2008 он).

⁶⁵ Лоретта Наполеони (Napoleoni, Loretta) (2013 он), хуудас 13-26.

⁶⁶ Марк Бейсил (Basile, Mark) (2004 он), хуудас 169-85.

⁶⁷ ФАТФ (2008), х.4.

⁶⁸ Ерөнхий тоймыг Хуан Мигель дель Сид Гомес (Gomez, Juan Miguel del Cid) (2010 он)-ын ажлаас үзнэ үү, хуудас 3-27-

⁶⁹ Жон Роллинс (Rollins, John); Лиана Сан Уайлер (Wyler, Liana Sun); Сет Розен (Rosen, Seth) (2010 он), хуудас 19-20.

хадгаламжаа ашигласан байв.⁷⁰ 2009 онд Нью-Йорк хотын метронд амиа золиослогч террористуудыг ашиглан бөмбөг дэлбэлэхээр төлөвлөсөн Нажибулла Зази нь өөрийн бүлэглэлийн зохион байгуулсан төлөвлөгөөний зарим хэсгийг санхүүжүүлэхэд хулгайлсан зээлийн картыг ашигласан байв.⁷¹ АББ-тай шууд хамааралтай тохиолдолд Их Британи Улсад байсан террористуудын орон нутгийн төлөвлөгөө байсан бөгөөд 2010 онд Бирмингхам хотод цуврал бөмбөг дэлбэлэх зорилгоор өөрсдийн төлөвлөсөн террорист халдлагыг санхүүжүүлэхэд орон нутгийн хоёр буяны байгууллагыг хууль бусаар ашигласан байв. Энэхүү хэрэг нь АББ-ыг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглахтай холбоотой тул энэ хэргийг илүү нарийвчлан судлах шаардлагатай юм. Доор дурьдсан кейс тохиолдлын судалгааг нээлттэй эх сурвалжийн баримтад тулгуурлаж боловсруулсан бөгөөд улс орнуудын илгээсэн асуулгын хариултаас аваагүй болно. Нээлттэй эх сурвалжаас авсан материал дээр үндэслэсэн бусад судалгааны нэгэн адил баримт мэдээллийн үнэн зөв байдал нь эх сурвалжийн найдвартай байдлаас шууд хамаарна.

Кейс тохиолдол 33

2011 онд Баруун Мидландын Цагдаагийн газар Их Британи Улсын Аюулгүй байдлын алба, Лондон хотын Цагдаагийн газартай хамтран Бирмингхам хотод амьдардаг хэд хэдэн хүнд мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.¹ Мөрдөн шалгах ажиллагааны гол хоёр сэжигтэн болох Ирфан Нассер, Ирфан Халид нар 2009, 2010 онд тус тус Пакистан Улс руу зорчиж, амиа золиослогчдын үйлдсэн террорист халдлагын тухай видео бичлэг хийж, террорист ажиллагаа явуулах бэлтгэлд хамрагдсан байв.² Нассер, Халид болон тэдгээрийн хамтрагч Ашик Али нарт явуулсан гадаад болон техникийн тандалт ажиглалтын ачаар Бирмингхам хотын хүн ам ихээр цуглардаг газарт найман тэсрэх төхөөрөмжийг дэлбэлэх томоохон хуйвалдааныг илрүүлжээ.

Гадаад ажиглалтаар Нассер, Халид, Али нар Их Британи Улсад үйл ажиллагаа явуулдаг “Мусульманчуудын тусламж» (Muslim Aid) нэртэй томоохон буяны байгууллагад зориулж хотын гудамжинд хандив цуглуулдаг байсныг илрүүлжээ.³ Мөрдөн шалгах ажиллагаагаар хуйвалдагчид “Мусульманчуудын тусламж» байгууллагад хандив цуглуулах ажилтнаар сайн дураараа орсныг тогтоосон. Энэ зорилгоор тэд буяны байгууллагын нэр бүхий хандивын хайрцаг, тодруулагчтай хантаазыг авчээ. Уг гурван этгээд нэг өдрийн турш хандив цуглуулж, цуглуулсан 2500 ам.долларын хандивыг “Мусульманчуудын тусламж»-д өгсөн.

Гэхдээ хандивын хайрцаг, хантаазыг буцааж өгөхөөсөө өмнө тэд буяны байгууллагад мэдэгдэлгүйгээр “Мусульманчуудын тусламж»-ийн сайн дурын ажилтнууд нэрээр дахин хэдэн өдрийн турш хандив цуглуулах ажлыг үргэлжлүүлэн хийсэн байв. Эдгээр өдрүүдэд цуглуулсан хандивыг хуйвалдагчид өөрсдийн хувийн банкны дансанд хийсэн. Террорист халдлагыг санхүүжүүлэх зорилгоор тэд нийтдээ

⁷⁰ 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Лондон хотод болсон дэлбэрэлтийн албан ёсны мэдээллийн тайлан, НС 1087 (Лондон: Албан ёсны баримт бичгийг хэвлэх газар, 2006 он) х.23.

⁷¹ Матт Апуццо (Apuzzo, Matt) болон Адам Голдман (Goldman, Adam) (2013 он), х.103.

23,000⁴ ам.долларыг шилжүүлсэн байв.⁵ Түүнчлэн үүнтэй ижил төстэй аргаар «Мадраш-и-Ашрафул Улум» гэх хоёр дахь буяны байгууллагын хөрөнгийг луйвардаж ашигласан байв.⁶

2011 оны 9 дүгээр сард цагдаагийн газраас Нассер, Халид, Али болон бусад хэд хэдэн сэжигтнийг баривчилж үйлдэхээр төлөвлөж байсан халдлагыг таслан зогсоосон. 2013 оны 2 дугаар сард дээрх гурван этгээдийг терроризмын хэрэгт яллагдагчаар татан, 15 жилээс бүх насаар нь хорих хүртэл ял оногдуулан шийтгэсэн.⁷

2011 онд гэмт этгээдүүдийг баривчилсны дараа цагдаагийн газраас “Мусульманчуудын тусламж” байгууллагад террорист халдлага хийхээр төлөвлөж байсан хүмүүс тус байгууллагыг хууль бусаар ашиглаж байсныг мэдэгдсэн. “Мусульманчуудын тусламж” байгууллагаас Их Британи Улсад үйл ажиллагаа явуулдаг буяны байгууллагын үндэсний хяналтын байгууллага болох Англи, Уэльсийн буяны асуудал эрхэлсэн хороонд “ноцтой хэргийн талаарх тайлан”-г явуулсан.⁸ Хорооноос эдгээр буяны байгууллагатай цаашид тэдгээрийг хууль бусаар ашиглах эрсдлийг бууруулах арга хэмжээнд үнэлгээ хийх, бэхжүүлэх чиглэлээр хамтран ажилласан.

Тэмдэглэл:

1. Викрам Додд (Dodd, Vikram) болон Ричард Нортон Тейлор (Taylor, Richard Norton) (2011 он); “Бирмингхамын шуудан» сонин (2013 он)
2. Сандра Лавилл (La Ville, Sandra) (2013 он)
3. Жон Виллетс (Willets, John) (2012 он)
4. Нэгэн жигд байдлыг хангах үүднээс энэхүү тайланд дурдсан бүх валютыг ам.долларт (\$USD) хөрвүүлсэн.
5. Баруун Мидландын Цагдаагийн газрын терроризмтой тэмцэх алба (2012 он)
6. Никки Мэй Янг (Young, Nicki May) (2013 он)
7. Би-Би-Си (BBC) (2013 он)
8. Ники Май Мэй Янг (Young, Nicki May) (2013 он)

79. Тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлуудын ихэнхи нь үндэстэн дамнасан шинжтэй байгаа нь ашгийн бус салбарыг террористууд хууль бусаар ашиглах эрсдэлийн ихээхэн хэсэг нь хөрөнгө нөөцийг тухайн улсаас гаргах эсхүл тухайн улс руу шилжүүлдэг олон улсын террорист байгууллагуудаас гардаг гэдгийг илэрхийлж байна. Гэхдээ нэг дэх кейс тохиолдолд дурдсан Бирмингхам хотод төлөвлөж байсан ажиллагаа нь тухайн орон нутгийн байгууллагыг хууль бус зорилгоор ашиглаж АББ-д мөн эрсдэл учруулж болно гэдгийг харуулж байна. Шинжлэн судалсан 102 кейс тохиолдлын 21-т нь хууль бусаар ашигласан үйлдэл буюу ашиглах ноцтой эрсдэл нь дотооддоо чиглэсэн эсхүл зөрчилдөгч тал нь орон нутгийн этгээд байсан. Мөн эдгээр 21 кейс тохиолдлын 14 нь дотооддоо томоохон террорист эсхүл босогчид байдаггүй улсад тохиолдсон байв. Иймд эдгээр шинжлэн судалсан кейс тохиолдлоос үзэхэд АББ нь харьцангуй тогтвортой орчинд дотооддоо үйл ажиллагаа эрхэлдэг тул эрсдэлээс ангид байна гэж үзэж болохгүй юм. Гэхдээ энэ нь бүх орон нутгийн АББ-ууд ихээхэн эрсдэлтэй тулгардаг гэсэн үг биш юм; хамгийн чухал нь хууль бусаар ашиглах эрсдэлд өртөх асуудлыг газарзүйн талаас харах нь тус салбарыг ноцтой эрсдэлд оруулах боломжтой хэвээр байна гэсэн үг юм.

80. Энэхүү тайланг бэлтгэх явцад шинжлэн судалсан кейс тохиолдлууд нь тухайн АББ-ын явуулж буй үйл ажиллагааны төрөл болон тэдгээрийг хууль бусаар ашиглах эрсдэл хоёрын хооронд уялдаа холбоо байгааг тогтоосон. Энэ Бүлгин эхэнд дурдаж байсанчлан бүх кейс тохиолдолд "үйлчилгээ үзүүлэх" үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АББ-ууд байсан бөгөөд нэг ч тохиолдолд идэвхтэй төлөөллийн үйл ажиллагаа явуулдаг АББ байгаагүй. Түүнчлэн шинжлэн судалсан кейс тохиолдол болон бусад судалгааны мэдээлэлд террористууд дэмжлэг авахыг зорьдог бүлэг, хүн ам дотор үйл ажиллагаа явуулдаг АББ-уудыг хууль бусаар ашиглах эрсдэл илүү өндөр байдгийг харуулж байна. Хамгийн чухал нь энэ нь газарзүйн зөрчил мөргөлдөөнтэй бүс эсхүл тогтворгүй (засаглал сул) байдалтай хамааралтай байдаггүй. Террорист хөдөлгөөнүүд үйл ажиллагаа явуулдаггүй эсхүл үйл ажиллагаа явуулах боломжгүй зөрчил мөргөлдөөн, засаглал султай бүс нутагт АББ-ууд терроризм бус харин авлига, гэмт хэрэгтэй холбоотой эрсдэлд өртөх боломжтой. Нөгөө талаас террорист хөдөлгөөнүүд харьцангуй тогтвортой бүс нутагт амьдардаг хүн амын дунд идэвхтэй үйл ажиллагаа явуулж болно. Тухайлбал, "Тамил-Иламын чөлөөлөх барууд" байгууллага санхүүгийн болон бусад дэмжлэг олох зорилгоор Шри-Ланк Улсын хэд хэдэн тогтвортой мужийн хүн амын дунд үйл ажиллагаа явуулж байв. Тиймээс иймэрхүү тогтвортой бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд өндөр эрсдэлд орох боломжтой байдаг байна. Эцсийн дүнд ямар АББ-ууд хууль бусаар ашиглах өндөр эрсдэлд байдгийг тодорхойлох шийдвэрлэх хүчин зүйл нь террорист байгууллагуудад тэдгээрийн хөрөнгө нөөц, үйлчилгээ хир "үнэ цэнэ"-тэй байх, түүнчлэн АББ-ыг хууль бусаар ашиглах боломж, зорилт байгаа нөхцөлд террорист идэвхтэй аюул заналтай хир ойрхон байхаас хамаарах юм.

81. Хоёрдахь анхаарах чухал зүйл нь терроризмын санхүүжилт, элсүүлэх үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоо нь ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглах эрсдэлд ямар хамаатай болох тухай юм. ФАТФ-аас "террористууд болон террорист байгууллагууд Ашгийн бус салбарыг хөрөнгө босгох, хөрөнгө шилжүүлэх, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, терроризмд элсэхийг дэмжих эсхүл террорист байгууллага, үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигладаг" гэж тэмдэглэсэн.⁷² ФАТФ-ын тэргүүлэх зарчимд, мөн (буяны) үйл ажиллагаанд орон нутгийн болон олон улсын терроризмыг шууд болон шууд бусаар дэмжих үйл ажиллагаа багтдаггүй гэдгийг бүгд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй" гэж тэмдэглэсэн.⁷³ Тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлуудад АББ-ын санхүүжилттэй хөтөлбөр эсхүл барилга байгууламжийг террорист хөдөлгөөнүүд элсүүлэх ажилд ашиглаж болзошгүй гэдгийг илтгэж байна. Энэхүү тайланд шинжлэн судалсан 102 кейс тохиолдлын 27-д нь террорист хөдөлгөөнүүд элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашгийн бус салбарыг ашигласан байв.

82. Хэдийгээр анх харахад элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоогүй мэт харагдах ч, үнэндээ чухал холбоо байдаг. АББ нь хууль ёсны боловсролын хөтөлбөртэй байж, түүндээ

⁷² ФАТФ-ын Зөвлөмж 8-ийн (Ашгийн бус байгууллага) тайлбарт (2012a), х.54.

⁷³ ФАТФ (2013b), х.6.

хөрөнгө нөөц гаргаж, багш нарыг хөлсөлж ажиллуулах боломжтой бөгөөд энэ нь бүхэлдээ хууль ёсны үйл ажиллагаа байдаг. Гэхдээ хэрэв дараа нь багш нар терроризмын шалтгаанаар элсүүлэх ажилд холбогдох юм бол боловсролын хөтөлбөр, түүнд зориулагдсан хөрөнгө нөөц хууль бусаар ашиглагдана. Ашгийн бус салбарт гадны болон орон нутгийн этгээдийн учруулж болзошгүй аюул заналыг тодорхойлохдоо зорилгыг үнэлэх нь өмнө нь аюул заналыг тодорхойлохдоо дурдсанчлан анхаарах ёстой чухал зүйл юм. Террорист байгууллагын элсэлтийг дэмжих үйл ажиллагаа эсхүл эд зүйл байх нь АББ-ын хөрөнгийг санаатайгаар хууль бусаар ашиглаж байгаа буюу ашиглах эрсдэлд орж болзошгүй гэдгийн дохио юм. Тодруулж авч үзвэл элсүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа нь өөрөө террорист байгууллагыг дэмжих нэг хэлбэр бөгөөд ихэвчлэн терроризмыг дэмжих гэсэн өргөн хүрээний зорилгын нэг илрэл юм. Түүнчлэн эдгээр үйл ажиллагаа эсхүл эд зүйлийн байгаа эсэх нь хэрэгжилтийн мөчид дээрх АББ-ын хөтөлбөрийг ашиглах боломжийг илэрхийлж болно.

СТРАТЕГИЙН АСУУДАЛ

83. Террорист байгууллагын ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглах нь стратегийн хэд хэдэн ээдрээтэй асуудлыг дэвшүүлдэг. Эдгээр асуудлыг өргөн хүрээнд хэлэлцэх эсхүл шийдлийг санал болгох нь тайлангийн зорилго биш бөгөөд харин эдгээр стратегийн асуудлыг тодорхойлох, цаашдын яриа хэлэлцээнд үндэслэл бүхий дүн шинжилгээтэй мэдээллээр хангахад чиглэж байна.

АСУУДАЛ 1- ОНЦГОЙ ШААРДЛАГААР ҮҮССЭН СӨРГӨЛДӨӨНТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

84. Дэлхийн хамтын нийгэмлэг дэх АББ-ын ач холбогдлыг ФАТФ-ын Зөвлөмж 8-ийн тайлбар хэсгийн эхний зүйлд "Ашгийн бус байгууллага (АББ) нь дэлхийн эдийн засагт болон олон улсын эдийн засаг, нийгэмд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний хүчин чармайлт дэлхийн өнцөг булан бүрт тусламж хэрэгтэй нэгэнд нэн чухал үйлчилгээ үзүүлэх, тав тухтай байдал, итгэл найдвараар хангахад Засгийн газар, бизнесийн салбарын үйл ажиллагааг харилцан нөхдөг".⁷⁴ Үүнээс үүдэн ФАТФ нь ашгийн бус салбарыг террорист байгууллагууд хууль бусаар ашиглах үйлдлээс хамгаалах арга хэмжээ нь "хууль ёсны буяны үйл ажиллагааг тасалдуулах, саад учруулах ёсгүй" гэдгийг тодорхой тэмдэглэсэн.⁷⁵ Гэхдээ зарим улсын зүгээс терроризмтой тэмцэх арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд хууль ёсны АББ-ын үйл ажиллагаанд яг ийм сөрөг нөлөөг үзүүлж байна гэсэн болгоомжлолыг дэвшүүлсэн. НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах алба (ОСНА), Норвеги Улсын Дүрвэгсдийн зөвлөл (NRC)-тэй хамтран үүрэг болгосон тайланд терроризмтой тэмцэх арга хэмжээний үр дүнд ашгийн бус салбарт болон бие даасан байгууллагуудад бүтцийн, үйл ажиллагааны болон дотоодын нөлөөлөл үзүүлсэн гэж үзсэн.⁷⁶ Ялангуяа ОСНА/NRC-ийн тайланд терроризмтой тэмцэх арга хэмжээ нь "хараат бус байх хүмүүнлэгийн үндсэн зарчмыг гажуудуулж", тусламжийг

⁷⁴ ФАТФ-ын Зөвлөмж 8-ийн (Ашгийн бус байгууллага) тайлбарт (2012a), х.54.

⁷⁵ Мөн тэнд.

⁷⁶ Кейт Макинтош (Mackintosh, Kate) болон Патрик Дуплат (Duplat, Patrick) (2013 он), х.102-114.

үр дүнтэй хүргэхэд саад бэрхшээл учруулж, бие даасан байгууллагуудад захиргааны ихээхэн нэмэлт дарамтыг үзүүлж байна гэсэн асуудал байгааг тэмдэглэсэн.⁷⁷ Түүнчлэн үндэсний болон олон улсын түвшинд терроризмтой тэмцэх арга хэмжээний зарим хүмүүнлэгийн үл хамаарах зүйл нь террорист байгууллагуудыг дэмжих ажиллагааг зогсоох бусад хүчин чармайлттай нийцэхгүй байгааг шүүмжилсэн байна.⁷⁸ Энэ асуудлыг хамгийн сүүлд судалж үзсэн Австрали Улсын Үндэсний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хараат бус хяналтын газар (INSLM)-аас хэд хэдэн тохиолдолд хүмүүнлэгийн үл хамаарах зүйлүүд нь Австрали Улсын Эрүүгийн хууль болон НҮБ-ын терроризмтой тэмцэх тогтоолуудтай нийцэхгүй байгааг тэмдэглэжээ. INSLM-аас үл хамаарах зүйл нь Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг эсхүл НҮБ-ын тусламжийн байгууллагууд зэрэг үйл ажиллагаа нь найдвартай гэдэг нь батлагдсан зөвхөн өндөр чадавхитай байгууллагуудад байх ёстой гэж үзсэн байна.⁷⁹ Энэ үзэл нь өөрөө зөвшилцсөн байр суурь юм. Учир нь ФАТФ-ын үзэж буйгаар хүмүүнлэгийн онцгой тохиолдлыг тодорхой тохиолдлын үндсэн дээр тусгай зөвшөөрөл эсхүл чөлөөлөгдөх баталгаа зэрэг үндэсний механизмын дагуу зохицуулах ёстой гэсэн.

85. Террорист байгууллагууд руу шилжих хөрөнгө нөөцийн урсгалыг таслан зогсоох, хүмүүнлэгийн тусламж шаардлагатай нэгэнд нь хүрч чадаж байгааг хангах нь адилхан чухал хүчин чармайлтууд юм. Гагцхүү ашгийн бус салбарын хувьд эдгээр хоёр хүчин чармайлтын хооронд зайлшгүй зөрчилдөөн үүсч байна. Нэг талаас, АББ нь тусламж хэрэгтэй нэгэнд төвийг сахиж, цаг алдалгүй туслах үүрэгтэй. Энэхүү зайлшгүй шаардлагыг ОСНА/NRC-ийн тайланд дурдсанчлан хүмүүнлэгийн зарчмуудад тусгасан байгаа. Үүний зэрэгцээ, АББ нь тэдэнд иргэдээс итгэл үзүүлж өгсөн мөнгийг, *нэн ялангуяа* террорист байгууллагуудад дэмжлэг үзүүлэх бусад зорилгоор бус, сайн үйлсийн зорилгод ашиглана гэсэн үүргийг донор хандивлагчдад хүлээсэн байдаг. Энэхүү ээдрээтэй асуудлыг чиглүүлэх нь ашгийн бус салбар, үндэсний төр засгийн газрын байгууллагууд, олон улсын байгууллагуудын хувьд анхаарах ёстой чухал асуудал юм. Эдгээр хоёр зайлшгүй хэрэгцээт шаардлагын уялдаа холбоонд үндэслэн, нэгнээс нөгөөд нь нөлөөлж буй нөлөөллийг ялгаж салгахад тодорхой сорилт бэрхшээлүүд тулгардаг байна.

АСУУДАЛ 2 - ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ХЭМ ХЭМЖЭЭГ УЛС ОРНУУД ХЭРЭГЛЭХ НЬ

86. ФАТФ зэрэг олон улсын байгууллагуудын тогтоосон стандартыг улс орны төр засгийн байгууллагууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ нь зайлшгүй шаардлагатай учир нь өөр өөр улс орнууд өөрсдийн ашгийн бус салбар, засаглалын тогтолцоо, соёлын онцлог шинж чанарт тааруулан хариу арга хэмжээ авах шаардлагатай байдаг. Үүнийг Зөвлөмж 8-ийн тайлбарт болон шилдэг туршлагын баримт бичигт тодорхой

⁷⁷ Мөн тэнд.

⁷⁸ Үндэсний аюулгүй байдлын асуудлаарх үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих хараат бус зөвлөх (2013 он), х.77-85.

⁷⁹ Мөн тэнд.

заасан.⁸⁰ Гэвч олон улсын стандартын дагуу авсан зарим үндэсний хариу арга хэмжээ нь улс төрийн зорилгоор, ялангуяа эсэргүүцлийг дарахад иргэний нийгмийг хууль бусаар ашигласан явдлыг зөвтгөх үүднээс ФАТФ-ын зөвлөмжийг хууль бусаар ашигласан гэх болгоомжлол байдаг.⁸¹ Хэдийгээр зарим тохиолдолд эдгээр асуудал нь иргэний нийгмийг хууль бусаар ашигладаг асуудалтай гэдгийг нь мэддэг улс орнуудад хамаатай мэт боловч 3.8-ыг иймэрхүү үйл ажиллагааг зөвтгөх зорилгоор ашиглах магадлалтайг үл тоомсорлож болохгүй бөгөөд энэ нь Зөвлөмжийн хууль ёсны зорилгыг алдагдуулж болзошгүй юм.

87. Иргэний нийгмийг цаашид хүчирхийлэх зорилгоор Зөвлөмж 8-ыг ашиглах эрсдэлтэй улсад хүний эрхийг хамгаалах асуудал өргөн хүрээний яриа хэлэлцүүлгийн сэдэв болж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас хүний эрхийн зөрчил, улс төрийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх болон үүнтэй холбогдох бусад асуудлыг "терроризмыг дэлгэрүүлэх нөхцөл байдал" гэж тодорхойлсон.⁸² Энэхүү яриа хэлэлцүүлгийн нэг сэдэв нь аюулгүй байдлыг хангах болон хүний эрхийг хамгаалах стандартыг хэрэгжүүлэхэд улс орнуудын олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага юм. Энэхүү яриа хэлэлцүүлгийн өөр нэг тал нь олон улсын этгээдүүд үндэсний хэмжээнд хөндлөнгөөс оролцох боломжийг хязгаарласан үндэсний тусгаар тогтнолын асуудал юм. Нэгэн зэрэг иргэний нийгмийн хөгжлийг дэмжиж, терроризмтой тэмцэх хатуу арга хэмжээг хэрэгжүүлэх замаар аюулгүй байдлыг бэхжүүлэх нь олон улсын байгууллагын зорилго байдаг хэдий ч зарим улсын засгийн газрын зүгээс эдгээр зэрэгцээ байх зорилгод хүрэхэд чиглэсэн энэхүү үзэл бодлыг хуваалцдаггүй байж болно. Энэ тохиолдолд олон улсын стандартын зорилтууд (энэ тохиолдолд ФАТФ-ын Зөвлөмж), тэдгээрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх чанарын ялгааг гаргах нь чухал юм.

ДҮГНЭЛТ

88. Терроризмын АББ-ын салбарт учруулах аюул занал, түүнчлэн тус салбарын эмзэг тал, олон улсын түвшинд шийдвэрлэх шаардлагатай зарим стратегийн чухал асуудлыг судалж үзэхэд эдгээр асуудлууд нь тус бүртээ цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгддөг гэдэг нь илэрхий болно. АББ-ын салбар нь олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус салбарын бүрэн бүтэн байдал, үр нөлөө нь түүний энэхүү үнэ цэнэтэй үүргийг

⁸⁰ ФАТФ-ын Зөвлөмж 8 (Ашгийн бус байгууллага)-ын тайлбарт, ФАТФ (2012а), х.55; ФАТФ (2013b), х.6.

⁸¹ Томас Каротерс (Carothers, Thomas) болон Саския Брекенмакер (Breckenmacher, Saskia) (2013 он); НҮБ-ын Хүний эрхийн хороо (2012 он).

⁸² НҮБ-ын Терроризмтой тэмцэх стратеги нь мөн улс орнуудыг ФАТФ-ын Зөвлөмжийг хэрэгжүүлэхийг уриалдаг. НҮБ-ын Дэлхийн терроризмтой тэмцэх стратеги, A/RES/60/299, 2006-г үзнэ үү. Гэхдээ НҮБ-ын Эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тусгай илтгэгч: "Донор хандивлагчид хүнд нөхцөл байдалд ажиллаж буй нийгэмлэгүүдэд үзүүлэх дэмжлэгээ зогсоход хүргэж болзошгүй зохисгүй хязгаарласан арга хэмжээ нь үнэндээ терроризм, хэт даврах үзэлтэй тэмцэхэд [Иргэний нийгмийн байгууллага]-ын үнэлж баршгүй санаачилгыг алдагдуулж, эцэст нь энх тайван, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй" гэдгийг тэмдэглэсэн. *Эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тусгай илтгэгчийн тайлан*, A/HRC/23/39 (НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 2013) х.9.

гүйцэтгэхэд чухал нөхцөл нь болдог. Үүний зэрэгцээ террорист хөдөлгөөний төвлөрсөн удирдлага саарахтай холбогдуулан хууль бус үйлдлийг илрүүлэх, таслан зогсооход илүү хүндрэлтэй болгож, аюул заналын илүү өргөн хүрээг хамарсан оролцогчдыг бий болгоход хүргэсэн бөгөөд зарим тохиолдолд АББ-ын салбарын тодорхой бүрэлдэхүүн хэсгийн эрсдлийг улам нэмэгдүүлсэн.

89. Эдгээр үйл явдалд хийсэн стратегийн дүн шинжилгээ нь тэдгээрийг тодорхойлсон харилцан хамааралтай олон хүчин зүйл байгааг илтгэж байна. Эдгээр хүчин зүйлүүд нь ихэвчлэн бие биенээ нөхдөг хэдий ч тэдгээр нь мөн хоорондоо зөрчилддөг байна. Эдгээр хүчин зүйлсийг Зураг 2.7-д нэгтгэн харуулав.

Зураг 2.7: Гадаад орчны гол хүчин зүйлс

Гадаад орчны хүчин зүйл	Тэмдэглэл
Хүчин зүйл 1: Террорист байгууллагаас учруулсан хохирлын улмаас терроризмтой тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай	Хүчин зүйл 1 гэдэг нь олон улсын байгууллагууд болон үндэсний төр засгийн байгууллагууд энгийн иргэдийг хамгаалах зорилгоор террорист аюул заналын эсрэг хариу арга хэмжээ авах шаардлагыг хэлнэ.
Хүчин зүйл 2: Ашгийн бус салбарын үйл ажиллагааны үр дүн	Хүчин зүйл 2 гэдэг нь хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашгийн бус салбарын үр ашиг, үр дүнг дэмжихийг хэлнэ.
Хүчин зүйл 3: Донор хандивлагчдад хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хариуцлагатай байх үүрэг хүлээсэн	Хүчин зүйл 3 гэдэг нь ашгийн бус салбар болон бусад оролцогч талууд тус салбарт донор хандивлагчдын зүгээс итгэл хүлээлгэн өгсөн хөрөнгө эсхүл эд зүйлсийг зориулалтын дагуу ашиглахад хяналт тавих үүрэг хүлээхийг хэлнэ.
Хүчин зүйл 4: Ашиг хүртэгч нарт тусламж үзүүлэх үүрэг хүлээсэн	Хүчин зүйл 4 гэдэг нь ашгийн бус салбар болон бусад оролцогч талууд олон улсын хүмүүнлэгийн хэм хэмжээнд нийцүүлсэн байдлаар ашиг хүртэгч нарт тусламж үзүүлэхэд хяналт тавих үүрэг хүлээхийг хэлнэ.
Хүчин зүйл 5: Олон улсын дэглэмийн хамтын үйл ажиллагаа	Хүчин зүйл 5 гэдэг нь хамтын хөгжил цэцэглэлт, аюулгүй байдлыг хангах үүднээс Олон улсын байгууллагууд (ФАТФ-ын 40 Зөвлөмж зэрэг)-ын тогтоосон дүрэм, стандартууд
Хүчин зүйл 6: Улс орнуудын бие даасан үйл ажиллагаа	Хүчин зүйл 6 гэдэг нь тухайн улс бүрэн эрхт хуулийн этгээд болох статусын үндсэн дээр олон улсын хэм хэмжээг дагаж мөрдөх эсхүл түүнтэй зөрчилддөг байхыг хэлнэ.

90. Эдгээр бүх хүчин зүйлс нь терроризмтой тэмцэх олон улсын хүчин чармайлтад болон мөн АББ-ын салбарыг хөгжүүлэх, хамгаалахад нөлөөлдөг. Энэхүү типологийн тайлангийн зорилго нь эдгээр хүчин зүйлсийг зохих ёсоор авч үзэх аналитик суурийг тавихад оршиж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ЭРСДЭЛ БА ТҮҮНИЙ АРГА, АРГАЧЛАЛ

- Кейс тохиолдлыг шинжлэн судалсан материалд үндэслэн террорист байгууллагууд ашгийн бус байгууллагын салбарыг хууль бусаар ашиглах арга, аргачлал, эрсдэлийн тодорхойлолт –

91. Террорист байгууллагууд АББ-ын салбарыг хууль бусаар ашиглах эрсдэлийг ойлгохын тулд хамгийн гол нь кейс тохиолдлын судалгааг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийх шаардлагатай. Хэдийгээр асуудлын цар хүрээг үнэлэхэд бодит байдалд ашгийн бус байгууллагыг хууль бус зорилгоор ашигласан тохиолдлыг судалж үзэх нь чухал ач холбогдолтой гэдэг нь ойлгомжтой ч террорист байгууллагууд АББ-ыг хууль бусаар ашиглах эрсдэл байсан тохиолдлыг судлах нь мөн адил чухал юм. Терроризмын санхүүжилт нь цаашдын ноцтой эрүүгийн гэмт хэргийн бэлтгэл ажлын явцад үйлдэгддэг бол мөнгө угаах ажиллагаа нь эрүүгийн гэмт хэргийг үйлдсэний дараа болдог. Аюул заналын шинж чанар, цар хүрээний талаар бүрэн гүйцэд ойлголттой болох хүртэл АББ-ын салбарыг террорист зорилгоор хууль бусаар ашиглах эрсдлийг үр дүнтэй бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй юм. Энэ зорилгын хүрээнд энэхүү тайланд АББ-ыг бодит байдалд хууль бусаар ашигласан тохиолдлоос гадна ашгийн бус байгууллагыг хууль бус зорилгоор ашиглах гэсэн эрсдэлийг илрүүлж, улмаар түүнийг бууруулсан эсхүл арилгасан тохиолдлыг харуулсан жишээг оруулсан.

92. Шинжлэн судалсан кейс тохиолдлууд нь террорист байгууллагууд хэд хэдэн аргын тусламжтайгаар АББ-ыг хууль бус зорилгоор ашиглаж болохыг харуулж байна. Зураг 3.1-т АББ-ыг хууль бусаар ашиглах нийтлэг арга замыг тоймлож, тэдгээрийг тус бүрт нь тайлбарласан.

Хүснэгт 3.1: Хууль бусаар ашиглах арга, эрсдэл

Хууль бусаар ашиглах арга, эрсдэл	
Санхүү хөрөнгийн зориулалтыг өөрчлөх	Ашгийн бус байгууллага эсхүл түүний төлөөний этгээд хөрөнгийг тогтоогдсон эсхүл сэжиглэгдсэн террорист байгууллагад шилжүүлэх
Террорист байгууллагатай холбоотой байх	Ашгийн бус байгууллага эсхүл түүний төлөөний этгээд террорист байгууллага эсхүл терроризмыг дэмжигчтэй хамааралтай байж, үйл ажиллагааг нь дэмжих
Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах	Хууль ёсны хүмүүнлэгийн зорилтыг дэмжих зорилготой ашгийн бус байгууллагын санхүүжилттэй хөтөлбөрийг эцэст нь терроризмыг дэмжихэд ашиглах

Террорист этгээдийг элсүүлэхэд ашиглах	Ашгийн бус байгууллагын санхүүжилттэй хөтөлбөр эсхүл барилга байгууламжийг террорист этгээдүүдийг элсүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжих нөхцөл байдлыг бүрдүүлэхэд ашиглах
Төлөөлөл нь төөрөгдүүлэх эсхүл халхавч ашгийн бус байгууллага байгуулах	Буяны үйл ажиллагаа явуулах нэрийн дор байгууллага эсхүл хувь хүн хандив цуглуулах болон/эсхүл терроризмыг дэмжих зорилгоор бусад үйл ажиллагаа явуулах

93. АББ-ыг хууль бусаар ашиглах эрсдэл, арга, аргачлалын нийтлэг эзлэх хувийг доорхи байдлаар харуулав:

Хүснэгт 3.2: Хууль бусаар ашиглах арга, аргачлал ба эрсдэл-Илрүүлсэн хэргийн эзлэх хувь

Хууль бусаар ашиглах арга, аргачлал ба эрсдэл	Илрүүлсэн хэргийн эзлэх хувь
Санхүү хөрөнгийн зориулалтыг өөрчлөх	54%
Террорист байгууллагатай холбоотой байх	45%
Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах	10%
Террорист этгээдийг элсүүлэхэд ашиглах	26%
Төлөөлөл нь төөрөгдүүлэх, халхавч ашгийн бус байгууллага	14%

Тэмдэглэл: Кейс тохиолдлын судалгаанд АББ-ыг хууль бусаар ашигласан хэд хэдэн арга болон/эсхүл эрсдэл байсан тул дурдсан тоо баримтын нийлбэр 100 хувьд хүрэхгүй болно.

94. Төслийг дэмжиж ирүүлсэн кейс тохиолдлын судалгаагаар ашгийн бус салбарын террорист хууль бусаар ашиглах эрсдэлд өртөх нь сул дорой дотоод удирдлагатай болон/эсхүл зохих гадаад хяналт байхгүй байснаас үүдэлтэй болохыг илтгэж байна. Түүнчлэн шинжлэн судалсан кейс тохиолдлуудын ихэнхэд нь террорист байгууллагатай ямар нэгэн холбоотой байсан мэдэгдэж байсан бол нэг нь террорист үйл ажиллагааг дэмждэг⁸³ гэж сэжиглэгдсэн байв. Мөн кейс тохиолдлуудыг шинжлэн судлах явцад "хуурамч" ашгийн бус байгууллагууд буюу зөвхөн террорист этгээдүүдийг дэмжих зорилгоор байгуулагдсан ашгийн бус

⁸³ Энэхүү тайлангийн туршид "сэжиглэгдсэн" гэх нэр томъёолол нь тухайн этгээдийг терроризмыг дэмждэг эсхүл холбогдсон гэдгийг баталгаатай илтгэх мэдээ мэдээлэл эсхүл тагнуулын мэдээлэл байгаа тохиолдолд хамаарна.

байгууллагаас илүүтэйгээр хууль ёсны ашгийн бус байгууллагууд дийлэнх олонхийг нь эзэлж байгаа нь ажиглагдлаа.

ХӨРӨНГИЙН ЗОРИУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ

95. Хамгийн их ажиглагдсан нэг зүйл нь терроризмыг дэмжих зорилготой ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах эрсдэл, арга, аргачлал нь хөрөнгийн зориулалтыг өөрчлөх үйлдэл юм. Энэхүү типологид ашгийн бус байгууллагуудын тусламж тэр дундаа гамшгийн тусламж, хүмүүнлэгийн тусламж, соёлын төв, ядуурлаас ангижруулах, боловсролыг дээшлүүлэх, шашныг хөгжүүлэх зэрэг хүмүүнлэгийн хөтөлбөрүүдэд зориулж босгосон хөрөнгийг ашгийн бус байгууллагын бизнесийн үйл явцад терроризмыг дэмжихэд зориулж өөрчилдөг байна. Үндсэндээ хөрөнгийн зориулалтыг өөрчлөх үйлдэл нь буяны зорилгоор босгосон хөрөнгийг террорист этгээдүүдэд шилжүүлэхэд болдог байна. Кейс тохиолдлыг шинжлэн судлахад ойролцоогоор тал хувьд нь хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн арга, шинжүүд илэрч байв.

96. Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх үйлдэл нь ашгийн бус байгууллагын бизнесийн үйл явцын өөр өөр үе шатанд, тухайлбал хөрөнгө босгох, шилжүүлэх үед гарсан байв. Зориулалтыг нь өөрчилсөн хөрөнгийг террорист байгууллагуудыг дэмжихэд буюу тодруулбал байгууллагын дэд бүтэц болон түүний цэргийн ажиллагааг санхүүжүүлэх зэрэгт ашиглажээ. Зэр зэвсэг, тоног төхөөрөмж, холбооны хэрэгсэл худалдан авах, мөн террористуудын ар гэрийнхэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг асуудал илэрч байсан. Мөн кейс тохиолдлуудыг шинжлэн судлахад зориулалтыг нь өөрчилсөн хөрөнгийг дотооддоо болон мөн гадаад дахь террорист хувь хүмүүс, байгууллагыг дэмжихэд ашигласан болохыг тогтоосон билээ.

97. Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх тухай типологийг тухайн байгууллагад хамаарал бүхий этгээд болон түүнд хамааралгүй этгээд зориулалтыг өөрчлөх үйлдлийг гүйцэтгэсэн гэдгээр нь шинжлэн судлагдсан кейс тохиолдлыг хувааж болох юм. Хамаарал бүхий этгээд гэдэгт ашгийн бус байгууллагын удирдах албан тушаалтан, ажилтан зэрэг хувь этгээдийг хамруулна. Хамааралгүй этгээд гэдэгт санхүүжүүлэгч, гадаад түнш зэрэг ашгийн бус байгууллагатай холбоотой гуравдагч этгээдийг хамруулна. Түүнчлэн зарим нөхцөлд ашгийн бус байгууллагатай хамааралтай эсхүл хамааралгүй этгээдийн оролцоотойгоор хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн эсэх нь тодорхойгүй байлаа.

АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД ХӨРӨНГИЙН ЗОРИУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ

98. Хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн байх тохиолдолд бүрт ихэнх нь ашгийн бус байгууллагатай хамаарал бүхий этгээдийн оролцоотой байв. Хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчлөх үйлдэл нь буяны зорилгоор ашгийн бус байгууллагаас босгосон хөрөнгийн тодорхой хэсгийг авч, өөр зориулалтаар террорист байгууллагад шилжүүлсэн тохиолдлыг хэлнэ. Түүнчлэн шинжлэн судалсан кейс тохиолдлуудад гуравдагч этгээдийн босгосон хөрөнгийг (буяны гэх

зорилгоор) ашгийн бус байгууллагаар дамжуулан террорист байгууллага руу шилжүүлсэн явдал гарч байв. Ашгийн бус байгууллагыг ашиглаж иймэрхүү гүйлгээ хийх нь аудитыг нуун дарагдуулах, террорист байгууллагатай холбоотой гэх аливаа холбоог таслах буюу түүнээс холдуулах, эрх баригчдын илрүүлэх магадлалыг бууруулахад нөлөөлдөг байна.

99. Шинжлэн судалсан кейс тохиолдолд ашгийн бус байгууллагад хамаарал бүхий этгээд (АББ-д харьяалагдах) янз бүрийн аргыг ашиглан харгис зорилгодоо хөрөнгө босгох, хадгалах, шилжүүлэх шатанд давуу эрхийг эдлэдэг. Энэ эмзэг байдал нь терроризмыг дэмжихийг эрэлхийлдэг хамаарал бүхий этгээдээс учруулах аюул заналын хамт ашгийн бус салбарт ихээхэн эрсдэлийг учруулдаг. Энэхүү эрсдэлийн ноцтой байдал нь ирүүлсэн кейс тохиолдлын бараг тал хувьд нь хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн гэдгээр нотлогдож байна.

100. Хөрөнгө босгох явцад хөрөнгийн зориулалтыг өөрчлөхөд АББ-ын дансанд орлого болгож хийхээс өмнө бэлэн мөнгийг авдаг бол хадгалах, шилжүүлэх явцад хөрөнгийг төрөл бүрийн аргаар шилжүүлэн эцэст нь террорист байгууллагын хяналтад ордог байна. АББ-д хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн нөхцөлд эдгээр аргыг ашиглан мөнгөө шилжүүлсэн байна:

- Электрон шилжүүлэг (санхүүгийн системээр дамжуулан);
- Бэлэн мөнгөний гүйлгээ, мөнгө тээвэрлэгч;
- Хамааралгүй хувь хүн, хувийн данс;
- Хамааралгүй бизнес, бизнесийн данс;
- Мөнгө олгох үйлчилгээ үзүүлдэг байгууллага болон/эсхүл;
- Аялалын болон бэлэн мөнгөний чек;

101. Доорх кейс тохиолдлын шинжлэн судлахад АББ-ын удирдах албан тушаалтан АББ-д зориулагдсан бэлэн мөнгөний хандивыг авч, хамааралгүй компанийн дансанд орлого болгож шилжүүлсэн байна. Ингээд дахин уг хөрөнгийг гадаадын террорист байгууллагад шилжүүлжээ.

Кейс тохиолдол 11

Ашгийн бус байгууллагад хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн нь

Хөрөнгө босгох үе шат

Арилжааны өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах зорилгоор орон нутгийн (үндэсний) компани байгуулагджээ. Дансанд гарын үсэг зурах эрх бүхий хүнээс

компанийн дансанд олон удаагийн үйлдлээр бага хэмжээний орлогын гүйлгээг хийсэн байв. Үүний дараагаар мөнгийг тэр даруй гадаадын компаниудад шилжүүлсэн байна.

Санхүүгийн мэдээллийн албанаас хийсэн шалгалтын явцад компанийн дансанд гарын үсэг зурах эрх бүхий хүн нь мөн ашгийн бус байгууллагын тэргүүн болох нь тогтоогджээ. Компанийн дансанд хийсэн бага хэмжээний орлогууд нь АББ-ын хөрөнгө босгох замаар олсон хөрөнгийн хэсэг байсан гэх хардлага төрсөн байна.

Хууль сахиулах байгууллагын мэдээлэлд уг АББ нь террорист бүлэглэлтэй холбоотой гэдгийг илтгэсэн байв. АББ-ын хоёр дахь удирдах албан тушаалтан бөгөөд тус компанийн менежер нь мөн уг террорист бүлэглэлтэй холбоотой байв.

Мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн компани нь гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой АББ-ын нэрийн өмнөөс мөнгө шилжүүлдэг байсан халхавч байгууллага байсан гэж дүгнэсэн.

102. Өөр нэг тохиолдолд, АББ-ын ажилтнууд хяналттай бүс нутагт нэвтрэх, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зорилгоор терроризмыг дэмждэг гэж сэжиглэгдсэн гадны байгууллагатай сайн дураараа хамтран ажилласан байв.

Кейс тохиолдол 32

Ашгийн бус байгууллагад хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн нь

Зөрчил мөргөлдөөнтэй бүс нутгаас цагаачилж ирсэн үндэсний цөөнхийн бүлгийн гишүүдэд шашны ёслол үйлдэх байраар хангах, хүмүүнлэгийн хэрэгцээнд зориулж хөрөнгө босгох, тараах зорилгоор үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагыг байгуулжээ.

Шилжүүлэх үе шат

Ашгийн бус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг үндэсний байгууллага тус АББ-ын заавал илтгэх тайланд түүний хөрөнгийн хууль ёсны дэмжлэгийг авдаггүй байгууллагад хөрөнгө мөнгө шилжүүлснийг илтгэсэн байсан нь сэжиг төрүүлжээ. Эдгээр хөрөнгийг цагаач үндэсний цөөнхийн бүлгийн эх нутагт болсон байгалийн гамшигт үзүүлэх тусламжид гэх нэрийдлээр явуулсан байв. Гэхдээ хүлээн авагч байгууллагын нэг нь цагаач үндэсний цөөнхийн бүлгийн эх нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын террорист бүлэглэлийн халхавчаар ажилладаг олон улсын байгууллагын орон нутгийн салбар байж болзошгүй байв.

Хяналтын байгууллагын тус АББ-д хийсэн аудитын шалгалтаар түүний хууль ёсны дэмжлэгийг авдаггүй таван байгууллага, хувь хүнд мөнгө шилжүүлсэн болохыг илрүүлжээ. Тодруулбал, түүний орон нутгийн салбараар дамжуулан 50,000 ам.долларыг олон улсын халхавч байгууллагад шилжүүлсэн, мөн зөрчил

мөргөлдөөнтэй бүс нутагт байрладаг уг халхавч байгууллагын төв рүү 80,000 ам.долларыг шууд шилжүүлсэн байв.

Шалгалт үргэлжилж байх хугацаанд хяналтын байгууллага олон нийтийн зүгээс тус АББ-тай холбоотой хоёр сэжүүр мэдээллийг хүлээж авсан. Эдгээр хоёр мэдээллийн аль алинд нь тус АББ-ын удирдлагын ил тод бус байдалд санаа зовниж буйгаа илэрхийлж, гадаад руу хөрөнгө шилжүүлэх шийдвэр нь ашгийн бус байгууллагын удирдах баримт бичигт заасан нягтлан бодох бүртгэл, хариуцлагын дүрэм журмыг зөрчсөн асуудлыг хөндсөн байв. Сэжүүр мэдээллийн нэгд нь цагаач үндэсний цөөнхийн бүлгийн хүн ам зүйн бүтцэд гарсан өөрчлөлт нь тус АББ-ын удирдах зөвлөл гадаадын террорист байгууллагад илүү эерэгээр ханддаг шинэ фракцын хяналтад орсныг илтгэсэн хэрэг гэсэн байв. Хэдийгээр эдгээр асуудлыг аудитын шалгалтын явцад хэдийнээ тогтоосон байсан ч эдгээр сэжүүр мэдээлэл нь тус АББ-ын удирдлагатай холбоотой хяналтын байгууллагын хардлагыг нотолсон.

Үүний хариуд тус АББ-ын удирдлага байгалийн гамшгийн дараа яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай байсан тул зарим дотоод дүрэм, журмыг зөрчиж, гамшигт нэрвэгдсэн бүс нутагт ажиллах боломжтой аливаа нэг байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай болсон гэж мэдэгджээ. Үүнтэй холбогдуулан тус АББ-ын бүртгэлийг цуцлаагүй ч түүнд торгууль ноогдуулсан. Түүнчлэн тус АББ нь хяналтын байгууллагатай хянан магадлагааны нийцүүлэлт, хариуцлагын хатуу хэм хэмжээг нэврүүлж, мөрдүүлэх хянан нийцүүлэлтийн гэрээг байгуулсан.

103. Хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн өөр нэг тохиолдолд терроризмыг дэмжих зорилгоор хүмүүнлэгийн үйл ажиллагаанд зориулж босгосон хөрөнгийг болон АББ-ын дансан дахь мөнгийг шилжүүлсэн гэж сэжиглэгдсэн АББ-ын удирдах ажилтантай холбоотой байв.

Кейс тохиолдол 28

Ашгийн бус байгууллагад хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн нь

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт амьдардаг хүн амд хүмүүнлэгийн тусламж үзүүлнэ гэх зорилгоор хандив цуглуулдаг байжээ. Тус АББ хандив цуглуулахын тулд шашны байгууллагуудын дэргэд суурилуулсан тусгай хандивын хайрцгийг ашигладаг байв. Цуглуулсан мөнгийг орон нутгийн банкны дансанд хадгалдаг байв.

Хадгалах, шилжүүлэх үе шат

Тус АББ-ыг үүсгэн байгуулагчийг цуглуулсан хөрөнгө мөнгийг дурдсан хүмүүнлэгийн үйл ажиллагаанд ашиглах бус харин терроризмыг дэмжих зорилгоор хөрөнгийн зориулалтыг өөрчлөн шилжүүлсэн хэрэгт сэжиглэжээ.

Хууль сахиулах байгууллагаас явуулсан шалгалтын үр дүнд тус ашгийн бус байгууллагын үүсгэн байгуулагчийг терроризмыг дэмжсэн хэргээр баривчилсан. Энэ хэргийг мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилсээр байгаа. Хэдийгээр өнөөг хүртэл гэм буруутай нь тогтоогдоогүй ч хандиваар цуглуулсан 60,000 ам.долларын хөрөнгийг хурааж авсан.

104. Дараах кейс тохиолдолд АББ-ын удирдах албан тушаалтнууд терроризмыг дэмжих зорилгоор хөрөнгийн зориулалтыг өөрчлөх олон аргыг ашиглажээ.

Кейс тохиолдол 3

Ашгийн бус байгууллагад хамаарал бүхий этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн нь

Үндэсний СМА тухайн улсад бүртгэлтэй гадаад дахь ашгийн бус байгууллагын орон нутгийн салбартай холбоотой сэжигтэй гүйлгээний мэдээллийг хүлээн авчээ. Орон нутгийн ашгийн бус байгууллага нь гуравдагч улсын банкны дансаар дамжуулан гадаад дахь хориотой АББ-д мөнгө шилжүүлсэн байв. Түүнчлэн уг АББ нь өндөр эрсдэлтэй бүс нутагт байрладаг бусад ашгийн бус байгууллагад мөнгөө шилжүүлж, том мөнгөн дэвсгэртээр их хэмжээний бэлэн мөнгийг данснаасаа авсан байв.

СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагааны явцад орон нутгийн АББ-ын удирдлага их хэмжээний бэлэн мөнгийг хилээр авч гарсныг олж тогтоогджээ. Хил дамнасан бэлэн мөнгөний шилжүүлэгтэй холбоотой санхүүгийн мэдээлэлд дурдсанаар тус АББ-ын удирдлага уг мөнгийг өндөр болон бага эрсдэлтэй бүс нутагт байрладаг буяны байгууллагад хандивласан гэж мэдэгджээ.

Түүнчлэн уг орон нутгийн ашгийн бус байгууллага нь орон нутгийн өөр нэг АББ-д мөнгө шилжүүлсэн байв. Хоёр дахь ашгийн бус байгууллагын талаар хүлээн авсан санхүүгийн сэжигтэй гүйлгээний мэдээлэлд түүний удирдлага АББ-ын үйл ажиллагаатай холбоогүй бүс нутагт байдаг хөгжингүй орнуудын иргэдэд мөнгө шилжүүлсэн болохыг илтгэсэн байна.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд орон нутгийн АББ-ыг терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулж, түүний эд хөрөнгийг царцаасан байна.

АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ХАМААРАЛГҮЙ ЭТГЭЭД ХӨРӨНГИЙН ЗОРИУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ

105. Хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн бусад тохиолдлууд нь АББ-д хамааралгүй этгээдийн оролцоотой байв. Эдгээр тохиолдолд АББ-ын гуравдагч этгээдийн хамтрагчид, гадны санхүүжүүлэгчид эсхүл гадаад түншүүд зэрэг нь тухайн АББ-д зориулагдсан эсхүл олгосон хөрөнгийг өөрчилдөг байна. Энэхүү төсөлд шинжлэн судалсан кейс тохиолдлуудад АББ-ын үйл ажиллагааны хөрөнгө босгох, хадгалах,

шилжүүлэх үе шатанд хамааралгүй этгээдүүд хөрөнгийн зориулалтыг өөрчилдөг болох нь илэрсэн байна.

106. Дараах кейс тохиолдолд хоёр тусдаа хамааралгүй этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчлөхөд оролцсон нөхцөл байдлыг харуулж байна. АББ, түүний хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчдын хооронд хөрөнгө шилжүүлэхэд дэмжлэг үзүүлж байсан мөнгө олгох үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь террорист байгууллагад шилжүүлэх зорилгоор “татвар” авч байжээ. Түүнчлэн хандивын сангийн хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчдаас террорист байгууллагууд татвар авсан байв.

Кейс тохиолдол 36

Ашгийн бус байгууллагад хамааралгүй этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн нь

Гамшгийн дараа олон улсын ашгийн бус томоохон байгууллагаас террорист байгууллагын хяналтанд байдаг бүс нутгийн хохирогчдод бэлэн мөнгө олгох замаар тусламж үзүүлж байв. Тус АББ нь бэлэн мөнгө тараах, олгох ажлыг орон нутгийн мөнгө олгох үйлчилгээ үзүүлдэг байгууллагаар дамжуулан хүргэдэг байжээ.

Шилжүүлэх үе шат

Дээрх АББ-ын хүсэлтээр хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрт түүний нэг түнш байгууллагаас хийсэн аудитын шалгалтын дүн анхаарал татжээ. Шалгалтаар зарим тохиолдолд мөнгө олгох үйлчилгээ үзүүлж байсан байгууллага нь жагсаалтад орсон террорист байгууллагад шилжүүлэх зорилгоор “татвар” авдаг байсныг тогтоожээ. Бусад тохиолдолд, санхүүгийн тусламж авсны дараа хандив хүлээн авагчид нь өөрсдөө террорист байгууллагын төлөөлөгчдөд "татвар" төлдөг байжээ. Шалгалтаар мөн хандивын хөрөнгийн тодорхой хэсгийг террорист зорилгоор ашиглуулахад шилжүүлнэ гэдэг нэгдсэн ойлголт, тохиролцоо байсныг илрүүлж, энэ нь тус бүс нутагт ажилладаг АББ болон бусад байгууллагын дунд түгээмэл үзэгдэл байсныг тогтоосон.

Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааг хянан шалгадаг үндэсний эрх бүхий байгууллага, үндэсний СМА болон хууль сахиулах байгууллагын хамтарсан шалгалтын дараа тус АББ-д иймэрхүү хэргийн талаар мэдээллэх үүрэгтэй болохыг мэдэгдсэн. Түүнчлэн цаашид иймэрхүү тохиолдлоос урьдчилан сэргийлэх үүднээс зохих арга хэмжээ авч ажилтнуудаа сургахыг тус АББ-д үүрэг болгосон.

107. Хамааралгүй этгээдийн оролцоотойгоор хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн өөр нэг тохиолдолд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зорилгоор шилжүүлсэн хөрөнгийг нэр бүхий террорист байгууллагатай холбоотой эсхүл хамааралтай хувь хүн, байгууллагад тодорхой дэс дараатайгаар шилжүүлсэн байна.

Кейс тохиолдол 22

Ашгийн бус байгууллагад хамааралгүй этгээд хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн нь

Гадаад дахь зөрчил мөргөлдөөнтэй бус нутагт буяны үйл ажиллагааг дэмжлэг зорилгоор үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагыг байгуулжээ.

Шилжүүлэх үе шат

Сэжигтэй гүйлгээний талаархи мэдээллийг хүлээн авсны дараа үндэсний СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн улсад босгосон хөрөнгийг гадаад дахь буяны байгууллагад шилжүүлсэн болохыг тогтоожээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар мөн гадаад дахь буяны байгууллагууд хөрөнгийг хүлээн авсны дараа түүнийгээ нэр бүхий террорист байгууллагатай холбоотой эсхүл хамааралтай хувь хүмүүс, байгууллагад тухай бүр шилжүүлж байсныг тогтоосон байна.

Хэдийгээр гадаад дахь буяны байгууллага, террорист байгууллагын хоорондын харилцаа холбоог тогтоосон боловч үндэсний (орон нутгийн) АББ, террорист байгууллага хоорондын шууд харилцаа холбоог тогтоож чадаагүй байна.

ТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБООТОЙ БАЙХ

108. Ирүүлсэн кейс тохиолдлуудыг шинжлэн судлахад хууль бусаар ашиглах хамгийн түгээмэл ажиглагдсан хоёр дахь арга, эрсдэл нь АББ, террорист этгээдийн хооронд үйл ажиллагааны харилцан хамаарал байгаа эсэх, эсвэл хамааралтай гэж сэжиг авах холбоотой асуудал байгаа эсэх юм. Энэхүү хамаарал нь аль нэг тал эсвэл аль аль талын үйл ажиллагааг санхүүжүүлэх, түүнчлэн өөр хэлбэрээр дэмжих зорилготой үйл ажиллагааг хэлнэ. Харилцан хамаарал нь АББ-ын удирдах албан тушаалтан, террорист байгууллагын албан бус хувийн харилцаа холбооноос эхлээд АББ, террорист байгууллага хооронд илүү албан ёсны харилцаатай байх хүртэл байсан нь ажиглагдсан. Энэхүү судалгаанд хамрагдсан нийт кейс тохиолдлын 45 орчим хувьд нь АББ, террорист байгууллага хоорондоо харилцан хамааралтай байв. Хамааралтай кейс тохиолдол нь АББ, террорист этгээдийн хооронд АББ-ын үйл ажиллагааны бүхий л хэсэгтэй холбоотойн зэрэгцээ хөрөнгө босгох, шилжүүлэх, хадгалах, зарцуулах, түүнчлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй шууд хамааралтай байв. Ихэнх тохиолдолд хамаарал нь эдгээр бүх бүрэлдэхүүн хэсэгт агуулдаж байна.

109. Энэ бүлгийн кейс тохиолдлуудыг шинжлэн судлахад хууль бусаар ашиглах болон/эсхүл эрсдэлд хүргэх харилцан хамаарлын үндсэн хоёр төрлийг харуулж байна. Харилцан хамаарлын эхний төрөл нь АББ-ын хамаарал бүхий этгээд, өөрөөр хэлбэл удирдах албан тушаалтан, ажилтнууд террорист байгууллагатай холбоо тогтоосон эсвэл холбоотой гэдэгт сэжиглэгдсэн. Террорист байгууллагатай холбогдсон хамаарал бүхий этгээдийн зүгээс АББ-ыг хууль бусаар ашиглах

тохиолдолд эдгээр хүмүүс АББ-ын үйл ажиллагаанд нөлөөлөх чадвартай байдаг тул энэ нь эцсийн дүндээ террорист этгээдүүдийг дэмжихэд чиглэдэг болохыг харуулж байна.

110. Дараах тохиолдолд терроризмын хяналтын жагсаалтад орсон этгээд боловсролыг хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан АББ-д ажилд орохын тулд хуурамч баримт бичиг ашигласан байна.

Кейс тохиолдол 50

Террорист байгууллагатай хамаарал бүхий этгээд

Төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Шашны ашгийн бус байгууллагаар бүртгэгдсэн дотуур байртай сургууль терроризмын хэрэгт оролцсон гэдэгт сэжиглэгдсэн хүмүүсийн жагсаалтад орсон хүнийг ажилд авчээ. Энэ хүн нь террорист халдлагын улмаас эрэн сурвалжлагдаж байсан оргодлуудыг орогнуулсан байв.

Хуурамч үнэмлэх ашиглан тэрбээр оршин суух зөвшөөрөл авч, дотуур байртай сургуульд англи хэлний багшаар ажилд орсон байв. Тус сургуулийн захирал энэ хүний жинхэнэ нэрийг болон түүнийг терроризмын хэрэгт сэжиглэж буй хүмүүсийн жагсаалтад орсныг мэдээгүй байсан.

Хожим нь энэ хүнийг терроризмтой холбоотой хэрэгт гэм буруутай гэж үзэж, ял оногдуулсан.

111. Хамаарлын хоёр дахь төрөл нь АББ, террорист байгууллагын хооронд илүү албан ёсны харилцаатай байх явдал юм. Хоёрдугаар бүлэгт дэлгэрэнгүй дурдсанчлан, АББ-ыг олон улсын амжилттай оролцогч болгодог шинж чанарууд нь түүнийг хууль бусаар ашиглуулах эрсдэлд өртөмтгий болгодог. Энэ төрлийн тохиолдлууд нь АББ-ын бүс нутгийн харьяа салбарын үйл ажиллагааг эрхэлдэг террорист байгууллагууд үйл ажиллагаандаа дэмжлэг үзүүлэх сүлжээгээ өргөжүүлэх боломжтойг харуулж байна. Кейс тохиолдлуудыг шинжлэн судлахад тэдгээр нь харьяа салбарыг хөрөнгө босгох, хөрөнгийн зориулалтыг өөрчлөх, зэр зэвсэг худалдан авах, дэмжигчдийг элсүүлэх, цэргийн бэлтгэл сургуулилт болон бусад үйл ажиллагааны зорилттой холбоотой үйл ажиллагааг явуулахад ашигладаг болох нь илэрч байв.

112. Дараах кейс тохиолдолд Тамилын зохицуулах хороо (ТСС) гэх жижиг хороогоор удирдуулсан Мельбурн хотод төвтэй АББ нь Шри-Ланк Улсад төвтэй Тамил Илам (LTTE)-ын чөлөөлөх барууд байгууллагын гадаад дахь цэргийн түшиц газраар ажилладаг байсан байна.

Кейс тохиолдол 44

Террорист байгууллагатай хамаарал бүхий этгээд

Хөрөнгө босгох, хадгалах, шилжүүлэх, зарцуулах болон төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

2005 оны 1 дүгээр сард Австралийн Холбооны цагдаагийн газарт (AFP) Шри Ланк Улсын Дээд Комисс (Ерөнхий консулын газар)-оос Тамил Иламын чөлөөлөх барсууд (LTTE) хөдөлгөөн Австрали Улсад хөрөнгө босгох үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй тул мөрдөн шалгах ажиллагаа явуулж өгөхийг хүсэлт болгосон захидал ирүүлжээ. Уг захидалд Азийн цунамигийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст тусламж үзүүлэх нэрийн дор LTTE-д хөрөнгө босгодог олон улсын сүлжээг заасан байв. Тус сүлжээнд Австрали, Дани, Франц, Герман, Итали, Нидерланд, Норвеги, Швед, Швейцарь, Их Британид амьдардаг иргэд холбогдсон байв. Уг захидлыг хүлээн авсны дараа Мельбурн хотын AFP-ийн Терроризмтой тэмцэх хамтарсан багийнхан захидалд дурдсан баримтуудыг шалгаж эхэлжээ.

Мөрдөн шалгах ажиллагаагаар жижиг хороогоор удирдуулсан Мельбурн хотод бүртгэлтэй ашгийн бус байгууллага болох Тамилын зохицуулах хороо (ТСС) нь Тамил Иламын чөлөөлөх барсууд хөдөлгөөний халхавч байгууллага байсныг тогтоожээ. ТСС нь Австрали дахь Тамилчуудын нийгэмлэгт хандив үзүүлэхийг уриалах, нийгэмлэгийн гишүүдийн дунд хэвлэмэл материал тараах, радио ухуулга хийдэг байжээ. Түүнчлэн Шри Ланк Улсаас Тамилчуудыг тусгаар тогтноулах үзэл санааг улстөрчдийн дунд лоббидох, LTTE-ийн нэрийн өмнөөс цахилгаан болон далайн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл явуулдаг байв. Ятгалганд автсан Австралид амьдардаг хэдэн зуун Тамилчууд сар болгон өөрсдийн данснаасаа ТСС-ийн данс руу шууд төлбөр хийдэг байжээ. Үүнээс гадна ТСС нь гудамж талбай, худалдааны төвүүдэд хандив цуглуулдаг байв.

Мэдээллийн дагуу LTTE-ийн Австралийн жигүүрийг гурван хүн удирддаг байсан, тодруулбал, тээвэрлэгчийн үүргийг гүйцэтгэдэг байсан Аруран Винягомурти, Тамилчуудын нийгэмлэгийн сонины редактор байсан Сивараян Ятаван, нягтлан бодогчоор ажиллаж байсан Арумуган Ражеван нар байв. Эдгээр гурван этгээд нь мөн Тамилийн зохицуулах хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг байсан. Тэдгээрийн гэрт хийсэн нэгжлэгийн үр дүнд Ражеван, Ятаван нар нь Шри Ланк Улс дахь LTTE-ийн завинаас автомат буугаар буудаж байгаа болон уг хөдөлгөөний бэлтгэл сургуулилт хийдэг газруудын нэгд нь очсон тухай видео бичлэгийг олжээ. Түүнчлэн Винягомурти, Ражеван нарын Тамил-Иламын чөлөөлөх барсууд хөдөлгөөний үүсгэн байгуулагч Велупилла Прабхакарантай хамт авахуулсан зургийг олсон. Олдсон видео бичлэгт Винягомурти нь хамтрагчдаа "ТСС бол барсууд, харин барсууд бол ТСС" гэж хэлснийг бичсэн байв.

Эцэстээ Винягомурти, Ятаван нар LTTE-д 1 сая гаруй ам.доллар шилжүүлсэнд гэм буруутай гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Винягомурти нь мөн LTTE-ийг цахилгаан төхөөрөмжөөр хангаж байсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд тэдгээрийн дор

хаяж нэгийг нь террорист халдлагын тэсрэх төхөөрөмжийг үйлдвэрлэх, дэлбэлэхэд ашигласан байв.

АББ-ын үйл ажиллагааг хянадаг эрх бүхий байгууллагын үүднээс авч үзэхэд Тамилын зохицуулах хорооны хэрэгт эрсдэлийн хэд хэдэн (анхаарах) шалгуур үзүүлэлтүүд байсан. Тус байгууллага нь террористууд үйл ажиллагаа явуулдаг хөгжиж буй оронд хөрөнгө шилжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн; тэрбээр байгалийн гамшигт үзэгдэлтэй холбогдуулан хөрөнгө босгосон; тэрбээр нэг үндэстэн угсаатан төвтэй байгууллага (нэг үндэстний төлөөллөөс бүрдсэн) байсан бөгөөд түүний гишүүд, дэмжигчид нь тус байгууллагыг террорист байгууллагын жагсаалтад оруулахыг зөвшөөрдөггүй байсан.

Хэргийг мөрдөн шалгах явцад Австрали Улсаас гадагшаа гарч буй хөрөнгийн урсгалд хяналт тавьдаг Австрали Улсын мөнгөн гүйлгээний тайлан, дүн шинжилгээний төв (Австралийн СМА)-өөс өгсөн санхүүгийн тагнуулын мэдээллийг ашигласан.

Тэмдэглэл:

Энэхүү кейс тохиолдлын судалгааг Австрали Улсаас өгсөн материал болон дараахь нээлттэй хэвлэлд нийтлэгдсэн нийтлэлийг үндэслэн боловсруулсан: Кейт Мур (Moog, Keith), "Буяны байгууллагыг Шри Ланк Улсын Тамилын барсуудыг санхүүжүүлэх халхавчаар ашиглаж байжээ", «Хэралд Сан» сонин " (цахим), 04/01/2010 он, www.heraldsun.com.au/news/charity-used-as-front-to-finance-sri-lankas-tamil-tigers/story-e6frf7jo-1225848229678, (ашигласан 04.2014 он).

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ

113. Террористууд АББ-ыг өөрсдийн зорилгодоо ашиглаж болох өөр нэг арга нь үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах явдал юм. Энэхүү типологийн тайлантай холбоотой жишээнүүдээс харахад АББ-ын санхүүжилттэй, сайн үйлсэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед өөрчлөх нь түүнийг террорист зорилгоор хууль бусаар ашиглахад хүргэдэг байна. Түүнчлэн шинжлэн судалсан кейс тохиолдлуудад АББ-ыг иймэрхүү хууль бусаар ашиглахад хамааралтай болон хамааралгүй этгээдийн оролцооны түвшин харилцан адилгүй байгааг харуулж байна. Хэдийгээр энэхүү типологитой холбоотой үйл ажиллагаа нь үндэсний хэмжээнд хэрэгжсэн ч хохирогчид нь илүү өргөн хүрээг хамарч байв.

114. Дараах кейс тохиолдлыг шинжлэн судлахад АББ-ын цахим орчин дахь төлөөллийг удирдах эрхтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс АББ-г хууль бусаар ашигласан байв. Хэдийгээр АББ-ын зорилтыг өргөжүүлэхийн тулд цахим хуудас ажиллуулах нь зохистой зүйл боловч терроризмыг дэлгэрүүлэх зорилгоор цахим хуудас ажиллуулах нь зохистой зүйл биш юм.

Кейс тохиолдол 75

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах

Орон нутгийн АББ өөрийн цахим хуудсандаа террорист амиа золиослогчдын үйлдлийг зөвтгөсөн байж болзошгүй үйлдэлтэй холбогдуулан түүний талаар сөрөг мэдээллэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарчээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний эрх бүхий байгууллагаас тус АББ-ын цахим хуудсанд дүн шинжилгээ хийхэд тус АББ нь хэд хэдэн террорист амиа золиослогчдын нэр бүхий “амиа золиослогчдын” жагсаалтыг нийтэлсэн болохыг илрүүлжээ. Хяналтын байгууллагын оролцоотойгоор уг зохисгүй агуулга бүхий мэдээллийг цахим хуудаснаас нь устгуулсан байна.

Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ-ын удирдлагын хяналтын тогтолцоо хангалтгүй, эрсдлийн менежментийн тогтолцоо үр дүнгүй байсан гэж дүгнэжээ. Тус АББ-д учирч болзошгүй эрсдлийг илүү үр дүнтэй бууруулахын тулд удирдлагын тогтолцоогоо нягталж харахыг чиглэл болгожээ.

115. Хөтөлбөрийг хууль бусаар ашигласан өөр нэгэн кейс тохиолдолд үйл ажиллагаа явуулсан тухайн улсдаа аль аль нь буяны зорилгоор байх шашин, боловсролыг хөгжүүлэх зорилготой АББ-ыг байгуулсан байна. Харин энэхүү үйл ажиллагааг террорист байгууллагад элсүүлэх ажиллагааг сурталчлах зорилгоор ашигласан байв.

Кейс тохиолдол 78

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах

Ашгийн бус байгууллага зөвхөн дотоддоо шашны болон боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байсан бөгөөд гадаадад ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй байжээ. Гэхдээ үндэсний СМА-аас өгсөн мэдээлэлд тус АББ нь гадаадын террорист бүлэглэлд дэмжлэг үзүүлдэг гадаадын байгууллагаас 13,000 гаруй ам.доллар хүлээн авсныг илтгэсэн байв.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Үүний дараа нээлттэй эх сурвалжийн мэдээллийг судалж үзэхэд тус АББ-ын боловсролын төсөл хөтөлбөрүүд нь гадаадын хэд хэдэн террорист бүлэглэлийн баримталдаг үзэл суртлыг дэмждэг болохыг илтгэсэн байна. Үүнтэй холбогдуулан уг үзэл суртлыг террорист байгууллагын шинэ гишүүд, дэмжигчдийг элсүүлэх зорилгоор ашигладаг гэж үзэх сэжиг, болгоомжлол төржээ. Хожим нь тус АББ-ын сургуулийн төгсөгчдийн нэг нь өөр улсад терроризмын гэмт хэрэгт буруутгагдаж байсныг илрүүлсэн байна. Энэхүү хуучин сурагч нь мөн терроризмын гэмт хэрэгт буруутгагдсан өөр хэд хэдэн хүнтэй уулзсан байжээ.

Үндэсний хяналтын байгууллагаас тус АББ-ын үйл ажиллагаанд аудитын шалгалт хийхэд тус АББ нь ихэнхи орлого, зарлагынхаа гарал үүслийн талаар тайлагнаагүй болох нь тогтоогджээ. Шалгалтын үр дүнд тус АББ-ын бүртгэлийг цуцалсан байна.

ЭЛСҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

116. Энэхүү тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлууд нь террорист хөдөлгөөнүүд элсүүлэх ажилдаа дэмжлэг үзүүлэх зорилгоор АББ-ын санхүүжилттэй хөтөлбөр, барилга байгууламжийг хууль бусаар ашиглаж болохыг илтгэж байна. Тайланд шинжлэн судалсан 102 кейс тохиолдлын 27-д нь террорист хөдөлгөөнүүд элсүүлэх ажилдаа дэмжлэг үзүүлэх зорилгоор ашгийн бус салбарыг ашигласан байв.

117. Хоёрдугаар бүлэгт дурдсанчлан террорист хөдөлгөөний элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, эд зүйл байх нь АББ-ын хөрөнгийг санаатайгаар ашиглагдаж байгаа эсвэл ашиглах аюулд орж болзошгүйн дохио юм. Элсүүлэх ажилд холбоотой үйл ажиллагаа нь террорист байгууллагыг дэмжих нэг хэлбэр бөгөөд ихэвчлэн терроризмыг дэмжих өргөн хүрээний зорилтын шинж тэмдгийн илэрхийлэл юм. Түүнчлэн эдгээр үйл ажиллагаа эсхүл эд зүйл байх эсэх нь хэрэгжүүлэх үед АББ-ын хөтөлбөрийг гажуудуулсны илэрхийлэл байж болно. АББ нь бүгд хууль ёсны үйл ажиллагаа болох хууль ёсны боловсролын хөтөлбөртэй байж, түүнд хөрөнгө гаргаж, багш сурган хүмүүжүүлэгчийг ажилд авч болно. Гэхдээ, хэрэв багш сурган хүмүүжүүлэгчид нь терроризмын зорилгоор элсүүлэх ажилд оролцвол тухайн боловсролын хөтөлбөр, түүнд зориулсан хөрөнгө нөөц гажуудалд орох юм.

118. Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх тохиолдолд террорист байгууллагууд АББ-ыг өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлах, элсүүлэх зорилгоор ашиглаж байсан эсхүл ашиглаж байсан гэж үзэж болох хууль бусаар ашиглах, эрсдэл учруулах тохиолдлыг хамарч байв. Хууль бусаар ашиглах энэ арга нь террорист хүчирхийлэлтэй шууд холбоотой зорилтыг хөхиүлэн дэмжих зорилгоор АББ-ын хөрөнгө нөөцийг ашигласан тохиолдлуудад хамааралтай юм. Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой АББ-ын санхүүжилттэй үйл ажиллагаа нь дотоодод болон олон улсын хэмжээнд аль алинд нь АББ-ын үйл ажиллагааны хөрөнгө босгох, цуглуулах, хэрэгжүүлэх үе шатуудад ажиглагдсан болно. Кейс тохиолдлуудаас элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх байдлыг шинжлэн судлахад АББ-ын оролцоог дараах байдалтай байна. Үүнд:

- террористуудад хөрөнгө мөнгө шилжүүлэх;
- террористуудын гэр бүлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- шатаагч тэсрэх бодис ашиглан террорист халдлага үйлдэх (ийм нэг халдлагыг АББ-ын удирдах албан тушаалтан зохион байгуулсан);
- терроризм эсхүл террорист байгууллагыг дэмжих зорилгоор арга хэмжээ зохион байгуулах, орон байраар хангах; болон
- терроризм эсхүл террорист байгууллагыг дэмжсэн материалыг Цахим орчинд болон бусад мэдээллийн хэрэгслээр нийтлэн түгээх.

119. Кейс тохиолдлыг шинжлэн судлахад АББ-аас санхүүжүүлсэн барилга байгууламжийг дараах зорилгоор хууль бусаар ашиглаж байсныг харуулсан. Үүнд:

- террорист халдлагад оролцох тэр дундаа тэсрэх бодис хийх, террорист амиа золиослогчид халдлага үйлдэхэд оролцох хүмүүсийг элсүүлэх, бэлтгэх;
- террорист байгууллагын гишүүдийн уулзалтыг зохион байгуулах орон байраар хангах; болон
- терроризмын үзэл санааг түгээх, сурталчлахад ухуулан сурталчлагчдыг урих.

120. Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой дараахь жишээнд суртал ухуулга, террористуудыг элсүүлэхэд болон цэргийн ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх зорилгоор жагсаалтад орсон террорист байгууллагын нэрийн өмнөөс төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, үйл ажиллагаа явуулж байсан АББ-ын тухай гардаг.

Кейс тохиолдол 80

Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

АНУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 13224 тоот захирамжийн дагуу “Аль Рехмат Траст” (Пакистан Улсад үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага)-ыг терроризмыг дэмждэг байгууллагын жагсаалтад оруулсан байна. Шалтгаан нь тус АББ “Аль Каида” болон түүнтэй холбоотой бусад байгууллагуудын хяналтад байсан, тэдгээрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, жагсаалтад орсон террорист байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн явдал байв.

Хэрэгжүүлэх, шилжүүлэх үе шат

“Аль Рехмат Траст” сан нь НҮБ-ын террорист байгууллагын жагсаалтад орсон “Жаиш-и-Мохаммед” байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хөрөнгө босгох зорилгоор байгуулагдсан халхавч байгууллага байсан. “Жаиш-и-Мохаммед” (Пакистан Улсад байрладаг, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 тоот тогтоолын дагуу террорист байгууллагын жагсаалтад орсон террорист бүлэглэл)-ыг 2002 онд Пакистан Улсад хориглосны дараа тэрбээр үйл ажиллагаагаа халхавчлах зорилгоор “Аль Рехмат Траст” санг ашиглаж эхэлсэн байна. “Аль Рехмат Траст” сан нь Афганистан, Пакистан дахь цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг байсан бөгөөд мөн хоёр улсад байлдаж байсан гадаадын дайчдад санхүүгийн болон зохион байгуулалтын туслалцаа, дэмжлэг үзүүлдэг байжээ. 2009 оны эхээр “Аль Рехмат Траст” сангийн хэд хэдэн нөлөө бүхий гишүүд Афганистан Улсад террорист ажиллагаа явуулах зорилгоор оюутнуудыг элсүүлсэн байв. Түүнчлэн, “Аль Рехмат Траст” сан нь өөрийн сүм, хийдэд дайчдыг сургах, үзэл сурталд автуулах зэрэг ажилд зориулж “Жаиш-и-Мохаммед” бүлэглэлд хөрөнгө босгодог байсан. 2009 оны эхээр “Аль Рехмат Траст” сан нь алагдсан эсхүл баривчлагдсан дайчдын ар

гэрийнхнийг дэмжих зорилгоор Пакистан Улсад хандивын төсөл хөтөлбөрийг эхлүүлсэн. Мөн 2007 оны эхээр “Аль Рехмат Траст” сан нь “Худам-ул-Ислам” (“Жаиш-и-Мохаммед” бүлэглэлийн өөр нэр) байгууллагын нэрийн өмнөөс хөрөнгө босгож байсан.

“Аль Рехмат Траст” сан нь Афганистан Улсаас ирсэн шархадсан Талибанчуудын дайчдад санхүүгийн тусламж үзүүлэх зэргээр “Талибан” хөдөлгөөнд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлдэг байсан.

ТӨӨРӨГДҮҮЛЭХ ТӨЛӨӨЛӨЛ, ХУУРАМЧ БУЮУ ХАЛХАВЧ АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА

121. Төөрөгдүүлэх төлөөлөл нь терроризмыг дэмжих зорилгоор буяны үйл ажиллагаа эрхлэх нэрийн дор байгууллага, хувь хүмүүс хөрөнгө босгох, үйл хэргийг сурталчлах болон бусад үйл ажиллагаа явуулахад ашигладаг. Тодруулбал төөрөгдүүлэх төлөөллийн хэргийг хоёр төрөлд хувааж болох юм. Эхний төрөл нь "хуурамч АББ"-тай холбоотой бөгөөд энэ нь террорист үйл ажиллагааг дэмжих зорилгоор халхавч АББ-ыг байгуулдаг бөгөөд түүний тавьсан зорилтууд нь хуурамч байдаг. Хоёр дахь төрөл нь хувь хүн эсхүл хэсэг бүлэг хүмүүс хууль ёсны АББ-ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа хэмээн худал мэдүүлэх тохиолдлыг хэлнэ.

122. Шинжлэн судалсан кейс тохиолдлуудад хуурамч АББ болон хууль ёсны АББ-ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа хэмээн худал мэдүүлсэн этгээд нь терроризмыг дэмжих зорилгоор хөрөнгө босгох эсхүл терроризмыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх далд явуулга хийдэг болох нь харагдаж байв.

123. Дараах шинжлэн судалсан кейс тохиолдолд “хуурамч АББ”-ыг байгуулахдаа сургууль гэх АББ нь үнэн хэрэгтээ зөвхөн орон нутгийн цагдаа, прокурор, шүүгчийн эсрэг халдлага үйлдэхэд оюутан элсүүлэх, тэсрэх бөмбөг үйлдвэрлэх зорилготой байна.

Кейс тохиолдол 96

Төөрөгдүүлэх төлөөлөл

Бүртгэлгүй АББ-аар үйл ажиллагаа явуулж байсан дотуур байртай шашны сургуульд тэсрэх бөмбөг дэлбэрчээ. Үүнтэй холбогдох мөрдөн шалгах ажиллагаагаар тус сургуулийг террорист бүлэглэлийн гишүүд орон нутгийн цагдаагийн албан хаагчид, прокурор, шүүгчдийн эсрэг халдлага үйлдэх, мөн гар хийцийн тэсрэх бөмбөг үйлдвэрлэхэд оюутан сурагчдыг элсүүлэхэд ашиглаж байсныг тогтоосон байна.

Төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Тус сургуулийн захирлыг терроризмтой холбогдох гэмт хэрэгт буруутгаж шийтгэсэн.

124. Дараах кейс тохиолдлыг шинжлэн судлахад хоёр этгээд гадаад дахь цэргийн ажиллагааг дэмжихэд хөрөнгө босгох зорилгоор өөрсдийгөө олонд танигдсан АББ-ын гишүүн мэтээр төөрөгдүүлэн төлөөлсөн байна.

Кейс тохиолдол 97

Төөрөгдүүлэх төлөөлөл

Хоёр этгээд жагсаалтад орсон террорист байгууллагад нэгдэж гадны улсад байлдаж байсан гэр бүлийн гишүүндээ зориулж орон нутагтаа хандив цуглуулж байжээ. Эдгээр этгээдүүд өөрсдийгөө хүмүүнлэгийн тусламжийн нэр бүхий орон нутгийн ашгийн бус байгууллагын төлөөлөгчид хэмээн мэдэгдэж, олон нийтийн газар гудамж талбайд хандив цуглуулах замаар хөрөнгө босгосон байна. Хөрөнгө босгох энэ арга нь дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл байв.

Хандив цуглуулах үе шат

Дээрх хоёр этгээд нь түүний нэрийн өмнөөс хандив цуглуулна гэж орон нутгийн АББ-аас зөвшөөрөл аваагүй байсан бөгөөд цуглуулсан хандивыг уг ашгийн бус байгууллагад шилжүүлдэггүй байжээ. Нилээд их хэмжээний мөнгө цуглуулсны дараа мөнгийг цахим шилжүүлгээр гадаад дахь гэр бүлийн гишүүндээ явуулсан байна.

СМА, АББ-ын хяналтын байгууллага, хууль сахиулах байгууллагын хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд дээрх хоёр этгээдийг баривчилж, терроризмыг дэмжих зорилгоор хөрөнгө босгосон хэргээр хорих ялаар шийтгэсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ИЛРҮҮЛЭХ АРГА, АРГАЧЛАЛ

- Төслийн явцад цуглуулсан мэдээллийн дүн шинжилгээгээр хууль бусаар ашиглах, эрсдэл учруулах үйлдлийг илрүүлэхэд ашигласан арга, аргачлал тайлбар -

125. Төслийн явцад цуглуулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр холбогдох талууд хууль бусаар ашиглах, эрсдэл учруулах үйлдлийг хэрхэн илрүүлснийг өөрөөр хэлбэл, хэн ямар мэдээллийг хэнд өгсөн болохыг судалсан. Дүн шинжилгээгээр олон талт мэдээллийн эх үүсвэр, тэдгээрийг ашиглах давтамж, террористууд АББ-ыг хууль бусаар ашиглах, эрсдэл учруулах үйлдлийг илрүүлэхэд тэдгээрийн гүйцэтгэх үүрэг оролцоог тодорхойлсон. Төслийг дэмжихэд цуглуулсан кейс тохиолдлыг шинжлэн судалж, бусад мэдээллээс үзэхэд илрүүлэхтэй холбоотой хүчин чармайлт нь олон талт мэдээллийн эх сурвалжид тулгуурладаг бөгөөд тэдгээрийг ерөнхийд нь зургаан бүлэгт ангилсан байна.

Зураг 4.1: Илрүүлэх арга, аргачлал-Мэдээллийн эх үүсвэр, түүний төрөл

Илрүүлэх арга, аргачлал - Мэдээллийн эх үүсвэр, түүний төрөл	
АББ-ын хяналт шалгалтын мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Олон нийтээс ирүүлсэн гол сэжүүр мэдээлэл • Шүгэл үлээгчид • Одоо ажиллаж байгаа АББ, АББ байгуулах хүсэлт гаргачдад аудит хийх • АББ-ын заавал илтгэх тайланг авах, дүн шинжилгээ хийх <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөр, үйл ажиллагааны тухай мэдээлэл - Удирдах албан тушаалтан, бусад хамаарал бүхий этгээдийн мэдээлэл - Түнш, бусад хамааралгүй этгээдийн мэдээлэл - Эх үүсвэр, хөрөнгийн хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчдын талаархи мэдээлэл - Санхүүгийн үйл ажиллагааны талаархи мэдээлэл • АББ-аас сайн дурын үндсэн дээр өгсөн мэдээлэл
Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл, мэдээллийн сан • Террористуудын бүртгэлийн жагсаалт • Нэр бүхий байгууллагын жагсаалт • Аж ахуйн нэгжийн мэдээллийн сан • АББ, түүнтэй холбогдох байгууллага цахим орчинд төлөөлөлтэй байгаа эсэхийг шалгах • Цахим бусад мэдээлэл


<p>СМА, бусад санхүүгийн мэдээлэл</p> <p>Үндэсний аюулгүй байдлын мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • СМА-ийн санхүүгийн тайлан <ul style="list-style-type: none"> - Сэжигтэй гүйлгээ - Хил дамнасан валютын гүйлгээ - Их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ - Цахим мөнгөн шилжүүлэг • СМА-ны санхүүгийн мэдээллийн дүн шинжилгээ • Аюул заналын үнэлгээ • Эрсдэлийн үнэлгээ • Геополитикийн үнэлгээ • Тагнуул, бусад нууцын зэрэглэлтэй мэдээлэл
<p>Хууль сахиулах байгууллагын мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • Холбогдох гэмт хэргийн бүртгэл • АББ-д хамааралтай болон хамааралгүй этгээдийн холбогдох мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой байх • АББ-ын гэмт хэрэгтэн, гэмт хэрэгтэй холбоотой эсэх мэдээлэл • Нэгжлэг хийх зөвшөөрөл, үйлдвэрлэлийн захиалгыг гүйцэтгэх • Тагнуул, бусад нууцын зэрэглэлтэй мэдээлэл
<p>Гадны мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • АББ-ын гадаадын түншүүд • Гадаадын түнш байгууллагууд (тухайн улсын) <ul style="list-style-type: none"> - Гадаадын үндэсний аюулгүй байдлын мэдээлэл - Хууль сахиулах байгууллагын мэдээлэл - СМА-ны мэдээлэл - Хяналт шалгалтын байгууллагын мэдээлэл

126. Төслийн явцад цуглуулсан мэдээлэлд үндэслэн илрүүлэх хүчин чармайлт нь гол төлөв олон талт эх сурвалжаас олж авсан мэдээллийн олон төрлийг хамардаг. Олон улс орны зүгээс терроризмын санхүүжилт, АББ-ыг хууль бусаар ашиглахтай тэмцэх чадвараа агентлаг хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа буюу Засгийн газрын бүхий л түвшинд хамтран ажиллах арга замтай холбон тайлбарласан. Үнэндээ илрүүлэх хүчин чармайлтынхаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн бүх улс ашгийн бус салбарыг террористууд хууль бусаар ашиглах эрсдэлтэй тэмцэхэд агентлаг хоорондын аргыг хэрэглэсэн байв. Кейс тохиолдлыг шинжлэн судлахад ихэнхи тохиолдолд олон талт эх сурвалжаас олсон олон төрлийн мэдээллийг нэгэн зэрэг авч үзсэнээр эрсдэл, хууль бусаар ашиглах үйлдлийг илрүүлдэг болохыг харуулж байна.

127. Түүнчлэн төслийн явцад цуглуулсан мэдээлэл нь хууль бусаар ашиглах, эрсдэл учруулах үйлдлийг хамтын арга замаар илрүүлэх нь нэг байгууллагаас явуулсан мөрдөн шалгах үйл ажиллагаа өөр байгууллагаас явуулсан үйл ажиллагаатай зөрчилдөхгүй эсхүл түүнийг эрсдэлд оруулдаггүй болохыг харуулж байна.

128. Эрсдэл, хууль бусаар ашигласан үйлдлийг илрүүлэхэд мэдээллийн олон талт эх сурвалжид тулгуурлахын ач холбогдол, давтамжийг кейс тохиолдлын судалгаа шинжилгээнээс харагдаж байна. Зураг 4.2-т тухайн тохиолдолд илрүүлэх арга, аргачлалын зургаан ангилал тус бүрийн ажиглагдсан давтамжийг харуулав. Дунджаар илрүүлэх ангиллын гурван аргын мэдээллийг тухайн тохиолдол бүрт ашигласан байв.

Зураг 4.2: Илрүүлэх арга, аргачлал-Шинжлэн судалсан кейс тохиолдлоор ажиглагдсан давтамж



Тэмдэглэл: Давтамжийг тооцоолоход зөвхөн илрүүлэхтэй холбоотой хүчин чармайлтад ашигласан мэдээллийн төрөл, эх сурвалжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн тохиолдлуудыг оруулсан болно.

АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

129. АББ-ын хяналт шалгалтын мэдээлэлд АББ-ын заавал илтгэх тайлан, АББ-ын нийцүүлэлт, албадан хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны мэдээлэл, АББ болон олон нийтээс сайн дурын үндсэнд өгсөн мэдээлэл багтана. Тайланд шинжлэн судалсан кейс тохиолдлын 68 хувьд нь илрүүлэхтэй холбоотой хүчин чармайлтад АББ-ын хяналт шалгалтын мэдээллийг ашигласан байв. Дээрх кейс тохиолдлууд нь АББ-ын хяналт шалгалтын байгууллага хууль ёсны буяны үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлэхийн зэрэгцээ АББ-ыг хууль бусаар ашиглах эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэх, багасгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор, гол төлөв захиргааны шинжтэй өргөн цар хүрээ бүхий арга, эрх мэдэлд тулгуурладаг болохыг харуулж байна. ФАТФ-ын Зөвлөмж 8-ийн тайлбарт террористууд АББ-ыг хууль бусаар ашигласан үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үр дүнтэй аргад ашгийн

бус салбарын удирдлага, хяналтын нэг хэсэг зайлшгүй байх ёстой гэдгийг тэмдэглэсэн. Кейс тохиолдлыг шинжлэн судлахад зарим улсын АББ-ын хяналт шалгалтын байгууллагаас зохион байгуулсан удирдлага, хяналтын ажлаар АББ-ыг хууль бусаар ашигласан үйлдлийг амжилттай илрүүлсэн байна. Түүнчлэн кейс тохиолдлыг шинжлэн судлахад АББ-ын хяналт шалгалтын байгууллага нь ихэнхдээ АББ-тай холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгодог байна. Ерөнхийдөө ийм практик нь АББ-ын хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлдэг.

130. Дараах кейс тохиолдолд АББ, террорист байгууллагын хооронд харилцаа холбоо байна гэсэн олон нийтээс ирүүлсэн сэжүүрийг үндэсний хяналт шалгалтын байгууллагын олж авсан нэмэлт мэдээллийн эх сурвалжаар нотолсон байна. Үндэсний хяналт шалгалтын байгууллага тус АББ-ын бүртгэлийг цуцлах шийдвэр гаргахдаа аудитын мэдээлэл, үндэсний аюулгүй байдлын мэдээлэл, нээлттэй эх сурвалжийн мэдээллийг тус тус харгалзан үзсэн байна.

Кейс тохиолдол 14

Илрүүлэх арга, аргачлал

АББ-ын хяналт шалгалтын мэдээлэл, нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, үндэсний аюулгүй байдлын мэдээлэл

Гадаадад хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт ажилладаг гадны түншдээ мөнгө явуулдаг байв. АББ-ын хяналт шалгалтын үндэсний байгууллагад олон нийтээс ирүүлсэн сэжүүр мэдээлэл тус АББ-ыг гадаадын террорист бүлэглэлийн халхавч гэдэг нь мэдэгдэж байсан байгууллагаас бага хэмжээний хандив хүлээж авсныг тогтоожээ. Тус АББ-аас үндэсний хяналтын байгууллагад явуулсан заавал илтгэх тайланд тус АББ-ыг уг хандивыг хүлээн авсныг нотолсон.

Тун удалгүй уг хандивтай холбоогүй аудитын шалгалтын явцад олж авсан баримтаар тус АББ нь террорист бүлэглэлийн халхавч байгууллагын мөнгө шилжүүлэх хамгийн зохимжтой суваг байсныг олж тогтоосон байна. Уг баримтын огноо нь АББ-ын хүлээн авсан хандивын хэмжээ огцом нэмэгдсэн хугацаатай таарч байв. Нээлттэй эх сурвалжийн судалгаа, үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд хийсэн дүн шижилгээгээр тус АББ-ын гурван төлөөлөгчийг гадаадын террорист бүлэглэлийн дэмжигчид байсныг тогтоож, АББ-ын гадны түнш нь дээрх гадаадын террорист бүлэглэлийн бас нэг халхавчаар ажилладаг байгууллага байсныг олж тогтоосон байна.

Үндэсний хяналт шалгалтын байгууллагаас тус АББ-д хийсэн дараагийн хяналт шалгалтаар уг АББ нь гадны түншдээ 700,000 ам.доллар хандивласан хэдий ч эдгээр хөрөнгийг зарцуулсан эцсийн зориулалтыг тайлбарлаж чадахгүй байсныг олж тогтоосон. Эцсийн дүнд үндэсний хяналтын байгууллага уг ашгийн бус байгууллагын бүртгэлийг цуцалсан.

НЭЭЛТТЭЙ ЭХ СУРВАЛЖИЙН МЭДЭЭЛЭЛ

131. Ашгийн төлөө байгууллагаас ялгаатай нь ашгийн бус байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, ил тод байдлыг хангах, хөрөнгө босгох зорилгоор цахим орчинг идэвхтэй ашигладаг. Үүнтэй холбогдуулан АББ болон түүнд хамааралтай болон хамааралгүй этгээдийн талаархи мэдээллийг олж авахад хялбар байдаг. Судлан шинжилсэн кейс тохиолдлын 96 хувьд нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл АББ-ыг хууль бусаар ашигласан үйлдэл, эрсдэлийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлсэн болохыг тэмдэглэжээ. Үүнээс гадна нээлттэй эх сурвалжийн мэдээлэл нь эрсдлийг бууруулахад чухал ач холбогдолтой. Мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагааг явуулахад ердөө дэмжлэг үзүүлэх мэдээлэл нь хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэхүү судалгаанд хийсэн дүн шинжилгээ нь мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн хүчин зүйлсийг тодорхойлохыг оролдоогүй. Тиймээс нээлттэй эх сурвалжийн мэдээлэл бусад мэдээллийн эх сурвалжаас олж авсан мэдээллээс илүү олон тохиолдолд гарсан нь бусад төрлийн мэдээллийн эх сурвалжтай харьцуулахад хууль бус үйлдлийг илрүүлэхэд илүү хэрэгтэй байсан гэсэн үг биш юм. Энэ нь мөн нээлттэй эх сурвалжийн мэдээлэл илүү найдвартай гэсэн үг биш юм.

132. Кейс тохиолдлын судалгаа шинжилгээгээр нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд хандах, хяналт тавих, дүн шинжилгээ хийх нь эрх бүхий байгууллагад хууль ёсны АББ-ын үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр АББ-ын үйл ажиллагаа явуулж байсан орчныг шинжлэх боломжийг олгосон. Өөрөөр хэлбэл, эрх бүхий байгууллага аудитын шалгалт зэрэг илүү нарийн илрүүлэх аргыг хэрэглэхээсээ өмнө эрсдэлийг үнэлэх боломжтой болсон. Түүнчлэн дээрх кейс тохиолдлууд нь нэрлэгдсэн байгууллагын жагсаалт, байгууллагын мэдээллийн сан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь бүгдээрээ хууль бусаар ашиглах үйлдэл, эрсдэлийг илрүүлэхэд өргөнөөр хэрэглэдэг мэдээллийн эх сурвалж болохыг харуулсан.

133. Дараах тохиолдолд, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр бүхий АББ болон террорист байгууллагын хооронд харилцаа холбоо байсныг анх тогтоож үндэсний СМА-д мэдэгдсэн. Мөрдөн шалгах ажиллагааны явцад СМА нь мөн дотоодын хууль сахиулах байгууллага, банкууд, Засгийн газрын түнш байгууллагууд, гадаадын АББ-ын хяналт шалгалтын байгууллага, мөн уг АББ болон түүний гадаад түншүүдээс авсан мэдээллийг шалгасан.

Кейс тохиолдол 30

Илрүүлэх арга, аргачлал

Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, СМА болон бусад санхүүгийн мэдээлэл, үндэсний аюулгүй байдлын мэдээлэл, хууль сахиулах байгууллагын мэдээлэл, гадны мэдээлэл

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага нь гадаад улсад дотоодын зөрчил мөргөлдөөний улмаас хохирсон хүмүүст эмнэлгийн болон нийгмийн нөхөн сэргээх

тусламж үзүүлэх зорилгоор байгуулагдсан гадаад улсад төвтэй, олон улсын АББ-ын олон салбаруудын нэг байв.

Тухайн гадны улс байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдэхэд орон нутгийн салбар нь хөрөнгө босгож байгалийн гамшигт нэрвэгдсэн бүс нутагт байрладаг олон улсын АББ-ын төв рүү хөрөнгийг шилжүүлжээ.

Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тус олон улсын АББ-г террорист бүлэглэлтэй холбоотой гэдэг мэдээлэл гарахад үндэсний санхүүгийн мэдээллийн албанаас мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлжээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ их хэмжээний мөнгийг хэд хэдэн завсрын дансаар дамжуулан террорист бүлэглэлийн гишүүдийн эзэмшдэг дансанд шилжүүлснийг тогтоожээ.

Гэхдээ мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ-ын удирдлага шилжүүлсэн хөрөнгийн эцсийн зориулалтыг мэдэж байсан эсэхийг нь тогтоож чадаагүй байна.

САНХҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА БОЛОН БУСАД САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

134. Тайланд дүн шинжилгээ хийсэн кейс тохиолдлын 49 хувьд нь СМА болон санхүүгийн бусад мэдээлэл байсан. СМА-ийн цуглуулсан мэдээлэл, тухайлбал санхүүгийн тайлан, түүнтэй холбоотой дүн шинжилгээ нь хууль бусаар ашиглах үйлдэл, эрсдэлийн нөхцөл байдлын талаар илүү сайн ойлголттой болох боломжийг эрх бүхий байгууллагад олгодог байна. Кейс тохиолдлууд нь олонхи тохиолдолд СМА, банк нь (тайлагнасан байгууллага) АББ-ын терроризмыг дэмжсэн байх боломжтой санхүүгийн сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэхэд онцгой байр суурийг эзэлдэг. Үүний дагуу хэд хэдэн кейс тохиолдлыг анх банкууд илрүүлж, сэжигтэй гүйлгээний тайландаа СМА-д мэдэгдсэн.

135. СМА болон бусад санхүүгийн мэдээлэл нь мөн эрх бүхий байгууллагад АББ-тай холбоотой хувь хүн, байгууллага хоорондын холбоо хамаарал, харилцааг тогтоох, хяналт тавихад дотоодод шаардлагатай АББ-ын тайланг баримтаар нотлоход дэмжлэг үзүүлсэн байна. Тайланд судалгаа дүн шинжилгээ хийсэн ихэнхи кейс тохиолдолд хэд хэдэн өөр өөр байгууллага хоорондын уялдаа холбоотой хүчин чармайлтаар хууль бусаар ашигласан үйлдлийг бууруулснаас харахад мэдээллийн бусад эх сурвалжийн хамт санхүүгийн гүйлгээгээр тодорхойлсон холбоо хамаарлыг авч үзэх нь гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийн нэгэн адил чухал ач холбогдолтой болох нь нотлогдсон.

136. Дараах тохиолдолд СМА болон бусад санхүүгийн мэдээллээр терроризмыг дэмжсэн гэж сэжиглэгдсэн санхүүгийн сэжигтэй үйл ажиллагааг илрүүлсэн байна. Улмаар СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар АББ-ын хяналтын мэдээлэл, нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, үндэсний аюулгүй байдлын мэдээлэл, хууль сахиулах байгууллагын мэдээллийг шалгасан. Мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ-ын удирдах гишүүдийн нэг нь гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой гадаадын дайтагч байгууллагын нэрт зүтгэлтэн байсныг тогтоожээ.

Кейс тохиолдол 60

Илрүүлэх арга, аргачлал

СМА болон бусад санхүүгийн мэдээлэл, АББ-ын хяналт шалгалтын мэдээлэл, нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, үндэсний аюулгүй байдлын мэдээлэл, хууль сахиулах байгууллагын мэдээлэл

Орон нутгийн АББ зөрчил мөргөлдөөнтэй газар нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын АББ-аас их хэмжээний хөрөнгийг хүлээн авчээ. Орон нутгийн АББ-ын удирдах албан тушаалтан хөрөнгийн ихэнхи хэсгийг бэлэн мөнгөөр авахаар оролджээ. Банк үүний эсрэг зөвлөсний дараагаар хөрөнгийн тодорхой хэсгийг банкны бэлэн мөнгөний автомат машинаас гаргаж авчээ. Түүнчлэн тус АББ-тай хамааралгүй өөр нэг этгээд их хэмжээний бэлэн мөнгө авсан байна.

Орон нутгийн АББ-ын банк нь сэжигтэй гүйлгээний тайланг үндэсний СМА-д хүргүүлжээ. Үндэсний СМА-гийн мөрдөн шалгах ажиллагаагаар гадаадын АББ нь нэр бүхий террорист байгууллагатай холбоотой байсныг тогтоосон. Түүнчлэн орон нутгийн АББ-ын удирдах гишүүдийн нэг нь мөн гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой гадаадын дайтагч байгууллагын нэрт зүтгэлтэн байсныг тогтоосон.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ

137. Тайлангийн зорилтын хүрээнд үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд тухайн улс эсхүл түүний иргэдийн аюулгүй байдалд учруулах террорист аюул заналтай холбоотой мэдээллийг хамааруулна. Үндэсний аюулгүй байдлын мэдээлэл нь шинжлэн судалсан кейс тохиолдлын 63 хувьд хууль бусаар ашиглах үйлдэл, эрсдэлийг илрүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Энэ нь олон талт эх сурвалжаас өргөн хүрээний сэдвээр тайлан гаргадаг. Судалгаа дүн шинжилгээгээр үндэсний аюулгүй байдлын мэдээлэл нь АББ-ын үйл ажиллагаа явуулдаг орчны эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлдог. Үүнд үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолтой зөрчилдөх үйл ажиллагаатай холбоотой хувь хүн, байгууллагын талаарх мэдээлэл ордог.

138. Дараахь тохиолдолд үндэсний АББ-ын хянан шалгагч улсын бүртгэлтэй АББ-ын үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг үнэлэхдээ үндэсний аюулгүй байдлын мэдээллийг ашиглажээ. Анх АББ-ын заавал илтгэх тайлангаар тухайн АББ-ын санхүүгийн сэжигтэй үйл ажиллагааг илрүүлсэн бол үндэсний аюулгүй байдлын мэдээллээр тухайн АББ-ын захиалгаар шилжүүлгийг хүлээн авсан хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчид нь террорист байгууллага байсныг олж тогтоосон.

Кейс тохиолдол 21

Илрүүлэх арга, аргачлал

Үндэсний аюулгүй байдлын мэдээлэл, АББ-ын хяналт шалгалтын мэдээлэл, нээлттэй эх сурвалжийн мэдээлэл

Зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт гадаадын хүмүүнлэгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх албан ёсны зорилготой ашгийн бус байгууллага байгуулагджээ. Үндэсний хяналтын байгууллага тус АББ-ын завал илтгэх тайланд дүн шинжилгээ хийх явцдаа тус АББ нь бүртгэлийн нөхцөл шаардлагыг зөрчиж түүний хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчид бус өөр байгууллагад санхүүжилт олгож байсныг тогтоосон байна.

Үндэсний хяналтын байгууллага тус АББ-д аудитын шалгалт хийж байхдаа үндэсний аюулгүй байдалтай холбоотой тагнуулын мэдээллийг хүлээн авжээ. Тагнуулын мэдээлэлд тус АББ-ыг тухайн зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын террорист байгууллагыг дэмждэг, түүний нөлөөнд байдаг хүмүүнлэгийн байгууллагын сүлжээнд харъяалагддаг гэдэгт сэжиглэгдэж байсныг илтгэж байв. Аудитын шалгалтаар тус АББ нь 600,000 гаруй ам.долларыг гадаадын террорист бүлэглэлийн халхавч байгууллагад явуулсныг тогтоосон. Уг халхавч байгууллага нь хэд хэдэн улсын жагсаалтад орсон террорист байгууллага байсан. Түүнчлэн аудитын шалгалтаар тус АББ нь өөрийн хандивласан хөрөнгийн ихэнх хэсгийн эцсийн зориулалтыг тайлбарлаж чадахгүй байсныг тогтоосон.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд үндэслэж үндэсний хяналтын байгууллага тус АББ-ын бүртгэлийг цуцалж, холбогдох баримт бичгийг үндэсний аюулгүй байдлын байгууллагад шилжүүлсэн.

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

139. Хууль сахиулах үйл ажиллагааны мэдээлэл шинжлэн судалсан кейс тохиолдлын 58 хувьд илэрсэн. Мөрдөн шалгах ажиллагааны мэдээлэл эрх бүхий байгууллагад АББ-ын үйл ажиллагаа явуулж байсан орчны эрсдэл, хууль бусаар ашигласан тохиолдол, эрсдэлийн нөхцөл байдлын талаар илүү сайн ойлголттой болоход дэмжлэг үзүүлсэн. Энэ нь АББ-тай холбоотой хувь хүн, байгууллага болон тэдгээрийн гэмт хэрэгтэй холбогдох холбоо хамаарлын талаар ойлголттой болгож өгсөн.

140. Дараах тохиолдолд хууль сахиулах ажиллагаа болон мөрдөн шалгах ажиллагаагаар улсад бүртгэлтэй, төрийн санхүүжилттэй АББ нь үнэн хэрэгтээ террорист байгууллагын халхавч байгууллага байсныг илрүүлсэн.

Кейс тохиолдол 93

Илрүүлэх арга, аргачлал

Хууль сахиулах байгууллагын мэдээлэл, СМА болон бусад санхүүгийн мэдээлэл, нээлттэй эх сурвалжийн мэдээлэл

Залуучуудын соёлын нийгэмлэг нэрээр байгуулагдсан үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага Засгийн газрын хэд хэдэн буцалтгүй тусламжийг авчээ.

Хууль сахиулах байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ нь террорист бүлэглэлийн халхавчаар ажиллаж байсан хуурамч байгууллага байсныг олж тогтоожээ. Тус АББ-ын бодит үйл ажиллагаа нь террорист бүлэглэлийн ашиг сонирхолд хөрөнгө босгох, хөрөнгийн зарцуулалтыг удирдах болон тус бүлэглэлийн хэт даврах үзэл суртлыг цахим сүлжээгээр түгээх явдал байв.

Хэдийгээр тус АББ нь албан ёсны удирдан зохион байгуулах зөвлөлтэй байсан ч бодит байдалд түүнийг нь террорист бүлэглэлийн гишүүд үүсгэн байгуулж, удирддаг байжээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар гол холбоотой этгээдүүдийг баривчилж, тус АББ болон түүний цахим хуудсыг хаасан байна.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ГАДААДААС АВСАН МЭДЭЭЛЭЛ

141. Гадаад мэдээлэлд АББ-ын гадаад түншүүдээс авсан мэдээлэл, мөн гадаад түнш (Засгийн газрын) агентлагуудын мэдээлэл орно. ФАТФ-ын Зөвлөмж 8-ын тайлбарт, АББ-ыг террористууд хууль бусаар ашигласан үйлдлийг үр дүнтэй илрүүлэх, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд улс орнууд олон улсын хамтын ажиллагааны үр дүнтэй механизмтай байх ёстой гэсэн. Кейс тохиолдлын судалгаа дүн шинжилгээнээс харахад олон АББ үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс ч олон улсын хамтын ажиллагаа, мэдээллийн солилцоо нь терроризмтой холбоотой хууль бусаар ашигласан үйлдэл, салбарт учруулах эрсдэлийг илрүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой гэж үзэх нь зүйн хэрэг. Гэвч шинжлэн судалсан кейс тохиолдлын дөнгөж 6 хувьд нь хууль бусаар ашигласан үйлдэл, эрсдэлийг илрүүлэхдээ гадны мэдээллийг ашигласан гэдгийг тогтоосон. Үүний шалтгаан нь гуравдугаар шатны үнэлгээгээр нэн ялангуяа олон улсын хамтын ажиллагаатай холбогдуулан Зөвлөмж 8-ийн хэрэгжилт ерөнхийдөө тааруу байсны илрэл юм.

142. Дараах кейс тохиолдолд гадаадын (Засгийн газрын) хоёр түнш байгууллагаас авсан мэдээлэл үндэсний хянан шалгагч олон улсын хүмүүнлэгийн ажил явуулдаг гэх АББ-тай холбоотой эрсдэлийн нөхцөл байдлыг илрүүлэх, ойлгох, шийдвэрлэхэд нь хувь нэмрээ оруулсан.

Кейс тохиолдол 62

Илрүүлэх арга, аргачлал

Гадны мэдээлэл, АББ-ын хяналтын байгууллагын мэдээлэл, нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, үндэсний аюулгүй байдлын мэдээлэл

Гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт олон улсын хүмүүнлэгийн ажил хийдэг ашгийн бус байгууллага үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Хяналтын байгууллага тус АББ-ын өргөдлийг нягталж үзэхэд тус АББ-ын зорилго, үйл ажиллагааны зарим төрөл нь хуулийн хүрээнд хамаарахгүй байсан нь анхаарал татжээ. Түүнчлэн тус АББ-ын гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт түншилдэг байсан гадны байгууллагууд нь түүний хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчид нь биш байв.

Хяналтын байгууллага тус АББ-ын өргөдлийг нягталж үзэж байхдаа үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг олж авчээ. Энэхүү мэдээллийн дагуу тус АББ нь гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг жагсаалтад орсон террорист бүлэглэлийн орон нутгийн халхавч байгууллага болохыг илтгэж байв. Тус АББ нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн байгууллагад хууль ёсны аргаар хөрөнгө шилжүүлдэг байсныг тогтоосон. Эдгээр гадны байгууллагын зарим нь өөрсдөө жагсаалтад орсон террорист бүлгийн дэд бүтцийн нэг хэсэг гэж тодорхойлсон байв.

Гадаадын түнш хоёр байгууллагаас мөн мэдээлэл өгсөн бөгөөд хяналтын байгууллага түүнийг нь өргөдлийг шалгах явцдаа ашиглажээ. Гадаадын нэг түнш нь тус улсад террорист үйл ажиллагаатай холбогдуулан уг АББ-тай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа явагдсаныг мэдээлсэн байв.

Хяналтын байгууллагаас тус АББ-д эдгээр асуудлын талаар мэдэгджээ. АББ-аас хяналтын байгууллагын зүгээс тавьсан зарим асуудлыг шийдвэрлэх гэж оролдсон. Тодруулбал гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт албан газрынхаа салбарыг нээсэн бөгөөд үүгээрээ хөрөнгийн хуваарилалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд илүү сайн хяналт тавьж байгаа гэдгээ харуулахыг хичээсэн. Гэхдээ хяналтын байгууллагаас явуулсан нэмэлт шалгалтаар үндсэн эрсдэлийг арилгаагүй байсныг тогтоосон тул энэ талаар тус АББ-д мэдэгджээ.

Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаа, захиргааны арга хэмжээний үр дүнд тус АББ бүртгүүлэх хүсэлтээ буцааж авчээ. Хяналтын байгууллагын судалгаа дүн шинжилгээний үр дүн, мэдээллийг үндэсний аюулгүй байдлын байгууллагуудын мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор шилжүүлсэн.

ДҮГНЭЛТ

143. Шинжлэн судалсан кейс тохиолдлууд нь ашгийн бус байгууллагын салбарыг террорист байгууллагууд хууль бусаар ашигласан баримт, эрсдэлийг илрүүлэхэд олон янзын эх сурвалжаас олж авсан мэдээллийн олон төрлийг ашиглах, үнэлэх

замаар хэрэгждэг болохыг харуулж байна. Мэдээллийн энэхүү олон төрөл нь тэдгээрийн ашиглалтын давтамж, АББ-ын үйл ажиллагаанд нөлөөлөх түвшин, хэргийг илрүүлэхэд гүйцэтгэх үүрэг болон АББ-ыг хууль бусаар ашиглах эрсдэл зэргээр ялгаатай байв. Зарим мэдээлэл мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэхэд түлхэц болж байсан бол зарим нь ерөнхий нөхцөл байдлыг илчилж өгснөөр мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хууль хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Ерөнхийдөө холбогдох оролцогч талууд АББ-ыг хууль бусаар ашигласан баримт, эрсдлийг хэрхэн илрүүлснийг судалж үзэхэд хэд хэдэн ондоо оролцогч талын хамтын хүчин чармайлтаар эрсдлийг бууруулж болно гэдэг үзэл санааг нотлож байна. Хэдийгээр оролцогч талууд заримдаа олон янзын мэдээллийг өгдөг ч, тэдгээрийг нэгтгэхэд эрсдэлийн шинж чанарыг илтгэсэн бүрэн дүр зургийг олж авдаг. Зөвхөн эрсдлийн шинж чанарын талаар гүнзгий, үнэн зөв ойлголттой болсноор эрсдэлийг зохих ёсоор бууруулах боломжтой байх тул энэхүү судалгаа дүн шинжилгээний үр дүн онцгой ач холбогдолтой байх юм.

ТАВДУГААР БҮЛЭГ ТАСЛАН ЗОГСООХ АРГА, АРГАЧЛАЛ

- Төслийн явцад цуглуулсан мэдээлэлд хийсэн судалгаа дүн шинжилгээгээр хууль бусаар ашигласан үйлдэл, эрсдэлийг илрүүлсэн арга, аргачлалын тайлбар –

144. Төслийн туршид цуглуулсан мэдээллийн судалгаа дүн шинжилгээнд холбогдох талууд хууль бусаар ашигласан үйлдэл, эрсдэлийг хэрхэн таслан зогсоосныг судалсан. Шинжлэн судалсан кейс тохиолдолд АББ-ын терроризм, террорист байгууллагыг шууд дэмжиж байсан эсхүл терроризмтой холбоотой илүү өргөн хүрээний зорилтод шууд бус үүрэг гүйцэтгэсэн өргөн хүрээний үйл ажиллагааг тодорхойлсон. Хууль бусаар ашигласан үйлдэл буюу ихээхэн эрсдэл учруулах тохиолдлыг бууруулах зорилгоор ашигласан таслан зогсоох арга, аргачлалыг тэдгээр арга, аргачлалыг ашигласан цаг хугацаатай холбогдуулан судалж үзсэн нь ашгийн бус салбар дахь терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах эрсдэлийн талаар илүү сайн ойлголттой болоход хувь нэмрээ оруулсан. Таслан зогсоох арга, аргачлал тэдгээрийн давтамжийг дараахь байдлаар тоймлон ангилав:

Зураг 5.1 Таслан зогсоох арга, аргачлал-Ажиглагдсан давтамж

Таслан зогсоох арга, аргачлал	Ажиглагдсан давтамж
Салбарын ухуулга сурталчилгаа хийх, боловсрол олгох, өөрийгөө хянах	20%
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	27%
Захиргааны албадлага, шийтгэл, зорилтот хориг арга хэмжээ	71%

Тэмдэглэл: Зарим кейс тохиолдолд таслан зогсоох хэд хэдэн аргыг хэрэглэсэн байсныг харгалзан дээрх давтамжийн задаргааны нийлбэр 100 хувьд хүрэхгүй юм.

145. Нэгдүгээр бүлэгт танилцуулсан Терроризмын дэмжлэгийн континуум загвараас үзэхэд терроризмын дэмжлэг олон янзын үйл ажиллагааг хамарч болдог. Энэхүү загварыг кейс тохиолдлын судалгаагаар тодорхойлсон таслан зогсоох арга, аргачлалыг дүрслэн тайлбарлахад энд ашиглав (Зураг 5.2-ыг үзнэ үү). Континуумын доод хэсэгт терроризмыг дэмжих үйл ажиллагаа бага нөлөөлөл үзүүлж, талуудын оролцооны түвшин илүү идэвхгүй талдаа байна. Үүний нэг адил, хамтран оролцсон түвшний хувьд континуумын доод хэсэг хууль бус үйл ажиллагаанд оролцоогүй талыг төлөөлнө⁸⁴. Харин континуумын эсрэг талд өндөр нөлөөлөл бүхий санаатай үйлдсэн хууль бусаар ашигласан тохиолдлыг төлөөлнө.


146. Континуумын доод төгсгөлд байх кейс тохиолдлыг салбарын ухуулга сурталчилгаа, боловсрол, өөрийгөө хянах зэрэг аргаар таслан зогсоосон. Таслан зогсоох эдгээр арга нь шинж чанарын хувьд бага түвэг учруулах тул хууль ёсны АББ-

⁸⁴ Холбоотой талууд нь энд ашигласан таслан зогсоох арга, аргачлалд халдашгүй байх магадлалтай тул континуумын дагуу цааш үргэлжлэх юм.

ын үйл ажиллагааг таслан зогсоох магадлал бага байх юм. Нөгөө талаар, өндөр нөлөөлөлтэй хууль бусаар ашигласан тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг илүү цочрол үүсгэх таслан зогсоох аргыг ашигласан. Шинжлэн судалсан кейс тохиолдлын дийлэнхи хувь нь эдгээрийн дунд байсан тул хууль бусаар ашигласан үйлдэл, ихээхэн эрсдэл бүхий тохиолдлыг захиргааны арга хэмжээгээр таслан зогсоосон. Континуумын дагуу үргэлжлэх хөдөлгөөн нь эрсдэлийг бууруулахад хууль бусаар ашигласан тодорхой үйлдлийг таслан зогсоох хүртэлх үйл явцыг дүрслэн харуулна.

147. Зураг 5.2-д Шинжлэн судалсан кейс тохиолдлыг хэрхэн, хаана таслан зогсоосныг тодорхойлж, континуумын дагуу шууд хамааруулан төлөөлж тэмдэглэсэн.

Зураг 5.2 Кейс тохиолдлын хувиарилалт



Тэмдэглэл: Энэхүү зураг дахь цэгүүдийн тоо нь тодорхой кейс тохиолдлыг илэрхийлэх зорилгогүй бөгөөд зөвхөн шууд хамаарлыг харуулна.

САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ, ӨӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

148. Зөвлөмж 8-ийн тайлбарт терроризмыг санхүүжүүлэх зорилгоор АББ-ыг хууль бусаар ашигласан үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх үр дүнтэй арга барилд салбарын ухуулга сурталчилгааны ажлыг багтаах ёстой гэж заасан. Кейс тохиолдлын судалгаагаар эдгээр төрлийн арга хэмжээ нь өндөр эрсдэлтэй үйл ажиллагааг хууль бусаар ашиглах үйлдэлд хүргэхээс нь өмнө таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх боломжтой гэдгийг харуулсан. Судалгаа дүн шинжилгээгээр энэ төрлийн арга хэмжээг тоон хэлбэрээр үзүүлэх гэж оролдоогүй; харин төр засгийн байгууллагууд болон төрийн бус оролцогчид, цагдаа, тагнуулын байгууллага, АББ-ын хянан шалгагч зэрэг бүхий л оролцогч талууд ухуулга сурталчилгаа хийх, мэдлэг боловсрол олгох ажилд оролцох боломжтой юм. Энэ төрлийн арга хэмжээ нь хамгийн өргөн хүрээнд олон нийтэд хүрэх боломжтой байдаг.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

149. Континуумын нөгөө талын төгсгөлд, хамтран оролцсон асуудал илүү тодорхой байх кейс тохиолдлууд орно. Континуумын шугамын дагуу аль нэг цэгт гэмт хэргийн босгыг давах болдог гэдгийг ойлгох нь чухал. Яг энэ цэгт хууль сахиулах байгууллага, шүүх нь голлох эрх бүхий байгууллагын үүргийг гүйцэтгэнэ. Шинжлэн судалсан кейс тохиолдлын 27 хувьд АББ-ын оролцоотой терроризмтой холбоотой хууль бусаар ашигласан үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа, шүүхээр ял шийтгэл оногдуулах үндэслэлийг олгосон. Таслан зогсоох энэ арга хэмжээнд хууль сахиулах ажиллагаа, эрүүгийн хэрэг үүсгэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн кейс тохиолдлыг хамарна.

150. Дараах кейс тохиолдлыг шинжлэн судлахад байгууллагатай холбогдох удирдах албан тушаалтнууд түүнийг хууль бусаар ашиглаж байсантай холбогдуулан ял оногдуулсан. Түүнчлэн хууль бусаар ашигласан үйлдлийг таслан зогсоох, цаашид хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг авсан.⁸⁵

Кейс тохиолдол 40

Таслан зогсоох арга, аргачлал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Америкийн исламын тусламжийн байгууллага (IARA, өмнө нь Африкийн исламын тусламжийн байгууллага байсан) нь Судан Улсын Хартум хотод байрладаг олон улсын төв байртай Исламын буяны байгууллага байв. Тус байгууллагын АНУ дахь салбарын (IARA-USA) төв байр нь Миссури мужийн Колумбия хотод байрладаг

⁸⁵ Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг ашиглах талаар "Захиргааны албадлага, шийтгэл, зорилтот хориг арга хэмжээ" хэсэгт илүү дэлгэрэнгүй талбарласан.

байв. Тус байгууллагын АНУ дахь салбар нь тус улсын татварын хууль тогтоомжийн 501(c)(3) хэсэгт заасны дагуу татвараас чөлөөлөгдсөн буяны ашгийн бус байгууллагаар бүртгэгдсэн байв.

2004 оны 10 дугаар сарын 13-ны өдөр, АНУ-ын Сангийн яамны 13224 дугаар тогтоолын дагуу IARA болон түүний олон улсын таван төлөөлөгчийг жагсаалтад орсон террорист байгууллагууд, түүний дотор «Аль-Каида»-гийн хяналтад байдаг, тэдгээрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг этгээдийн жагсаалтад оруулжээ. IARA нь «Аль-Каида»-гийн өмнөх байгууллага болох «Мактаб Аль-ХидаMAT» (МК) байгууллагатай албан ёсны холбоотой байсан бөгөөд түүний үүсгэн байгуулагч, санхүүжүүлэгчдийн нэг нь Осама бин Ладен байв. Хүлээн авсан баримтууд нь Америкийн исламын тусламжийн байгууллага (IARA), «Мактаб Аль-ХидаMAT», Осама бин Ладен нарын хооронд 1997 оноос эхлэн хэдэн жилийн туршид нягт хамтран ажилласан болохыг илтгэж байв. 2000 онд IARA-ийн Афганистаны удирдагчдын нэг «Мактаб аль-ХидаMAT» байгууллагын Афганистан Улс дахь удирдагчтай хамт Судан болон Ойрхи Дорнодын бусад улс орнуудад очиж, «Мактаб Аль-ХидаMAT»-ын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 5 сая ам.долларын хандивыг цуглуулсан байв. Нэмэлт мэдээлэлд дурдсанаар Америкийн исламын тусламжийн байгууллагын тэргүүн нь Осама бин Ладеныг аюулгүй хоргодох байранд шилжүүлэх зорилгоор яриа хэлэлцээ хийж байсан бөгөөд үүнд мөн Бин Ладены өөрийнх нь төлөөлөгчид «Мактаб аль-ХидаMAT», «Лажнат Аль-Дава» байгууллагаас оролцсон байв. Түүнчлэн нэгэн Судан Улсын иргэн Мали Улс руу зорчиж, тэнд IARA-ийн захирлын хамт Бин Ладенд хоргодох байр хайсан байв. Мөн ирүүлсэн баримт нотолгоогоор 2003 оны эхээр Америкийн исламын тусламжийн байгууллага (IARA) нь Баруун Европын нэг улсад «Хамас» хөдөлгөөний төлөөлөгч, зуучлагчийн үүргийг гүйцэтгэж, террорист үйл ажиллагаанд зориулж Палестины нутаг дэвсгэр рүү хөрөнгө шилжүүлдэг байжээ. Хөрөнгө босгох ажилд "Аллах", "Израил" гэсэн нэр бүхий хандивын хайрцгийг ашиглаж байсан бөгөөд энэ нь мөнгийг израильчуудын эсрэг үйлдэх террорист халдлагад зарцуулагдах болно гэдгийг илтгэсэн хэрэг байв.

Америкийн исламын тусламжийн байгууллагыг террорист байгууллагын жагсаалтад оруулснаас гадна IARA-ийн АНУ дахь салбартай холбоотой хэд хэдэн хүнд тус улсын хууль тогтоомжийг зөрчсөн хэргээр ял оногдуулжээ. 2005-2007 онд IARA нь түүнийг террорист байгууллагын жагсаалтад оруулсан шийдвэрийг эсэргүүцэж давж заалдсан нь амжилтгүй болсон бөгөөд уг хэрэг нь холбооны тойрогт болон давж заалдах шатны шүүхэд ялагдсан.

IARA-ийн АНУ дахь салбар нь Америкийн иргэдийн "аюул заналхийлэл учруулах" улс орнуудтай хийх худалдааг хязгаарласан АНУ-ын Хуулийн дагуу (IEEPA хууль) Ирак Улс руу мөнгө эсхүл бараа бүтээгдэхүүнийг зөвшөөрөлгүйгээр шууд болон шууд бусаар дамжуулах, эсхүл шилжүүлэхийг хориглосон хориг арга хэмжээг зөрчсөн. Ирак Улсын эсрэг авсан хориг арга хэмжээг бүхэлд нь зөрчиж, IARA нь Ирак Улс дахь төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор товхимол, хэвлэмэл

сурталчилгааны материал, мэдээллийн товхимол, хувийн захидал тараах зэрэг аргаар мөнгө хандивлахыг уриалсан байв.

2010 оны 6 дугаар сард АНУ-ын иргэншилтэй, IARA-ийн АНУ-ын салбарын Гүйцэтгэх захирал асан шүүгдэгч Мубарак Хамед нь IEEPA-ийн хуулийг зөрчиж, татварын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд саад учруулсан хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Гүйцэтгэх захирлын хувьд Хамед нь тухайн улсын эсрэг авсан хориг арга хэмжээ хэрэгжиж байх үед Ирак дахь төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлыг хариуцдаг байв. Хамед 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2004 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хооронд IARA-ийн АНУ дахь салбарын татвараас чөлөөгдсөн статусыг ашиглан татварын тухай хууль тогтоомжийг зөрчсөн (АНУ-ын татварын тухай хуулийн 501(c)(3) хэсэгт заасны дагуу) гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Тэрбээр босгосон хөрөнгөө хууль ёсны буяны хандив хэмээн мэдүүлж, түүний зарим хэсгийг хууль бусаар Ирак Улс руу шилжүүлсэн байв. Хамид мөн Холбооны татварын албанд IARA-гийн АНУ дахь салбараас явуулсан татварын тайланд Ирак дахь хувь хүн, хуулийн этгээдтэй хийсэн гүйлгээний мэдээлэл, IARA-ийн АНУ дахь салбарын удирдлага, хяналтын бүтэц, түүний түүх, харилцааны талаархи мэдээллийг тусгаагүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн.

2010 оны 4 дүгээр сард АНУ-ын иргэншилтэй, шүүгдэгч Али Мохамед Багегни нь 1991-2004 оны хооронд IEEPA-аас тавьсан хориг арга хэмжээг зөрчсөн хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Багегни нь IARA-ийн АНУ дахь салбартай холбоотой байсан бөгөөд тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг захирлуудын зөвлөлд ажилладаг байв.

2010 оны 7 дугаар сард шүүгдэгч Абдель Азим Эл-Сиддиг нь гадаадын төлөөлөгчдийг бүртгэх тухай хуулийг зөрчсөн хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Тэрбээр шүүгдэгч Силжандер болон Хамед нартай Силжандерийг гадаадын байгууллагын төлөөлөгч болгон ашиглахаар хуйвалдсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Эл-Сиддиг нь Силжандерыг Ерөнхий прокурорт бүртгүүлээгүй байсан тул түүний үйлдэл хууль бус гэдгийг мэдэж байсан. Түүнчлэн уг үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагад мэдэгдээгүй бөгөөд Силжандерын үйлчилгээнд зориулж АНУ-ын засгийн газраас төлбөр хүлээн авсан баримтыг нуусан байв.

2009 оны 12 дугаар сарын 17-нд АНУ-д хууль ёсоор байнга оршин суудаг Ирак Улсын иргэн Ахмад Мустафа нь АНУ-ын хориг арга хэмжээг зөрчиж Ирак Улс руу хууль бусаар мөнгө шилжүүлсэн хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Мустафа нь IARA-т хандивын мөнгийг цуглуулдаг хөрөнгө босгогчоор ажиллаж байсан бөгөөд Америк даяар зорчиж буяны хандив үзүүлэхийг уриалдаг байжээ.

ЗАХИРГААНЫ АРГА ХЭМЖЭЭ, ТОРГУУЛЬ, ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

151. Энэ ангилалд орсон таслан зогсоох арга хэмжээ нь голдуу захиргааны шинж чанартай байсан бөгөөд АББ-тай холбоотой үүрэг хариуцлагыг хүлээсэн хяналт, шалгалт, удирдлагын байгууллагыг оролцуулсан байв. Энэ ангилалд ашгийн бус салбарыг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах эрсдэлтэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулсан захиргааны тогтолцоог АББ-ууд сайн дураараа эсхүл өөр хэлбэрээр хэрэгжилтийг хангах замаар хууль бусаар ашигласан үйлдэл, эрсдэлийг шийдвэрлэхэд чиглэсэн хяналт нийцүүлэлтийн арга хэмжээг багтаасан. Шинжлэн судалсан кейс тохиолдлын 71 хувьд энэ ангилалд орсон нэг эсхүл хэд хэдэн аргыг хэрэглэсэн байв.

152. Энэ ангилалд мөн террорист үйл ажиллагааг дэмжигчид хэмээн тодорхойлсон байгууллагын хөрөнгийн нөөцийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор олон улсын болон үндэсний тогтолцооны зорилтот хориг арга хэмжээг багтаасан. ФАТФ-ын Зөвлөмж 6 нь зорилтот хориг арга хэмжээг ашиглахыг дэмждэг, энэ нь мөн олон улсын хэмжэээнд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолоор, ялангуяа 1267, 1373 тогтоолоор баталгаажсан. *Зураг 5.3-т* захиргааны албадлага, шийтгэл, хориг арга хэмжээ гэсэн бүлэгт орсон арга хэмжээний жагсаалтыг оруулав.

Зураг 5.3: Таслан зогсоох арга, аргачлал - Захиргааны албадлага, шийтгэл, хориг арга хэмжээ

Таслан зогсоох арга, аргачлал-Захиргааны албадлага, шийтгэл, зорилтот хориг арга хэмжээ	
Хяналт шалгалтын хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> • Хяналтын эрх бүхий байгууллагаас холбогдох АББ-д өөрсдийн анхааралд орсон асуудлыг тусгасан, тухайн АББ-д уг асуудлыг шийдвэрлэх боломжийг олгосон албан бичгийг хүргүүлнэ. • Хянан магадлагааны нийцүүлэлт, хариуцлагын хэм хэмжээг илүү хатуу мөрдүүлэх зорилгоор хяналтын байгууллагатай нийцүүлэлтийн гэрээ байгуулна.
Албадлагын арга хэмжээ (эрх бүхий байгууллагаас)	<ul style="list-style-type: none"> • АББ-ыг бүртгэхээс татгалзах • АББ-ын үйл ажиллагааг түр зогсоох • АББ-ын мэдээлэлтэйгээр АББ-ын үйл ажиллагааг хянах • АББ-ын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх • АББ-д аудит хийх • АББ-д санхүүгийн торгууль оногдуулах • АББ-ын эд хөрөнгийг хурааж авах
Зорилтот хориг арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> • АББ-ыг терроризмыг дэмжигчдийн жагсаалтад оруулах • АББ данс, хөрөнгийг царцаах

153. Нууц мэдээлэл агуулаагүй дараах кейс тохиолдлын судалгаанд терроризмын зорилгоор АББ-ын хөрөнгийг хууль бусаар ашиглаж байсан үйлдлийг таслан зогсооход захиргааны арга хэмжээ, зорилтот хориг арга хэмжээг ашигласан.

Кейс тохиолдол 41¹

Таслан зогсоох арга, аргачлал

Захиргааны албадлага, торгууль

Гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах Иерусалимын сан (JFHS) нь Палестин Улсын газар нутаг дахь түнш байгууллагаараа дамжуулан хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зорилготой 1992 онд байгуулагджээ. 1992 онд JFHS нь Канад Улсын буяны байгууллагуудын үндэсний хяналтын байгууллага болох Канад Улсын татварын алба (CRA)-нд буяны байгууллагаар бүртгүүлэх хүсэлт гаргажээ. CRA-аас өргөдлийг хянаж үзэх явцад JFHS-ийн зорилго, үйл ажиллагаа нь Канад Улсын хууль тогтоомжийн дагуу буяны үйл ажиллагаатай холбоогүй, үндсэндээ улс төрийн шинж чанартай байсан нь анхаарал татжээ. Түүнчлэн JFHS-ийн Палестин Улсын газар нутагт хамтран ажилладаг түнш байгууллага нь Канад Улсын хууль тогтоомжийн дагуу түүний хууль ёсны тусламжийг хүлээн авагчид биш байв. Нээлттэй эх сурвалжийн мэдээллээс үзэхэд JFHS-ийн олон улсын түншийн зарим нь Канад Улсад террорист байгууллагын жагсаалтад орсон «Хамас» хөдөлгөөний удирдлагад үйл ажиллагаа явуулдаг хөрөнгө босгох сүлжээнд ордог байсныг илтгэж байв.² CRA-тай олон удаа харилцахдаа Иерусалимын тусламжийн сан нь хуульд заасан шаардлагын дагуу өөрийн хөрөнгө нөөцийг зохистой удирдлага, хяналтаар хангах чадвартай гэдгээ харуулж чадаагүй байна.

1998 онд Канад Улсын татварын алба (CRA)-наас JFHS-ийг бүртгэх боломжгүй гэж мэдэгджээ. Энэхүү мэдэгдлийн дараа удалгүй Канад Улс дахь Гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах олон улсын сан (IRFAN-Canada) гэх хоёрдахь АББ-аас бүртгүүлэх хүсэлт гаргажээ. 1999 онд IRFAN-Canada-ийн хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн бол JFHS нь өөрийгөө бүртгүүлэх гэсэн оролдлогоо үргэлжлүүлсээр байв. 2000 онд CRA-аас JFHS-ийг бүртгэх боломжгүй гэж дахин мэдэгдсэний дараа JFHS нь хүсэлтээ буцаасан байна. Үүний дараа Канад Улс татварын албанд мэдэгдэлгүйгээр JFHS нь өөрийн хөрөнгийг IRFAN-Canada-д шилжүүлсэн. Хоёр байгууллага хоёулаа үйл ажиллагаагаа албан ёсоор нэгтгэхээр шийдэж, JFHS-ийн хэд хэдэн удирдах албан тушаалтан IRFAN-Canada-ийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдаж эхэлжээ.

2003 онд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр JFHS болон IRFAN-Canada-г нэгдсэн тухай, мөн IRFAN-Canada-г «Хамас»-тай холбоотой гэсэн мэдээлэл гарчээ. Канад Улсын татварын албанаас IRFAN-Canada-ийн заавал илтгэх жилийн тайланд хийсэн дүн шинжилгээгээр эдгээр асуудлыг улам бататгаж өгчээ. 2003 оны сүүлчээр CRA-аас IRFAN-Canada-д аудитын шалгалт хийж, хянан нийцүүлэлтийн шаардлагыг хангаагүй хэд хэдэн ноцтой зөрчлийг илрүүлжээ. IRFAN-Canada нь

зохих хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөрөнгийн эцсийн зориулалтыг тооцолгүйгээр гадны байгууллагад их хэмжээний хөрөнгийг шилжүүлсэн байв. Тэдгээр гадны байгууллагын зарим нь «Хамас»-ын хяналтад байдаг гэж үздэг байв. Тус байгууллага хянан магадлагааны нийцүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсний дараа IRFAN-Canada-ийн бүртгэлийг хэвээр үлдээсэн байна.

2009 онд Канад Улсын татварын албанаас 2003 онд тодорхойлсон алдаа дутагдлыг арилгасан эсэхийг нь баталгаажуулах зорилгоор IRFAN-Canada-д дахин шалгалт хийжээ. CRA нь IRFAN-Canada-ийн орон нутаг болон олон улс дахь ажлын байрнаас нь авсан санхүүгийн бүртгэл, дижитал бүртгэлийн мэдээлэл болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн баримт бичгийг шалгасан. Эдгээр баримтыг нээлттэй эх сурвалжийн мэдээлэл болон түнш байгууллагуудаас өгсөн тоо баримттай нэгтгэжээ.³

CRA-аас 2009 онд IRFAN-Canada-д хийсэн аудитын шалгалтаар хянан магадлагааны нийцүүлэлтийн шаардлагыг хангаагүй дараахь ноцтой зөрчлийг илрүүлсэн:

- 2006 оны 3 дугаар сараас 2007 оны 4 дүгээр сар хүртэл IRFAN-Canada нь орон нутгийн түншээрээ дамжуулан «Хамас»-ын байлдагчдын гэр бүлд мөнгө тараах ажилд холбоотой байсан Газа дахь “Хамас”-ын хяналттай Харилцаа холбооны яаманд 500,000 гаруй ам.долларыг шилжүүлсэн бөгөөд энэ зорилгоор шуудангийн үйлчилгээг ашигласан байв.
- Мөн энэ хугацаанд IRFAN-Canada нь орон нутгийн түншээрээ дамжуулан Газа дахь «Хамас»-ын хяналттай Эрүүл мэндийн яаманд 160,000 гаруй ам.долларыг шилжүүлсэн.
- IRFAN-Canada нь «Рамалла Закат» Хороог үргэлжлүүлэн санхүүжүүлж байсан бөгөөд 2007 онд тус Хороонд 77,000 гаруй ам.долларыг хуваарилсан байв. 1998, 2004 онд Канад Улсын татварын албанаас тус Хороог «Хамас» хөдөлгөөнтэй холбоотой гэж үздэгийг IRFAN-Canada-д анхааруулж мэдэгдсэн байв. Үүний хариуд IRFAN-Canada 2004 онд дээрх Хороотой хамтын ажиллагаагаа зогсоосон гэж мэдээлжээ. Гэхдээ аудитын шалгалтын баримтууд CRA-аас явуулсан эхний шалгалт дууссанаас хойш нэг сарын дараа тус Хороотой харилцаагаа дахин сэргээснийг илтгэж байв.
- 2007 онд IRFAN-Canada нь «Аль-Мунтада Ал-Тахкафи»-ийн Соёлын форумын төв байранд Израилийн цэргүүд дайралт хийсний дараа тус байгууллагад шинэ компьютер, албан тасалгааны тоног төхөөрөмжийг хандивлажээ. Тус байгууллага нь «Хамас»-тай нягт холбоотой байсан тул Израил Улсад хууль бус нийгэмлэгээр зарласан байв. Хандивласан тоног төхөөрөмжийн өртөг 15,000 гаруй ам.доллар байсан.

• 2007 онд IRFAN-Canada нь Израил Улсад Хамасыг дэмждэг байгууллагын жагсаалтад орсон Ливан Улсад байрладаг «Закат» санд 8.6 сая гаруй ам.долларын хөрөнгийг олгосон.

Түүнчлэн шалгалтын явцад олж авсан баримтууд нь Иордан голын Баруун эрэгт байрлах IRFAN-Canada-ийн салбарын удирдлага, тэрбээр байгууллагын дансанд нэвтрэх эрхтэй байсан, IRFAN-Canada-ын хөрөнгө болох 100,000 гаруй ам.долларыг хууль бусаар завшсаныг тогтоосон. Уг удирдах албан тушаалтан нь «Хамас»-тай холбоотой байв.

2009 онд хийсэн шалгалтын үр дүнд үндэслэн 2011 онд Канад Улсын татварын албанаас эхлээд IRFAN-Canada-ийн буяны байгууллагын бүртгэлийг түдгэлзүүлж, дараа нь цуцалсан.

2014 онд Канад Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу болон мөн CRA-аас тус байгууллагыг террорист байгууллагын жагсаалтад орсон «Хамас» хөдөлгөөнд дэмжлэг үзүүлж байсныг олж тогтоосон баримтад үндэслэж Канад Улсын Засгийн газраас IRFAN-Canada-г террорист байгууллагын жагсаалтад оруулсан.

Тэмдэглэл:

1. Энэхүү кейс тохиолдлын судалгааг зөвхөн нээлттэй эх сурвалжаас авсан материалын үндсэн дээр боловсруулсан бөгөөд түүнийг эмхэтгэхэд улс орны асуулгын хариултыг ашиглаагүй болно. 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Канад Улсын татварын албаас IRFAN-Canada руу явуулсан байгууллагыг зохих удирдлагаар хангах шаардлагын тухай захидлыг үзнэ үү. www.globalphilanthropy.cf/index.php/blog/commnts/international_releif_fund_for_the_afflicted_and_needycanada_irfan_canada_h, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан.
2. Аль-Мукавама Аль-Исламия (Хамас). Олон нийтийн аюулгүй байдал, онцгой байдлын бэлэн байдлыг хангах тухай Канад Улс дахь цахим хуудсыг үзнэ үү: <http://www.publicsafety.gc.ca/cnt/ntnl-scr/contr-trrrsm/lstd-ntts/crmt-lstd-ntts-eng.aspx>, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
3. "Гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах олон улсын сан (Канад) болон Канад Улс (Канад Улсын татварын алба)", 2013 оны Холбооны давж заалдах шатны шүүх 178 [хавтас А-20-13] <https://www.canlii.org/en/ca/fac/doc/2013/2013fca178/2013fca178.html>, 2014 оны 6 дугаар сарын 18-нд цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

ДҮГНЭЛТ

154. Төслийн явцад цуглуулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр эрх бүхий байгууллагууд АББ-ын салбарыг хууль бусаар ашигласан тохиолдлыг таслан зогсоход болон түүнийг хууль бусаар ашиглах эрсдлийг бууруулахад өргөн хүрээний арга хэмжээг ашигладаг болохыг харуулж байна. Янз бүрийн шатанд холбогдох тохиромжтой аргыг ашигласан. Кейс тохиолдлын судалгаанаас тухайн байгууллагатай холбоотой тодорхой нөхцөл байдал, зарим тохиолдолд түүний удирдлагын оролцооны түвшин нь хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох ямар аргыг хэрэглэхэд хамгийн тохиромжтой болохыг тодорхойлдог гэдгийг харуулж байна. Бага хэмжээний сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд АББ-ын үйл ажиллагаанд хамгийн бага хэмжээгээр саад учруулах арга хэмжээг ихэвчлэн ашигладаг байсан. Эсрэгээр нь сөрөг нөлөөлөл ихтэй, ялангуяа АББ-ын удирдлагын оролцоотой тохиолдолд хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох илүү хатуу арга хэмжээг хэрэглэх шаардлагатай байв. Ерөнхийдөө шинжлэн судалсан кейс тохиолдлууд

АББ-ыг хууль бусаар ашигласан тохиолдлыг амжилттай таслан зогсооход эрх бүхий байгууллагын эрсдэлийн шинж чанарын талаархи ойлголтоос хамаардаг болохыг харуулж байна. Хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох арга, аргачлалтай холбоотой судалгааны үр дүнд нийцүүлэн кейс тохиолдлын судалгаа нь байгууллага хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоход чиглэсэн нэгдсэн арга барилыг ашиглах нь АББ-ын салбарыг хууль бусаар ашигласан үйлдлийг таслан зогсоох зохих аргыг сонгож, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ



ТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГУУД АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЭРСДЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

155. Шалгуур үзүүлэлтүүдийг урьдчилан сэргийлэх нь хамгийн чухал ач холбогдолтой салбарууд болох бизнес, анагаах ухааны салбар зэрэгт өргөнөөр ашигладаг.⁸⁶ Шалгуур үзүүлэлтүүд нь сэрэмжлүүлгийг нэмэгдүүлж, эрсдэлийг бодит болохоос нь өмнө бууруулахад туслах эсхүл хууль бусаар ашиглаж байсан үйлдлийг илрүүлэхэд тусалж чадна. Кейс тохиолдлын судалгаа дүн шинжилгээгээр АББ-ыг хууль бусаар ашиглаж байсан буюу хууль бусаар ашиглах ноцтой эрсдэл байгааг илтгэсэн олон бүрэлдэхүүн хэсгийг олж тогтоосон. Эдгээр бүрэлдэхүүн хэсгийг АББ, Засгийн газрын оролцогч талууд, санхүүгийн байгууллагууд, санхүүгийн бус бизнес эрхлэгчид эсхүл мэргэжлийн байгууллагууд (DNFBPs) зэрэг оролцогч бүх талуудад тодорхой нэг АББ эсхүл ашгийн бус салбарт бүхэлд нь хууль бусаар ашигласан байж болзошгүй хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахад нь туслах зорилгоор энэхүү бүлэгт нэгтгэсэн. Хэдийгээр энд танилцуулсан шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалт нь бодитой бөгөөд үндэстэн дамнасан шинж чанартай ч энэ нь бүрэн гүйцэд биш юм; ФАТФ-ын Зөвлөмж 1 (үндэсний эрсдэлийн үнэлгээ)-ийн дагуу тодорхой нэг улсын эрх мэдлийн хүрээнд тогтоосон тодорхой нөхцөл байдалд өвөрмөц нэмэлт шалгуур үзүүлэлт байх боломжтой юм.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНДСЭН ШИНЖ

156. Шалгуур үзүүлэлт нь үндсэндээ хууль бусаар ашигласан үйлдлийн мөн чанар, түүний эрсдэлийг үнэлэхийн тулд нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийх шаардлагатай болгодог сэжүүр юм. Тиймээс ч бүх шалгуур үзүүлэлтүүд терроризмтой холбоотой эрсдэлд адилхан өндөр баталгааг өгдөггүй нь кейс тохиолдлын судалгаанаас тодорхой харагдаж байна. "Эрсдэлийн шалгуур үзүүлэлт" гэх олон шалгуур үзүүлэлтийн хувьд терроризмд дэмжлэг үзүүлэх гэдэг боломжит тайлбар байх хэдий ч энэ нь цорын ганц боломжит тайлбар байх албагүй юм. "Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт" гэсэн арай цомхон дэд шалгуур үзүүлэлт нь терроризмтой холбоотой үйл ажиллагаатай илүү ойр харилцаа холбоог заах юм. Зураг 6.1-т эдгээр хоёр төрлийн шалгуур үзүүлэлтийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн.

Зураг 6.1: Эрсдэлийн шалгуур үзүүлэлт, терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт

 Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	 Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
---	--

⁸⁶ Жонатан Дейвис (Davies, Jonathan), Майк Финли (Finlay, Mike), Тара Мак-Ленаген (McLenaghan, Tara) болон Дункан Уилсон (Wilson, Duncan) (2006 он), мөн Ричард Р.Балсамо (Balsamo, Richard R) болон Макс Дуглас Браун (Brown, Max Douglas) (2007 он) нарыг үзнэ үү, х.285-304.


<p>АББ-ын үйл ажиллагааны нэг чиглэл нь түүнийг террорист зорилгоор хууль бусаар ашиглах эсхүл хууль бусаар ашиглах эрсдэл байгааг илэрхийлж болох бөгөөд мөн түүнийг өөрөөр бас тайлбарлаж болох юм.</p>	<p>Террорист үйл ажиллагаатай шууд холбоотой, түүнийг хууль бусаар ашиглах эсхүл хууль бусаар ашиглах эрсдэл байгааг илэрхийлсэн АББ-ын үйл ажиллагааны нэг чиглэл нь юм. Ийм шалгуур үзүүлэлт байх нь бусад хувилбартай харьцуулахад хууль бусаар ашигласан үйлдэл эсхүл эрсдэлийг терроризмтой холбоотой гэдгийг улам баталгаажуулж өгнө.</p>
---	---


157. Мэдээллийн төрлөөс хамааран олон төрлийн шалгуур үзүүлэлтийг өөр өөр оролцогч талууд илрүүлж болно. Тухайлбал, төр засгийн газрын байгууллагууд, тэр дундаа СМА нь санхүүгийн мэдээлэлд хандах боломжтой тул санхүүгийн гүйлгээг зохион байгуулдаг АББ-ууддыг олж илрүүлэх илүү боломжтой байдаг. Үүнтэй адил АББ-ууд нь дотоод бүртгэлдээ чөлөөтэй нэвтрэх боломжтой тул хөрөнгийн зориулалтыг өөрчилснийг илрүүлэх илүү боломжтой байдаг. Гэхдээ, хянан шалгагч аудитын шалгалтын явцад мөн эдгээр бүртгэлд нэвтрэх эрхийг авах боломжтой.

158. Эцэст нь шалгуур үзүүлэлтүүд нь цаашдын судалгаа дүн шинжилгээний сэжүүр байдаг тул шалгуур үзүүлэлтийг тодорхой хэргийн нөхцөл байдлын хүрээнд авч үзэх шаардлагатай. Зарим тохиолдолд ганц шалгуур үзүүлэлт эсхүл цөөн тооны шалгуур үзүүлэлт нь томоохон мөрдөн шалгах ажиллагааг өдөөхөд хангалттай байж болох юм. Доор дурдсан кейс тохиолдолд хэргийн нөхцөл байдал, хоёр шалгуур үзүүлэлтийн мөн чанар нь энэ тохиолдолд ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглаж байсан үйлдэл нь терроризмтой холбоотой гэж үнэлэхэд хангалттай байсан.

Кейс тохиолдол 100

Өнчин хүүхдэд тусламж үзүүлдэг ашгийн бус байгууллагын хаягийг байрлуулсан байшинд гар хийцийн тэсрэх төхөөрөмж дэлбэрчээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар бодит байдалд ямар нэгэн АББ байдаггүй байсныг илрүүлж, террорист бүлэглэл өөрсдийн тэсрэх төхөөрөмж хийдэг үйлдвэрээ ашгийн бус байгууллагын албан байр мэт харагдахаар нуун дарагдуулсныг илрүүлжээ.

Хууль сахиулах байгууллагаас тэсрэх төхөөрөмж, зэвсэг үйлдвэрлэх зориулалттай их хэмжээний эд зүйлсийг хураан авчээ. Уг террорист бүлэглэлийн нэг гишүүнийг терроризмтой холбоотой гэмт хэрэгт буруутгаж, ял шийтгэл оногдуулсан.  Террорист ажиллагаатай холбоотой гэмт хэргийн үйл ажиллагааг АББ-ын барилга байгууламжид нуун дарагдуулсан.

 Байгуулсан АББ нь хуурамч байсан.

159. Бусад тохиолдолд хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг хослуулан хэрэглэх нь АББ-ыг хууль бусаар ашигласан үйлдэл, эрсдэл нь терроризмтой холбоотой гэж үнэлэхэд хүргэж болохыг дараахь кейс тохиолдлын судалгаа харуулж байна. Энэ тохиолдолд эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүд нь өөрсдөө ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглаж болохыг заадаг боловч АББ-ыг ямар зорилгоор хууль бусаар ашиглах нь тодорхойгүй хэвээр байна. Энэхүү гурван шалгуур үзүүлэлтийг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлттэй хослуулахад хууль бусаар ашиглах үйлдэл буюу эрсдэл нь терроризмтой холбоотой болох нь илүү тодорхой болох юм.

Кейс тохиолдол 68

2005 оны 6 дугаар сард Хойд Америкийн Исламын нийгэмлэгийн хөгжлийн сан (IDF) нь буяны байгууллагуудын үйл ажиллагааг хянадаг үндэсний байгууллага болох Канад Улсын татварын алба (CRA)-нд буяны байгууллага нэрээр бүртгэгджээ. Уг бүртгүүлсэн сангийн (IDF) гол зорилго нь Канад Улсад шашны байгууллага байгуулах, тэдгээрийг үйл ажиллагааг удирдах замаар шашныг дэлгэрүүлэх, мөн Канад Улсад тусламж хэрэгтэй хүмүүст санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн ядуу давхаргад туслах явдал байв.

2011 оны 1 дүгээр сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр IDF-ийн толгой байгууллага болох Хойд Америкийн Исламын Нийгэмлэг (ISNA)-т хийсэн хараат бус, дотоодын аудитын үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлсэн. Шалгалтын үр дүнгээр ISNA нь хөрөнгө нөөцийг хууль бусаар ашигласан, ялангуяа зохимжгүй хүлээн авагчдад мөнгө шилжүүлсэн, хандивын хөрөнгийг хууль бус баримтаар олгосон, бүртгэгдсэн буяны байгууллагын удирдлагын талаарх Канад Улсыг хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний хөрөнгө хуваарилсантай холбоотой ноцтой асуудлуудыг илрүүлсэн байна. Түүнчлэн их хэмжээний хөрөнгө нөөцийг Канад Улсын өөр нэг АББ болох Канад Улс дахь Кашмирт тусламж үзүүлэх сан (KFPC)-д, Кашмирт үйл ажиллагаа явуулах нэрээр шилжүүлсэн байв.

2011 оны 12 дугаар сард Канад Улсын татварын албанаас IDF-ийн үйл ажиллагаанд шалгалт хийжээ. Шалгалтаар IFC нь KFPC болон түүний харьяа байгууллага болох Кашмир-Канадын Зөвлөл (KCC)-тэй санхүүжилтийн гэрээ байгуулж, цуглуулсан хөрөнгөө Кашмирын мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (ROKM) гэж нэрлэгддэг Пакистаны ашгийн бус байгууллагад явуулах зорилготой байсан. Энэхүү гэрээний дагуу KCC/KRFC нь Кашмирт "туслах" зорилгоор хөрөнгө босгосон бөгөөд IDF нь донор хандивлагчдад хандив хүлээж авсан тухай албан ёсны бичгийг өгч, цуглуулсан 250,000 гаруй ам.долларын хандивыг Кашмирийн мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (ROKM)-д шууд буюу KSS/KRFC-ээр дамжуулан олгосон байв. Хойд Америкийн Исламын нийгэмлэгийн хөгжлийн сан (IDF)-д хийсэн шалгалтаар түүний удирдлага ROKM болон/эсхүл санхүүжилтэд шилжүүлсэн хөрөнгийг чиглүүлэх үйл ажиллагааны талаар тодорхой ямар нэг зүйлийг огт мэдэхгүй гэж мэдүүлсэн байна. Нэмж дурдахад дээр дурдсан хандив цуглуулсан баримт олгох тохиролцоог Канад Улсын хууль тогтоомжийн дагуу хориглосон байдаг. Түүнээс гадна IDF нь шилжүүлсэн хөрөнгөө удирдлагаар

хангаж, хянах чадваргүй байсан бөгөөд түүний хөрөнгө нөөцийг хуваарилж, чиглүүлсэн хөтөлбөрийн мөн чанарыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй байна.

IDF-ийн цахим баримт бичгүүдэд хийсэн дүн шинжилгээ нь Канад Улсын татварын албанд IDF-ийн Кашмир дахь хөтөлбөр төслийг хянаж, удирдлагаар хангаж байгааг батлах баримт бичиг нь хуурамч байсныг олж тогтоох боломжийг олгосон. Тухайлбал, Канад Улсын Засгийн газраас Хойд Америкийн Исламын нийгэмлэгийн хөгжлийн сан (IDF)-ийн Кашмир дахь үйл ажиллагааг удирдлага, хяналтаар хангаж байгааг харуулсан гэрэл зурагт шүүх эмнэлгийн дүн шинжилгээ хийхэд эдгээр зургуудыг дижитал технологи ашиглан хуурамчаар үйлдэж IDF-ийн нэр бүхий тэмдэглэгээтэй дарцгийг нэмж оруулсан байв.

Канад Улсын татварын албаны судалгаа дүн шинжилгээ нь Кашмирын мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (ROKM) нь Жамаат-и-Ислами хөдөлгөөний буяны халхавч байгууллага байсныг илтгэсэн. Тус байгууллага нь өөрийн цэргийн жигүүр болох Хизбул Мужахидин байгууллагын дэмжлэгтэйгээр мөн Энэтхэгийн Жамму, Кашмир мужууд дахь эрх мэдлийг сулруулах зорилготой улс төрийн байгууллага байв. Хизбул Мужахидин нь Европын Холбооны Зөвлөлөөс террорист байгууллагуудын жагсаалтад багтсан бөгөөд Энэтхэг Улсын Дотоод хэргийн яамны 1967 оны Хууль бус үйлдлийн (урьдчилан сэргийлэх) тухай хуульд заасны дагуу хориг тавьсан террорист байгууллагаар зарлагдсан байв.

ROKM болон Жамаат-и-Исламигийн удирдлагын ижил төстэй байдал, эдгээр хүмүүсийн Хизбул Мужахидин байгууллагыг байгуулахад оролцсон, түүний үйл ажиллагааг дээд түвшинд хянадаг байсан, мөн эдгээр хүмүүсийн олонхи нь Кашмир дахь зэвсэгт хөдөлгөөнийг дэмжиж олон нийтэд мэдэгдэл гаргаж байсныг харгалзан CRA нь IDF-ийн хөрөнгө нөөцийг Жамаат-и-Ислами байгууллага болон/эсхүл түүний цэргийн жигүүр болох Хизбул Мужахидиний улс төрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигласан байж болзошгүй гэж үзэж анхаарлаа хандуулжээ.

Аудитын шалгалтын дүнд үндэслэн 2013 оны 9 дүгээр сард Хойд Америкийн исламын нийгэмлэгийн хөгжлийн сангийн (IDF) бүртгэлийг цуцалсан. Уг АББ-ын бүртгэлийг цуцалсан хэрэг нь Канад, АНУ, Энэтхэг зэрэг улсын олон хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол сэдэв болж гарсан. Үүний дараагаар мөн Кашмирын мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (ROKM)-ын цахим хуудсыг хаасан.

▢ АББ нь террорист байгууллагууд ихээр байдаг бүс нутаг/газар нутагт хөрөнгө нөөц шилжүүлсэн эсхүл үйл ажиллагаа явуулсан.

▢ АББ нь өөрийн үйл ажиллагаа, хөтөлбөр, түнш хамтрагчдынхаа талаар мэдэгдээгүй.

▢ АББ нь өөрийн бүх хөрөнгө нөөцийн эцсийн зориулалтыг тайлбарлаж чадаагүй.

▢ АББ эсхүл түүний төлөөлөгч хуурамч буюу зөрчилтэй баримт бичиг ашигласан.

⚠ АББ эсхүл түүний төлөөлөгч террорист ажиллагаанд оролцдог эсхүл түүнийг дэмждэг гуравдагч этгээдтэй холбоотой болохыг нотолсон (найдвартай) мэдээлэл байгаа эсэх.

Тэмдэглэл:

Энэхүү шинжлэн судалсан кейс тохиолдлыг зөвхөн олон нийтэд нээлттэй эх сурвалжийн баримт бичгээс боловсруулсан бөгөөд кейс тохиолдлын судалгаанд оролцсон аливаа нэг улсын мэдээллийг ашиглаагүй болно. Канад Улсын татварын албанаас 2013 оны 5 дугаар сарын 28-ны өдөр IDF-т явуулсан байгууллагын зохих менежментийг хангах шаардлагын тухай захидлыг үзнэ үү.

www.thestar.com/news/canada/2013/07/25/star_investigation_federal_audit_raises_concern_that_canadian_charity_funded_terror.html.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН АНГИЛАЛ

160. Кейс тохиолдлыг шинжлэн судлахад гарсан шалгуур үзүүлэлтүүдийг долоон ерөнхий ангилалд хуваасан. Гэхдээ олон шалгуур үзүүлэлт хэд хэдэн ангилалд орж болно. Ойлгоход хялбар болгох үүднээс энэхүү тайланд дүн шинжилгээг үндэслэн шалгуур үзүүлэлт тус бүрийг хамгийн тохиромжтой гэж үзсэн ангилалд зөвхөн нэг удаа оруулсан. Шалгуур үзүүлэлтийн ангилал нь АББ-ыг хууль бусаар ашиглах типологийн (арга хэлбэрийн) шууд тусгал болдоггүй, учир нь шалгуур үзүүлэлтийн олон төрөл зөвхөн нэг типологт орох боломжтой байдаг. Тухайлбал, *Хуурамч АББ байгуулах, төөрөгдүүлсэн төлөөлөл* гэсэн типологийн төрөлд бүх ангилалын шалгуур үзүүлэлтийг агуулсан байж болно. АББ-ыг хууль бусаар ашиглах тодорхой хэлбэр, аргыг тодорхой шалгуур үзүүлэлттэй шууд холбох гэсэн оролдлого нь дүн шинжилгээний явцад буруу таамаглалд хүргэж болзошгүй тул уг тайланд ийм оролдлогыг хийгээгүй болно.

161. Шалгуур үзүүлэлтийг *төрийн байгууллагуудад түлхүү хамаарах болон төрийн байгууллага, ашгийн бус салбарын байгууллагуудын аль алинд нь хамаарах* гэж хоёр хэсэгт хуваасан. Эдгээр шалгуур үзүүлэлтийг ашгийн бус салбарт дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг бодитоор ашиглах боломжтой байх нь ашгийн бус байгууллагууд хууль бус үйлдлийн хамтрагчид байдаггүй гэсэн таамаглалд үндэслэж байна. Эс бөгөөс хууран мэхлэлт нь бусад АББ-ын байгууллагуудад ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашигладаг гэсэн баримтыг илрүүлэхэд илүү төвөгтэй болгох юм.

АНГИЛАЛ 1: МЭДЭГДЭЖ БУЙ ЭСХҮЛ СЭЖИГЛЭГДЭЖ БУЙ ТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГАД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

162. Ашгийн бус салбарын үйл ажиллагааг хууль бусаар ашиглах үйлдэл, эрсдэлийн асуудлыг авч үзэхэд хамгийн түрүүнд санаанд ордог зүйл нь АББ-ын санхүүгийн хөрөнгө нөөцийг шууд ашиглах явдал юм. Гуравдугаар бүлэгт дурдсанчлан, энэ төрлийн хууль бус ашиглах үйлдэл нь олон янзын арга, хэлбэрээр илэрч болно.

Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
<i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт</i>	<i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i>

<p>▣ Террорист ажиллагаа явуулдаг нь тодорхой газар нутагт АББ-ын хөрөнгийг шилжүүлэх зорилгоор бэлэн мөнгө тээвэрлэгчдийг ашиглах.</p> <p>▣ АББ-аас явуулдаг үйл ажиллагааг сэжигтэй гүйлгээний мэдээлэлд оруулахаас зайлсхийхийн тулд хэд хэдэн хэсэгт хуваасан (бүтэц зохион байгуулалт).</p> <p>▣ АББ-ын хөрөнгийг шилжүүлэх хүсэлт нь тодорхой, нарийн үндэслэлгүй байх.</p> <p>▣ АББ санхүүгийн хөрөнгийг дамжуулах сувгаар халхавч (бодитоор оршдоггүй) байгууллагыг ашиглах.</p> <p>▣ АББ-ын төлөөлөгчид олон улсын хилээр гарахдаа их хэмжээний бэлэн мөнгийг мэдэгдэхгүй гарах.</p> <p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>▣ АББ-ын банкны дансыг өөрсдийнх нь дансанд хязгаарлалт тавьсан байгууллагууд ашиглах.</p> <p>▣ АББ-ын хөрөнгийг хувийн мөнгө эсхүл хувийн компаниудын санхүүгийн хөрөнгөтэй нийлүүлэх.</p> <p>▣ Тодорхой хөтөлбөр эсхүл үйл ажиллагаатай холбоотой банкны дансыг нуун дарагдуулах.</p> <p>▣ АББ-ын хөрөнгийг ашгийн бус байгууллагаас мэдүүлсэн хөтөлбөр, үйл ажиллагаатай холбоогүй байгууллагад шилжүүлэх.</p>	<p>⚠ Террорист үйл ажиллагаанд оролцдог эсхүл террорист үйл ажиллагааг дэмждэг аж ахуйн нэгж (байгууллага)-д шилжүүлсэн.</p> <p>⚠ АББ нь терроризмын үйл ажиллагааг дэмждэг байж болзошгүй аж ахуйн нэгж (байгууллагаас) мөнгө авдаг.</p>
--	---

АНГИЛАЛ 2: МЭДЭГДЭЖ БУЙ ЭСХҮЛ СЭЖИГЛЭГДЭЖ БУЙ ТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГАД МАТЕРИАЛАГ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

163. АББ нь материаллаг болон санхүүгийн хөрөнгө нөөцийг ашиглах боломжтой байдаг тул террорист байгууллагууд АББ-ыг хууль бус зорилгоор ашигладаг. Эдгээр материаллаг нөөц нь барилга байгууламжаас хоёрдмол зориулалттай тоног төхөөрөмжийг хүртэл маш өргөн хүрээг хамарна. Энэ ангилал нь мэдэгдэж байгаа эсхүл сэжиглэгдэж буй террорист байгууллагад хамаарах тул анхааруулах шалгуур үзүүлэлт илүү олон байна.

Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
<p><i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>▣ Терроризмын үйл ажиллагааг дэмждэг гэж үздэг хувь хүмүүс АББ-ын байгууламжид олон удаа ирэх.</p> <p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>▣ АББ нь хоёрдмол зориулалттай тоног төхөөрөмжийг худалдаж авах.</p>	<p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>⚠ АББ-ын хөрөнгийг террорист үйл ажиллагаанд оролцдог эсхүл террорист үйл ажиллагааг дэмждэг гэдэг нь тогтоогдсон аж ахуйн нэгж (байгууллага)-д шилжүүлэх.</p> <p>⚠ АББ нь террорист үйл ажиллагааг дэмждэг эсхүл террорист үйл ажиллагаанд оролцдог гэж үздэг аж ахуйн нэгж (байгууллагаас) хөрөнгө нөөц хүлээж авах.</p> <p>⚠ Террорист үйл ажиллагааг дэмждэг гэж үздэг бусад байгууллагад үл хөдлөх хөрөнгө олгох.</p>

АНГИЛАЛ 3: ЖАГСААЛТАД ОРСОН ТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГАД САНХҮҮ, МАТЕРИАЛЛАГ ЭСХҮЛ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

164. Шинжлэн судалсан кейс тохиолдолд ашгийн бус байгууллагатай холбоотой жагсаалтад орсон байгууллагыг тодруулах тохиолдол үе үе давтагдан гарсан. Ихэнхдээ жагсаалтад орсон байгууллага байх нь санаатайгаар эсхүл санаандгүй байдлаар АББ тогтоосон хянан нийцүүлэлтийн шаардлагыг өргөн хүрээнд хэрэгжүүлээгүй байсны үзүүлэлт юм. Энэ ангилал нь жагсаалтад орсон террорист байгууллагад хамаарах тул голдуу анхааруулах шалгуур үзүүлэлтүүд байна.

Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
<p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p>	<p><i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p>

<p>▣ АББ-ын үйл ажиллагаа нэр, нэршил нь жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр, нэршилтэй давхцсан хувь хүн эсхүл байгууллагыг дэмжих зорилгоор явуулах.</p>	<p>⚠ АББ эсхүл түүний төлөөлөгч террорист үйл ажиллагааг дэмжихэд оролцсоныг илтгэх найдвартай мэдээлэл байгаа эсэх.</p> <p>⚠ АББ эсхүл түүний төлөөлөгч террорист үйл ажиллагааг дэмждэг эсхүл террорист үйл ажиллагаанд оролцдог гуравдагч этгээдтэй холбоотой болохыг харуулсан найдвартай мэдээлэл байгаа эсэх.</p> <p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>⚠ Террористуудын жагсаалтад орсон нэрс нь АББ-ын удирдлага эсхүл түүний ажилтнуудын нэртэй давхцах.</p>
---	--

АНГИЛАЛ 4: ТЕРРОРИЗМЫН АЮУЛ ЗАНАЛ ИДЭВХТЭЙ ГАЗАР НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

165. Ихэвчлэн зөрчил мөргөлдөөнтэй бүс нутаг дахь АББ-ын үйл ажиллагааг эдгээр бүс нутгийн тогтворгүй байдал, сул засаглалаас болж террорист байгууллагууд хууль бусаар ашиглах хамгийн их эрсдэлтэй гэж үздэг. Гэхдээ шинжлэн судалсан кейс тохиолдолд хэдийгээр зөрчил мөргөлдөөнтэй бүс нутаг өндөр эрсдэлийг дагуулдаг ч идэвхтэй террорист аюул заналхийлэл байх нь эрсдэлийг тодорхойлох чухал хүчин зүйл байсныг харуулж байна. Доорхи шалгуур үзүүлэлтүүд нь дүн шинжилгээний энэхүү дүгнэлтийн тусгал юм. Түүнчлэн кейс тохиолдлыг шинжлэн судлах явцад АББ-ын үйл ажиллагаа, террорист хөдөлгөөн хоорондын шууд хамаарлыг тодорхойлох нь гадаадын улс орнуудад илүү хэцүү болох нь тодорхой болсон. Эдгээр тохиолдолд террорист байгууллагын оролцоог нотлох баримтыг газар дээр нь олж авах илүү хэцүү байх тул энэ нь сэрэмжлүүлэх үзүүлэлт байх юм. Тиймээс ч ийм нөхцөлд олон улсын хамтын ажиллагаа, мэдээллийн солилцоо илүү чухал ач холбогдолтой болно. Газар нутгийн алслагдсан байдлаас шалтгаалан АББ-ын гадаад дахь үйл ажиллагааг шалгахад илүү хэцүү байна. Үүнтэй холбогдуулан хөрөнгө нөөц, сүлжээг хянах чадвар нь олон улс орны хамтын ажиллагаанаас хамаарах болно. Эдгээр хүндрэлүүд нь энэ ангилалд анхааруулах үзүүлэлт байхгүй байгаагаар нотлогдож байна.

Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
<i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт:</i>	

<p>🚩 Террорист үйл ажиллагаа явагддаг нь тодорхой бүс нутагт ажилладаг хувь хүн, байгууллагаас АББ, түүний удирдлага эсхүл ажилтнуудын дансанд хөрөнгө мөнгө шилжүүлэх.</p> <p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>🚩 Террорист байгууллагууд ихээр байдаг бүс нутагт АББ хөрөнгө нөөц шилжүүлэх эсхүл үйл ажиллагаа явуулах.</p> <p>🚩 АББ-ын баримт бичгийг террорист байгууллагууд ихээр байдаг бүс нутагт хөтлөж, хадгалдаг.</p> <p>🚩 АББ-ын төлөөлөгчид террорист байгууллагууд ихээр байдаг бүс нутагт ойр ойрхон зорчих.</p>	
---	--

АНГИЛАЛ 5: ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, УДИРДЛАГА

166. Хэд хэдэн шалгуур үзүүлэлт АББ-ын ерөнхий үйл ажиллагаа, удирдлагатай холбоотой байв. Эдгээр шалгуур үзүүлэлтийн зарим нь хамтран оролцогч этгээд (гадаад эсхүл дотоод) өөрсдийн үйлдлийг нуун дарагдуулах, тухайлбал, хөтөлбөр, үйл ажиллагаа эсхүл санхүүжилтийн талаарх мэдээллийг нуун дарагдуулах гэсэн оролдлогоос гарсан. Энэ ангилалд багтдаг бусад шалгуур үзүүлэлт нь хууль бус үйл ажиллагаанд оролцсон этгээдийн хууль бус үйл ажиллагаанд оролцоогүй ашгийн бус байгууллагад нөлөөлөх, хянах гэсэн оролдлогоос үүдэлтэй.

Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
<p><i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>🚩 АББ нь өөрийн үйл ажиллагаа, хөтөлбөр эсхүл түншүүдийн талаар тайлагнадаггүй.</p> <p>🚩 АББ нь үйл ажиллагаа явуулахад ер бусын нарийн төвөгтэй санхүүгийн схемийг ашигладаг.</p>	<p><i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>⚠️ Олон нийтийн зүгээс ирүүлсэн сэжүүр нь АББ-ыг терроризмтой холбоотой үйл ажиллагаанд оролцдог гэж зөвтгөх.</p>

<p>▣ АББ нь заавал илтгэх тайлангийн шаардлагыг хангадаггүй.</p> <p>▣ АББ нь хяналтын эрх бүхий байгууллагад өөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны талаар тодорхой тайлбарлаж чадахгүй байх.</p> <p>▣ АББ-ын нэр дээр данс нээлгэх эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулахын тулд гуравдагч этгээдийг ашиглах.</p> <p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>▣ АББ-ын зардал түүний хөтөлбөр, үйл ажиллагаатай нийцэхгүй байх.</p> <p>▣ АББ нь өөрийн бүх хөрөнгө нөөцийн эцсийн зориулалтыг тайлбарлаж чадахгүй байх.</p> <p>▣ АББ нь орлогын эх үүсвэрээ тайлбарлаж чадахгүй байх.</p> <p>▣ Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл болон/эсхүл АББ-ын заавал илтгэх тайлангийн мэдээлэл хоорондын зөрүүтэй байдал.</p> <p>▣ АББ-ын удирдлагын бүтэц зохион байгуулалт эсхүл шийдвэр гаргах үйл явц илт тод биш байх.</p> <p>▣ АББ эсвэл түүний төлөөлөгч хуурамч эсхүл зөрчилтэй баримт бичгийг ашиглах.</p>	<p>⚠ АББ нь террорист үйл ажиллагааг дэмждэг гэж үздэг бусад байгууллагатай нэгдэх.</p> <p>⚠ АББ-ын хүмүүнлэгийн тусламж нь террорист байгууллагатай шууд холбоотой этгээдэд дэмжлэг үзүүлэхэд чиглэх.</p> <p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>⚠ АББ-ын удирдлага нь террорист үйл ажиллагааг дэмждэг гэж үздэг бусад байгууллагын удирдлагаар ажилладаг эсхүл ажиллаж байсан.</p> <p>⚠ АББ дотоодын зөрчилдөөнтэй байх бөгөөд тэдний нэг тал нь террорист байгууллагыг сайшааж ханддаг эсхүл идэвхтэй дэмждэг.</p>
--	--

АНГИЛАЛ 6: ЭЛСҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

167. Зарим тохиолдолд АББ-ын хөрөнгө нөөцийг өөрсдийн дэмжигчид, дагагчдыг элсүүлэхтэй холбоотой террорист хөдөлгөөний үйл ажиллагаанд чиглэгдэж байв. Кейс тохиолдлыг шинжлэн судлахад элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа нь санхүүгийн болон материаллаг хөрөнгө нөөцийн нэмэлт эрсдэлтэй холбоотой байсныг илтгэж байна. Түүнчлэн шашны болон боловсролын чиглэлд

зориулсан хууль ёсны буяны хөтөлбөрийг элсүүлэх ажлыг дэмжих зорилгоор хууль бусаар ашиглаж болдог.

Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
<p><i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>🚩 Террорист үйл ажиллагаанд оролцдог этгээдүүд нь АББ-тай холбоотой байх.</p> <p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>🚩 АББ-ын хэвлэл нийтлэл эсхүл илтгэгчдийн илтгэл терроризм эсхүл террорист байгууллагыг дэмжихийг уриалсан агуулгатай байх.</p>	<p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>⚠️ АББ-ын удирдлага эсхүл ажилтнууд нь хүчирхийлэлд дэмжлэг үзүүлэх этгээдүүдийг элсүүлэх зорилготой үйл ажиллагаанд оролцох.</p>

АНГИЛАЛ 7: БУСАД ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

168. Терроризмын зорилгоор АББ-ыг хууль бусаар ашиглах үйлдлийг бусад төрлийн гэмт хэргийг илрүүлсний үр дүнд төрийн байгууллага эсхүл ашгийн бус байгууллагуудын өөрсдийнх нь анхааралд орох боломжтой. Мөн шинжлэн судалсан зарим кейс тохиолдолд гэмт хэрэг, терроризм нь хоорондоо уялдаа холбоотой байгаа нь харагдаж байна.⁸⁷ Өмнө нь хэвлэгдсэн ФАТФ-ын тайланд мөн терроризмыг санхүүжүүлэх зорилгоор гэмт хэргийн үйл ажиллагааг ашигладаг болохыг тэмдэглэсэн байна.⁸⁸ Терроризмтой холбоотой тохиолдолд АББ нь ийм төрлийн гэмт хэргийн үйл ажиллагаанд оролцоогүй байж болно, гэхдээ гадны эсхүл дотоодын этгээдийн хохирогч байж болно. Гэмт хэргийн бусад үйл ажиллагаа, ялангуяа терроризмын шинж тэмдэгтэй хавсарсан тохиолдолд эрсдлийн ноцтой шинж тэмдэг байгаагийн илрэл болдог.

Эрсдэлийн шалгуур үзүүлэлт	Терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах шалгуур үзүүлэлт
<p><i>Төрийн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <p>🚩 Сурталчилсан АББ нь хуурамч байх.</p>	<p><i>Төрийн байгууллага болон АББ-дад хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p>

⁸⁷ Тухайлбал, Хуан Мигель дел Сид Гомез (Gomez, Juan Miguel del Cid)-ыг үзнэ үү. (2010 он), х.3-27.

⁸⁸ ФАТФ (2008 он), х.15-19.

<p><i>Төрийн байгууллага болон АББ-дэд хамаарах шалгуур үзүүлэлт:</i></p> <ul style="list-style-type: none"> ▣ АББ-ын барилга байгууламжийг гэмт хэргийн үйл ажиллагааг нуун дарагдуулахад ашиглах. ▣ АББ-ын удирдлага эсхүл ажилтнууд нь бусад гэмт хэргийн үйл ажиллагаанд оролцсон байх. 	<ul style="list-style-type: none"> ⚠ АББ-ын барилга байгууламжид террорист ажиллагаатай холбоотой гэмт хэргийн үйл ажиллагааг нуун дарагдуулахад ашиглах. ⚠ Террорист үйл ажиллагаатай холбоотой бусад гэмт хэргийн үйл ажиллагаанд АББ-ын удирдлага эсхүл ажилтнууд оролцох.
---	---

ДОЛООДУГААР БҮЛЭГ ДҮГНЭЛТ

169. Энэхүү типологийн судалгаа дүн шинжилгээний зорилго нь үндэсний болон олон улсын бодлого боловсруулагчид, төрийн байгууллагууд, ашгийн бус байгууллагад террорист байгууллагууд ашгийн бус салбарыг хууль бусаар ашиглахаас хамгаалах хүчин чармайлтад туслах зорилгоор дүн шинжилгээтэй мэдээлэл, дүгнэлт өгөх явдал юм. Тайлангийн гол үр дүнг Зураг 7.1-д нэгтгэв.

Зураг 7.1: Судалгаа дүн шинжилгээний дүгнэлтийн хураангуй

1. Ашгийн бус салбарт харилцан хамааралтай олон эмзэг байдал байдаг бөгөөд террорист байгууллагууд хэд хэдэн төрлийн эмзэг байдлыг ашиглахыг хичээдэг. Энэхүү тайланг боловсруулахад шинжлэн судалсан кейс тохиолдолд ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах гол (давамгайлсан) арга нь АББ-ын хөрөнгийг террорист байгууллагад шилжүүлэх үйлдэл байв. Гэхдээ хууль бус зорилгоор ашиглах санхүүгийн бус тухайлбал, АББ-ын хөтөлбөрийг хууль бус зорилгоор ашиглах, дэмжигч, дагагчдыг элсүүлэхэд дэмжлэг үзүүлэх тохиолдол мөн гарсан.

2. Терроризмын идэвхтэй аюул заналхийлэлтэй бүс нутагт ажилладаг, “үйлчилгээ” үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд хамгийн их эрсдэлд өртдөг. Энэ нь террорист аюул заналхийлэл идэвхтэй байх тохиолдолд зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг АББ-д хамаарна. Гэхдээ энэ нь мөн дэмжлэг үзүүлэх, нуух хамгаалах зорилгоор террорист хөдөлгөөний зорилтот хүн амын бүлэгтэй хамтран ажилладаг, эх орондоо үйл ажиллагаа явуулдаг АББ-дад хамаатай байж болно. Энэ хоёр тохиолдолд эрсдэлийн гол хувьсагч нь газарзүйн хүчин зүйл бус, харин идэвхтэй аюулын ойролцоо байх явдал юм.

3. Аюул занал, мөн үүний дагуу төрөөс энэ аюул заналыг даван туулах арга хэмжээний мөн чанараас шалтгаалан ихээхэн эрсдэлтэй тохиолдол нь типологийн судалгаа дүн шинжилгээнд шаардлагатай мэдээллийн чухал эх үүсвэр болдог.

4. Янз бүрийн этгээдийн эзэмшдэг олон төрлийн мэдээллийг нэгтгэх нь АББ-ыг хууль бусаар ашиглах тохиолдол, ноцтой эрсдэлийг илрүүлэхэд чухал хүчин зүйл болсон.

5. АББ-ыг хууль бусаар ашиглах үйлдлийг таслан зогсоох эсхүл ноцтой эрсдэлийг бууруулахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг олон янзын арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд хүрсэн. Захиргааны арга хэмжээ авах, мөнгөн торгууль ногдуулах, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах нь ашгийн бус байгууллагыг хууль бус зорилгоор ашиглах үйлдлийг таслан зогсооход чухал үүрэг гүйцэтгэсэн.

170. Нэгдүгээр бүлэгт үйл ажиллагааны болон стратегийн судалгааны аль алинд нь тавигдах шаардлагатай холбоотой хэд хэдэн түлхүүр асуултыг тусгасан. Энэхүү

типологийн төслийн хүрээнд хийсэн судалгаа, дүн шинжилгээний дүнд бид эдгээр асуултын хариултыг өгч, улмаар террорист байгууллагаас ашгийн бус салбарт учруулах аюул заналын талаар илүү гүнзгий ойлголттой болох боломжтой юм.

СТРАТЕГИЙН АСУУДЛУУД

171. Стратегийн дүн шинжилгээгээр ашгийн бус салбарт байдаг хүндрэл бэрхшээл, терроризмын аюул занал, терроризмтой тэмцэхэд үндэсний болон олон улсын түвшинд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүмүүнлэгийн хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны удирдлага, менежмент нь ерөнхий нөхцөлийг тодорхойлдог олон хүчин зүйлийг бий болгодог болохыг харуулж байна.

Гадаад хүчин зүйл	Тайлбар
1 дүгээр хүчин зүйл: Террорист байгууллагуудын зүгээс учруулах хохирлын улмаас терроризмын санхүүжилттэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай	1 дүгээр хүчин зүйл нь энгийн иргэдийг хамгаалах зорилгоор террорист аюул заналхийллийг эсэргүүцэх олон улсын байгууллагууд болон үндэсний төр засгийн газрын байгууллагуудад тавигдах шаардлагатай холбоотой.
2 дугаар хүчин зүйл: Ашгийн бус салбарын үр дүнтэй үйл ажиллагаа	2 дугаар хүчин зүйл нь ашгийн бус салбарын хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн үр нөлөө, чанарыг хангахтай холбоотой.
3 дугаар хүчин зүйл: Хандивлагч (донор)-дад хүмүүнлэгийн үйл ажиллагааны хариуцлага, ил тод байдлыг хангах үүргийг хүлээнэ	3 дугаар хүчин зүйл нь ашгийн бус салбар болон бусад оролцогч талуудын ашгийн бус салбарын хандивлагчид (донорууд)-аас тус салбарт хандивласан хөрөнгө, материалыг зөвхөн зориулалтын дагуу ашиглах үүрэг хариуцлагатай холбоотой.
4 дүгээр хүчин зүйл: Хүлээн авагчдад тусламж үзүүлэх үүргийг хүлээнэ	4 дүгээр хүчин зүйл нь ашгийн бус салбар болон бусад оролцогч талуудын хүлээн авагчдад үзүүлэх тусламж нь олон улсын хүмүүнлэгийн хэм хэмжээнд нийцсэн байх үүргийг хүлээнэ.
5 дүгээр хүчин зүйл: Олон улсын дэглэмийн нэгдсэн үйл ажиллагаа	5 дугаар хүчин зүйл нь бүх нийтийн хөгжил цэцэглэлт, аюулгүй байдлыг хангах үүднээс олон улсын байгууллагаас тогтоосон дүрэм, хэм хэмжээтэй (ФАТФ-ын 40 Зөвлөмж зэрэг) холбоотой.
6 дугаар хүчин зүйл: Улс орнуудын бие даасан үйл ажиллагаа	6 дугаар хүчин зүйл нь улс орнуудын бүрэн эрхтэй байдлын хувьд олон улсын хэм хэмжээг дагаж мөрдөх эсхүл түүнтэй зөрчилдөх үйл ажиллагаа явуулах чадварыг хэлнэ.

172. Эдгээр гол хүчин зүйлүүд нь тус тусдаа болон хамтдаа холбогдох бүх байгууллагад олон талын шаардлагыг тодорхойлж өгдөг. Эдгээр хүчин зүйлүүд нь тус бүрдээ чухал байх тул эдгээр олон талын шаардлагыг хангахын тулд зөв тэнцвэрийг нь олох шаардлагатай болно.

СУДАЛГАА ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Юу вэ...	террорист байгууллагын ашгийн бус салбарт учруулах аюул заналын үндсэн шинж...?
----------	---

173. Энэхүү типологийн судалгаа дүн шинжилгээгээр тодорхойлсон хамгийн чухал зүйл нь террорист байгууллагууд АББ-ыг хууль бусаар ашиглах нь ноцтой асуудал гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрснөөс хойшхи арав гаруй жилийн дараа ч гэсэн хууль бусаар ашиглах үйлдлийн аюул занал хэвээр байсаар байна. Хэдийгээр дэлхийн хэмжээнд ашгийн бус салбарын хүрээнд тус салбарыг террорист байгууллагууд хууль бусаар ашиглах эрсдэл магадлал багатай ч түүний хор уршигтай үйлдлийн сөрөг нөлөөлөл нь зөвхөн санхүүгийн алдагдлаар хязгаарлагдахгүй. Хандивлагчид (донорууд) нь санхүүгийн эсхүл материаллаг эх үүсвэрээс үл хамааран АББ-д сайн дураараа хандивласан хөрөнгө нөөцийг сайн үйлсийн зорилгоор ашиглана гэдэгт итгэдэг - энэ итгэл үнэмшил нь ашгийн бус салбарын оршин тогтнохын гол үндэс суурь нь болдог. Гол зорилго нь хор уршиг учруулах байгууллагын ашиг сонирхолд нийцүүлэх зорилгоор эдгээр хөрөнгө нөөцийг шилжүүлэх нь ашгийн бус салбарт үзүүлэх иргэдийн итгэлийг алдагдуулж, ашгийн бус байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн хортой үр дагаварыг авчирдаг.

174. Үйл ажиллагааны түвшинд хийсэн судалгаа дүн шинжилгээ нь ашгийн бус байгууллага нь олон төрлийн террорист байгууллагын зорилтот этгээд болдгийг харуулж байна. Уламжлалт үндэстэн дамнасан террорист байгууллагууд нь ашгийн бус салбарт ихээхэн аюул заналыг учруулдаг. Эдгээр уламжлалт террорист байгууллагууд нь өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд хууль ёсны ашгийн бус байгууллагыг ашиглахыг оролддог эсхүл хуурамч АББ үүсгэн бүх салбарын нэр хүндэд ноцтой хохирол учруулдаг.

175. Судалгаа дүн шинжилгээнээс харахад уламжлалт үндэстэн дамнасан террорист байгууллагаас гадна нутгийн, өөрсдөө санаачилсан байгууллага нь мөн ашгийн бус салбарт аюул занал учруулах бөгөөд аюул заналын орчны өсөн нэмэгдэж буй шинэ бүрдэл хэсэг нь болж байна. Судалгаа дүн шинжилгээгээр дотоодын эдгээр байгууллага нь дотооддоо (үндэсний хэмжээнд) үйл ажиллагаа явуулдаг АББ-ыг хор уршигтай зорилгоор ашиглаж болох нь тогтоогдсон. Эдгээр тохиолдлууд нь олон улсын үйл ажиллагаанд эсхүл гадаадын байгууллагатай холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлд анхаарлаа төвлөрүүлснээс тухайн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг АББ-ын үйл ажиллагааг (улсын хэмжээнд) хууль бусаар ашиглахад эмзэг болгодгийг харуулж байна.

Ямар...

... АББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд хамгийн ихээр өртдөг вэ?

176. Хэдийгээр дэлхийн хэмжээнд ашгийн бус салбарын цар хүрээ (хэмжээ) өргөн ч судалгаа дүн шинжилгээгээр тодорхой нөхцөл байдалд, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд нь хууль бусаар ашиглах үйлдэлд хамгийн эмзэг байдгийг харуулж байна. Ялангуяа террорист байгууллагын хамгийн их анхааралд өртдөг байгууллага нь үйл ажиллагаандаа ашигладаг хөрөнгө нөөц, үйл ажиллагааны газарзүйн хамрах хүрээ, эмзэг бүлгийн иргэдэд нэвтрэх боломж зэргээс нь шалтгаалан хүмүүнлэгийн үйлчилгээ үзүүлдэг АББ-ууд байдаг. Шинжлэн судалсан кейс тохиолдлын алинд нь ч террорист байгууллагууд “идэвхтэй төлөөллийн” үйл ажиллагаа эрхэлдэг, гол төлөв улс төрийн үйл ажиллагаа, хэн нэгний эрх ашгийг төлөөлж ажилладаг зэрэг АББ-ын давуу талыг ашиглахыг оролдоогүй.

177. Терроризмын хөдөлгөөний идэвхтэй зорилт тавьдаг хүн амын дунд үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд тэдгээрт хууль бусаар ашиглуулах өндөр эрсдэлд байдаг. Гэхдээ иймэрхүү газар нутаг нь үргэлж зөрчил мөргөлдөөнтэй эсхүл тогтворгүй бүс нутаг байдаггүй гэдгийг анхаарах нь чухал юм. Террорист хөдөлгөөнүүд идэвхгүй эсхүл ажиллах чадваргүй зөрчил мөргөлдөөнтэй, тогтворгүй байдалтай (сул засаглалтай) бүс нутагт АББ нь авлига, гэмт хэрэгтэй холбоотой, терроризмын бус эрсдэлтэй тулгарч болзошгүй. Нөгөө талаар, террорист хөдөлгөөнүүд нь тодорхой бүлэглэлийн зөрчилдөөнтэй холбоотойгоор харьцангуй тогтвортой бүс нутагт амьдардаг хүн амын дунд идэвхтэй ажиллаж болдог. Тухайлбал, Ирландын Бүгд Найрамдах Арми нь Ирланд Улсын цагаач нийгэмлэгийн дунд, ялангуяа АНУ-ын зүүн хэсэгт дэмжлэг, хөрөнгө босгох чиглэлээр байнга ажилладаг байв.⁸⁹ Тиймээс ч тогтвортой бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг АББ-ууд нь өндөр эрсдэлтэй хэвээр байна. Эцсийн эцэст ямар АББ-ыг хууль бусаар ашиглах өндөр эрсдэлтэй байгааг тодорхойлох гол хүчин зүйл нь террорист байгууллагын хувьд тухайн АББ-ын хөрөнгө нөөц, үйл ажиллагаа хэр үнэ цэнэтэй, ач холбогдолтой байх, түүнчлэн АББ-ыг хууль бус зорилгоор ашиглах чадвартай, санаатай байдаг идэвхтэй террорист аюул заналын ойролцоо байх явдал юм.

⁸⁹ Жон Хорган (Horgan, John), Макс Тейлор (Taylor, Max) (1999 он, 2003 он)-ыг үзнэ үү. Үүнтэй төстэй жишээ нь Шри Ланк Улсын ард түмнээс тусламж, дэмжлэг авах зорилгоор тус улсын хүн амын дунд ажиллаж байсан «Тамил Иламын чөлөөлөх барууд хөдөлгөөн»-тэй холбоотой (2 дугаар бүлгийг үзнэ үү).

Хэзээ...

... АББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд хамгийн ихээн өртдөг вэ?

178. Дээр дурдсанчлан, судалгаа дүн шинжилгээгээр ашгийн бус байгууллага террорист аюул занал идэвхтэй байдаг газар нутагт тусламж үйлчилгээ үзүүлэх үеэр хууль бусаар ашиглуулах эрсдэлд хамгийн ихээр өртдөг болохыг харуулсан. Түүнчлэн байгалийн аюултай үзэгдэл зэрэг стратегийн гамшигт үзэгдэл нь АББ-ын санхүүжилт, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, террорист аюул занал идэвхтэй байдаг бүс нутагт тусламж үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллагын эмзэг байдлыг нэмэгдүүлдэг гэсэн баримт байдаг. Тусламж үйлчилгээ үзүүлэх эрэлт хэрэгцээ огцом нэмэгдэх нь АББ-ын ажилтнуудын ачааллыг нэмэгдүүлэх бөгөөд энэ нь дотоодын хяналт, удирдлагын чанарыг улам дордуулж, түүний удирдах албан тушаалтнуудыг бусад ажил үүргийг гүйцэтгэх зорилгоор хянан магадлагааны нийцүүлэлтийн ажлыг хариуцсан ажилтныг шилжүүлэхээс өөр аргагүй байдалд хүргэдэг. Хэдийгээр стратегийн гамшигт үзэгдэл, АББ-ын эмзэг байдлын хооронд уялдаа холбоо байгаа мэт боловч үүнийг батлахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай байна.

Хаана...

... АББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд хамгийн ихээр өртдөг вэ?

179. Судалгаа дүн шинжилгээгээр ашгийн бус байгууллагын үйл ажиллагаа нь АББ-ын үйл ажиллагааны ерөнхий загварын олон цэгт эмзэг байж болзошгүйг харуулсан (Зураг 2.6-г үзнэ үү). АББ-ыг хууль бусаар ашиглах тохиолдол хөрөнгө нөөцтэй холбоотой ажлын бүх шатанд, тухайлбал хөрөнгө нөөцийг цуглуулах, шилжүүлэх, хадгалах, зарцуулах үе шатуудад тогтоогдсон. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх шатанд АББ-ыг хууль бусаар ашиглаж байсан тохиолдлууд тогтоогдсон. Эдгээр нөхцөлд хөтөлбөрийн үр дүнг хүлээн авагчид шилжүүлэх хүртэл АББ-ын үйл ажиллагаа хууль ёсны байсан. Үүний нэг тод жишээ нь террорист байгууллагын элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсролын буюу соён гэгээрүүлэх хөтөлбөрийг хууль бусаар ашигласан явдал юм. Иймэрхүү үзэгдэл хэд хэдэн шинжлэн судалсан кейс тохиолдолд гарсан болно. Эдгээр тохиолдолд хөрөнгө нөөцийг цуглуулах, хадгалах, шилжүүлэх, зарцуулах ажил нь бүгд боловсролын/соён гэгээрлийн хөтөлбөрийн шинж чанарт бүрэн нийцүүлсэн байдаг. Гэхдээ хөтөлбөрийн бодит хэрэгжилтийг нь террорист зорилгоор ашигласан байв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шатанд АББ-ыг хууль бусаар ашиглах нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөвхөн АББ-ын хөрөнгө нөөцөд төвлөрүүлэх нь тус салбарыг хууль бусаар ашигласан зарим ноцтой хэргийг илрүүлэхгүй байхаас гадна хөтөлбөрийн талаархи мэдлэг нь хөрөнгө нөөцийн урсгалын талаархи мэдлэгээс дутахгүй чухал байж болно гэдгийг харуулж байна.

Яагаад...	... АББ-ууд террорист байгууллагын хууль бусаар ашиглах эрсдэлд өртдөг вэ?
------------------	--

180. Ашгийн бус байгууллага болон террорист байгууллага нь дэлхийн ижил ертөнцөд оршин тогтнодог. Тэдгээр нь ихэнхдээ ижил хүн амын дунд ажиллахыг хичээдэг, гагцхүү тэдний зорилго нь өөр байдаг. Ашгийн бус байгууллагууд нь тусламж хэрэгтэй хүмүүст тусалдаг бол террорист байгууллагууд нөхцөл байдлыг улам хурцатгаж, түүнийгээ өөрсдийн зорилгодоо ашигладаг. Үйл ажиллагааныхаа үр дүнтэй байдлыг хангахын тулд АББ-ууд хөдөлгөөнтэй байх, шаардлагатай хөрөнгө нөөцтэй байхыг хичээж, гадаад түншүүдээ бага судалдаг байна. Стратегийн болон үйл ажиллагааны судалгаа дүн шинжилгээний үр дүнгээс үзэхэд АББ-ын зохион байгуулалтын эдгээр онцлог байдал нь хор уршигтай зорилгоор ашиглахыг хичээдэг террорист байгууллагын анхаарлыг татдаг. Террорист байгууллагууд АББ-ыг өөрсдийн зорилгодоо ашиглахыг хичээдэг, учир нь АББ-ууд нь эд зүйлс, санхүүгийн эх үүсвэр, зохион байгуулалтын сүлжээнд түвэггүйгээр, хууль ёсны дагуу хялбархан нэвтрэх боломжтой байдаг. Террорист байгууллагууд мөн эдгээр эд зүйлс, мөнгө санхүүгийн эх үүсвэр, сүлжээг ашиглах боломжийг олж авахыг эрэлхийлдэг боловч хууль бус тул үүнийгээ нууцаар хийх шаардлагатай болдог. Энэ нь террорист байгууллагууд эдгээр хөрөнгө нөөц, боломжийг олж авахын тулд эдийн засгийн хууль ёсны салбарыг хууль бусаар ашиглахад ихээхэн ач холбогдол өгч, түүнийгээ өөрсдийнхөө хор уршигтай үйлдлийг илрүүлэхэд хэцүү байхаар хийдэг гэсэн үг юм.

Хэрхэн...	... АББ-ууд террорист үйл ажиллагаанд эмзэг болдог вэ?
------------------	--

181. Судалгаа дүн шинжилгээ нь ашгийн бус салбар дахь хэд хэдэн зохион байгуулалтын чиг хандлагаас болж терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд эмзэг болдгийг харуулж байна. Хөгжингүй, өргөжсөн зохион байгуулалтын сүлжээ, ялангуяа олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд хяналт, удирдлагыг хэрэгжүүлэхэд хэцүү болгодог. Тухайн салбарт олон тооны түр хугацааны ажиллах хүчин байдаг нь байгууллагуудад боловсон хүчнийг үр дүнтэй сонгон шалгаруулахад хүндрэл учруулж, хянан магадлагааны нийцүүлэлт, хянан нийцүүлэлтийн ажиллагааны туршлага, мэдлэгтэй мэргэжилтнийг татахад хүндрэл учруулдаг. Түүнчлэн хөрөнгө нөөц, зохион байгуулалтын сүлжээнд нэвтрэх, олон нийтийн зүгээс ихээхэн итгэл үзүүлдэг зэрэг үйл ажиллагааны томоохон боломжууд нь ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах талаас нь эмзэг болгодог. Эцэст нь байгууллагын соёлын хүрээнд зорилгодоо хүрэхэд өндөр ач холбогдол өгөх нь ашгийн бус байгууллагыг эмзэг байдалд хүргэж болзошгүй, учир нь зарим тохиолдолд АББ-ын удирдлага эсхүл ажилтнууд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд өндөр эрсдэлийг үл хайхарч болдог.

182. Гэхдээ ажил үүрэгтээ анхаарлаа төвлөрүүлэх нь зайлшгүй буруу зүйл байх албагүй юм. Зорилгодоо хүрэхийн төлөө төвлөрч анхаарах нь ашгийн бус

байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй болгодог. Гэхдээ ихээхэн эрсдэлтэй тохиолдолд зорилгоо биелүүлэх хүсэл эрмэлзэл, ашгийн бус салбарын бүрэн бүтэн байдлыг хангах хэрэгцээ шаардлагын зөв тэнцвэрийг олох хэрэгтэй юм.

Яаж...	... террорист этгээдүүд ашгийн бус салбарыг хууль бусаар ашигладаг вэ?
---------------	--

183. Шинжлэн судалсан кейс тохиолдлын дүнгээс үзэхэд ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах эсхүл ийм төрлийн хор уршиг дагуулах эрсдэл нь таван янзын хэлбэрээр илэрдэг.

Хууль бусаар ашиглах арга, аргачлал/эрсдэл
Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх
Террорист байгууллагатай холбоотой байх
Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах
Элсүүлэхэд дэмжлэг үзүүлэх
Төөрөгдүүлэх төлөөлөл

Яаж...	... АББ-ыг хууль бусаар ашигласан тохиолдлыг илрүүлж, таслан зогсоосон вэ?
---------------	--

184. Судалгаа дүн шинжилгээнд мөн хууль бусаар ашигласан үйлдэл буюу эрсдэлийг хэрхэн тогтоосныг судалсан. АББ-ыг хор уршиг учруулах зорилгоор ашигласан баримтыг тодорхойлох, ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах хэргийг мөрдөн шалгах чадвартай байх нь олон төрлийн мэдээлэлд хандах түвшнээс хамаардаг бөгөөд тэдгээр нь тус бүртээ өөрийн үнэ цэнэ, давуу талтай байдаг. Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, түүнчлэн хянан шалгах эрх бүхий байгууллага, санхүүгийн мэдээллээр дамжуулан хянан магадлагааны нийцүүлэлт, хяналтыг хангах боломжтой. Гэхдээ шинжлэн судалсан кейс тохиолдлын дүнгээс харахад оролцогч талууд үйлдлээ хууран мэхлэх аргаар нуун дарагдуулсан тохиолдолд үндэсний эрх бүхий байгууллага эсхүл гадны түншүүдээс хүлээн авсан хууль сахиулах байгууллагын мэдээлэл, үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл АББ-ыг хууль бусаар ашигласан баримтыг ил болгоход шаардлагатай байв. Эцэст нь, ил тод байдлыг хангах замаар хандивлагчид (донорууд)-ын итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр хийж буй хүчин чармайлт нь тус салбарыг террорист

байгууллагууд хууль бусаар ашиглахаас хамгаалахад чиглэсэн нэмэлт хэрэгсэл болж байна. Хөтөлбөр, үйл ажиллагааны талаархи илүү их мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох нь ил тод байдлыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь эргээд АББ-ыг хууль бусаар ашиглах тохиолдлыг илрүүлэх хүчин чармайлтад хувь нэмрээ оруулдаг. Гэхдээ дээр дурдсанчлан, тайлангийн хүрээнд хийсэн судалгаа дүн шинжилгээгээр хамтран оролцсон байгууллага, хувь хүмүүс нь өөрсдийн үйлдлийг хууран мэхлэх аргаар нуун дарагдуулсан нөхцөлд үндэсний болон гадаадын олон байгууллагын хамтын хүчин чармайлтаар АББ-ыг хууль бусаар ашигласан ноцтой хэргийг илрүүлэх, таслан зогсооход шаардлагатай гэдгийг харуулсан.

Илрүүлэх арга
АББ-ыг хянан шалгах эрх бүхий байгууллагын мэдээлэл
Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл
СМА болон бусад санхүүгийн мэдээлэл
Үндэсний аюулгүй байдлын мэдээлэл
Хууль сахиулах байгууллагын мэдээлэл
Гаднаас ирүүлсэн мэдээлэл

185. Тавдугаар бүлэгт ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах үйлдлийг таслан зогсооходой холбоотой асуудлыг авч үзсэн. Кейс тохиолдлын нилээдгүй их хувьд хууль бусаар ашигласан эсхүл ашиглах эрсдэл байсан тохиолдлыг захиргааны арга хэмжээгээр эсхүл мэдээлэл-соён гэгээрүүлэх болон өөрийн хянан шалгах аргаар шийдвэрлэсэн. Түүнчлэн зорилтот хориг арга хэмжээ авах арга нь ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах үйлдлийг таслан зогсоох, цаашид иймэрхүү хууль бусаар ашиглах боломжийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. АББ-ыг хууль бусаар ашиглах үйлдлийг таслан зогсооход эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан цөөн хэдэн тохиолдлын харгалзан авч үзэхэд шүүхийн мөрдөн шалгах ажиллагааны статистик нь тус салбарын эрсдэлийн ерөнхий түвшний талаарх найдвартай үзүүлэлт болдоггүй.

Таслан зогсоох арга
Салбарын мэдээлэл-соён гэгээрүүлэх ажил, өөрийн хяналт шалгалт
Мөрдөн шалгах ажиллагаа

ЦААШДЫН АЖИЛ

186. Энэхүү типологийн тайлан нь террорист байгууллагаас ашгийн бус салбарт учруулах аюул заналын талаарх ойлголтыг эрс нэмэгдүүлсэн. Нэмэлт судалгаа дүн шинжилгээ нь энэхүү ойлголтыг улам өргөжүүлэх боломжтой. Тухайлбал, тодорхой улс орны хүрээнд, ялангуяа террорист үйл ажиллагаанд өртөх өндөр эрсдэлтэй газар нутагт энэ асуудлын ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд үндэсний хэмжээнд АББ-ыг хууль бусаар ашиглах асуудлыг судлах шаардлагатай байна. ФАТФ-ын бүх гишүүн орнууд үндэсний хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай гэсэн ФАТФ-ын Зөвлөмж 1 нь ийм төрлийн судалгааг дэмждэг. Эдгээр судалгаа нь шинэ өвөрмөц шалгуур үзүүлэлтийг тогтоох, цаашдын уялдаа холбоог илүү сайн ойлгоход тус дөхөм болно. Түүнчлэн донор болон ашгийн бус байгууллагын тусламж үйлчилгээг хүлээн авдаг улс орнуудад учрах аюул заналыг илүү гүнзгий (эрсдэл, эмзэг байдлын хувьд) харьцуулсан үнэлгээ хийх шаардлагатай байна. Эцэст нь (энэ нь өмнөх тайлбартай холбоогүй) хөрөнгийн зориулалтыг өөрчлөн шилжүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд АББ-ын урсгал хөрөнгө нөөцийг хянан шалгахад илүү их анхаарал хандуулах хэрэгтэй. Гэхдээ цаашдын судалгаа, дүн шинжилгээнд террорист байгууллага, террорист үйл ажиллагаатай холбогдохоос урьдчилан сэргийлэх, улмаар ашгийн бус салбарын бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор АББ-ын хүлээн авдаг хөрөнгө нөөцтэй холбоотой асуудлыг авч үзэх боломжтой юм.

НОМ ЗҮЙ

ЦАХИМ ХУУДАС

1. "Би-Би-Си" (BBC) (2013 он), "Бирминхэмийн этгээдүүд томоохон хэмжээний дэлбэрэлт хийхээр төлөвлөсөн хэрэгт гэм буруутайг тогтоов", BBC News (онлайн), 2013 оны 2 дугаар сарын 21-ний өдөр, www.bbc.com/news/uk-21534048, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
2. "Бирминхэмийн шуудан" (Birmingham Mail) (2013 он), "Бирминхэмд төлөвлөсөн террорист ажиллагаа нь "дахин нэг 7 дугаар сарын 7» болох байсан, *Бирминхэмийн шуудан сонин*, 2013 оны 02 дугаар 21-ний өдөр, www.birminghammail.co.uk/news/local-news/birmingham-terror-plot-could-been-1337863, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
3. Викрам Додд, Ричард Нортон Тейлор (Dodd, Vikram and Taylor, Richard Norton) (2011 он), "Бирминхэмийн терроризмтой тэмцэх ажиллагааны үеэр зургаан хүнийг баривчлав", *"Гардиан" сонин*, 2011 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр, www.theguardian.com/uk/2011/sep/19/anti-terrorist-police-arrest-birmingham, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
4. "Жихадистын бүлэглэл Олон улсын Улаан загалмайн нийгэмлэгийн төлөөлөгчдийг Барьцаалсан гэж мэдэгдэв», Швейцарийн өргөн нэвтрүүлгийн корпораци (*SwissInfo*), 2014 он, www.swissinfo.ch/eng/politics/Jihadist_group_says_it_kidnapped_ICRC_team.html?cid=37935364, 2014 оны 6 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
5. Сандра Лавилл (LaVille Sandra) (2013 он), "Бирминхэм хотод дэлбэрэлт хийхээр төлөвлөж байсан гэмт этгээдүүдийн хөрөг", *"Гардиан" сонин*, 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдөр, www.theguardian.com/uk/2013/feb/21/birmingham-terror-cell-plotters-profiles, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
6. Аршам Мохаммед, Табассум Захариа (Mohammed, Arsham and Zakaria, Tabassum) (2013 он), "АНУ Аль-Каидагийн аюул заналхийлэлтэй холбогдуулан олон улсад зорчих талаар мэдээгдэл гаргав" Ройтерс агентлаг (онлайн), 2013 оны 8 дугаар сарын 2-ны өдөр, www.reuters.com/article/2013/08/02/us-usa-embassies-idUSBRE9710V320130802, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
7. Кейт Мур (Moore, Keith) (2010 он), "Буяны байгууллагыг Шри Ланка Улс дахь «Тамилын баруудыг» санхүүжүүлэхэд ашигладаг байв», *"Хэралд Сан" сонин*, 2010 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр, www.heraldsun.com.au/news/charity-used-as-front-to-finance-sri-lankas-tamil-tigers/story-e6frf7jo-1225848229678, 2014 оны 4 дүгээр сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

8. Алан Мунро (Munro, Alan) (1999 он), "Хүйтэн дайны дараах дэлхий дахины хүмүүнлэгийн асуудал ба зөрчил мөргөлдөөн", "Улаан загалмайн олон улсын тойм" сэтгүүл №835, www.icrc.org/eng/resources/documents/misc/57jq2s.htm, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

9. Захари А. Поллинджер (Pollinger, Zachary A.) (2008 он), "Баленсиагаас тэсрэх бөмбөг хүртэл: Террорист бүлэглэлүүд хуурамч бүтээгдэхүүний худалдааг ашиг хийх, аллага үйлдэхэд хэрхэн ашигладаг вэ?", Харвардын их сургууль, <http://isites.harvard.edu/fs/docs/icb.../Pollinger%202490%20FINAL.doc>, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

10. НҮБ-ын Хүний эрхийн дээд хорооны алба, (2012 он), "Төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хийсэн шинэ хязгаарлалт нь хүний эрхийг дордуулж байна: Пиллэй", Хэвлэлийн мэдээ, (Женев хот, 2012 оны 4 дүгээр сарын 25), www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=12081&LangID=E, 2014 оны 5 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

11. Дэвид Самуэлс (Samuels, David) (2012 он), "Жихадын шинэ удирдагч", "Уолл Стрит" сэтгүүл (онлайн), 2012 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр, <http://online.wsj.com/news/articles/SB10001424052702303299604577323750859163544>, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

12. Олон улсын террорист байгууллагыг хайж олох, таних Бүлгийн хяналтын алба (SITE monitoring Service) (2014 он), "Шаббааб нь Америкийн залуучуудыг Можихидын хөдөлгөөнд нэгдэхийг уриалав" 2014 оны 5 дугаар сарын 13-ны өдөр, <https://news.siteintelgroup.com/Jihadist-News/sgabaab-calls-american-youth-to-join-them-in-mujahideem-movements-5.html>, 2014 оны 5 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

13. Сталинский, Стивен (Stalinsky, Steven) (2011 он), "Аль-Каидагийн цэргийн стратегич Абу Мусаба Аль-Суригийн дөрөв дэх үеийн дайн (4GW), хувийнжихад болон Аль-Каидагийн ирээдүйн талаархи сургаал", Судалгаа дүн шинжилгээний №698 тайлан, Ойрхи Дорнодын хэвлэл мэдээллийн судалгааны хүрээлэн, 2011 оны 06 дугаар сарын 22-ны өдөр, www.memri.org/report/en/0/0/0/0/0/5395.htm, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

14. Швейцарийн өргөн нэвтрүүлгийн корпораци (Swissinfo) (2014 он), "Жихадист бүлэглэл Олон улсын Улаан загалмайн нийгэмлэгийн төлөөлөгчдийг барьцаалсан гэж мэдэгдэв", www.swissinfo.ch/eng/politics/Jihadist_group_says_it_kidnapped_ICRC_team.html?cid=37935364, 2014 оны 5 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

15. Баруун Мидлэнд хотын цагдаагийн газрын Терроризмтой тэмцэх алба (2012 он), "Гэмт этгээдүүд "хандивын мөнгийг хулгайлсан" хэрэгт гэм буруутайг тогтоов, хэвлэлийн мэдээ, 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр,

www.muslimaid.org/images/stories/pdfs/trial_updated.pdf, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

16. Жон Виллетс (Willets, John) (2012 он), "Террористууд бөмбөг дэлбэлэхээр бэлтгэж байсан хэргийг тандсан гэрэл зургуудыг нийтлэв", "ITV" суваг, 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, www.itv.com/news/central/topic/trial/?page=2, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

17. Ники Мэй Янг (Young, Nicki May) (2013 он), "Буяны байгууллагуудын хороо нь "Мусульманчуудын тусламж" байгууллагыг (Muslim Aid) хууль бусаар ашиглахаар төлөвлөж байсан "аймшигт" террорист халдлагыг буруушаав", CivilSociety.co.uk цахим хуудас, 2013 оны 02 дугаар сарын 22-ны өдөр, www.civilsociety.co.uk/fundraising/news/content/14526/charity_commission-condemns-abhorrent_abuse_of_muslim_aid_by_terror_plotter, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

18. Аарон Е.Зелин (Zelin, Aaron Y.) (2013 он), "Сирийн фронтоос буцаж ирсэн Тунисын цэрэгтэй хийсэн уулзалт", «Syria Deeply» цахим хуудас, 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр, <http://beta.syriadeeply.org/op-eds/meeting-returned-tunisian-foreign-fighter-syrian-front/> 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

НОМ

19. Мэтт Апуццо (Apuzzo, Matt) болон Адам Голдман (Goldman, Adam) (2013 он), "Enemies Within: Inside the NYPD's Secret Spying Unit and Bin Laden's Final Plot Against America" ("Дайснуудын дотор: Нью-Йоркийн Цагдаагийн газрын нууц тагнуулын тасаг ба Бин Ладенийн Америкийн эсрэг хийсэн сүүлчийн хуйвалдаан"), "Touchstone" хэвлэлийн газар, Нью-Йорк хот.

20. Ричард Р. Балсамо (Balsamo, Richard R) болон Макс Дуглас Браун (Brown, Max Douglas) (2007 он), "Risk Management in Legal Medicine" ("Хууль ёсны эрүүл мэндийн салбар дахь эрсдлийн менежмент"), 7 дугаар хэвлэл, "Moseby Elsevier" хэвлэлийн газар, Филадельфи хот.

21. Тоби Ж.Ф. Бишоп (Bishop, Toby J.F.) болон Фрэнк Е.Хидоски (Hydoski, Frank E.) (2009 он), "Corporate Resiliency: Managing the Growing Risk of Fraud and Corrupton" ("Корпорацийн тэсвэртэй байдал: Луйвар, авлигын өсөн нэмэгдэж буй эрсдлийг удирдах нь"), "Wiley & Sons" хэвлэлийн газар, Хобокен хот, АНУ.

22. Жонатан Дэвис (Davies, Jonathan), Майк Финлай (Finlay Mike), Тара МакЛенаген (McLenaghan, Tara) болон Дункан Уилсон (Wilson, Duncan Уилсон) (2006 он), "Key Risk Indicators – Their Role in Operational Risk Management and Measurement" ("Эрсдлийн үндсэн үзүүлэлтүүд - Үйл ажиллагааны эрсдлийн менежмент, үнэлгээ дэх үүрэг оролцоо"), "ARM and Risk Business International Ltd" хэвлэлийн газар, Прага хот.

23. Гилл Кепел (Kepel, Gilles) (2002 он), “*Jihad: The Trial of Political Islam*” (“Жихад: Улс төрийн исламын хэрэг”), “I.B. Tauris and Co. Ltd.”, хэвлэлийн газар, Лондон хот.
24. Лиа Брайнжар (Lia, Brynjar) (2008 он), “*Architect of Global Jihad: The Life of Al-Qaeda Strategist Abu Mus’ab Al-Suri*”, (“Дэлхийн Жихадын бүтээгч: Аль-Каидагийн стратегич Абу Мусаб Аль-Суригийн амьдрал”), «Oxford University Press» хэвлэлийн газар, Оксфорд хот, Их Британи.
25. Жорж Майкл (Michael George) (2012 он), “*Lone Wolf Terror and the Rise of Leaderless Resistance*” (“Ганц чонын заналхийлэл ба удирдагчгүй эсэргүүцлийн өсөлт”, «Vanderbilt University Press» хэвлэлийн газар.
26. Наполеони Лоретта (Napoleoni, Loretta) (2013 он), “*The Evolution of Terrorist Financing Since 9/11: How the New Generation of Jihadists Fund Themselves*”, (“9/11-ээс хойшхи терроризмын санхүүжилтийн хувьсал: Жихадистуудын шинэ үеийнхэн хэрхэн өөрсдийгөө санхүүжүүлдэг вэ”), *Терроризмын эдийн засаг*, Дэвид Голд болон Шин С. Костиган нарын найруулсан, «Ashgate Publishing» хэвлэлийн газар, Алдершот хот, Их Британи Улс.
27. Марк Сегемэн (Sagement, Marc) (2008 он), “*Leaderless Jihad: Terror Networks in the Twenty-First Century*”, (“Удирдагчгүй Жихад: Хорин нэгдүгээр зууны террорист сүлжээ”, «University of Pennsylvania Press» хэвлэлийн газар.
28. Лестер М. Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2003 он), “*Global Civil Society: An Overview*”, (“Дэлхийн иргэний нийгэм: тойм”), Жон Хопкинсийн их сургуулийн Иргэний нийгмийн судалгааны төв, Балтимор хот, АНУ.
29. Лестер М. Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2013 он), “*The State of Global Civil Society and Volunteering: Latest Findings of the Implementation of the UN Nonprofit Handbook*”, (“Дэлхийн иргэний нийгэм, сайн дурын хөдөлгөөний төлөв байдал: НҮБ-ын ашгийн бус гарын авлагын хэрэгжилтийн талаархи сүүлийн үеийн ололт дүгнэлт”), Жон Хопкинсийн их сургуулийн Иргэний нийгмийн судалгааны төв, Балтимор хот, АНУ.
30. Лестер М. Саламон (Salamon, Lester M.) болон бусад (2013 он), “*Global Civil Society: Dimensions of the Non-profit Sector*”, (“Дэлхийн иргэний нийгэм: ашгийн бус салбарын хэмжээ”), Жон Хопкинсийн их сургуулийн Иргэний нийгмийн судалгааны төв, Балтимор хот, АНУ.
31. Клифтон Смит (Smith, Clifton) болон Дэвид Жей Брукс (Brooks, David J) (2013 он), “*Security Science: The Theory and Practice of Security*”, (“Аюулгүй байдлын шинжлэх ухаан: Аюулгүй байдлын онол ба практик”), «Elsevier» хэвлэлийн газар, Оксфорд хот, Их Британи Улс.

32. Малколм С. Спарроу (Sparrow Malcolm) (2000 он), "The Regulatory Craft: Controlling Risks, Solving Problems, and Managing Compliance", ("Хяналт шалгалтын урлаг: Эрсдэлийг хянах, асуудлыг шийдвэрлэх, хянан нийцүүлэлтийн менежмент"), «Brookings Institution Press» хэвлэлийн газар, Вашингтон хот, Колумбийн дүүрэг.

33. Тимоти Виттиг (Wittig, Timothy) (2011 он), "Understanding Terrorism Financing", ("Терроризмын санхүүжилтийн талаархи ойлголт", «Palgrave Macmillan» хэвлэлийн газар, Нью-Йорк хот.

ТАЙЛАН ИЛТГЭЛ, БУСАД НИЙТЛЭЛ

34. Хельмут К. Анейер (Anheier, Helmut K.) (2000 он), «Ашгийн бус байгууллагын менежмент: Шинэ хандлага руу», Иргэний нийгмийн асуудлаархи ажлын баримт бичиг 1, Лондонгийн эдийн засгийн их сургуулийн Иргэний нийгмийн төв, Лондон хот.

35. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG), (2011 он) «Судалгааны тайлан: Ашгийн бус салбарын эмзэг байдал», Сидней хот, Австрали Улс.

36. Марк Бейсил (Basile, Mark) (2004 он), "Эх сурвалжид хандах нь: Яагаад Аль-Кайдагийн санхүүгийн сүлжээ өнөөгийн терроризмын санхүүжилттэй тэмцэх дайнд тэсвэрлэж үлдэх магадлалтай болох", Зөрчил мөргөлдөөн, терроризмын судалгаа, 27: 3.

37. Томас Каротерс (Carothers, Thomas) болон Саскиа Бреченмачер (Breckenmacher, Saskia) (2013 он), "Агшиж буй орон зай: галын доорхи ардчилал, хүний эрхийн дэмжлэг" (Дэлхийн энх тайвны төлөөх Карнегийн сан, 2013 он), http://carnegieendowment.org/files/closing_space.pdf, 2014 оны 4 дүгээр сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

38. Терроризмтой тэмцэх дэлхийн хамтын ажиллагааны төв болон бусад (2013 он), "Хамгаах, урьдчилан сэргийлэх: Ашгийн бус салбарыг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах үйлдэлтэй тэмцэх асуудлаархи дэлхийн яриа хэлэлцээний үр дүн", Терроризмтой тэмцэх дэлхийн хамтын ажиллагааны төв, АНУ, х. в., www.globalcenter.org/wp-content/uploads/2013/06/Protect-Prevent-Final.pdf

39. Крон, Манни (Crone, Manni) болон Мартин Харроу (Harrow, Martin), «Баруун дахь орон нутгийн терроризм, 1989-2008», Данийн Олон улсын судалгааны хүрээлэнгийн ажлын баримт бичиг 2010:30, Дани Улсын Олон улсын судалгааны хүрээлэн, Копенгаген хот.

40. Оливер Де Шуттер (De Schutter, Oliver), Анита Рамастри (Ramastry, Anita), Марк Б. Тейлор (Taylor, Mark B.) болон Роберт С. Томпсон (Thompson, Robert C.) (2012 он), "Хүний эрхийн хянан нийцүүлэлт: Улс орны үүрэг оролцоо", Олон улсын

компанийн хариуцлагын талаархи дугуй ширээний уулзалт/Компанийн шударга байдлын талаархи Европын нийгэмлэг/Компанийн хариуцлагын талаархи Канад Улс дахь сүлжээ.

41. Хөгжил, үзэл баримтлал, сургаалын төв (2013 он), «2040 он хүртэлх дэлхийн стратегийн чиг хандлага», 4 дүгээр хэвлэл, Батлан хамгаалах яам, Лондон хот.

42. Мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх Евразийн бүлэг (EAG), (2012 он), "Мөнгө угаах зорилгоор ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах нь", Москва хот.

43. ФАТФ (2012а), "Мөнгө угаах, терроризмын санхүүжилт, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх ажилтай тэмцэх олон улсын хэм хэмжээ – ФАТФ-ын Зөвлөмж" (Зөвлөмж 8, Зөвлөмж 8-ийн тайлбар), ФАТФ, Парис хот.

44. ФАТФ (2004 он), "Мөнгө угаах асуудлын судалгааны тайлан 2002-2003 он", Парис хот.

45. ФФАТФ (2013b) "Олон улсын шилдэг туршлага: Ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглахтай тэмцэх нь", Парис хот.

46. ФАТФ (2008 он), "Терроризмын санхүүжилт", Парис хот.

47. ФАТФ (2012b), "Үйл ажиллагааны асуудлууд - Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны гарын авлага", Парис хот.

48. ФАТФ (2013а), "Мөнгө угаах, терроризмын санхүүжилтийн үндэсний түвшний эрсдэлийн үнэлгээ", Парис хот.

49. Хуан Мигуэл дель Сид (Gomez, Juan Miguel del Cid), (2010 он), "Аль-Каида болон түүнтэй холбоотой байгууллагуудын терроризмын санхүүгийн дүр зураг", Терроризмын ирээдүйн төлөв байдал, 4: 4.

50. Томас Хеггэммер (Hegghammer, Thomas) (2013 он), "Би үлдэх үү эсхүл явах уу? Өрнөдийн жихадистуудын дотооддоо эсхүл гадаадад дайтах сонголтын тайлбар», «*American Political Science Review*» сэтгүүл, 107: 1, 2013 оны 2 дугаар сар.

51. Жон Хорган (Horgan, John) болон Макс Тейлор (Taylor, Max), "Ногоон карт"-аар тоглох нь - Ирландын түр Бүгд Найрамдах Армийн санхүүжилт, 1 дүгээр хэсэг", «*Терроризм ба улс төрийн хүчирхийлэл*» сэтгүүл, 11:2, 1999 он.

52. Жон Хорган (Horgan, John) болон Макс Тейлор (Taylor, Max), "Ногоон карт"-аар тоглох нь - Ирландын түр Бүгд Найрамдах Армийн санхүүжилт, 2-р хэсэг", «*Терроризм ба улс төрийн хүчирхийлэл*» сэтгүүл, 15:2, 2003 он.

53. Үндэсний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах бие даасан зөвлөх (2013 он). 2013 оны жилийн тайлан, Австрали Улс, Канберра хот.

54. Брайан Майкл Женкинс (Jenkins, Brian Michael) (2011 он), *"Золбин ноход ба виртуал арми: 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн дараах жихадист терроризмын гишүүд, дэмжигчдийг радикалчлах, элсүүлэх"*, «RAND» корпораци.

55. Кейт Макинтош (Mackintosh, Kate) болон Патрик Дуплат (Duplat, Patrick) (2013 он), *"Донор орнуудын терроризмтой тэмцэх арга хэмжээний хүмүүнлэгийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн судалгаа"*, НҮБ-ын Хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохицуулах алба/Норвегийн дүрвэгсдийн асуудал эрхэлсэн зөвлөл.

56. Кейт Макинтош (Mackintosh, Kate) болон Патрик Дуплат (Duplat, Patrick) (2013 он), *"Донор орнуудын терроризмтой тэмцэх арга хэмжээний хүмүүнлэгийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн судалгаа"*, НҮБ-ын Хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохицуулах алба/Норвегийн дүрвэгсдийн асуудал эрхэлсэн зөвлөл, 2013 он.

57. Тамара Макаренко (Makarenko, Tamara) (2012 он), *"Европ дахь гэмт хэрэг, терроризмын харилцаа холбоо: Европын Холбоон дахь террористууд болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн харилцаа холбоо"*, Дотоод бодлогын Ерөнхий газар, Европын парламент, Брюссель хот.

58. Дэвид Малет (Malet, David) (2013 он), *"Гадаадын дайчид: Иргэний зөрчил мөргөлдөөн дэх үндэстэн дамнасан этгээдүүд"*, «Oxford University Press» хэвлэлийн газар, Нью-Йорк хот.

59. Үндэсний тагнуулын Зөвлөл (2012 он), *"2030 он хүртэлх дэлхийн чиг хандлага: Альтернатив ертөнц"*, Үндэсний тагнуулын даргын ажлын алба, Вашингтон хот, Колумбийн дүүрэг.

60. Рональд К. Нобле (Noble, Ronald K.) (2003 он), Оюуны өмч, терроризмын санхүүжилтийн гэмт хэрэг хоорондын харилцаа холбоо, Гадаад харилцааны хороонд хийсэн нийтийн сонсгол, Конгрессын 108-р хурал, АНУ-ын Төлөөлөгчдийн танхим.

61. Томас Прехт (Precht, Tomas) (2007 он), Европ дахь орон нутгийн терроризм ба исламын радикал үзэл: өөрчлөлтөөс терроризм хүртэл, Дани Улсын Хууль зүйн яам.

62. НҮБ-ын тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн тусгай илтгэгчийн тайлан, A/HRC/23/39 (НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 2013 он).

63. Жон Роллинз (Rollins, John), Жон Лайна Сун Уайлер (Wylер, Liana Sun), Сет Розен (Rosen, Seth) (2010 он), *"Олон улсын терроризм ба үндэстэн дамнасан гэмт хэрэг: Аюулгүй байдлын аюул занал, АНУ-ын улс төрийн бодлого,*

Конгресст хэлэлцэх асуудлууд”, Конгрессын судалгааны алба, Вашингтон хот, Колумбийн дүүрэг.

64. Ф. Тонкисс (Tonkiss, F.) болон А.Пэйси (Pasey, A.) (1999 он), *"Итгэл, үнэмшил, найдвар ба сайн дурын байгууллага: Шилдэг үнэт зүйлс, байгууллагууд"*, «Социологи» сэтгүүл, 33:2.

65. Их Британийн Төлөөлөгчдийн танхим (2006 он), 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Лондонгийн террорист халдлагын албан ёсны тайлан, Албан ёсны баримт бичгийг нийтлэх алба, Лондон хот, Их Британи.

66. НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба (2012 он), *"Цахим орчинг терроризмын зорилгоор ашиглах нь"*, НҮБ, Нью-Йорк хот.

67. Эмили Ван дер Дос де Вилбойс (Van der Does de Willebois, Emily) (2010 он), Ашгийн бус байгууллага, терроризмын санхүүжилттэй тэмцэх нь: Хувь тэнцүүлсэн арга хэмжээ», *Дэлхийн банкны ажлын баримт бичиг № 208*, Дэлхийн банк, Вашингтон хот, Колумбийн дүүрэг.

68. Инон фон Бехер (Von Behr, Ines), Аннинг Рединг (Reding, Anais), Чарли Эдвардс (Edwards Charlie) болон Гриббон Люк (Gribbon Luke) (2013 он), *"Тоон эрин дэх радикалчлал: терроризм, экстремизмтэй холбоотой 15 тохиолдолд цахим орчинг ашигласан нь"*, «RAND» корпорацийн Европын салбар, Кембридж хот.

БУСАД НОМ ЗОХИОЛ

69. Европын комиссын хууль зүй, эрх чөлөө, аюулгүй байдлын Ерөнхий газар (2008 он), *"ЕХ-ны түвшинд санхүүгийн гэмт хэргийн зорилгоор ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашигласан үйлдлийн цар хүрээг үнэлэх судалгаа"*, «Matrix Insight» зөвлөх компани, 2008 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр.

70. Их Британи Улсын Дотоод хэргийн яам (2007 он), *"Буяны салбарыг (Англи, Уэльст) терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах үйлдлээс хамгаалах арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ"*, *Зөвлөгөөний баримт бичиг*, 2007 оны 5 дугаар сар.

71. Их Британи Улсын Дотоод хэргийн яам, Сангийн яам (2007 он), *"Буяны салбарыг (Англи, Уэльст) терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах үйлдлээс хамгаалах арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ, Хариу арга хэмжээ, дараагийн алхмын хураангуй"*, 2007 оны 12 дугаар сар.

72. НҮБ-ын Терроризмтой тэмцэх ажлын хэсэг, *"Терроризмын санхүүжилттэй тэмцэх нь"*, 2009 оны 10 дугаар сар.

ХАВСРАЛТ А – КЕЙС ТОХИОЛДЛЫН СУДАЛГАА

187. Энэхүү типологийн тайланг бэлтгэх судалгааг олон янзын аргаар явуулсан. Үндсэндээ ФАТФ-ын гишүүн орнуудаас ирүүлсэн кейс тохиолдлын судалгааны баримт бичгийг цуглуулах, дүн шинжилгээ хийх арга замаар явуулсан бөгөөд мөн нээлттэй эх сурвалжийн мэдээллийг судалсан.

188. Кейс тохиолдлын судалгаанд хамрагдах хүсэлтийн дагуу ФАТФ-ын гишүүн орнууд болон бүс нутгийн байгууллагаас нийтдээ 14 улсын 102 кейс тохиолдлын судалгааг хүлээн авсан. Хүлээн авсан кейс тохиолдлын судалгаа нь газарзүйн хувьд Европ, Хойд Америк, Африк, Ойрхи Дорнод, Зүүн Өмнөд Ази, Далайн орнуудыг хамарч байна. Түүнчлэн тодорхой илгээгч байгууллагын хувьд кейс тохиолдлын судалгааг хууль сахиулах, тагнуул, хяналт шалгалтын байгууллага зэрэг олон янзын байгууллагаас ирүүлсэн.

189. Энэхүү тайланд нууц мэдээлэл агуулсан болон агуулаагүй кейс тохиолдлын судалгааны аль алиныг нь оруулсан. Энэ нь хоёр аргын аль алиныг нь ашиглахын тулд ингэсэн болно.

190. Кейс тохиолдлын судалгаа дүн шижилгээ нь террорист байгууллагууд АББ-ыг хууль бусаар ашиглаж болох олон янзын аргыг хэрэглэдэг болохыг харуулсан. Ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашиглах арга, эрсдэлд дараах зүйлс орно:

- Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх
- Террорист байгууллагатай харилцаа холбоотой байх
- Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах
- Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх
- Төөрөгдүүлсэн төлөөлөл

191. Төслийг хэрэгжүүлэх явцад дүн шинжилгээ хийсэн нэг зуун хоёр (102) кейс тохиолдлын судалгааг доор харуулав. Эдгээрийг АББ-ыг хууль бусаар ашиглах арга, эрсдлээр нь ангилсан. Шинжлэн судалсан кейс тохиолдлын ихэнхэд ашгийн бус байгууллагыг хууль бусаар ашигласан хэд хэдэн аргачлал, эрсдэлийн тохиолдол байсан. Гэхдээ ойлгоход хялбар болгох үүднээс кейс тохиолдлын судалгаа тус бүрийг хамгийн ноцтойгоор ашигласан арга эсхүл хор уршигтай эрсдлийг үндэслэн зөвхөн нэг бүлэгт оруулсан.

ХӨРӨНГИЙН ЗОРИУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ

Кейс тохиолдол 1-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Оффшор бүсэд бүртгэлтэй компанитай гадаадын нэгэн иргэн орон нутгийн банкинд бизнесийн данстай байжээ. Уг дансанд урт хугацаагаар нийт 1.6 сая ам.доллар бүхий чекээр орлого хийсэн байв. Банкнаас энэхүү орлогыг хийсэн хүнийг тодорхойлохыг хүссэн боловч данс эзэмшигч нь уг мэдээллийг өгөхөөс татгалзжээ.

Үүний дараагаар данс эзэмшигч нь банкандаа өөрийн нэр дээрх гадаадын банканд дахь дансанд уг мөнгөн хөрөнгийн тал хувийг шилжүүлэх захиалгыг факсаар мэдэгдсэн байна. Орон нутгийн банк энэ хэргийг сэжигтэй гэж үзэж сэжигтэй гүйлгээний мэдээллийг үндэсний санхүүгийн мэдээллийн албанд илгээжээ. Мөнгө шилжүүлэх захиалгын яаралтай байдлыг харгалзан, СМА-аас мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байх хугацаанд тав хоногийн дотор мөнгө шилжүүлэхгүй байх зааварчилгааг банкинд өгчээ.

СМА-гийн мөрдөн шалгах ажиллагааны явцад уг компани нь тус улсад албан ёсны нэг ч бизнесийн холбоо, харилцаа үүсгээгүй болох нь тогтоогдсон. Энэ хэрэгт гарсан зарим чекийг данс эзэмшигчийн гадаадад амьдардаг ах нь бичсэн байв. Бусад чекийг гадаад дахь компаниудын нэр дээр гаргасан байсан бөгөөд бүгд данс эзэмшигчийн ахтай холбоотой байв.

Түр хугацаагаар түдгэлзүүлсэн байсан уг шилжүүлгийг эцсийн дүнд хийгээгүй бөгөөд хууль сахиулах байгууллагаас авсан мэдээллээр данс эзэмшигчийн ах нь терроризмыг санхүүжүүлэхэд сэжиглэгдсэн гадаадын ашгийн бус байгууллагын үүсгэн байгуулагч нь байсан.

Мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн данс эзэмшигч нь үнэн хэрэгтээ өөрийн ахын хийсэн шилжүүлгийг нуун дарагдуулахын тулд нэр төдий өмчлөгчийн үүргийг гүйцэтгэсэн байж болзошгүй гэж дүгнэсэн. Энэ нь түүний ахад явуулсан мөрдөн шалгах ажиллагааг хүндрүүлэх зорилгоор үйлдсэн хэрэг байв.

Кейс тохиолдол 2-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Дэлхийн 160 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг нэгэн томоохон ашгийн бус байгууллага нийгмийн янз бүрийн туслалцаа дэмжлэг үзүүлдэг гэх албан ёсны зорилгодоо хөрөнгө босгох ажил хийдэг байв. Гэхдээ өмнө нь уг АББ дэлхийн олон улс оронд террорист бүлэглэлтэй нягт холбоотой байж болзошгүй хэмээн сэжиглэгдэж байсан. Сүүлийн үед хэд хэдэн улсаас уг ашгийн бус байгууллагыг олон жилийн өмнө байгуулагдаж, өнөөг болтол үйл ажиллагаа явуулж буй террорист байгууллагын ашиг сонирхолд нийцүүлэн хүмүүнлэгийн тусламжийн төсөлд хандивласан хөрөнгийн зориулалтыг өөрчлөн шилжүүлсэн гэж олон нийтийн өмнө буруутгажээ.

Тус АББ-ын бүртгэлтэй улсад данс нээлгэсэн банк нь уг АББ болон бусад байгууллагын сэжигтэй гүйлгээтэй холбогдуулан сэжигтэй гүйлгээний мэдээллийг СМА-нд явуулсан байна. Тус банкнаас болон СМА-аас явуулсан шалгалтаар эдгээр

гурван АББ-ын үйл ажиллагаа нь хоорондоо уялдаа холбоотой байсныг илрүүлжээ. Үүнтэй холбогдуулан хөрөнгийн эцсийн зориулалт болон хөрөнгийг буяны ажилд зориулаагүй, харин бусад зорилгоор ашигласан байж болзошгүй гэсэн эргэлзээ төрүүлсэн. Үнэндээ, эдгээр хөрөнгийг терроризмыг санхүүжүүлэхэд, тодруулбал «золиослогч» гэх этгээдийн өнчин хүүхэд, гэр бүлд материаллаг дэмжлэг үзүүлэх зорилгоор зарцуулсан байв.

Хууль сахиулах байгууллагаас энэ хэргийг үргэлжлүүлэн шалгаж байна.

Кейс тохиолдол 3-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Үндэсний СМА тухайн улсад бүртгэлтэй гадаад дахь ашгийн бус байгууллагын орон нутгийн салбартай холбоотой сэжигтэй гүйлгээний мэдээллийг хүлээн авчээ. Орон нутгийн ашгийн бус байгууллага нь гуравдагч улсын банкны дансаар дамжуулан гадаад дахь хориотой АББ-д мөнгө шилжүүлсэн байв. Түүнчлэн уг АББ нь өндөр эрсдэлтэй бүс нутагт байрладаг бусад ашгийн бус байгууллагад мөнгөө шилжүүлж, том мөнгөн дэвсгэртээр их хэмжээний бэлэн мөнгийг данснаасаа авсан байв.

СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагааны явцад орон нутгийн АББ-ын удирдлага их хэмжээний бэлэн мөнгийг хилээр авч гарсныг олж тогтоогджээ. Хил дамнасан бэлэн мөнгөний шилжүүлэгтэй холбоотой санхүүгийн мэдээлэлд дурдсанаар тус АББ-ын удирдлага уг мөнгийг өндөр болон бага эрсдэлтэй бүс нутагт байрладаг буяны байгууллагад хандивласан гэж мэдэгджээ.

Түүнчлэн уг орон нутгийн ашгийн бус байгууллага нь орон нутгийн өөр нэг АББ-д мөнгө шилжүүлсэн байв. Хоёр дахь ашгийн бус байгууллагын талаар хүлээн авсан санхүүгийн сэжигтэй гүйлгээний мэдээлэлд түүний удирдлага АББ-ын үйл ажиллагаатай холбоогүй бүс нутагт байдаг хөгжингүй орнуудын иргэдэд мөнгө шилжүүлсэн болохыг илтгэсэн байна.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд орон нутгийн АББ-ыг терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулж, түүний эд хөрөнгийг царцаасан байна.

Кейс тохиолдол 4-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага терроризмтой холбоотой байж болзошгүй гадны байгууллагад, түүний дотор дотооддоо болон олон улсад жагсаалтад орсон байгууллагуудад төлбөр хийсэн гэх мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсны дараа АББ-ын үйл ажиллагааг хянан шалгах үндэсний эрх бүхий байгууллагаас мөрдөн шалгах ажиллагааг явуулжээ.

Орон нутгийн АББ-ын нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт хийсэн шалгалтаар уг жагсаалтад орсон байгууллагын хаягаар төлбөр хийхээр хөрөнгө хуваарилсан байсан ч түүнийгээ хараахан шилжүүлээгүй байсан нь тогтоогджээ. Хэдийгээр орон нутгийн АББ уг байгууллагад санхүүжилт олгож байсан ч уг байгууллагыг жагсаалтад орохоос өмнө нь санхүүжүүлж байсан байна. Хэрвээ хөрөнгийг

жагсаалтад орсны дараа уг байгууллагад шилжүүлсэн байсан бол тухайн орон нутгийн АББ-ын удирдлагыг гэмт хэрэгт буруутгах байсан.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад олж авсан мэдээллийн дагуу жагсаалтад орсон байгууллагад өмнө нь шилжүүлэхийг зөвшөөрсөн байсан төлбөрийн шилжүүлгийг хийгээгүй болно.

Кейс тохиолдол 5-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Гадаадын хоёр иргэн орон нутгийн ашгийн бус байгууллагын удирдлагаар ажилладаг байв. Тус АББ-ын данстай банкны ажилтнууд тэдгээр хүмүүсийг шилжүүлэг хийхдээ дансны нэрийг (дугаарыг) андуурдаг байсныг анхааралдаа авсан байна. Түүнчлэн тэдгээр хүмүүс нь дансанд орлого хийхдээ гадаад хэл дээр гүйлгээний утгыг тайлбарлаж бичдэг байсны заримд нь террорист үйл ажиллагааны талаар дурдсан байв.

Үндэсний СМА-аас хийсэн мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ-д зөрчил мөргөлдөөнтэй бүсэд хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулахад зориулж шилжүүлэг болон мөнгөн хөрөнгө оруулалт хэлбэрээр хэд хэдэн удаагийн хандив авсан болохыг тогтоосон. Түүнчлэн тус АББ-ын дансанд хүлээн авсан хөрөнгийн тодорхой хэсгийг бэлэн мөнгөөр авсан нь тогтоогдсон байна.

Гадаад дахь террористуудын сургалтын баазыг санхүүжүүлэхэд хөрөнгө шилжүүлсэн гэх хардлага байсан тул уг ашгийн бус байгууллагыг терроризмын санхүүжилттэй холбоотой байж болзошгүй гэдэг үндэслэлээр шалгаж байгааг хууль сахиулах байгууллагаас нотолсон байна.

Кейс тохиолдол 6-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Үйл ажиллагааны зорилго нь шашин, боловсрол, хүмүүнлэгийн хөтөлбөрийг дэмжих, хэрэгжүүлэхэд чиглэнэ гэж мэдэгдсэн ашгийн бус байгууллага үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Нээлттэй эх сурвалжийн мэдээллээр уг АББ-ын нэр нь гадаадын террорист бүлэглэлийг дэмждэг гадны байгууллагын нэртэй давхцаж байсан нь үндэсний хяналтын байгууллагын анхаарлыг татжээ. Үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд уг ашгийн бус байгууллагыг гадаадын террорист бүлэглэлийг хөрөнгө нөөцөөр хангахад ашигладаг сүлжээ байгууллагатай холбоотой гэдгийг илтгэж байв. Гэхдээ хангалттай нотлох баримт байхгүй гэдэг үүднээс уг АББ-ыг бүртгэсэн байна.

Хяналтын байгууллага уг АББ-ын бүртгэлийн биелэлтийг хянах явцад тус ашгийн бус байгууллагаас ирүүлсэн заавал илтгэх тайлан нь бүрэн бус бөгөөд зөрчилтэй байсныг тэмдэглэсэн. Үүнтэй холбогдуулан хяналт шалгалтын ажиллагаа явуулаад, тус АББ-ын ихэнхи хөрөнгийг террорист бүлэглэлийн халхавч байгууллага гэдэг нь мэдэгдэж байсан гадны байгууллагаас авсан болохыг тогтоожээ. Түүнчлэн тус ашгийн бус байгууллага нь террорист байгууллагын жагсаалтад орсон хоёр байгууллагад байнга хөрөнгө нөөц явуулж байжээ.

Ерөнхийдөө уг АББ нь өөрийн ихэнхи хөрөнгө нөөц, ялангуяа гадаад руу гаргасан хөрөнгийн эцсийн зориулалтыг тайлбарлаж чадахгүй байв.

Эдгээр баримтуудыг олж мэдсэний дараа уг АББ-ын бүртгэлийг цуцалж, хяналтын байгууллага хэргийн материалыг хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлын байгууллагуудад хүргүүлжээ.

Кейс тохиолдол 7-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Орон нутгийн нэг оршин суугчийн дансанд их хэмжээний цахим мөнгөний шилжүүлэг, бэлэн мөнгөний орлогыг хийжээ. Эдгээр орлого, шилжүүлгийг тухайн нутгийн оршин суугчийн суугаа улсад байрлах хэд хэдэн хүний зүгээс хийсэн байв. Хүлээн авсан бүх хөрөнгийг данс эзэмшигч нь бэлэн мөнгөөр гаргаж авчээ.

Үндэсний СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн этгээд нь аливаа нэгэн арилжааны эсхүл бусад үйл ажиллагаа эрхэлдэггүй байсан бөгөөд зөвхөн багахан хэмжээний нийгмийн тэтгэмж авдаг байсан тул эдгээр шилжүүлгийн үндэслэлтэй тайлбарыг олж чадаагүй байна. Хамгийн өндөр хэмжээтэй төлбөрийн нэгийг орон нутгийн ашгийн бус байгууллагын удирдлагаас хийсэн байв. Хууль сахиулах байгууллагын мэдээлэл уг АББ-ын удирдлага террорист бүлэглэлтэй холбоотой байсныг илтгэсэн.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн хүний дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө нь терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан бөгөөд эдгээр хөрөнгийн тодорхой хэсгийг орон нутгийн ашгийн бус байгууллагад буяны хандивын хөрөнгийн зориулалтыг өөрчлөн шилжүүлсэн гэдгийг тогтоожээ.

Кейс тохиолдол 8-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт буяны үйлсэд зориулан хандив цуглуулдаг байв.

Тус АББ-ын удирдлагын нэг нь их хэмжээний жижиг мөнгөн дэвсгэртийг цөөн тооны том дэвсгэртэй мөнгөн тэмдэгтээр сольсны дараа банкнаас сэжигтэй гүйлгээний мэдээллийг явуулжээ. Уг удирдах албан тушаалтан энэхүү мөнгийг “дайтагч АББ” руу шилжүүлнэ гэж тайлбарласан байна.

Мөрдөн шалгах ажиллагаагаар энэхүү хөрөнгө мөнгийг бэлэн мөнгө, банкны шилжүүлэг, зээлийн картнаас хийсэн төлбөр, «PayPal» зэрэг төлбөрийн бусад системээр дамжуулж цуглуулсан хандив болохыг тогтоосон. Цаашдын мөрдөн шалгах ажиллагаагаар мөнгөн дэвсгэртийг сольсны дараахан удалгүй дээрх удирдах албан тушаалтан зөрчил мөргөлдөөнтэй бүс рүү зорчсон бөгөөд хууль зөрчиж, тухайн улсын хилээс гарахдаа бэлэн мөнгө авч гарсан тухай мэдүүлээгүй байна.

Кейс тохиолдол 9-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

АББ-ын дансанд гарын үсэг зурах эрх бүхий үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагын удирдлага ашгийн бус байгууллагын дансанд их хэмжээний бэлэн мөнгө хийхээр завджээ. Тэрбээр үл хөдлөх хөрөнгө худалдаж авах өмгөөлөгчид шилжүүлэх мөнгө байсан гэж мэдэгджээ. Гэхдээ тэрбээр мөнгөний гарал үүслийн талаар тодорхой тайлбар өгч чадаагүй бөгөөд буяны хандив байсан гэж шууд бусаар тайлбарлажээ. Орлого хийх гэж оролдсон салбарт холбогдох дансны бүртгэл байхгүй байсан гэдэг үндэслэлээр банкнаас уг бэлэн мөнгөний орлогыг авахаас татгалзсан бөгөөд банкнаас явуулсан сэжигтэй гүйлгээний мэдээлэл үндэсний СМА-ны анхаарлыг татжээ.

СМА-ийн мөрдөн шалгах ажиллагааны явцад дээрх этгээд нь хэд хэдэн удаа ашгийн бус байгууллагын нэр дээр их хэмжээний бэлэн мөнгө хийсэн нь тогтоогджээ. Түүнчлэн СМА-аас уг хүний хувийн дансанд хэд хэдэн удаа бэлэн мөнгөний орлого хийсэн болохыг тогтоосон бөгөөд энэ нь цаг хугацаа, мөнгөний хэмжээгээрээ АББ-ын нэрээр хувийн хандивлагч нараас ирсэн хандивтай тохирч байв. Мөн уг этгээд нь өөрийн хувийн данснаасаа гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой нь мэдэгдэж байсан хүний нэр дээр хэд хэдэн удаа олон улсын гүйлгээ хийсэн байна.

СМА-гийн мөрдөн шалгах ажиллагаагаар ашгийн бус байгууллагыг хөрөнгө босгох зорилгоор ашиглаж, түүнийгээ дараа нь гадаад дахь террорист үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэсэгчлэн шилжүүлсэн болохыг тогтоожээ. Уг хэрэгт нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар холбогдох хууль сахиулах болон шүүхийн байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 10-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага террорист байгууллагын жагсаалтад орсон гадаад дахь ашгийн бус байгууллагад хөрөнгө шилжүүлсэний дараагаар банкнаас сэжигтэй гүйлгээний мэдээллийг явуулжээ. Сэжигтэй гүйлгээний мэдээлэлд жагсаалтад орсон террорист байгууллагыг санхүүжүүлсэн тухай заалт орсон байв.

Хууль сахиулах байгууллага болон хэд хэдэн улсын байгууллагатай хамтран явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн орон нутгийн ашгийн бус байгууллага жагсаалтад орсон гадны АББ-д 800,000 ам.доллар шилжүүлсэн гэсэн дүгнэлтэд хүрчээ. Орон нутгийн АББ-ын удирдлага хүмүүнлэгийн тусламжийн зорилгоор мөнгө шилжүүлсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Гэхдээ тус орон нутгийн АББ-ын удирдлага уг гадны ашгийн бус байгууллагыг террорист байгууллагын жагсаалтад орсон байсныг мэддэггүй болох нь тогтоогджээ.

Эрх бүхий байгуулагаас тус АББ-ын удирдлагыг шүүхэд шилжүүлэхгүй байхаар шийджээ. Гэхдээ, цаашид АББ-ыг хууль бусаар ашиглах эрсдэлийг бууруулахын тулд тус байгууллагын удирдлага террорист байгууллагуудын жагсаалттай

танилцаж, тодорхой улс орнуудад хөрөнгө мөнгө шилжүүлэх талаар холбогдох байгууллагатай зөвлөлдөх замаар хянан магадлагааны нийцүүлэлтийн арга хэмжээг чангатгасан байна.

Кейс тохиолдол 11-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Арилжааны өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах зорилгоор орон нутгийн (үндэсний) компани байгуулагджээ. Дансанд гарын үсэг зурах эрх бүхий хүнээс компанийн дансанд их хэмжээний жижиг дэвсгэртээр орлого хийсэн байна. Үүний дараагаар мөнгийг хурдан хугацаанд гадаадын компаниудад шилжүүлжээ.

Санхүүгийн мэдээллийн албанаас хийсэн шалгалтын явцад компанийн дансанд гарын үсэг зурах эрх бүхий хүн нь мөн ашгийн бус байгууллагын тэргүүн болох нь тогтоогджээ. Компанийн дансанд орсон бага хэмжээний мөнгө нь АББ-ын цуглуулсан хөрөнгийн нэг хэсэг байсан гэх хардлага төрсөн байна.

Хууль сахиулах байгууллагын мэдээллээр уг АББ нь террорист бүлэглэлтэй холбоотой гэдэг нь мэдэгдэж байсан. АББ-ын удирдалгаар ажиллаж байсан хоёрдахь этгээд нь мөн компанийн захирал байсан бөгөөд ажиллаж уг террорист бүлэглэлтэй холбоотой байв.

Мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн компани нь гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой АББ-ын нэрийн өмнөөс мөнгө шилжүүлдэг байсан халхавч байгууллага байсан гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Кейс тохиолдол 12-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Гадаадын нэгэн иргэнээс их хэмжээний мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг хувь хүний банкны хувийн дансанд хийжээ. Хүлээн авсан мөнгийг аажмаар бэлнээр нь гаргаж авсан байна. Мэдээллийн дагуу уг этгээд нь ямар нэгэн арилжааны үйл ажиллагаа эрхэлдэггүй байсан бөгөөд шилжүүлсэн мөнгөн дүнгийн хэмжээ нь түүний дансны хувьд ер бусын байв.

Санхүүгийн мэдээллийн албанаас хийсэн шалгалтын явцад нэгэн ашгийн бус байгууллагын удирдах албан тушаалтан уг хүний дансыг захиран зарцуулах итгэмжлэлтэй болох нь тогтоогджээ. Мөн уг дансанд олон удаагийн бэлэн мөнгөний орлого хийсэн нь тогтоогдсон байна. Гэхдээ АББ-ын удирдах албан тушаалтан болон тухайн хувь хүний орлого нь шилжүүлсэн мөнгөн дүнгийн хэмжээтэй тохирохгүй байв. Түүнчлэн уг АББ нь терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах хэргийн мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан өмнө нь СМА-гийн анхаарлын төвд байжээ.

Хууль сахиулах байгууллагын мэдээллээр дээрх АББ болон тухайн удирдах албан тушаалтан нь терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахтай холбоотой үйл

ажиллагаанд явуулсан мөрдөн шалгах ажиллагааны гол этгэдүүд байжээ. СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд АББ-ын удирдах албан тушаалтан өөрийн үйл ажиллагааг нуун далдлах зорилгоор хувь хүний дансыг ашиглаж байсан нь тогтоогджээ.

Кейс тохиолдол 13-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Банкнаас гадаадын иргэд өөрсдийн эх орондоо террорист байгууллагыг дэмжих зорилгоор хөрөнгө мөнгө авсан гэх мэдээллийг хүлээн авсны дараа сэжигтэй гүйлгээний мэдээллийг явуулжээ. Мэдээллийн дагуу, хөрөнгийг олон янзын хүнээс бэлэн мөнгөний орлого хэлбэрээр эсхүл янз бүрийн хэмжээтэй мөнгөн дүнгээр цахим шилжүүлгээр авсан байв. Үүний дараагаар мөнгийг мөнгө тээвэрлэгчээр эсхүл бусад аргаар тухайн улс руу эсхүл түүний хөрш зэргэлдээ улс руу илгээсэн байв.

Үндэсний СМА-аас хийсэн шалгалтаар уг террорист байгууллагыг дэмждэг гэж сэжиглэгдэж байсан орон нутгийн (үндэсний) ашгийн бус байгууллагын удирдлагын дансан дахь мөнгөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийсэн байна. Мөрдөн шалгах ажиллагаагаар АББ-ын удирдлагын дансан дахь мөнгөний шилжилт хөдөлгөөн нь банкнаас авсан мэдээлэлтэй, тухайлбал: олон хүнээс бага хэмжээний бэлэн мөнгийг дансанд хийсэн, нийцэж байсныг тогтоосон. Үүний дараагаар мөнгийг тухайн улс руу эсхүл түүний хөрш зэргэлдээ улс руу цахим шилжүүлгээр явуулсан байв. Түүнчлэн данснаас бэлэн мөнгө гаргаж авсан байв.

Хэргийг зэрэгцэн мөрдөн шалгалт явуулж байсан хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 14-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Дөрөвдүгээр бүлэгт иш татсан)

Гадаадад хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт ажилладаг гадны түншдээ мөнгө явуулдаг байв. АББ-ын хяналт шалгалтын үндэсний байгууллагад олон нийтээс ирүүлсэн сэжүүр мэдээлэл тус АББ-ыг гадаадын террорист бүлэглэлийн халхавч гэдэг нь мэдэгдэж байсан байгууллагаас бага хэмжээний хандив хүлээж авсныг тогтоожээ. Тус АББ-аас үндэсний хяналтын байгууллагад явуулсан заавал илтгэх тайланд тус АББ-ыг уг хандивыг хүлээн авсныг нотолсон.

Тун удалгүй уг хандивтай холбоогүй аудитын шалгалтын явцад олж авсан баримтаар тус АББ нь террорист бүлэглэлийн халхавч байгууллагын мөнгө шилжүүлэх хамгийн зохимжтой суваг байсныг олж тогтоосон байна. Уг баримтын огноо нь АББ-ын хүлээн авсан хандивын хэмжээ огцом нэмэгдсэн хугацаатай таарч байв. Нээлттэй эх сурвалжийн судалгаа, үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд хийсэн дүн шижилгээгээр тус АББ-ын гурван төлөөлөгчийг гадаадын террорист

бүлэглэлийн дэмжигчид байсныг тогтоож, АББ-ын гадны түнш нь дээрх гадаадын террорист бүлэглэлийн бас нэг халхавчаар ажилладаг байгууллага байсныг олж тогтоосон байна.

Үндэсний хяналт шалгалтын байгууллагаас тус АББ-д хийсэн дараагийн хяналт шалгалтаар уг АББ нь гадны түншдээ 700,000 ам.доллар хандивласан хэдий ч эдгээр хөрөнгийг зарцуулсан эцсийн зориулалтыг тайлбарлаж чадахгүй байсныг олж тогтоосон. Эцсийн дүнд үндэсний хяналтын байгууллага уг ашгийн бус байгууллагын бүртгэлийг цуцалсан.

Кейс тохиолдол 15-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага хэд хэдэн данстай байсан бөгөөд уг АББ-ын үүсгэн байгуулагч нь тэдгээрт гарын үсэг зурах эрхтэй байв. Энэхүү дансанд хандивлагчид (донорууд)-аас бэлэн мөнгөний орлого, мөнгөн шилжүүлгийг хийдэг байсан бөгөөд шилжүүлгийн утгад хөрөнгийг зөрчил мөргөлдөөнтэй бүс нутаг руу явуулахад зориулагдсан гэж мэдэгддэг байв. Үүний дараагаар орон нутгийн ашгийн бус байгууллага гадаадад байрладаг олон улсын ашгийн бус байгууллагад их хэмжээний мөнгөн хөрөнгийг цахимаар шилжүүлсэн байна.

Үндэсний СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ-ын үүсгэн байгуулагч нь терроризмыг санхүүжүүлэхэд өөрийн албан тушаалыг санаатайгаар ашигласан болох, олон улсын ашгийн бус байгууллага нь орон нутгийн АББ-ын толгой байгууллага байсныг олж тогтоосон. Түүнчлэн уг олон улсын АББ-ыг террорист сүлжээтэй холбоотой гэдэгт сэжиглэж, түүний нэг харилцагч нь терроризмыг дэмждэг хүмүүсийн жагсаалтад орсон байв.

Кейс тохиолдол 16-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Үндэсний СМА хэд хэдэн орон нутгийн (үндэсний) ашгийн бус байгууллагын данстай холбоотой сэжигтэй гүйлгээний мэдээллийг банкнаас хүлээн авчээ. Эдгээр АББ-ын дансанд олон удаагийн бага хэмжээний орлого орж, шилжүүлгүүд гарсан байв.

Хууль сахиулах байгууллагын мэдээлэлд эдгээр ашгийн бус байгууллагын нэг нь террорист байгууллагатай холбоотой гэдэгт сэжиглэгдэж байсныг илтгэж байв. Санхүүгийн мэдээллийн албанаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар АББ-ын дансанд хийсэн бага хэмжээний орлогууд нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт хүмүүнлэгийн зорилгоор мөнгө явуулах хүсэлтэй хүмүүсээс цуглуулсан хандивын мөнгө байсныг олж тогтоожээ. Дансанд орж ирсэн мөнгөний ихэнхийг эдгээр АББ-ын нэг удирдлагынх нь хувийн дансанд шилжүүлсэн байв. Санхүүжилт орсны дараагаар уг удирдах албан тушаалтан бүх мөнгийг бэлнээр нь авдаг байсан тул уг хөрөнгийн эцсийн хүлээн авагчийг тодорхойлоход хүндрэлтэй байв.

Терроризмын үйл ажиллагааг санхүүжүүлэх эцсийн зорилготойгоор санхүүгийн системийг хөрөнгийн зориулалтыг өөрчлөхөд ашигласан байж болзошгүй гэж үзсэн

байна. Мэдээллийг уг хэрэгт холбогдсон этгээдийг шүүхээр шийдвэрлэх боломжтой гэж үзэж хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 17-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Дотооддоо болон гадаадад хүмүүнлэг, соёлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага АББ-ын хяналтын үндэсний байгууллагад хүсэлт гаргаж, бүртгүүлжээ. Тус АББ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь орон нутгийн шашны сургуулийг эрхлэн, удирдаж явуулах ажил байв. Хэсэг хугацааны дараа тус АББ-ын заавал илтгэх тайланд түүний хууль ёсны хүлээн авагчид бус олон улсын байгууллагад мөнгө шилжүүлсэн байсан нь хяналтын байгууллагын анхаарлыг татжээ.

Үүний дагуу үндэсний хяналтын байгууллагаас дээрх АББ-д шалгалт хийх явцад хянан нийцүүлэлтийн шаардлага, эрсдлийн менежменттэй холбоотой хэд хэдэн дутагдалтай асуудал илэрчээ. Тус АББ-ын төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээгээр тус АББ нь ихэвчлэн нэг удирдлагатай, хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг үндэсний АББ-ын сүлжээний хэсэг байсныг илрүүлсэн. Тус АББ-тай хамтарч ажилладаг орон нутгийн зарим байгууллагууд нь гадаадын террорист байгууллагатай холбоотой байсан. Шашны сургуулийн удирдлагаар ажиллаж байсан нэг албан тушаалтныг терроризмыг дэмжигчдийг элсүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж болзошгүй үйл ажиллагатай нь холбогдуулан хяналтын байгууллагад танигдсан байсан. Зарим нутгийн оршин суугчдаас сургуулийн сургалтын хөтөлбөрийн зарим зүйлд санаа зовж байгаагаар илэрхийлсэн боловч хууль сахиулах байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ-ын зүгээс элсүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох ямар нэг хүсэл эрмэлзэл байхгүй байсныг тогтоосон.

Түүнчлэн тус ашгийн бус байгууллага нь хараат бус хуулийн этгээд (хууль тогтоомжид заасны дагуу)-ийн хувьд үйл ажиллагаа явуулдаггүй болох нь тогтоогдсон. Тус АББ нь гадаадын хоёр томоохон байгууллагын салбар байсан. Тус АББ-ын хөрөнгийн ихээхэн хэсгийг гадаадын байгууллагад шилжүүлсэн байсан бөгөөд эдгээр хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах тухай нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг тус АББ-д бус харин дээрх гадны байгууллагад хадгалдаг байв.

Үндэсний хяналтын байгууллагаас хэрэгжилт, хянан магадлагааны нийцүүлэлтийн хангалтгүй байдал, олон улсын үйл ажиллагаанд хяналт тавихгүй байх, бусад ашиг сонирхлын байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллаж байгаа байдал нь тус АББ-ыг хууль бусаар ашиглахад өртөмтгий болгож байгааг тогтоосон. Хяналтын байгууллагаас тус АББ-ыг хууль тогтоомж, хянан магадлагааны нийцүүлэлтийг дагаж мөрдөх үүргийн талаар танилцуулж, хариуцлага, хяналтаа нэмэгдүүлэх зорилгоор хянан магадлагааны хэрэгжилтийн гэрээ байгуулсан. Уг хэргийг хараахан хаагаагүй болно.

Кейс тохиолдол 18-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Гадаадын нэгэн иргэн орон нутгийн (үндэсний) ашгийн бус байгууллагыг удирдан чиглүүлэх итгэмжлэлтэй байв. Уг этгээд нь орон нутгийн банканд хоёр хувийн данстай байсан бөгөөд түүнд нь нийгмийн даатгалын төлбөр, бэлэн мөнгөний орлогыг хүлээн авдаг байсан. Бодит байдалд уг этгээд нь ямар нэгэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй, орлогын ихэнх хэсэг нь харилцаа холбооны салбартай холбоотой байсан бөгөөд энэ нь түүний бэлэн мөнгөний орлоготой зөрж байсанд банкны анхаарлыг татжээ.

Үндэсний Санхүүгийн мэдээллийн албанаас мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж шалгалтын явцад тус АББ-ын дансанд орсон хөрөнгө нь орж ирсэн хандивын хэмжээтэй тохирч байсныг тогтоожээ. Түүнчлэн тухайн хүний дансанд болон АББ-ын дансанд орсон мөнгөний ихэнх хэсгийг уг этгээд бэлэн мөнгөөр авч байсныг тогтоожээ.

Хууль сахиулах байгууллагын мэдээллээр уг ашгийн бус байгууллагыг тухайн хувь хүн шашны байгууллагын хувьд удирдаж ажиллуулдаг байсан бөгөөд энэхүү этгээд нь тус АББ-д шашны ажил явуулдаг байжээ. Түүнчлэн хууль сахиулах байгууллагын мэдээлэлд тус АББ-ыг террорист үйл ажиллагаатай холбоотой болохыг илтгэж байв.

Кейс тохиолдол 19-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Орон нутгийн оршин суугчдыг гадаадын террорист байгууллагын нэрийн өмнөөс хөрөнгө босгож, худалдан авалт хийдэг гэх хэрэгт сэжиглэжээ. СМА, хууль сахиулах байгууллагын хамтарсан мөрдөн шалгах ажиллагаагаар хэд хэдэн хүн (сэжигтэн)-ээс их хэмжээний олон улсын мөнгөн шилжүүлэг хийж байсан нь эцсийн дүндээ гадаад дахь террорист байгууллагыг дэмжих зорилготой байсныг илрүүлжээ.

Мөрдөн шалгах ажиллагаагаар сэжигтнүүдийн босгосон хөрөнгийн ихэнх нь буяны үйл ажиллагаа эрхлэх нэрийн дор цуглуулсан бэлэн мөнгөний хандив байсныг тогтоосон байна. Түүнчлэн хүнсний барааны худалдагчид, зоогийн газар, зочид буудал зэрэг хууль ёсны бизнесийг ашиглаж хөрөнгө босгодог байжээ. Цуглуулсан мөнгийг гуравдагч этгээдийн төв банкны ашгийн бус байгууллагын нэр дээрх дансанд (нэр төдий) шууд орлого хийх замаар шилжүүлсэн байв. Хөрөнгө босгох зардлыг дээрх дансаар дамжуулан бэлэн мөнгө, чек, зээлийн картаар санхүүжүүлдэг байв.

АББ-ын банкны үндсэн дансыг шалгаж үзэхэд бусад гуравдагч этгээдээс мөнгө шилжүүлдэг байсныг илрүүлсэн. Түүнчлэн АББ-ын үйл ажиллагааны захиргааны зардлыг төлөхтэй холбоотой гэх үндэслэлээр уг үндсэн дансан дахь мөнгийг хувийн дансанд шилжүүлж байсныг тогтоожээ. Үндсэн (төв) дансны мөнгийг нэг хүний данснаас нөгөө хүний данс руу шилжүүлэх, банканд орлого хийх, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах зэрэг янз бүрийн аргаар хуваарилдаг байжээ.

Түүнчлэн уг данснаас олон улсын цахим шилжүүлэг хийх захиалгыг гол төлөв цахимаар (интернэт) хийдэг байв. Сэжигтнүүд их хэмжээний олон улсын мөнгөн шилжүүлгийг гадаадын компанид цахимаар шилжүүлдэг байсан бөгөөд тэдгээр

компанийг террорист байгууллагын санхүүгийн эх үүсвэрийг хянах, удирдахад ашигладаг халхавч байгууллага байж болзошгүй гэж үздэг байв. Мөнгөн шилжүүлгийг хүлээн авсны дараа эдгээр компаниуд нь хөрөнгийг гуравдагч орны террорист байгууллагад шилжүүлсэн байна.

Үндэсний СМА-ийн мэдээлснээр сэжигтэй гүйлгээний мэдээллээс зайлсхийх үүднээс их хэмжээний "зохион байгуулалттай" (бага хэмжээгээр хуваасан) шилжүүлгийг хийсэн байна. Ийм аргаар нэг хүнээс 300,000 гаруй ам.долларыг шилжүүлсэн байв. Олон улсын шилжүүлгийг үндсэн (төв) данс руу биш харин хоёр дахь улсын олон ондоо банкны данс руу явуулсан байв.

Эдгээр гүйлгээний ихэнхи хэсгийг сэжигтнүүдийн нэрээр хийсэн байв. Гэхдээ мөн гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс төв данснаас авсан мөнгийг цахим банкны шилжүүлэг, худалдан авалт хийхэд ашигласан байв.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд эрх баригчид хэд хэдэн хүнийг баривчилж, террорист байгууллагын гишүүнчлэл, террорист байгууллагад дэмжлэг үзүүлж, хөрөнгө нөөц олгосон, террорист байгууллагад хөрөнгө мөнгө шилжүүлсэн хэрэгт гэм буруутайд тооцсон.

Кейс тохиолдол 20-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Мехрдад Ясреби нь Иран Улсад төрсөн, АНУ-ын байнгын оршин суугч байв. 1994 онд Ясреби нь АНУ-д ашгийн бус байгууллага байгуулжээ. Уг АББ нь "Хүүхдийн сан" нэртэй байсан бөгөөд дэлхийн өнцөг булан бүрийн зовж шаналсан өнчин хүүхдүүдэд халамж тавьж, туслалцаа дэмжлэг үзүүлнэ гэх зорилгоор байгуулагдсан байв. Дээрх этгээдийн хүсэлтийн дагуу 1995 оны 1 дүгээр сард АНУ-ын Холбооны татварын алба АНУ-ын татварын тухай хуулийн 501(с)(3) хэсэгт заасны дагуу "Хүүхдийн сан"-г татвараас чөлөөлөгдөх буяны үйлсийн төлөөх ашгийн бус байгууллага гэдгээр бүртгэсэн байна.

"Хүүхдийн сан" нь татвараас чөлөөлөгдсөн статустай байсан тул түүний нийт орлогын дүн орлогын хамгийн доод хэмжээг давсан жил бүр Холбооны татварын албанд 990 маягтыг - "Татвараас чөлөөгдсөн байгууллагын мэдүүлэг"-ийг гаргаж өгөх ёстой байв. 990 маягтыг гаргуулдаг зорилгын нэг нь Холбооны татварын албыг татвараас чөлөөлөгдсөн байгууллагуудад хяналт тавих боломжоор хангадаг байв.

Мөрдөн шалгах ажиллагаагаар "Хүүхдийн сан" нь зовж шаналсан өнчин хүүхдүүдэд туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан гэж мэдүүлсэн хэдий ч тус байгууллага нь үнэн хэрэгтээ Иран Улсад үл хөдлөх хөрөнгө болон бусад зүйлд хөрөнгө оруулалт хийх хөрөнгийг шилжүүлдэг суваг байсныг олж тогтоожээ. Уг мөнгөний зарим хэсгийг олон улсын терроризм болон бусад хууль бус үйл ажиллагааг дэмждэг гэсэн шалтгаанаар Иран Улсад санхүүгийн хөрөнгө нөөцөөр хангахыг хуулиар хориглосон АНУ-ын хориг арга хэмжээг зөрчиж Иран Улсын

Засгийн газарт шууд шилжүүлсэн байв. 2011 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Ясребн болон “Хүүхдийн сан” нь уг хуйвалдаанд гэм буруутайгаа хүлээн зөршөөрсөн.

АНУ-д амьдардаг Иран Улсын иргэн байсан, доктор Хосейн Лахижи нь “Хүүхдийн сан”-ийн хамгийн том хөрөнгө оруулагч хандивлагч нь байсан. Барагцаалбал 1998 оноос 2007 оныг хүртэл Лахижни болон түүний эхнэр Нажме Вахид нар “Хүүхдийн сан”-д ойролцоогоор 1.8 сая ам.доллар хандивласан байна. Лахижни болон түүний эхнэр Вахид нар дээрх жилүүдэд өгсөн “хандивыг” өөрсдийн татварын мэдүүлгээсээ хассан байв. 2013 оны 6 дугаар сарын 27-нд хоёр долоо хоногийн турш үргэлжилсэн шүүх хуралдааны дараагаар Лахижни, Вахид нарыг мөнгө угаасан, АНУ-ын татвараас зайлсхийсэн хэрэгт буруутгаж, 12 сар 1 өдрийн хорих ял, 600,000 ам.долларын торгуулийг ноогдуулжээ. 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Лахижни, Вахид нар өөр хэрэгт гэм буруутайгаа мэдэгдэж, 12 сар 1 өдрийн хорих ялаар шийтгүүлж (өмнөх хэргийн хамт ял эдлэхээр), мөн торгууль, алданги нөхөж төлөхөөр болсон.

Кейс тохиолдол 21-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Дөрөвдүгээр бүлэгт иш татсан)

Зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт гадаадын хүмүүнлэгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх албан ёсны зорилготой ашгийн бус байгууллага байгуулагджээ. Үндэсний хяналтын байгууллага тус АББ-ын завал илтгэх тайланд дүн шинжилгээ хийх явцдаа тус АББ нь бүртгэлийн нөхцөл шаардлагыг зөрчиж түүний хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчид бус өөр байгууллагад санхүүжилт олгож байсныг тогтоосон байна.

Үндэсний хяналтын байгууллага тус АББ-д аудитын шалгалт хийж байхдаа үндэсний аюулгүй байдалтай холбоотой тагнуулын мэдээллийг хүлээн авжээ. Тагнуулын мэдээлэлд тус АББ-ыг тухайн зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын террорист байгууллагыг дэмждэг, түүний нөлөөнд байдаг хүмүүнлэгийн байгууллагын сүлжээнд харъяалагддаг гэдэгт сэжиглэгдэж байсныг илтгэж байв. Аудитын шалгалтаар тус АББ нь 600,000 гаруй ам.долларыг гадаадын террорист бүлэглэлийн халхавч байгууллагад явуулсныг тогтоосон. Уг халхавч байгууллага нь хэд хэдэн улсын жагсаалтад орсон террорист байгууллага байсан. Түүнчлэн аудитын шалгалтаар тус АББ нь өөрийн хандивласан хөрөнгийн ихэнх хэсгийн эцсийн зориулалтыг тайлбарлаж чадахгүй байсныг тогтоосон.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд үндэслэж үндэсний хяналтын байгууллага тус АББ-ын бүртгэлийг цуцалж, холбогдох баримт бичгийг үндэсний аюулгүй байдлын байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 22-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Гадаад дахь зөрчил мөргөлдөөнтэй бус нутагт буяны үйл ажиллагааг дэмжлэг зорилгоор үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагыг байгуулжээ.

Сэжигтэй гүйлгээний талаархи мэдээллийг хүлээн авсны дараа үндэсний СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн улсад босгосон хөрөнгийг гадаад дахь буяны байгууллагад шилжүүлсэн болохыг тогтоожээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар мөн гадаад дахь буяны байгууллагууд хөрөнгийг хүлээн авсны дараа түүнийгээ нэр бүхий террорист байгууллагатай холбоотой эсхүл хамааралтай хувь хүмүүс, байгууллагад тухай бүр шилжүүлж байсныг тогтоосон байна.

Хэдийгээр гадаад дахь буяны байгууллага, террорист байгууллагын хоорондын харилцаа холбоог тогтоосон боловч үндэсний (орон нутгийн) АББ, террорист байгууллага хоорондын шууд харилцаа холбоог тогтоож чадаагүй байна.

Кейс тохиолдол 23-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Банкнаас төлбөрийн буцаан олголтын талаарх сэжигтэй гүйлгээний мэдээллийг явуулжээ. Хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг ашгийн бус байгууллагаас гадаадын байгууллагад төлбөрийн буцаан олголтыг явуулахыг оролджээ. Гэхдээ уг гүйлгээг санаачилсан АББ нь террорист үйл ажиллагааг санхүүжүүлдэг байж болзошгүй гэж сэжиглэгдэж байсан байгууллагын жагсаалтад орсон байсан тул уг гүйлгээнээс татгалзсан байв.

Тус ашгийн бус байгууллагын хүлээн авсан хөрөнгийн ихэнх хэсэг нь хууль ёсны хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжих хүсэлтэй хувь хүмүүсээс өгсөн хандив байв. Тиймээс ч уг хөрөнгийг хууль ёсны гарал үүсэлтэй гэж үзэж болохоор байв. Гэхдээ цаашдын дүн шинжилгээний явцад тус АББ-ын ерөнхийлөгч нь нэгэн зэрэг гадаадын байгууллагын санхүүгийн албаны даргаар ажиллаж байсан нь илэрсэн бөгөөд тухайн байгууллага нь терроризмтой холбоотой байж болзошгүй байгууллагын хэд хэдэн жагсаалтад орсон байв. Уг этгээд өмнө нь эх орондоо засгийн газрынхаа эсрэг үйл ажиллагаанд оролцож байсан төдийгүй хэд хэдэн удаа олон нийтийн өмнө эрс тэс үзэлтэй мэдэгдэл хийж байжээ.

Тус АББ болон гадаадын хоёрдахь байгууллагаас хийсэн банкны гүйлгээг террорист үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй гэдэгт сэжиглэжээ. Уг хэрэгт нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 24-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллийн дагуу орон нутгийн (үндэсний) байгууллага гадаадад “тусламжийн цуваа”-нд хандив босгоход туслалцаа үзүүлж, энэхүү “тусламжийн цуваа”-нд оролцсон байв.

Хэдийгээр тус байгууллага өөрийгөө АББ гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй ч үндэсний хяналтын байгууллагаас түүний хөрөнгө босгосон нөхцөл байдлыг шалгаж, дүн

шинжилгээ хийхэд тус байгууллага нь үнэндээ АББ болох нь тогтоогдсон бөгөөд тиймээс ч хуульд заасны дагуу зайлшгүй бүртгүүлэх ёстой байв.

Гэхдээ хяналтын байгууллагын зүгээс тухайн байгууллагыг ашгийн бус байгууллага гэж бүртгэхэд хууль эрх зүйн шаардлагыг хангахгүй байж болзошгүй гэдэг эргэлзээтэй байжээ. Энэхүү эргэлзээ нь "тусламжийн цуваа"-ны улс төрийн шинж чанартай холбоотой байв. Ялангуяа энэ нь тус АББ-ын удирдлага террорист байгууллагын улс төрийн зэвсэгт жигүүрийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэсэн хардлагатай холбоотой байв.

Хяналтын байгууллагаас дээрх байгууллагад хандивласан хөрөнгийг (түүний цахим хуудсаар дамжуулан) хандивын бус байгууллагын дансанд шилжүүлсэн болохыг тогтоожээ. Уг "хандивын бус" байгууллага нь дайны эсрэг олон нийтийн кампанит ажил зохион байгуулах зорилгоор байгуулагдсан байв. Хяналтын байгууллагын анхаарлыг татсан зүйл нь уг хөрөнгийн нэлээдгүй их хэсгийг "хандивын бус" байгууллага эзэмшиж, хянадаг байсан бөгөөд хандив тусламжийг явуулдаг байсан нутаг дэвсгэрийн нэлээд их хэсгийг хянаж байсан террорист байгууллагад дэмжлэг үзүүлдэг улс төрийн зорилготой байгууллага байжээ.

Кейс тохиолдол 25-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Жагсаалтад орсон гадаадын террорист байгууллагын төлөөлөгчид олон нийтийн, соёлын төв гэж байгуулагдсан ашгийн бус хэд хэдэн байгууллагаар дамжуулан орон нутгийн цагаач цөөнхийн бүлгийн гишүүдээс хөрөнгө босгодог байв.

Хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагааны явцад орон нутгийн цагаач цөөнхийн бүлгийн гишүүд байсан эдгээр этгээдүүд нь цуглуулсан мөнгөө АББ-аар дамжуулан террорист байгууллагатай холбоотой гадаадын улс оронд байрладаг байгууллагууд руу шилжүүлж байсан нь тогтоогджээ.

Цахим банкны шилжүүлгийг сэжигтэй гүйлгээний мэдээлэл, санхүүгийн мэдээллийн тайлангаас зайлсхийх үүднээс "зохион байгуулалттай" (бага хэмжээгээр хувааж)-гаар шилжүүлсэн байв. Эдгээр заль мэхийг үл харгалзан уг гүйлгээний талаарх мэдээллийг үндэсний СМА-хан олж тогтоон, эрх баригчдад мөнгөний урсгалыг хянах, энэ хэрэгт холбогдсон хүмүүсийн нэрсийг тогтоох боломжийг олгосон.

Кейс тохиолдол 26-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Олон улсын ашгийн бус байгууллагын орон нутгийн салбар нь тус АББ-ын үзүүлдэг нийгмийн үйлчилгээг хөрөнгө босгох, олон нийтийн дэмжлэг авах зорилгоор ашигладаг байжээ. Үйл ажиллагааныхаа хүрээнд тус орон нутгийн салбар нь жагсаалтад орсон террорист бүлэглэлийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гадаад улс дахь гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах зорилгоор хандив цуглуулсан байв. Хууль сахиулах байгууллагаас үндэсний санхүүгийн мэдээллийн албанд тус орон

нутгийн салбарыг жагсаалтад орсон террорист бүлгийн халхавч байгууллага байж болзошгүй гэдгийг мэдэгджээ.

Гамшгийн дараа тэр даруй СМА-ийн хүлээн авсан их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээний мэдээлэлд тус орон нутгийн салбар нь ойролцоогоор 100,000 ам.долларыг дансандаа хийсэн байв. Эдгээр орлогыг хийсэн цаг хугацааг харгалзан үзвэл, мөнгийг гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах хандивын хэлбэрээр хүлээн авсан байх магадлалтай байв. Үүний дараа тус орон нутгийн салбар нь гамшигт нэрвэгдсэн улсад байрладаг олон улсын АББ-ын салбарт ойролцоо хэмжээний мөнгийг шилжүүлжээ.

Санхүүгийн мэдээллийн албанаас хийсэн дүн шинжилгээгээр дээрх олон улсын АББ болон жагсаалтад орсон террорист бүлгийн нэрийн өмнөөс худалдан авалт хийсэн байж болзошгүй гэж сэжиглэгдсэн хэсэг бүлэг хүмүүсийн хоорондын холбоог илрүүлжээ. Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээллээр худалдан авалтад оролцсон нэг хүн нь тус олон улсын АББ-ын нэрийн өмнөөс хандив цуглуулах ажилд оролцсон байв. Худалдан авах үйл ажиллагаанд оролцсон бас нэг хүн нь олон улсын АББ-тай холбоотой гуравдагч байгууллагад 20,000 гаруй ам. долларыг шилжүүлсэн өөр нэг АББ-ын захирал байсан.

Хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тайлангийн мэдээлэлд дараахь зүйлийг илтгэсэн байв. Дээр дурдсан олон улсын АББ-ыг терроризмыг санхүүжүүлсэн үйл ажиллагаатай холбогдуулан гадаад улсын жагсаалтад орсны дараа түүний орон нутгийн салбараас тус олон улсын ашгийн бус байгууллагад ажилладаг нэр бүхий хөрөнгө босгогчид их хэмжээний мөнгөн дүнтэй чек бичиж өгсөн.

Кейс тохиолдол 27-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Бүртгэлтэй орон нутгийн (үндэсний) ашгийн бус байгууллага сайн дурын ажилтнуудад буяны байгууллагын тодорхойлох тэмдэг, хандив цуглуулах хайрцаг сав, тодорхойлолтын бичиг зэрэг хөрөнгө босгох эд материалаар хангаж өгчээ. Эдгээр хүмүүс нь хүмүүнлэгийн хямралд нэрвэгдсэн хүмүүст туслах зорилгоор тус АББ-ын нэрийн өмнөөс хөрөнгө босгох бусад эд зүйлсийг цуглуулах ёстой байв. Түүнчлэн хөрөнгө босгохоос гадна тусламж хэрэгтэй хүмүүст хандив тараахыг сайн дурын ажилтнуудад даалгажээ.

АББ-ын удирдлага сайн дурын ажилтнуудынхаа үйл ажиллагаанд хамгийн бага түвшинд хяналт тавьдаг байсан бөгөөд үүнд хандивыг тараах ажил ордог байсан нь нягтлан бодох бүртгэлийн бүрдүүлэлт хийдэггүй байснаас харагдаж байв. АББ-ын удирдлага босгосон хөрөнгө мөнгө болон бусад эд хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилсан гэх нотолгоог өгч чадахгүй байсан бөгөөд зөвхөн сайн дурынхны тайланд найдаж байсан.

Ашгийн бус салбарын хяналтын үндэсний байгууллагаас хийсэн шалгалтаар сайн дурын ажилтнуудын нэг нь хөрөнгө босгох зорилгоор АББ-аас өгсөн материалыг

өөртөө үлдээсэн байсныг олж тогтоожээ. Түүнийг терроризмтой холбоотой гэдэгт сэжиглэж санхүүгийн хориг арга хэмжээ авсан жагсаалтад оруулсан байжээ. Ашгийн бус салбарын хяналтын байгууллагаас тус АББ-ын удирдлагад уг хүнийг жагсаалтад орсон болохыг мэдэгдэж, тус АББ-д хамаарах эд хөрөнгийг буцааж авах арга хэмжээг авах, цаашид үндэсний хориг арга хэмжээг зөрчсөн санхүүгийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг зөвлөсөн.

Жагсаалтад орсон уг хүн АББ-ын эд хөрөнгийг терроризмыг дэмжих зорилгоор хандив хүсэх, хөрөнгө босгоход ашигласан байсныг үгүйсгэх аргагүй юм.

Кейс тохиолдол 28-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт амьдардаг хүн амд хүмүүнлэгийн тусламж үзүүлнэ гэх зорилгоор хандив цуглуулдаг байжээ. Тус АББ хандив цуглуулахын тулд шашны байгууллагуудын дэргэд суурилуулсан тусгай хандивын хайрцгийг ашигладаг байв. Цуглуулсан мөнгийг орон нутгийн банкны дансанд хадгалдаг байв.

Тус АББ-ыг үүсгэн байгуулагчийг цуглуулсан хөрөнгө мөнгийг дурдсан хүмүүнлэгийн үйл ажиллагаанд ашиглах бус харин терроризмыг дэмжих зорилгоор хөрөнгийн зориулалтыг өөрчлөн шилжүүлсэн хэрэгт сэжиглэгжээ.

Хууль сахиулах байгууллагаас явуулсан шалгалтын үр дүнд тус ашгийн бус байгууллагын үүсгэн байгуулагчийг терроризмыг дэмжсэн хэргээр баривчилсан. Энэ хэргийг мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилсээр байгаа. Хэдийгээр өнөөг хүртэл гэм буруутай нь тогтоогдоогүй ч хандиваар цуглуулсан 60,000 ам.долларын хөрөнгийг хурааж авсан.

Кейс тохиолдол 29-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Гурав хоногийн туршид нисэх онгоцны буудалд ирсэн тухайн улсын гурван иргэн нийтдээ 120,000 ам.долларын бэлэн мөнгийг гаалийн ажилтнуудад мэдэгджээ. Гурвуулаа мөнгийг террорист бүлэглэлүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын ашгийн бус байгууллагаас авсан гэж мэдэгдсэн.

Гаалийн ажилтнууд бэлэн мөнгө оруулж ирсэн тухай мэдээллийг үндэсний санхүүгийн мэдээллийн албанд явуулжээ. Үндэсний СМА-наас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар гурвуулаа орон нутгийн банкинд данстай байсныг тогтоосон. Түүнчлэн өмнө нь тэдгээр хүмүүсийн дансанд гадаадын АББ-тай холбоотой орон нутгийн хэт даврагч шашны байгууллагаас мөнгө орж ирдэг байсныг тогтоосон.

Жилийн туршид дээрх хүмүүсийн данснаас ойролцоогоор 27,000 ам.долларыг бэлнээр гаргаж авсан байсан бөгөөд орон нутгийн хэт даврагч шашны

байгууллагын дэмжлэгтэй хөдөлгөөнүүд байдаг улс орнууд руу шилжүүлсэн байв. Үндэсний аюулгүй байдлын байгууллагын мэдээлэлд дээрх гурван этгээд нь гурвуулаа орон нутгийн хэт даврагч шашны хөдөлгөөний идэвхтэй гишүүд байсныг илтгэж байв. Түүнчлэн тухайн гадны АББ-ын байрлаж байсан улсын СМА-аас дурдсан гадны АББ нь терроризмыг дэмждэг байгууллагын жагсаалтад орсон хоёр дахь АББ-тай нэг ижил удирдлагатай байсан бөгөөд хоёр дахь АББ-тай нягт холбоотой байсныг мэдээлжээ.

Мөрдөн шалгах ажиллагаанд үндэслэн үндэсний санхүүгийн мэдээллийн албанаас хэргийг шүүх прокурорын газарт хүргүүлжээ. Хэргийг шилжүүлсний дараа үндэсний СМА-д өнөөх ашгийн бус байгууллагад бэлэн мөнгө тээвэрлэсэн гэх ижил төстэй сэжигтнүүдтэй холбоотой хэд хэдэн мэдээллийг хүлээн авчээ. Эдгээр мөнгийг ижил төстэй шашны хөдөлгөөнийг дэмжих зорилгоор зөрчил мөргөлдөөнтэй бусад бүс нутагт хүргэх зорилготой байсан.

Кейс тохиолдол 30-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Дөрөвдүгээр бүлэгт иш татсан)

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага нь гадаад улсад дотоодын зөрчил мөргөлдөөний улмаас хохирсон хүмүүст эмнэлгийн болон нийгмийн нөхөн сэргээх тусламж үзүүлэх зорилгоор байгуулагдсан гадаад улсад төвтэй, олон улсын АББ-ын олон салбаруудын нэг байв.

Тухайн гадны улс байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдэхэд орон нутгийн салбар нь хөрөнгө босгож байгалийн гамшигт нэрвэгдсэн бүс нутагт байрладаг олон улсын АББ-ын төв рүү хөрөнгийг шилжүүлжээ.

Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тус олон улсын АББ-г террорист бүлэглэлтэй холбоотой гэдэг мэдээлэл гарахад үндэсний санхүүгийн мэдээллийн албанаас мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлжээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ их хэмжээний мөнгийг хэд хэдэн завсрын дансаар дамжуулан террорист бүлэглэлийн гишүүдийн эзэмшдэг дансанд шилжүүлснийг тогтоожээ.

Гэхдээ мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ-ын удирдлага шилжүүлсэн хөрөнгийн эцсийн зориулалтыг мэдэж байсан эсэхийг нь тогтоож чадаагүй байна.

Кейс тохиолдол 31-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Гадаадад үйл ажиллагаа явуулдаг үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага олон нийтээс хандив хүсэх, бусад олон улсын байгууллагаас хандив авах замаар хөрөнгө босгодог байв. Тус АББ нь террорист бүлэглэлийн дайчдад тусламж үзүүлдэг гэдэгт сэжиглэгдэж байсан түнш олон улсын байгууллагад мөнгө шилжүүлсэн хэрэгт сэжиглэгдсэн.

Хууль сахиулах байгууллага, үндэсний СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ-ын удирдлага нь ашгийн бус байгууллагын үйл

ажиллагаатай холбоогүй гуравдагч этгээдийн компанийг удирддаг байсныг илрүүлсэн. Тус АББ-ын дансан дахь мөнгийг энэхүү компанийн дансанд шилжүүлэн түүний удирдлагад орлого оруулдаг байжээ. Үүний дараа тус АББ-ын удирдлагад төрөл бүрийн залилан луйврын хэрэгт ял шийтгэл оногдуулсан.

Кейс тохиолдол 32-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Зөрчил мөргөлдөөнтэй бүс нутгаас цагаачилж ирсэн үндэсний цөөнхийн бүлгийн гишүүдэд шашны ёслол үйлдэх байраар хангах, хүмүүнлэгийн хэрэгцээнд зориулж хөрөнгө босгох, тараах зорилгоор үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагыг байгуулжээ.

Ашгийн бус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг үндэсний байгууллага тус АББ-ын заавал илтгэх тайланд түүний хөрөнгийн хууль ёсны дэмжлэгийг хүлээн авдаггүй байгууллагад хөрөнгө мөнгө шилжүүлсэн болохыг илтгэсэн байсан нь сэжиг төрүүлжээ. Эдгээр хөрөнгийг цагаач үндэсний цөөнхийн бүлгийн эх нутагт болсон байгалийн гамшигт үзүүлэх тусламжид гэх нэрийдлээр явуулсан байв. Гэхдээ хүлээн авагч байгууллагын нэг нь цагаач үндэсний цөөнхийн бүлгийн эх нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын террорист бүлэглэлийн халхавчаар ажилладаг олон улсын байгууллагын орон нутгийн салбар байж болзошгүй байв.

Хяналтын байгууллагын тус АББ-д хийсэн аудитын шалгалтаар түүний хууль ёсны дэмжлэгийг авдаггүй таван байгууллага, хувь хүнд мөнгө шилжүүлсэн болохыг илрүүлжээ. Тодруулбал, түүний орон нутгийн салбараар дамжуулан 50,000 ам.долларыг олон улсын халхавч байгууллагад шилжүүлсэн, мөн зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт байрладаг уг халхавч байгууллагын төв рүү 80,000 ам.долларыг шууд шилжүүлсэн байв.

Шалгалт үргэлжилж байх хугацаанд хяналтын байгууллага олон нийтийн зүгээс тус АББ-тай холбоотой хоёр сэжүүр мэдээллийг хүлээж авсан. Эдгээр хоёр мэдээллийн аль алинд нь тус АББ-ын удирдлагын ил тод бус байдалд санаа зовниж буйгаа илэрхийлж, гадаад руу хөрөнгө шилжүүлэх шийдвэр нь ашгийн бус байгууллагын удирдах баримт бичигт заасан нягтлан бодох бүртгэл, хариуцлагын дүрэм журмыг зөрчсөн асуудлыг хөндсөн байв. Сэжүүр мэдээллийн нэгд нь цагаач үндэсний цөөнхийн бүлгийн хүн ам зүйн бүтцэд гарсан өөрчлөлт нь тус АББ-ын удирдах зөвлөл гадаадын террорист байгууллагад илүү эерэгээр ханддаг шинэ фракцын хяналтад орсныг илтгэсэн хэрэг гэсэн байв. Хэдийгээр эдгээр асуудлыг аудитын шалгалтын явцад хэдийнээ тогтоосон байсан ч эдгээр сэжүүр мэдээлэл нь тус АББ-ын удирдлагатай холбоотой хяналтын байгууллагын хардлагыг нотолсон.

Үүний хариуд тус АББ-ын удирдлага байгалийн гамшгийн дараа яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай байсан тул зарим дотоод дүрэм, журмыг зөрчиж, гамшигт нэрвэгдсэн бүс нутагт ажиллах боломжтой аливаа нэг байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай болсон гэж мэдэгджээ. Үүнтэй холбогдуулан тус АББ-ын

бүртгэлийг цуцлаагүй ч түүнд торгууль ноогдуулсан. Түүнчлэн тус АББ нь хяналтын байгууллагатай хянан магадлагааны нийцүүлэлт, хариуцлагын хатуу хэм хэмжээг нэвтрүүлж, мөрдүүлэх хянан нийцүүлэлтийн гэрээг байгуулсан.

Кейс тохиолдол 33-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Хоёрдугаар бүлэгт иш татсан)

2011 онд Баруун Мидландын Цагдаагийн газар Их Британи Улсын Аюулгүй байдлын алба, Лондон хотын Цагдаагийн газартай хамтран Бирмингхам хотод амьдардаг хэд хэдэн хүнд мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.¹ Мөрдөн шалгах ажиллагааны гол хоёр сэжигтэн болох Ирфан Нассер, Ирфан Халид нар 2009, 2010 онд тус тус Пакистан Улс руу зорчиж, амиа золиослогчдын үйлдсэн террорист халдлагын тухай видео бичлэг хийж, террорист ажиллагаа явуулах бэлтгэлд хамрагдсан байв.² Нассер, Халид болон тэдгээрийн хамтрагч Ашик Али нарт явуулсан гадаад болон техникийн тандалт ажиглалтын ачаар Бирмингхам хотын хүн ам ихээр цуглардаг газарт найман тэсрэх төхөөрөмжийг дэлбэлэх томоохон хуйвалдааныг илрүүлжээ.

Гадаад ажиглалтаар Нассер, Халид, Али нар Их Британи Улсад үйл ажиллагаа явуулдаг “Мусульманчуудын тусламж» (Muslim Aid) нэртэй томоохон буяны байгууллагад зориулж хотын гудамжинд хандив цуглуулдаг байсныг илрүүлжээ.³ Мөрдөн шалгах ажиллагаагаар хуйвалдагчид “Мусульманчуудын тусламж» байгууллагад хандив цуглуулах ажилтнаар сайн дураараа орсныг тогтоосон. Энэ зорилгоор тэд буяны байгууллагын нэр бүхий хандивын хайрцаг, тодруулагчтай хантаазыг авчээ. Уг гурван этгээд нэг өдрийн турш хандив цуглуулж, цуглуулсан 2500 ам.долларын хандивыг “Мусульманчуудын тусламж»-д өгсөн.

Гэхдээ хандивын хайрцаг, хантаазыг буцааж өгөхөөсөө өмнө тэд буяны байгууллагад мэдэгдэлгүйгээр “Мусульманчуудын тусламж»-ийн сайн дурын ажилтнууд нэрээр дахин хэдэн өдрийн турш хандив цуглуулах ажлыг үргэлжлүүлэн хийсэн байв. Эдгээр өдрүүдэд цуглуулсан хандивыг хуйвалдагчид өөрсдийн хувийн банкны дансанд хийсэн. Террорист халдлагыг санхүүжүүлэх зорилгоор тэд нийтдээ 23,000⁴ ам.долларыг шилжүүлсэн байв.⁵ Түүнчлэн үүнтэй ижил төстэй аргаар «Мадраш-и-Ашрафул Улум» гэх хоёр дахь буяны байгууллагын хөрөнгийг луйвардаж ашигласан байв.⁶

2011 оны 9 дүгээр сард цагдаагийн газраас Нассер, Халид, Али болон бусад хэд хэдэн сэжигтнийг баривчилж үйлдэхээр төлөвлөж байсан халдлагыг таслан зогсоосон. 2013 оны 2 дугаар сард дээрх гурван этгээдийг терроризмын хэрэгт яллагдагчаар татан, 15 жилээс бүх насаар нь хорих хүртэл ял оногдуулан шийтгэсэн.⁷

2011 онд гэмт этгээдүүдийг баривчилсны дараа цагдаагийн газраас “Мусульманчуудын тусламж» байгууллагад террорист халдлага хийхээр төлөвлөж байсан хүмүүс тус байгууллагыг хууль бусаар ашиглаж байсныг мэдэгдсэн. “Мусульманчуудын тусламж» байгууллагаас Их Британи Улсад үйл ажиллагаа

явуулдаг буяны байгууллагын үндэсний хяналтын байгууллага болох Англи, Уэльсийн буяны асуудал эрхэлсэн хороонд “ноцтой хэргийн талаарх тайлан”-г явуулсан.⁸ Хорооноос эдгээр буяны байгууллагатай цаашид тэдгээрийг хууль бусаар ашиглах эрсдлийг бууруулах арга хэмжээнд үнэлгээ хийх, бэхжүүлэх чиглэлээр хамтран ажилласан.

Тэмдэглэл:

1. Викрам Додд (Dodd, Vikram) болон Ричард Нортон Тейлор (Taylor, Richard Norton) (2011 он); “Бирминхемийн шуудан» сонин (2013 он)
2. Сандра Лавилл (La Ville, Sandra) (2013 он)
3. Жон Виллетс (Willets, John) (2012 он)
4. Нэгэн жигд байдлыг хангах үүднээс энэхүү тайланд дурдсан бүх валютыг ам.долларт (\$USD) хөрвүүлсэн.
5. Баруун Мидландын Цагдаагийн газрын терроризмтой тэмцэх алба (2012 он)
6. Никки Мэй Янг (Young, Nicki May) (2013 он)
7. Би-Би-Си (BBC) (2013 он)
8. Ники Май Мэй Янг (Young, Nicki May) (2013 он)

Кейс тохиолдол 34-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

АББ-ын үйл ажиллагаанд хяналт тавих үндэсний эрх бүхий байгууллагаас өнчин хүүхдийн хүмүүнлэгийн хэрэгцээнд тусламж үзүүлэх зорилгоор байгуулагдсан орон нутгийн (үндэсний) ашгийн бус байгууллагад шалгалт хийжээ.

Ашгийн бус салбарын үндэсний хяналтын байгууллагаас хийсэн шалгалтын үеэр тус АББ-ын зүгээс хууль зөрчсөн олон үйлдлийг илрүүлсэн нь терроризмыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг гэдэгт сэжиглэх үндэслэл болжээ. Тус ашгийн бус байгууллага нь тусгай зөвшөөрөл авахаасаа өмнө үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байсан бөгөөд эрх бүхий байгууллагад санхүүгийн тайлангаа явуулаагүй байжээ. Тэрбээр хөрөнгө босгох үйл ажиллагаа явуулж, холбогдох зөвшөөрөлгүйгээр мөнгө шилжүүлж, авсан байв. Түүнчлэн тус АББ нь үндэсний хяналтын байгууллагаас зөвшөөрсөн банкиг ашигладаггүй, харин түүний удирдлага, ажилчдын хувийн банкны дансыг үйл ажиллагаандаа ашигласан байв. Хяналтын байгууллагаас хийсэн мөрдөн шалгах ажиллагааны явцад тус АББ нь түүний мэдэгдсэн зорилгод үл нийцэх улс төрийн үйл ажиллагаатай холбоотой төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан нь тогтоогджээ. Уг АББ нь мөн гадаад түншүүдийнхээ талаар мэдэгдээгүй байсан.

Илрүүлсэн баримтыг харгалзан үзэж үндэсний хяналтын байгууллагаас тус АББ-ын банкны дансыг царцааж, үйл ажиллагааг нь түр зогсоож, түүний төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчилсөн.

Кейс тохиолдол 35-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Ашгийн бус байгууллага түүний хууль ёсны тусламжийг авдаггүй байгууллагаар дамжуулан гадаад дахь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт их хэмжээний мөнгө шилжүүлсэний дараа үндэсний хяналтын байгууллагын анхааралд өртжээ.

Үндэсний хяналтын байгууллагаас тус АББ-т хийсэн аудитын шалгалтын дүнгээр тус байгууллага нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг терроризмтой холбоотой нэр бүхий халхавч байгууллагад хэд хэдэн удаа их хэмжээний мөнгө шилжүүлснийг тогтоожээ. Түүнчлэн тус АББ нь эдгээр хөрөнгийн эцсийн зориулалтыг тодорхой тайлбарлаж чадахгүй байжээ.

Шалгалтын дараа үндэсний хяналтын байгууллагаас дээрх АББ-д санхүүгийн торгууль оногдуулсан. Түүнчлэн хяналтын байгууллагаас тус АББ-тай хянан магадлагааны нийцүүлэлт, хариуцлагын хатуу хэм хэмжээг нэврүүлж, мөрдүүлэх хянан нийцүүлэлтийн гэрээг байгуулсан.

Кейс тохиолдол 36-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Гамшгийн дараа олон улсын ашгийн бус томоохон байгууллагаас террорист байгууллагын хяналтанд байдаг бүс нутгийн хохирогчдод бэлэн мөнгө олгох замаар тусламж үзүүлж байв. Тус АББ нь бэлэн мөнгө тараах, олгох ажлыг орон нутгийн мөнгө олгох үйлчилгээ үзүүлдэг байгууллагаар дамжуулан хүргэдэг байжээ.

Дээрх АББ-ын хүсэлтээр хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрт түүний нэг түнш байгууллагаас хийсэн аудитын шалгалтын дүн анхаарал татжээ. Шалгалтаар зарим тохиолдолд мөнгө олгох үйлчилгээ үзүүлж байсан байгууллага нь жагсаалтад орсон террорист байгууллагад шилжүүлэх зорилгоор "татвар" авдаг байсныг тогтоожээ. Бусад тохиолдолд, санхүүгийн тусламж авсны дараа хандив хүлээн авагчид нь өөрсдөө террорист байгууллагын төлөөлөгчдөд "татвар" төлдөг байжээ. Шалгалтаар мөн хандивын хөрөнгийн тодорхой хэсгийг террорист зорилгоор ашиглуулахад шилжүүлнэ гэдэг нэгдсэн ойлголт, тохиролцоо байсныг илрүүлж, энэ нь тус бүс нутагт ажилладаг АББ болон бусад байгууллагын дунд түгээмэл үзэгдэл байсныг тогтоосон.

Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааг хянан шалгадаг үндэсний эрх бүхий байгууллага, үндэсний СМА болон хууль сахиулах байгууллагын хамтарсан шалгалтын дараа тус АББ-д иймэрхүү хэргийн талаар мэдээллэх үүрэгтэй болохыг мэдэгдсэн. Түүнчлэн цаашид иймэрхүү тохиолдлоос урьдчилан сэргийлэх үүднээс зохих арга хэмжээ авч ажилтнуудаа сургахыг тус АББ-д үүрэг болгосон.

Кейс тохиолдол 37-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Сэжигтэй гүйлгээний тайланд нэгэн хувь хүн цахим орчинд онлайн-данс нээж, түүгээрээ хандив цуглуулж, дараа нь хандивлагчдын ашгийн бус байгууллагад шилжүүлдэг талаар дурдсан байв. Энэ хүн нь хэд хэдэн арилжааны байгууллагын удирдлагаар ажилладаг байснаас гадна мөн уг онлайн-дансанд ордог хөрөнгийн тодорхой хэсгийг авдаг хоёр АББ-ын удирдлагаар ажилладаг байжээ.

Уг хоёр АББ-ын нэг нь 2007 онд байгуулагдсан хэдий ч 2011 оныг хүртэл орлого, зарлагын тайлангаа мэдүүлээгүй байсантай холбогдуулан сэжигтэй гүйлгээний

мэдээлэл ирсэн байв. Сэжигтэй гүйлгээний тайланд дээрх этгээд нь тус АББ-д хандивын хөрөнгийн ихээхэн хэсгийг шилжүүлсэн болохыг мэдэгдсэн байв. Түүнчлэн хоёрдахь АББ нь шашны байгууллага байсан бөгөөд дотооддоо болон гадаадад террористууд үйл ажиллагаа явуулдаг зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг байсан.

Кейс тохиолдол 38-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Орон нутгийн банкнаас үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага гадаадад байдаг террорист байгууллагад хөрөнгө босгодог гэх гадны төрийн байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу сэжигтэй гүйлгээний мэдээллийг явуулжээ. Мэдээлэлд мөн тус АББ-ын тэргүүн нь террорист байгууллагын үйл ажиллагаа явуулдаг улсын зөрчил мөргөлдөөнд оролцогч талуудын нэг талыг олны өмнө илт дэмжиж ажилладаг байсныг дурдсан байв. Түүнчлэн банкны авсан мэдээлэлд террорист байгууллагыг дэмжих зорилгоор тус АББ-ын хүлээж авсан хөрөнгийг мөнгө тээвэрлэгч эсхүл бусад аргаар уг террорист байгууллагын байрлаж байсан улс руу эсхүл түүний хөрш зэргэлдээ аль нэг улс руу шууд дамжуулдаг байсныг илтгэж байв.

Үндэсний санхүүгийн мэдээллийн албанаас хийсэн мөрдөн шалгах ажиллагаа нь банкны гадны байгууллагаас хүлээж авсан мэдээллийг баталгаажуулсан: тодруулбал тус АББ-ын хэд хэдэн хүнээс хүлээж авсан мөнгийг эдгээр хөрш зэргэлдээ улс орнууд руу илгээсэн байв. Үүнтэй холбогдуулан тус АББ-ын босгосон хөрөнгийг террорист үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигладаг байсан болж болзошгүй гэдэг сэжиг авчээ.

Хэргийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн бөгөөд түүнийг өөрсдийн мөрдөн шалгах ажиллагааны баримтад нэгтгэн бүртгэж авсан.

Кейс тохиолдол 39-Хөрөнгийн зориулалтыг өөрчлөх

Гадаадад хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага ашгийн бус салбарын үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Өргөдлийг шалгах явцад тус ашгийн бус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны талаар маш бага мэдээлэл өгсөн байсанд хяналтын байгууллага анхаарлаа хандуулжээ. Өгсөн мэдээллээс харахад тус АББ-ын үйл ажиллагааны гол зорилго нь тухайн улсдаа хөрөнгө босгох, дараа нь түүнийгээ нутгийн нэлээд хэсэг нь жагсаалтад орсон террорист байгууллагын хяналтад байдаг зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт ажилладаг гадны байгууллагад шилжүүлэхэд оршдог байсан нь тодорхой байв.

Түүнчлэн хяналтын байгууллагаас хүсэлт гаргасан АББ нь хэдийнээ бүртгүүлсэн байгууллагатай хамтран ажилладаг байсныг тогтоожээ. Хүсэлт гаргасан тус АББ-д зориулагдсан бэлэн мөнгө хэлбэртэй хандивыг хандивлагчдад (доноруудад) хүлээн авсан баримтыг гаргах боломжтой бүртгэгдсэн байгууллага нь хүлээн авдаг байв. Үүний дараа бүртгэлтэй байгууллагаас бүртгүүлэх хүсэлт гаргасан дээрх АББ-д

мөнгийг шилжүүлдэг байв. Үүнээс өмнөхөн бүртгэлтэй байгууллагад хяналт шалгалт хийх үеэр тэрбээр жагсаалтад орсон өнөөх л террорист байгууллагын халхавчаар ажиллаж байсан байгууллагад мөнгө шилжүүлснийг илрүүлсэн. Хүсэлт гаргасан АББ-ын тэргүүн өмнө нь бүртгэгдсэн байгууллагын удирдлагаар ажиллаж байсан. Түүнчлэн хүсэлт гаргасан АББ-ын өөр нэг удирдах албан тушаалтан нь бүртгэлтэй хоёрдахь байгууллагатай холбоотой байсан бөгөөд шалгалтаар уг байгууллага нь дээрх террорист байгууллагын халхавчаар ажиллаж байсан байгууллагад хөрөнгө мөнгө шилжүүлдэг байсныг илрүүлсэн.

Үндэсний хяналтын байгууллагаас хүсэлт гаргасан АББ-д тус АББ-ын үйл ажиллагаа, түүний хамтран ажилладаг үндэсний болон гадаад түншүүдийн талаар нэмэлт илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай байгаа талаар мэдэгджээ. Үүнээс хойш удалгүй тус АББ нь бүртгүүлэх хүсэлтээ буцааж авсан.

ТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБООТОЙ БАЙХ

Кейс тохиолдол 40-Террорист байгууллагатай холбоотой байх (Тавдугаар бүлэгт иш татсан)

Америкийн исламын тусламжийн байгууллага (IARA, өмнө нь Африкийн исламын тусламжийн байгууллага байсан) нь Судан Улсын Хартум хотод байрладаг олон улсын төв байртай Исламын буяны байгууллага байв. Тус байгууллагын АНУ дахь салбарын (IARA-USA) төв байр нь Миссури мужийн Колумбия хотод байрладаг байв. Тус байгууллагын Америк дахь салбар нь АНУ-д татварын тухай хууль тогтоомжийн 501(с)(3) хэсэгт заасны дагуу татвараас чөлөөлөгдсөн буяны ашгийн бус байгууллагаар бүртгэгдсэн байв.

2004 оны 10 дугаар сарын 13-ны өдөр, АНУ-ын Сангийн яамны 13224 дугаар тогтоолын дагуу IARA болон түүний олон улсын таван төлөөлөгчийг жагсаалтад орсон террорист байгууллагууд, түүний дотор «Аль-Каида»-гийн хяналтад байдаг, тэдгээрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг этгээдийн жагсаалтад оруулжээ. IARA нь «Аль-Каида»-гийн өмнөх байгууллага болох «Мактаб Аль-Хидамат» (МК) байгууллагатай албан ёсны холбоотой байсан бөгөөд түүний үүсгэн байгуулагч, санхүүжүүлэгчдийн нэг нь Осама бин Ладен байв. Хүлээн авсан баримтууд нь Америкийн исламын тусламжийн байгууллага (IARA), «Мактаб Аль-Хидамат», Осама бин Ладен нарын хооронд 1997 онос эхлэн хэдэн жилийн туршид нягт хамтран ажилласан болохыг илтгэж байв. 2000 онд IARA-ийн Афганистаны удирдагчдын нэг «Мактаб аль-Хидамат» байгууллагын Афганистан дахь удирдагчтай хамт Судан болон Ойрхи Дорнодын бусад улс орнуудад очиж, «Мактаб Аль-Хидамат»-ын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 5 сая ам.долларын хандивыг цуглуулсан байв. Нэмэлт мэдээлэлд дурдсанаар Америкийн исламын тусламжийн байгууллагын тэргүүн нь Осама бин Ладеныг аюулгүй хоргодох байранд шилжүүлэх зорилгоор яриа хэлэлцээ хийж байсан бөгөөд үүнд мөн Бин Ладены өөрийнх нь төлөөлөгчид «Мактаб аль-Хидамат», «Лажнат Аль-Дава» байгууллагаас оролцсон байв. Түүнчлэн нэгэн Судан Улсын иргэн Мали Улс руу зорчиж, тэнд IARA-ийн захирлын хамт Бин Ладенд хоргодох байр хайсан байв. Мөн

ирүүлсэн баримт нотолгоогоор 2003 оны эхээр Америкийн исламын тусламжийн байгууллага (IARA) нь Баруун Европын нэг улсад «Хамас» хөдөлгөөний төлөөлөгч, зуучлагчийн үүргийг гүйцэтгэж, террорист үйл ажиллагаанд зориулж Палестины нутаг дэвсгэр рүү хөрөнгө шилжүүлдэг байжээ. Хөрөнгө босгох ажилд "Аллах", "Израил" гэсэн нэр бүхий хандивын хайрцгийг ашиглаж байсан бөгөөд энэ нь мөнгийг израильчуудын эсрэг үйлдэх террорист халдлагад зарцуулагдах болно гэдгийг илтгэсэн хэрэг байв.

Америкийн исламын тусламжийн байгууллагыг террорист байгууллагын жагсаалтад оруулснаас гадна IARA-ийн Америк дахь салбартай холбоотой хэд хэдэн хүнд АНУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн хэргээр ял оногдуулжээ. 2005-2007 онд IARA нь түүнийг террорист байгууллагын жагсаалтад оруулсан шийдвэрийг эсэргүүцэж давж заалдсан нь амжилтгүй болсон бөгөөд уг хэрэг нь холбооны тойрогт болон давж заалдах шатны шүүхэд ялагдсан.

IARA-ийн Америк дахь салбар нь Америкийн иргэдийн "аюул заналхийлэл учруулах" улс орнуудтай хийх худалдааг хязгаарласан АНУ-ын Хуулийн дагуу (IEEPA хууль) Ирак Улс руу мөнгө эсхүл бараа бүтээгдэхүүнийг зөвшөөрөлгүйгээр шууд болон шууд бусаар дамжуулах, эсхүл шилжүүлэхийг хориглосон хориг арга хэмжээг зөрчсөн. Ирак Улсын эсрэг авсан хориг арга хэмжээг бүхэлд нь зөрчиж, IARA нь Ирак дахь төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор товхимол, хэвлэмэл сурталчилгааны материал, мэдээллийн товхимол, хувийн захидал тараах зэрэг аргаар мөнгө хандивлахыг уриалсан байв.

2010 оны 6 дугаар сард АНУ-ын иргэншилтэй, IARA-ийн АНУ-ын салбарын Гүйцэтгэх захирал асан шүүгдэгч Мубарак Хамед нь IEEPA-ийн хуулийг зөрчиж, татварын тухай хуулийн хэрэгжилтэд саад учруулсан хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Гүйцэтгэх захирлын хувьд Хамед нь тухайн улсын эсрэг авсан хориг арга хэмжээ хэрэгжиж байх үед Ирак дахь төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлыг хариуцдаг байв. Хамед 1997 оны 1 дүгээр сарын 1-нээс 2004 оны 10 дугаар сарын 13-ны хооронд IARA-ийн Америкийн салбарын татвараас чөлөөгдсөн статусыг ашиглан татварын тухай хууль тогтоомжийг зөрчсөн (АНУ-ын татварын тухай хуулийн 501(c)(3) хэсэгт заасны дагуу) гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Тэрбээр босгосон хөрөнгөө хууль ёсны буяны хандив хэмээн мэдүүлж, түүний зарим хэсгийг хууль бусаар Ирак Улс руу шилжүүлсэн байв. Хамид мөн Холбооны татварын албанд IARA-гийн Америк дахь салбараас явуулсан татварын тайланд Ирак дахь хувь хүн, хуулийн этгээдтэй хийсэн гүйлгээний мэдээлэл, IARA-ийн Америк дахь салбарын удирдлага, хяналтын бүтэц, түүний түүх, харилцааны талаархи мэдээллийг тусгаагүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн.

2010 оны 4 дүгээр сард АНУ-ын иргэншилтэй, шүүгдэгч Али Мохамед Багегни нь 1991-2004 оны хооронд IEEPA-аас тавьсан хориг арга хэмжээг зөрчсөн хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Багегни нь IARA-ийн Америк дахь салбартай холбоотой байсан бөгөөд тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг захирлуудын зөвлөлд ажилладаг байв.

2010 оны 7 дугаар сард шүүгдэгч Абдель Азим Эл-Сиддиг нь гадаадын төлөөлөгчдийг бүртгэх тухай хуулийг зөрчсөн хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Тэрбээр шүүгдэгч Силжандер болон Хамед нартай Силжандерийг гадаадын байгууллагын төлөөлөгч болгон ашиглахаар хуйвалдсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Эл-Сиддиг нь Силжандерыг Ерөнхий прокурорт бүртгүүлээгүй байсан тул түүний үйлдэл хууль бус гэдгийг мэдэж байсан. Түүнчлэн уг үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагад мэдэгдээгүй бөгөөд Силжандерын үйлчилгээнд зориулж АНУ-ын засгийн газраас төлбөр хүлээн авсан баримтыг нуусан байв.

2009 оны 12 дугаар сарын 17-ны өдөр АНУ-д хууль ёсоор байнга оршин суудаг Ирак Улсын иргэн Ахмад Мустафа нь АНУ-ын хориг арга хэмжээг зөрчиж Ирак Улс руу хууль бусаар мөнгө шилжүүлсэн хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Мустафа нь IARA-т хандивын мөнгийг цуглуулагчаар ажиллаж байсан бөгөөд Америк даяар зорчиж буяны хандив үзүүлэхийг уриалдаг байжээ.

Кейс тохиолдол 41¹ -Террорист байгууллагатай холбоотой байх (Тавдугаар бүлэгт иш татсан)

Гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах Иерусалимын сан (JFHS) нь Палестины газар нутаг дахь түнш байгууллагаараа дамжуулан хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зорилготой 1992 онд байгуулагджээ. 1992 онд JFHS нь Канад Улс дахь буяны байгууллагуудын үндэсний хяналтын байгууллага болох Канад Улсын татварын алба (CRA)-нд буяны байгууллагаар бүртгүүлэх хүсэлт гаргажээ. CRA-аас өргөдлийг хянаж үзэх явцад JFHS-ийн зорилго, үйл ажиллагаа нь Канад Улсын хууль тогтоомжийн дагуу буяны үйл ажиллагаатай холбоогүй, үндсэндээ улс төрийн шинж чанартай байсан нь анхаарал татжээ. Түүнчлэн JFHS-ийн Палестин Улс дахь газар нутагт хамтран ажилладаг түнш байгууллага нь Канад Улсын хууль тогтоомжийн дагуу түүний хууль ёсны тусламжийг хүлээн авагчид биш байв. Нээлттэй эх сурвалжийн мэдээллээс үзэхэд JFHS-ийн олон улсын түншийн зарим нь Канад Улсад террорист байгууллагын жагсаалтад орсон «Хамас» хөдөлгөөний удирдлагад үйл ажиллагаа явуулдаг хөрөнгө босгох сүлжээнд ордог байсныг илтгэж байв.² CRA-тай олон удаа харилцахдаа Иерусалимын тусламжийн сан нь хуульд заасан шаардлагын дагуу өөрийн хөрөнгө нөөцийг зохистой удирдлага, хяналтаар хангах чадвартай гэдгээ харуулж чадаагүй байна.

1998 онд Канад Улсын татварын алба (CRA)-наас JFHS-ийг бүртгэх боломжгүй гэж мэдэгджээ. Энэхүү мэдэгдлийн дараа удалгүй Канад Улс дахь Гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах олон улсын сан (IRFAN-Canada) гэх хоёрдахь АББ-аас бүртгүүлэх хүсэлт гаргажээ. 1999 онд IRFAN-Canada-ийн хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн бол JFHS нь өөрийгөө бүртгүүлэх гэсэн оролдлогоо үргэлжлүүлсээр байв. 2000 онд CRA-аас JFHS-ийг бүртгэх боломжгүй гэж дахин мэдэгдсэний дараа JFHS нь хүсэлтээ буцаасан байна. Үүний дараа Канад Улсын татварын албанд мэдэгдэлгүйгээр JFHS нь өөрийн хөрөнгийг IRFAN-Canada-д шилжүүлсэн. Хоёр байгууллага хоёулаа үйл ажиллагаагаа албан ёсоор нэгтгэхээр шийдэж, JFHS-ийн

хэд хэдэн удирдах албан тушаалтан IRFAN-Canada-ийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдаж эхэлжээ.

2003 онд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр JFHS болон IRFAN-Canada-г нэгдсэн тухай, мөн IRFAN-Canada-г «Хамас»-тай холбоотой гэсэн мэдээлэл гарчээ. Канад Улсын татварын албанаас IRFAN-Canada-ийн заавал илтгэх жилийн тайланд хийсэн дүн шинжилгээгээр эдгээр асуудлыг улам бататгаж өгчээ. 2003 оны сүүлчээр CRA-аас IRFAN-Canada-д аудитын шалгалт хийж, хянан нийцүүлэлтийн шаардлагыг хангаагүй хэд хэдэн ноцтой зөрчлийг илрүүлжээ. IRFAN-Canada нь зохих хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөрөнгийн эцсийн зориулалтыг тооцолгүйгээр гадны байгууллагад их хэмжээний хөрөнгийг шилжүүлсэн байв. Тэдгээр гадны байгууллагын зарим нь «Хамас»-ын хяналтад байдаг гэж үздэг байв. Тус байгууллага хянан магадлагааны нийцүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсний дараа IRFAN-Canada-ийн бүртгэлийг хэвээр үлдээсэн байна.

2009 онд Канад Улсын татварын албанаас 2003 онд тодорхойлсон алдаа дутагдлыг арилгасан эсэхийг нь баталгаажуулах зорилгоор IRFAN-Canada-д дахин шалгалт хийжээ. CRA нь IRFAN-Canada-ийн орон нутаг болон олон улс дахь ажлын байрнаас нь авсан санхүүгийн бүртгэл, дижитал бүртгэлийн мэдээлэл болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн баримт бичгийг шалгасан. Эдгээр баримтыг нээлттэй эх сурвалжийн мэдээлэл болон түнш байгууллагуудаас өгсөн тоо баримттай нэгтгэжээ.³

CRA-аас 2009 онд IRFAN-Canada-д хийсэн аудитын шалгалтаар хянан магадлагааны нийцүүлэлтийн шаардлагыг хангаагүй дараахь ноцтой зөрчлийг илрүүлсэн:

- 2006 оны 3 дугаар сараас 2007 оны 4 дүгээр сар хүртэл IRFAN-Canada нь орон нутгийн түншээрээ дамжуулан «Хамас»-ын байлдагчдын гэр бүлд мөнгө тараах ажилд холбоотой байсан Газа дахь «Хамас»-ын хяналттай Харилцаа холбооны яаманд 500,000 гаруй ам.долларыг шилжүүлсэн бөгөөд энэ зорилгоор шуудангийн үйлчилгээг ашигласан байв.
- Мөн энэ хугацаанд IRFAN-Canada нь орон нутгийн түншээрээ дамжуулан Газа дахь «Хамас»-ын хяналттай Эрүүл мэндийн яаманд 160,000 гаруй ам.долларыг шилжүүлсэн.
- IRFAN-Canada нь «Рамалла Закат» Хороог үргэлжлүүлэн санхүүжүүлж байсан бөгөөд 2007 онд тус Хороонд 77,000 гаруй ам.долларыг хуваарилсан байв. 1998, 2004 онд тус тус Канад Улсын татварын албанаас тус Хороог «Хамас» хөдөлгөөнтэй холбоотой гэж үздэгийг IRFAN-Canada-д анхааруулж мэдэгдсэн байв. Үүний хариуд IRFAN-Canada 2004 онд дээрх Хороотой хамтын ажиллагаагаа зогсоосон гэж мэдээлжээ. Гэхдээ аудитын шалгалтын баримтууд CRA-аас явуулсан эхний шалгалт дууссанаас хойш нэг сарын дараа тус Хороотой харилцаагаа дахин сэргээснийг илтгэж байв.

- 2007 онд IRFAN-Canada нь «Аль-Мунтада Ал-Тахкафи»-ийн Соёлын форумын төв байранд Израилийн цэргүүд дайралт хийсний дараа тус байгууллагад шинэ компьютер, албан тасалгааны тоног төхөөрөмжийг хандивлажээ. Тус байгууллага нь «Хамас»-тай нягт холбоотой байсан тул Израил Улсад хууль бус нийгэмлэгээр зарласан байв. Хандивласан тоног төхөөрөмжийн өртөг 15,000 гаруй ам.доллар байсан.

- 2007 онд IRFAN-Canada нь Израил Улсад Хамасыг дэмждэг байгууллагын жагсаалтад орсон Ливан Улсад байрладаг «Закат» санд 8.6 сая гаруй ам.долларын хөрөнгийг олгосон.

Түүнчлэн шалгалтын явцад олж авсан баримтууд нь Иордан голын Баруун эрэгт байрлах IRFAN-Canada-ийн салбарын удирдлага, тэрбээр байгууллагын дансанд нэвтрэх эрхтэй байсан, IRFAN-Canada-ын хөрөнгө болох 100,000 гаруй ам.долларыг хууль бусаар завшсаныг тогтоосон. Уг удирдах албан тушаалтан нь «Хамас»-тай холбоотой байв.

2009 онд хийсэн шалгалтын үр дүнд үндэслэн 2011 онд Канад Улсын татварын албанаас эхлээд IRFAN-Canada-ийн буяны байгууллагын бүртгэлийг түдгэлзүүлж, дараа нь цуцалсан.

2014 онд Канад Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу болон мөн CRA-аас тус байгууллагыг террорист байгууллагын жагсаалтад орсон «Хамас» хөдөлгөөнд дэмжлэг үзүүлж байсныг олж тогтоосон баримтад үндэслэж Канад Улсын Засгийн газраас IRFAN-Canada-г террорист байгууллагын жагсаалтад оруулсан.

Тэмдэглэл:

4. Энэхүү шинжлэн судалсан кейс тохиолдолд зөвхөн нээлттэй эх сурвалжаас авсан материалын үндсэн дээр боловсруулсан бөгөөд түүнийг эмхэтгэхэд улс орны асуулгын хариултыг ашиглаагүй болно. 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Канад Улсын татварын албаас IRFAN-Canada руу явуулсан байгууллагыг зохих удирдлагаар хангах шаардлагын тухай захидлыг үзнэ үү. www.globalphilanthropy.cf/index.php/blog/commnts/international_releif_fund_for_the_afflicted_and_needycanada_irfan_canada_h, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
5. Аль-Мукавама Аль-Исламия (Хамас). Олон нийтийн аюулгүй байдал, онцгой байдлын бэлэн байдлыг хангах тухай Канад Улс дахь цахим хуудсыг үзнэ үү: <http://www.publicsafety.gc.ca/cnt/ntnl-scrnt/contr-trrrsm/lstd-ntts/crnt-lstd-ntts-eng.aspx>, 2014 оны 3 дугаар сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.
6. "Гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслах олон улсын сан (Канад) болон Канад Улс (Канад Улсын татварын алба)", 2013 оны Холбооны давж заалдах шатны шүүх 178 [хавтас А-20-13] <https://www.canlii.org/en/ca/fac/doc/2013/2013fca178/2013fca178.html>, 2014 оны 6 дугаар сарын 18-нд цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

Кейс тохиолдол 42-Террорист байгууллагатай холбоотой байх

Гадаад дахь шүүх хурлын явцыг ажиглаж байх явцдаа үндэсний хяналтын байгууллага тухайн улсын үндэсний (орон нутгийн) байгууллага нь террорист байгууллагыг санхүүжүүлэхэд сэжиглэгдсэн гадаадын сүлжээтэй нягт харилцаатай байсныг анхааралдаа авчээ. Эдгээр харилцааны талаарх мэдээлэлд үндэслэн

хяналтын байгууллагаас нийтлэг удирдлага, барилга байгууламж, хөрөнгө нөөцтэй үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагын сүлжээг судалсан байна. Үүний зэрэгцээ, хяналтын байгууллага энэ бүлэгт багтсан байгууллагуудын гадаад харилцаа холбооны талаарх сэжүүр мэдээллийг олон нийтээс хүлээж авчээ.

Олон нийтийн зүгээс хүлээж авсан нэмэлт мэдээлэл нь эдгээр байгууллагын нэг удирдах албан тушаалтан нь сэжигтэй санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байсныг илтгэсэн байна. Тодруулбал, банканд мэдүүлээгүй гадаад валютын данстай байсан, АББ-ын хөрөнгийг хууль бусаар завшсан, хүчирхийлэл үйлдэх зорилгоор элсүүлэх ажилд уриалдаг хүмүүсийг дэмждэг байжээ. Илүү өргөн хүрээнд явуулсан мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд эдгээр ашгийн бус байгууллагын нэгд (дээрх бүлэгт багтсан) нь шалгалт хийхэд тус АББ нь өөрийн хөрөнгөнд зохих түвшинд хяналт тавьдаггүй байсан асуудлыг тэмдэглэжээ. Мөн хянан шалгагч нараас тавьсан үнэлгээгээр шалгалтын явцад зарим АББ-ын удирдлага буруу, дутуу мэдээлэл өгсөн байв. Түүнчлэн АББ-аас санхүүждэг гадны байгууллагыг гадаад дахь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг террорист байгууллагатай холбоотой гэж үздэг байв. Эдгээр олж тогтоосон баримтад үндэслэн уг ашгийн бус байгууллагын бүртгэлийг цуцалж, мөрдөн шалгах ажиллагааны баримт бичгийг үндэсний аюулгүй байдлын байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 43-Террорист байгууллагатай холбоотой байх

Соёлын үйл ажиллагаа явуулдаг үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Хяналтын байгууллага өргөдөлийг шалгаж үзэх явцад бодит байдалд тус АББ нь улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилготой байсанд анхаарал хандуулжээ.

Үндэсний аюулгүй байдлын мэдээллээс тус АББ нь давхардсан удирдлагатай сүлжээ байгууллагад ордог байсныг нь илрүүлжээ. Тэдгээрийн хэд хэдэн удирдах албан тушаалтан нь жагсаалтад орсон террорист байгууллагын тэргүүлэгч гишүүдтэй холбоотой гэдгийг мэддэг байжээ. Уг сүлжээнд ордог хэд хэдэн байгууллагыг жагсаалтад орсон өнөөх террорист байгууллагын халхавчаар ажилладаг олон улсын ашгийн бус байгууллагын ивээл дор ажилладаг байсан гэж үздэг байв. Түүнчлэн дээрх АББ-ын барилга байгууламжийг жагсаалтад орсон террорист байгууллагын дэмжигчдийн уулзах газар байсныг мэддэг байв.

Тус АББ-ын өргөдлийг нарийвчлан судалсны дараа үндэсний хяналтын байгууллага хэдийгээр хэд хэдэн чухал эрсдэлтэй асуудал байсан ч тухайн үед тус АББ-ыг террорист үйл ажиллагаатай холбосон гэсэн баталгаатай, найдвартай мэдээлэл байхгүй гэдэг шийдвэрт хүрчээ. Хяналтын байгууллагаас эргэлзэж байгаа асуудлын талаар тус АББ-д мэдэгдсэн бөгөөд үүний хариуд тус АББ нь мэдүүлсэн зорилго, үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулж, үүний дараа бүртгэсэн байна. Гэхдээ илрүүлсэн эрсдэлийг харгалзан үзэж хяналтын байгууллагаас АББ-ын заавал

илтгэх тайланг байнга шалгаж, тус ашгийн бус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж байв.

Дээрх АББ-ын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх явцад нээлттэй эх сурвалжийн мэдээллээс тус АББ-ын шашны удирдагчийн нэрийг нь тогтоосон байна. Үүний зэрэгцээ, үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд уг хүнийг жагсаалтад орсон террорист байгууллагатай нягт холбоотой гэдгийг илтгэсэн байна. Түүнчлэн гадаадын түншүүдээс авсан нэмэлт мэдээлэлд тус АББ-ыг бүртгүүлсэн өдрөөс хойш жагсаалтад орсон өнөөх террорист байгууллагын нэгэн өндөр албан тушаалтай гишүүн нь тус АББ-тай холбоо тогтоож, үйл ажиллагаанд нь оролцож эхэлсэн байна. Энэ хэргийг үндэсний хяналтын байгууллага үргэлжлүүлэн шалгаж байна.

Кейс тохиолдол 44-Террорист байгууллагатай холбоотой байх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

2005 оны 1 дүгээр сард Австралийн Холбооны цагдаагийн газарт (AFP) Шри Ланк Улсын Дээд Комисс (Ерөнхий консулын газар)-оос Тамил Иламын чөлөөлөх барсууд (LTTE) хөдөлгөөн Австрали Улсад хөрөнгө босгох үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй тул мөрдөн шалгах ажиллагаа явуулж өгөхийг хүсэлт болгосон захидал ирүүлжээ. Уг захидалд Азийн цунамигийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст тусламж үзүүлэх нэрийн дор LTTE-д хөрөнгө босгодог олон улсын сүлжээг заасан байв. Тус сүлжээнд Австрали, Дани, Франц, Герман, Итали, Нидерланд, Норвеги, Швед, Швейцарь, Их Британи улсуудад амьдардаг иргэд холбогдсон байв. Уг захидлыг хүлээн авсны дараа Мельбурн хотын AFP-ийн Терроризмтой тэмцэх хамтарсан багийнхан захидалд дурдсан баримтуудыг шалгаж эхэлжээ.

Мөрдөн шалгах ажиллагаагаар жижиг хороогоор удирдуулсан Мельбурн хотод бүртгэлтэй ашгийн бус байгууллага болох Тамилын зохицуулах хороо (ТСС) нь Тамил Иламын чөлөөлөх барсууд хөдөлгөөний халхавч байгууллага байсныг тогтоожээ. ТСС нь Австрали дахь Тамилчуудын нийгэмлэгт хандив үзүүлэхийг уриалах, нийгэмлэгийн гишүүдийн дунд хэвлэмэл материал тараах, радио ухуулга хийдэг байжээ. Түүнчлэн Шри Ланк Улсаас Тамилчуудыг тусгаар тогтноулах үзэл санааг улстөрчдийн дунд лоббидох, LTTE-ийн нэрийн өмнөөс цахилгаан болон далайн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл явуулдаг байв. Ятгалганд автсан Австралид амьдардаг хэдэн зуун Тамилчууд сар болгон өөрсдийн данснаасаа ТСС-ийн данс руу шууд төлбөр хийдэг байжээ. Үүнээс гадна ТСС нь гудамж талбай, худалдааны төвүүдэд хандив цуглуулдаг байв.

Мэдээллийн дагуу LTTE-ийн Австрали Улс дахь жигүүрийг гурван хүн удирддаг байсан, тодруулбал, тээвэрлэгчийн үүргийг гүйцэтгэдэг байсан Аруран Винягомурти, Тамилчуудын нийгэмлэгийн сонины редактор байсан Сивараян Ятаван, нягтлан бодогчоор ажиллаж байсан Арумуган Ражеван нар байв. Эдгээр гурван этгээд нь мөн Тамилийн зохицуулах хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг байсан. Тэдгээрийн гэрт хийсэн нэгжлэгийн үр дүнд Ражеван, Ятаван нар нь Шри Ланка дахь LTTE-ийн завинаас автомат буюугаар буудаж байгаа

болон уг хөдөлгөөний бэлтгэл сургуулилт хийдэг газруудын нэгд нь очсон тухай видео бичлэгийг олжээ. Түүнчлэн Виньягомурти, Ражеван нарын Тамил-Иламын чөлөөлөх барсууд хөдөлгөөний үүсгэн байгуулагч Велупилла Прабхакарантай хамт авахуулсан зургийг олсон. Олдсон видео бичлэгт Виньягомурти нь хамтрагчдаа "ТСС бол барсууд, харин барсууд бол ТСС" гэж хэлснийг бичсэн байв.

Эцэстээ Виньягомурти, Ятаван нар LTTE-д 1 сая гаруй ам.доллар шилжүүлсэнд гэм буруутай гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Виньягомурти нь мөн LTTE-ийг цахилгаан төхөөрөмжөөр хангаж байсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд тэдгээрийн дор хаяж нэгийг нь террорист халдлагын тэсрэх төхөөрөмжийг үйлдвэрлэх, дэлбэлэхэд ашигласан байв.

АББ-ын үйл ажиллагааг хянадаг эрх бүхий байгууллагын үүднээс авч үзэхэд Тамилын зохицуулах хорооны хэрэгт эрсдэлийн хэд хэдэн (анхаарах) шалгуур үзүүлэлтүүд байсан. Тус байгууллага нь террористууд үйл ажиллагаа явуулдаг хөгжиж буй оронд хөрөнгө шилжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн; тэрбээр байгалийн гамшигт үзэгдэлтэй холбогдуулан хөрөнгө босгосон; тэрбээр нэг үндэстэн угсаатан төвтэй байгууллага (нэг үндэстний төлөөллөөс бүрдсэн) байсан бөгөөд түүний гишүүд, дэмжигчид нь тус байгууллагыг террорист байгууллагын жагсаалтад оруулахыг зөвшөөрдөггүй байсан.

Хэргийг мөрдөн шалгах явцад Австрали Улсаас гадагшаа гарч буй хөрөнгийн урсгалд хяналт тавьдаг Австрали Улсын мөнгөн гүйлгээний тайлан, дүн шинжилгээний төв (Австралийн СМА)-өөс өгсөн санхүүгийн тагнуулын мэдээллийг ашигласан.

Тэмдэглэл:

Энэхүү шинжлэн судалсан кейс тохиолдолд Австрали Улсаас өгсөн материал болон дараахь нээлттэй хэвлэлд нийтлэгдсэн нийтлэлийг үндэслэн боловсруулсан: Кейт Мур (Moog, Keith), "Буяны байгууллагыг Шри Ланк Улсын Тамилын барсуудыг санхүүжүүлэх халхавчаар ашиглаж байжээ", «Хэралд Сан» сонин " (цахим), 04/01/2010 он, www.heraldsun.com.au/news/charity-used-as-front-to-finance-sri-lankas-tamil-tigers/story-e6frf7jo-1225848229678, 2014 оны 4 дүгээр сард цахим хуудаст хандаж, мэдээллийг авсан болно.

Кейс тохиолдол 45-Террорист байгууллагатай холбоотой байх

АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний эрх бүхий байгууллага орон нутгийн АББ-ын хэд хэдэн удирдах албан тушаалтан дотоодод болон олон улсад терроризмыг дэмждэг байгууллагын жагсаалтад орсон байгууллагын нэрийн өмнөөс ажилладаг болох, мөн тэдгээр удирдах албан ташаалтнууд нь дурьдсан байгууллагын гишүүдтэй уулзсан гэх гомдлыг олон нийтийн зүгээс хүлээж авчээ.

Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагааны явцад тус АББ-ыг үүсгэн байгуулахаасаа өмнө түүний хоёр удирдлага жагсаалтад орсон байгууллагын гишүүдтэй уулзахаар гадагшаа явсныг илрүүлжээ. Тэдгээр удирдлагын нэг нь гадаадад энх тайвны яриа хэлэлцээг урагшлуулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд жагсаалтад орсон байгууллагын төлөөлөгчөөс түүнд хандаж энэ үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэхийг хүсэлт болгосон байв. Гэхдээ дээрх

удирдах албан тушаалтан тухайн арга хэмжээнд жагсаалтад орсон байгууллагын далбаа байсан тул жагсаал дээр үг хэлэхээс татгалзжээ.

Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар дээрх удирдах албан тушаалтнууд жагсаалтад орсон байгууллагыг дэмжиж олон нийтийн өмнө ямар нэгэн мэдэгдэл хийсэн гэх нотлох баримт олоогүй байна. Гэхдээ тус АББ-ын нягтлан бодох бүртгэл, тайланд дүн шинжилгээ хийхэд тус АББ-ын санхүүгийн үйл ажиллагаанд гарч болзошгүй зарим сул талыг илрүүлж, тус АББ болон түүний удирдлага өөрсдийн дотоодын санхүүгийн бодлого, журмыг дагаж мөрдөөгүйгээс болж шаардлагагүй эрсдэлд өртсөн гэдэг дүгнэлтэд хүрчээ.

Кейс тохиолдол 46-Террорист байгууллагатай холбоотой байх

Тухайн улсад байрладаг хууль бус гэж зарлагдсан террорист байгууллага терроризмтой холбоотой үйл ажиллагааг дэмжих зорилгоор АББ-дыг хууль бусаар ашигладаг байв. Энэхүү террорист байгууллага нь тухайн улсад соёлын нийгэмлэг нэрээр бүртгэгдсэн 100 гаруй АББ-ын сүлжээг хянадаг байв. Эдгээр АББ-ууд түүний үйл ажиллагаанд зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна ашиг сонирхолд нь нийцсэн мэдээллийг түгээдэг байжээ.

Ажиглалтын явцад тус АББ-дын сүлжээ нь ресторан, баар ажиллуулах, мөн бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг байсныг нь тогтоожээ. Түүнчлэн эдгээр АББ-ууд нь сайн дурын хандивыг цуглуулж, тус террорист байгууллагыг дэмжих зорилгоор хэвлэмэл материал, бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг байжээ. Эцэст нь тус сүлжээ нь засгийн газрын буцалтгүй тусламжийг авахын тулд өөрсдийн АББ-ын статусыг ашигласан байв.

Одоогийн байдлаар тус АББ-ын сүлжээтэй холбоотой 25 гаруй хүнийг шүүхээр эрүүгийн хариуцлага хүлээлгээд байна. Түүнчлэн 100 гаруй АББ болон тэдгээртэй холбоотой хүмүүсийн эд хөрөнгийг хураах, царцаах болон АББ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх эсхүл зогсоох арга хэмжээг авсан.

Кейс тохиолдол судалгаа 47-Террорист байгууллагатай холбоотой байх

Нэрд гарсан орон нутгийн АББ нь бусад орон нутгийн АББ-дын тусын тулд цалингаасаа хандив үзүүлэх хүсэлтэй хүмүүст цахим-зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг байжээ.

Дотоодын терроризмтой тэмцэх хууль тогтоомжийн дагуу тус АББ нь терроризмтой холбоотой гэдэгт сэжиглэгдэж байсан ашгийн бус салбарын байгууллагад хандив өгч байсан хүмүүс болон мөн тэдгээр байгууллагуудын талаар хэд хэдэн сэжигтэй гүйлгээний мэдээллийг явуулжээ. Мэдээллийн дагуу тэдгээр байгууллагууд нь өөр хоорондоо холбоотой томоохон АББ-ууд байжээ.

Сэжигтэй гүйлгээний мэдээлэл явуулсан АББ нь өөрийн үйлчлүүлэгчиддээ тавих хянан магадлагааны нийцүүлэлтийн шалгалтаар тэдгээр байгууллагуудын нэг нь

терроризмтой холбоотой байж болзошгүй гэдэг үндэслэлээр хориг тавиулж байсныг нь тогтоожээ.

Кейс тохиолдол 48-Террорист байгууллагатай холбоотой байх

Өнчин хүүхдүүдэд тусламж үзүүлэх зорилготой орон нутгийн АББ ашгийн бус байгууллагын үйл ажиллагааг хянадаг үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Өргөдөлд тус АББ нь гадаад дахь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт, ялангуяа террорист байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хотуудад хөрөнгийг явуулна гэдгийг заасан байв.

Нээлттэй эх сурвалжийн мэдээллийг судалж үзэхэд тус АББ-ын нэг захирал нь терроризмын хэрэгт татагдаж гадны улсад хэрэгт холбогдож байсныг нь илчилсэн байна. Шүүхийн баримт бичгийн дагуу тус АББ-ын захирал нь гадны террорист бүлэглэлийн нэрд гарсан гишүүнтэй хамтран ажилладаг байжээ. Түүнчлэн нээлттэй эх сурвалжийн мэдээллийн судалгаагаар тус АББ нь бүртгүүлэх өргөдөлд заасан төсөл хөтөлбөртэй нь үл нийцэх үйл ажиллагааг гадны улсад явуулж байсныг тогтоожээ.

Хяналтын байгууллагад өгсөн үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд уг захирал нь үнэхээр гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой байсныг мөн өнөөх террорист бүлэглэлтэй холбоотой гэж үздэг өндөр эрсдэлтэй хэд хэдэн байгууллагын захирлаар ажиллаж байсныг нь илтгэж байв. Түүнчлэн үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд тус АББ нь өнөөх террорист бүлэглэлийг дэмждэг байсан өндөр эрсдэлтэй бусад байгууллагатай үйл ажиллагааны холбоотой байжээ.

Эдгээр судалгааны үр дүнд үндэслэж үндэсний хяналтын байгууллагаас тус АББ-ыг бүртгэхээс татгалзаж, холбогдох мэдээллийг эрх бүхий бусад үндэсний аюулгүй байдлын байгууллагын мэдэлд шилжүүлжээ. Тус АББ нь хяналтын байгууллагын шийдвэрийг давж заалдах гэж оролдсон ч амжилтанд хүрээгүй байна.

Кейс тохиолдол 49-Террорист байгууллагатай холбоотой байх

Зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт төвтэй олон улсын АББ нь террорист байгууллага үйл ажиллагаа явуулдаг улсын орон нутгийн банкинд данс нээхийг оролджээ. Тус банкны үйлчлүүлэгчиддээ хийсэн хянан нийцүүлэлтийн шалгалтаар тус АББ болон түүний нэг удирдах албан тушаалтан нь хоёр улсад терроризмыг санхүүжүүлсэн хэрэгт буруутгагдаж байсныг тогтоожээ. Тус банкнаас сэжигтэй гүйлгээний мэдээллийг үндэсний СМА-нд явуулж, үндэсний СМА-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд тус АББ нь тухайн улсад удаан хугацаанд үйл ажиллагаа явуулж байсныг, мөн гурван өөр банкинд хэд хэдэн данстай байсныг нь илрүүлжээ. Эдгээр данснаас хийсэн гүйлгээ нь дансны мэдээлэлтэй таарахгүй байв. Ойр ойрхон дансанд бэлэн мөнгөөр орлого хийж, авч байсан бөгөөд мөн

тухайн улсын доторх АТМ-ээр дамжуулан гүйлгээг хийдэг байсан бөгөөд эдгээр гүйлгээг террорист байгууллагуудын үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг газар нутагт, тус АББ-тай тодорхой холбоогүй хүмүүс хийсэн байжээ. Түүнчлэн тус АББ-ын данснаас энэ байгууллагатай тодорхой холбоогүй хүмүүсийн дансанд хөрөнгө шилжүүлсэн байв. Бэлэн мөнгөний орлогыг нэг ижил банкны хэд хэдэн салбараар дамжуулж шилжүүлдэг байсан бөгөөд терроризмыг дэмждэг улсын иргэн гадны улсаас АББ-ын данс руу шилжүүлсэн байв. Мөн зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт байрладаг түүний төв байрнаас АББ-ын дансанд хэд хэдэн удаа шилжүүлэг хийсэн байв.

Цаашдын мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ нь террорист бүлэглэлийг дэмждэг байгууллагатай холбоотой байсан бөгөөд түүний үйл ажиллагаа нь гадаадын хоёр террорист хөдөлгөөнийг дэмжсэн болохыг тогтоожээ. Тус АББ-аас тус улсын дотор зорчдог ажилчдынхаа цалинг тавьсан гэж мэдэгджээ.

Кейс тохиолдол 50-Террорист байгууллагатай холбоотой байх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Шашны ашгийн бус байгууллагаар бүртгэгдсэн дотуур байртай сургууль терроризмын хэрэгт оролцсон гэдэгт сэжиглэгдсэн хүмүүсийн жагсаалтад орсон хүнийг ажилд авчээ. Энэ хүн нь террорист халдлагын улмаас эрэн сурвалжлагдаж байсан оргодлуудыг орогнуулсан байв.

Хуурамч үнэмлэх ашиглан тэрбээр оршин суух зөвшөөрөл авч, дотуур байртай сургуульд англи хэлний багшаар ажилд орсон байв. Тус сургуулийн захирал энэ хүний жинхэнэ нэрийг болон түүнийг терроризмын хэрэгт сэжиглэж буй хүмүүсийн жагсаалтад орсныг мэдээгүй байсан.

Хожим нь энэ хүнийг терроризмтой холбоотой хэрэгт гэм буруутай гэж үзэж, ял оногдуулсан.

Кейс тохиолдлын судалгаа 51 – Террорист байгууллагатай холбоотой байх

АББ ашгийн бус байгууллагын үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргахдаа шашин, соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой гэж мэдэгджээ. Хяналтын байгууллагаас тус АББ-ын өргөдөл болон нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд судалгаа дүн шинжилгээ хийх явцад тус АББ-ын зарим төрлийн үйл ажиллагаа нь түүний мэдүүлсэн зорилтын нь хүрээнээс гарсан байсныг анхааралдаа авч тэмдэглэжээ. Үүний зэрэгцээ, үндэсний хяналтын байгууллага үндэсний тагнуул, аюулгүй байдлын байгууллагын тайлантай танилцахад түүнд тус АББ-ын удирдах албан тушаалтны нэг нь терроризмыг дэмждэг гэдгээрээ нэрд гарсан улстай нягт холбоотой гэдгийг илтгэсэн байв.

Хяналтын байгууллагаас тус АББ-ын хүсэлтэд хариу мэдэгдэхдээ эргэлзэж буй асуудлын талаар тайлбарлаж, тус АББ-ын үйл ажиллагаа болон түүний бусад

байгууллагуудтай харилцах харилцааны талаар нэмэлт мэдээлэл ирүүлэхийг хүсэлт болгожээ. Хожим нь тус АББ өргөдлөө буцааж, хэзээ ч бүртгүүлээгүй байна.

Кейс тохиолдол 52-Террорист байгууллагатай холбоотой байх

Жагсаалтад орсон террорист байгууллагатай холбоотой гэдэгт сэжиглэгдэн хэд хэдэн улсын жагсаалтад орсон гадаадын АББ хэд хэдэн орон нутгийн АББ-д хөрөнгө шилжүүлсэн байв. Хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлын байгууллагаас үндэсний СМА-д өгсөн мэдээлэлд тэдгээр орон нутгийн АББ-ууд нь тухайн улсын жагсаалтад орсон хэт даврагч үзэлтэй бүлэглэлүүд, түүний дотор орон нутгийн террорист байгууллагуудад үзэл суртлын болон санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн хэрэгт сэжиглэгдэж байжээ.

Санхүүгийн тагнуулын мэдээлэлд уг гадны АББ нь 100,000 гаруй ам.долларыг үндэсний шашны төвд шилжүүлсэн байв. Уг шашны төвийн захирлыг тухайн улсын жагсаалтад орсон террорист байгууллагууд болон хэт даврагч үзэлтэй бүлэглэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хувийн болон шашны байгууллагын дансыг ашигласан гэдэгт сэжиглэгдэж байжээ. СМА-д өгсөн мэдээллийн дагуу энэ хүн өмнө нь террорист үйл ажиллагааг дэмжсэн үг хэлсэн байв.

СМА-аас мөн дээрх гадны АББ-ын хяналтад байдаг олон улсын АББ-аас 150,000 гаруй ам.долларыг орон нутгийн хоёрдахь шашны төвд шилжүүлснийг тогтоожээ. Энэхүү хоёрдахь шашны төвийг СМА-аас тус улс дахь терроризмын хуйвалдаанд холбоотой гэж тодорхойлсон байв.

Түүнчлэн гадны АББ болон түүнтэй холбоотой байгууллагууд нь ойролцоогоор 120,000 ам.долларыг орон нутгийн гуравдахь АББ-д шилжүүлсэн байв. Энэхүү гуравдахь АББ-ыг өмнө нь террорист бүлэглэлийн халхавч байгууллага гэдэг нь мэдэгдэж байсан гадны АББ руу мөнгө шилжүүлсэн гэдгээр СМА-ийн анхаарлын төвд байжээ. СМА-д үндэсний аюулгүй байдал, тагнуулын түнш байгууллагаас нь өгсөн мэдээллээр гурав дахь АББ-ын удирдлага нь албан тушаалаа ашиглан радикал үзэл суртлыг дэлгэрүүлдэг байжээ. Түүнчлэн уг гуравдахь АББ нь хоёр дахь олон улсын АББ-аас бараг 1 сая ам.долларын цахим шилжүүлгийг хүлээн авсан байв. СМА-д өгсөн мэдээллээр хоёрдахь олон улсын АББ нь хэт даврах үзэлтэй холбоотой орон нутгийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар өөрийн радикалчлалын хөтөлбөрийг өргөжүүлэх гэж оролдсон байв.

Кейс тохиолдол 53-Террорист байгууллагатай холбоотой байх

Орон нутгийн жижиг арилжааны компанийн эзэн мөн орон нутгийн АББ-ын тэргүүнээр ажилладаг байв. Хууль сахиулах байгууллагын мэдээллээр тус орон нутгийн АББ нь террорист байгууллага болон амиа золиослогч террористуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг гэдэгт сэжиглэгдэж байсан олон улсын АББ-ын салбар нь байжээ.

СМА-гийн мөрдөн шалгах ажиллагаагаар ихээхэн хэмжээний хөрөнгийг дээрх жижиг арилжааны компанийн дансанд тогтмол хийдэг байжээ. Үүний дараа уг хөрөнгийн зарим хэсгийг гадны зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт байдаг хүмүүст шилжүүлсэн байв. Уг гүйлгээний шинж чанар нь компанийн үйл ажиллагаатай нийцэхгүй байв. Тус жижиг арилжааны компаниас шилжүүлсэн хөрөнгийн гадаад дахь хүлээн авагчдын нэг нь терроризмтай холбоотой олон улсын АББ-ын тэргүүн нь байв.

Дээрх орон нутгийн АББ-ыг өмнө нь мөн терроризмыг санхүүжүүлсэн хэргийн мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан үндэсний СМА анхааралдаа авсан байжээ.

Кейс тохиолдол 54-Террорист байгууллагатай холбоотой байх

АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний хяналтын байгууллагад АББ бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Өргөдөл гаргагч АББ-ын үндсэн үйл ажиллагаа нь шашны байгууллага болон түүнтэй холбогдох боловсрол, соёлын хөтөлбөрийг удирдан зохион байгуулах гэж мэдүүлжээ. Хяналтын байгууллага өргөдөл гаргасан АББ-ын баримт бичгийг нягтлан үзэх явцад тус АББ нь бүртгэлтэй өөр нэг байгууллагатай нягт холбоотой болохыг анзаарчээ. Өргөдөл гаргагч АББ болон уг бүртгэлтэй байгууллага нь нийтлэг хаяг, холбоо барих мэдээлэл, удирдлагатай байснаас гадна хоорондоо их төстэй санхүүгийн тайлантай байжээ. Уг бүртгэгдсэн байгууллага нь терроризмтой холбоотой байж болзошгүй, тэр дундаа террорист үйл ажиллагааг дэмждэг гэж үздэг гадны этгээдүүдээс санхүүжилт авсан зэрэг асуудлаар өмнө нь хяналтын байгууллагын хараанд орсон байжээ. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой тагнуулын мэдээлэлд мөн өргөдөл гаргагч АББ болон бүртгэлтэй байгууллагад нийтлэг хэд хэдэн удирдах албан тушаалтан нь терроризмыг дэмжсэн үйл ажиллагаатай холбоотой гэж үздэг байсныг илтгэж байв.

Хяналтын байгууллагаас тус АББ-ын хүсэлтийн хариуд бүртгэлтэй байгууллагатай ямар харилцаатай болох талаар нэмэлт мэдээлэл ирүүлэхийг хүсэлт болгожээ. Өргөдөл гаргагч АББ-аас хариу мэдэгдэхдээ тэрбээр уг бүртгэлтэй байгууллагын шууд охин компани болох, ерөнхийдөө түүний шашны салбарын үүргийг гүйцэтгэдэг байсан гэжээ. Өргөдөл гаргагч АББ болон бүртгэлтэй байгууллага нь үндсэндээ нэг байгууллагын ондоо бүрэлдэхүүн хэсгүүд байсан. Энэхүү хариулт нь өргөдөл гаргагч АББ нь гадаадын этгээдийг санхүүжүүлнэ гэсэн утгатай байсан бөгөөд энэ үйл ажиллагааг эхний өргөдөлдөө тусгаагүй байсан тул хянан нийцүүлэлтийн тал дээр шинэ эргэлзээ төрүүлжээ.

Хяналтын байгууллага эдгээр эргэлзээг үнэлж байх хооронд хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр бүртгэлтэй байгууллагад бие даасан аудитын шалгалт хийсэн талаар мэдээлжээ. Шалгалтыг зарим удирдах албан тушаалтан нь санхүүгийн зөрчил гаргасныг илрүүлсний дараа төлөөлөн удирдах зөвлөлөөс бие даасан нягтлан бодох бүртгэлийн компанид хүсэлт гаргасан байжээ. Аудитын шалгалтаар хянан нийцүүлэлтийн нэлээд их асуудлыг илрүүлсэн, үүнд:

- гадаад валютын бүртгэлгүй банкны данснууд;
- хөрөнгө мөнгө шилжүүлсэн талаар тайланд бүрэн тусгаагүй байх;
- гадаад улсад зорчсон гэж мэдэгдсэнээ тайланд бүрэн тусгаагүй байх;
- хандивласан хөрөнгийг банканд хадгалахаа хойшлуулах;
- хандивласан хөрөнгийг байгууллагын олон дансанд хадгалах.

Хараат бус аудитын шалгалтын явцад илрүүлсэн хянан нийцүүлэлтийн асуудлууд болон терроризмтой холбоотой асуудалд үндэслэн үндэсний хяналтын байгууллагаас бүртгэлтэй байгууллага, түүний салбар болон өргөдөл гаргагч АББ-д өөрийн аудитын шалгалтыг хийсэн. Үүний дараа өргөдөл гаргасан АББ бүртгүүлэх хүсэлтээ буцаасан.

Кейс тохиолдол 55-Террорист байгууллагатай холбоотой байх

2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр АНУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг №13224-т заасны дагуу Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагыг (TRO) жагсаалтад орсон террорист байгууллагын хяналтад байсан, түүний нэрийн өмнөөс ажиллаж, санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан, АНУ-д жагсаалтад орсон “Тамил-Иламын чөлөөлөх барсууд” Tamil Eelam Liberation Tigers (LTTE) террорист хөдөлгөөнд хөрөнгө босгох, худалдан авалт хийдэг халхавчаар ашиглаж байсан гэдэг шалтгаанаар терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулсан. АНУ-д Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллага нь АНУ-ын Татварын тухай хуулийн 501(с)(3) хэсэгт заасны дагуу татвараас чөлөөлөгдсөн, буяны АББ байсан бөгөөд LTTE-ийн нэрийн өмнөөс бие даасан төлөөлөгчдийн сүлжээгээр дамжуулан хөрөнгө босгодог байжээ. Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллага нь мөн LTTE-д зэр зэвсэг, цэргийн хэрэгсэл, харицаа холбооны тоног төхөөрөмж болон бусад техник хэрэгслийг худалдаж авахад LTTE-ийн АНУ дахь худалдан авалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг байсан. Мэдээллийн дагуу Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагын дэлхий дахинаа явуулсан ажлын үр дүнд 2004 оны 12 дугаар сард болсон цунамигийн дараа олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээж авсан хүмүүнлэгийн тусламжийг LTTE-ийн цэргийн чадавхийг бэхжүүлэхэд ашиглах боломжийг олгосон байна. Нэмэлт мэдээллийн дагуу LTTE-ээс өөрийх нь нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан олон улсын төрийн бус байгууллагуудад Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагатай хамтран удирддаг байсан орон нутгийн төрийн бус байгууллагаар дамжуулан бүх төслийн санхүүжилтийг олгохыг үүрэг болгосон байв. Энэхүү тохиролцоо нь Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагад орон нутгийн төрийн бус байгууллагын данснаас мөнгө гаргах, тусламжийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг LTTE руу шилжүүлэх боломжийг олгодог байв.

АНУ-ын Ерөнхийлөгчийн 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 13224 дугаар зарлигийн дагуу АНУ-д байрладаг Тамилчуудын санг “Тамил-Иламын чөлөөлөх барсууд” Tamil Eelam Liberation Tigers (LTTE) хөдөлгөөний хяналтад байсан, түүний нэрийн өмнөөс ажиллаж, санхүүгийн дэмжлэг үзүүлж, түүнд хөрөнгө босгох халхавчаар ашиглаж байсан гэдэг шалтгаанаар терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулсан. Олон жилийн туршид Мэрилэнд мужийн

Камберлэнд хотод байрладаг байсан Тамилчуудын сан болон Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллага нь хөрөнгөө нэгтгэж, санхүүгийн үйл ажиллагаагаа хамтран хэрэгжүүлдэг байжээ. Бусад террорист бүлгүүдийн нэгэн адил LTTE нь хөрөнгө босгох, өөрсдийн хэрцгий зорилгоо хэрэгжүүлэх зорилгоор буяны гэх байгууллагуудад түшиглэдэг байсан. Тамилчуудын сангийн тэргүүн нь мөн АНУ дахь Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагын ерөнхийлөгч нь байсан. АНУ-ын Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 13224 дугаар зарлигийн дагуу Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагыг олон улсын терроризмын тусгай субъектээр жагсаалтад оруулсан. Олон жилийн туршид Тамилчуудын сан болон Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллага нь хөрөнгөө нэгтгэж, санхүүгийн үйл ажиллагаагаа хамтран хэрэгжүүлдэг байжээ. Нэмэлт мэдээллийн дагуу Тамилчуудын сан нь хандивыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагатай холбоотой байв. Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллага болон Тамилчуудын сангийн нэгдмэл удирдлага эдгээр үйл ажиллагааг явуулахад дөхөмтэй байсан.

2006-2009 оны хооронд Тамилчуудын нөхөн сэргээлтийн байгууллагатай холбоотой хэд хэдэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Олон улсын террорист байгууллагын жагсаалтад орсон байгууллагад (LTTE) материаллаг дэмжлэг үзүүлэх зорилгоор нууцаар хуйвалдсан, төрийн албан хаагчийг хахуульдахаар нууцаар хуйвалдсан, нууц материал авах гэж оролдсон, "аюул заналхийлэл учруулах" улс орнуудтай худалдаа хийхийг хязгаарласан АНУ-ын онцгой байдлын хууль (IEEPA)-ийг зөрчсөн, хориотой зэр зэвсгийг экспортлох зорилготой нууцаар хуйвалдсан, хориотой зэр зэвсгийг экспортлох гэж оролдсон, олон улсын хэмжээнд мөнгө угаасан, хүнд ноцтой гэмт хэрэг үйлдэх зорилгоор зэвсэг эзэмшиж байсан зэрэг олон төрлийн хуулийг зөрчсөн хэрэгт буруутгагдсан 10 шүүгдэгчид яллах дүгнэлт хийсэн.

Тухайлбал, 2009 оны 1 дүгээр сарын 27-нд Нью-Йорк хотын Зүүн дүүрэгт Тирутаникан Танигасалам (Thiruthanikan Thanigasalam), Сахилал Сабаратнам (Sahilal Sabaratnam) нар нууц хуйвалдаанд оролцож, Тамил-Иламын чөлөөлөх барсууд буюу "Тамилын барсууд" гэдэг олон улсын террорист байгууллагын жагсаалтад орсон байгууллагад материаллаг дэмжлэг үзүүлэхээр завдсан, нисэх онгоцны эсрэг пуужинг худалдаж экспортлохоор оролдсон нууц хуйвалдаанд гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн.

2009 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр шүүгдэгч Сатхажан Сарачандран (Sathajhan Sarachandran) LTTE-д материаллаг дэмжлэг үзүүлсэн, үзүүлэхээр оролдсон, нисэх онгоцны удирдлагатай пуужин авахаар оролдож нууцаар хуйвалдсан хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн. Харин шүүгдэгч Надараса Йогараса (Nadarasa Yogarasa) LTTE-д материаллаг дэмжлэг үзүүлэхээр завдсан, энэ зорилгоор нууцаар хуйвалдсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Танигасалам, Сабаратнам, Сарачандран нарыг шоронд 25 жилээс бүх насаар нь хорих хүртэл хууль ёсны шийтгэл хүлээж байгаа бөгөөд ялын дээд хэмжээгээр хорих хүртэл ялаар шийтгүүлэх юм. Йогараса нь хууль ёсны шийтгэл хүлээх бөгөөд 30 жил хүртэл хорих ялаар шийтгүүлэх юм.

Мэрилэнд муц дахь LTTE-д материаллаг дэмжлэг үзүүлсэнтэй холбоотой өөр нэг хэрэгт 2008 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Ханиффа Бин Осман (Haniffa Bin Osman)-ыг LTTE-д материаллаг дэмжлэг үзүүлэх зорилгоор нууцаар хуйвалдсан, мөнгө угаасан хэргээр 37 сар шоронд хорих, 3 жил хяналттай суллагдах ялаар шийтгүүлсэн. 2006 оны 4 дүгээр сараас 9 дүгээр сарын 29-ний хооронд Осман нь Хажу Субанди (Haji Subandi), Эрик Вотуло (Erick Wotulo), Тирунавукарасу Варатхараса (Thirunavukarasu Varatharasa) нартай хамтран Шри Ланка Улсын засгийн газрын хүчний эсрэг тэмцэлд ашиглах зорилгоор Шри Ланка Улсад үйл ажиллагаа явуулдаг LTTE хөдөлгөөнд орчин үеийн галт зэвсэг, автомат бууг зэр зэвсгийн хамт, газраас агаарт хөөргөдөг пуужин, шөнийн дуран зэрэг бусад цэргийн зэр зэвсгийг хангах зорилгоор нууцаар хуйвалдсан байв. Бусад гурван шүүгдэгч гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч, бүгдэд нь ял шийтгэл оногдуулсан. 2007 оны 12 дугаар сарын 14-нд Субандиг 37 сар шоронд хорих, 3 жил хяналттай суллагдах ялаар шийтгэсэн. 2008 оны 1 дүгээр сарын 3-нд Варатарасаг 57 сар шоронд хорих ялаар, 2008 оны 7 дугаар сарын 10-нд Вотулог 30 сар шоронд хорих ялаар шийтгэсэн.

Кейс тохиолдол 56-Террорист байгууллагатай холбоотой байх

2012 оны 10 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгчийн 13224 дугаар зарлигийн дагуу АНУ-ын Сангийн яам Ливан Улсад байрлах хоёр буяны байгууллагыг АНУ-д бүртгэлтэй террорист байгууллага болох “Хамас”-ын хяналтад байсан, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан учраас терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулсан. Бейрут хотод байрлах Аль-Вакфая, Аль-Кудс байгууллага нь “Хамас”-ын байлдагчид болон хоригдлуудын ар гэрийнхнийг дэмжих зорилгоор байгуулагдсан бөгөөд террорист байгууллага болох “Хамас”-ын нөлөөлөл, эрх мэдлийг түгээх зорилгоор Палестины нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байсан төсөл хөтөлбөрт хөрөнгө босгодог байжээ.

Аль-Вакфая нь “Юнион оф Гүд” байгууллагын гол бүрэлдэхүүн хэсэг нь байсан бөгөөд 2008 оны 11 дүгээр сард АНУ-ын Ерөнхийлөгчийн 13224 дугаар зарлигаар АНУ-д бүртгэлтэй террорист байгууллага болох “Хамас”-ын хяналтад байсан, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан учраас терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад орсон. Аль-Вакфаяг 2000 онд “Хамас”-ын гишүүн террористуудын ар гэрийнхэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хамас” хөдөлгөөнөөс байгуулсан. Олон жилийн турш уг байгууллагыг “Хамас”-ын удирдлага удирдаж байсан бөгөөд “Хамас”-ын хэд хэдэн удирдах албан тушаалтан тус байгууллагад тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг байв. Аль-Вакфая нь “Хамас”-ын нэрийн өмнөөс мөнгө цуглуулахад дэмжлэг үзүүлж, Ойрхи Дорнод дахь өөрийн мөнгө шилжүүлэх үйлчилгээ үзүүлдэг байгууллага, худалдаачидтай харилцах харилцаа холбоогоо ашиглаж Газа дахь “Хамас”-ын хаяг руу мөнгө шилжүүлдэг байсан. Газа хотод мөнгө шилжүүлэхдээ Аль-Вакфая нь мөнгөний гарал үүслийг нуун дарагдуулдаг байсан тул хандивыг гэм зэмгүй буяны үйлсийн хандив мэт харагдуулдаг байв. Аль-Вакфаягаас “Хамас”-ын хаяг руу явуулсан хөрөнгийн тодорхой хэсгийг “Хамас”-ын цэргийн агентууд

ашигладаг байсан бөгөөд Палестины нутаг дэвсгэр дэх “Хамас”-ын дэд бүтэц, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулсан байв.

Аль-Кудс байгууллагыг “Хамас”-ын гишүүд буяны байгууллагын нэрийн дор Иерусалим дахь “Хамас”-ын төсөл хөтөлбөрт хөрөнгө босгох зорилгоор 2001 онд Бейрут хотод байгуулжээ. “Хамас”-ын удирдлага тус байгууллагын бүхий л үйл ажиллагааг түүний Удирдах зөвлөл, Захирлуудын зөвлөл болон бусад захиргааны хороодод байх “Хамас”-ын гишүүдээр дамжуулан явуулдаг байв. Аль-Кудсын бүх баримт бичиг, төлөвлөгөө, төсөв, төсөл хөтөлбөрийг “Хамас”-ын албаны хүмүүс боловсруулдаг байв. АНУ-д бүртгэгдсэн террористууд болох Муса Абу-Марзук (Musa Abu- Marzuq), Усама Хамдан (Usama Hamdan) зэрэг “Хамас”-ын хэд хэдэн хариуцлагатай албан тушаалтан Аль-Кудсын Удирдах зөвлөлийн гишүүд байсан. Аль-Кудсын хурал чуулганд оролцсон төлөөлөгчдийг өөрсдийгөө тус улс дахь “Хамас”-ын албан бус элчин сайд гэж тооцохыг хэлдэг байжээ.

Кейс тохиолдол 57-Террорист байгууллагатай холбоотой байх

Соёлын болон шашны үйл ажиллагаа, түүний дотор шашны байгууллагыг удирддаг орон нутгийн АББ-аас, АББ-ын үйл ажиллагааг зохицуулдаг үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Хяналтын байгууллагаас тус АББ-ын өргөдөлийг нягтлан үзэх явцад тус АББ-аас мэдүүлсэн үйл ажиллагааны төрөл, зорилго нь тодорхой бус байсан бөгөөд улс төрийн үйл ажиллагааг багтаасан байж болзошгүй байсан тул анхааралдаа авчээ. Түүнчлэн түүний удирдах албан тушаалтны нэг нь терроризмыг дэмждэг үйл ажиллагаанд холбогдсон гэдгээрээ алдартай нэгэн байв.

Хяналтын байгууллагад өгсөн үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд уг удирдах албан тушаалтан нь жагсаалтад орсон террорист байгууллагын халхавчаар ажилладаг болохыг нь мэддэг гадаадын байгууллагатай харилцаа холбоо тогтоох зорилгоор хэд хэдэн удаа гадагшаа зорчсон болохыг нь илтгэж байв. Түүнчлэн уг удирдах албан тушаалтан нь террорист үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн гэж үздэг бусад орон нутгийн байгууллагатай холбоотой байжээ. Тус АББ нь өөрөө жагсаалтад орсон террорист байгууллагуудыг дэмждэг гэдгийг нь мэддэг гадаадын хандивлагч байгууллагуудаас санхүүжилт, тоног төхөөрөмж хэлбэрээр тусламж авсан бөгөөд энэ хүрээнд сургалт, сурталчилгааны материалаар хангадаг байжээ.

Хяналтын байгууллагаас тус АББ-ын хүсэлтийн хариуд тус АББ-аас явуулдаг үйл ажиллагааны мөн чанар болон гадны доноруудаас хараат бус байдаг нь эргэлзээ байгаагаа мэдэгджээ. Тус АББ-д эдгээр асуудалд байр сууриа тодруулах боломжийг олгосон боловч хариу өгөөгүй байна. Үүний дараа тус АББ-ыг бүртгэхээс татгалзжээ.

Кейс тохиолдол 58-Террорист байгууллагатай холбоотой байх

Дотооддоо болон гадаадад соёл, хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон жилийн өмнө бүртгэгдсэн АББ заавал илтгэх тайлангаа АББ-ын үйл

ажиллагааг хянадаг үндэсний хяналтын байгууллагад өгөөгүй гэдэг шалтгаанаар бүртгэлээ хасуулжээ. Үүний дараа тус АББ-аас дахин бүртгүүлэх хүсэлт гаргажээ.

Тус АББ-аас дахин бүртгүүлэх хүсэлт гаргасан нь үндэсний хяналтын байгууллагаас тус АББ-ын үйл ажиллагаанд аудитын шалгалт явуулах нөхцөлийг бүрдүүлжээ. Хяналтын байгууллагаас тус АББ-ын хүсэлтийг болон аудитын шалгалтын баримт бичгийг нягтлан үзэх явцад түүний үйл ажиллагаа нь тодорхой бус, хүмүүнлэгийн зорилго гэхээсээ илүү улс төрийн шинжийг илтгэж байсан тул анхаарлдаа авчээ. Нээлттэй эх сурвалжийн судалгааг аудитын шалгалтын баримт бичигтэй нэгтгэн шалгахад тус АББ нь гадаадын хэд хэдэн террорист бүлэглэлийн халхавч гэдэгт сэжиглэгдэж байсан гадаадын томоохон байгууллагын (толгой байгууллага) орон нутгийн салбарын үүргийг гүйцэтгэж байсныг илтгэсэн байна. Тус АББ-ын бараг бүх санхүүжилт толгой байгууллагаас ирдэг байсан бөгөөд ажилчдын цалинг толгой байгууллагаас олгож, олон зочин илтгэгчийг толгой байгууллагаас явуулдаг байжээ.

Хяналтын байгууллагын авсан үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд тус АББ нь олон улсын толгой байгууллагатай холбоотой сүлжээ салбарын бүрэлдэхүүн хэсэг байсныг илтгэж байв. Толгой байгууллага нь террорист байгууллагын шинээр гишүүн элсүүлэх ажилд тустай үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог гэдгээрээ алдартай байжээ. Түүнчлэн салбаруудын хөтөлбөр, тоног төхөөрөмжийг толгой байгууллагаас хангадаг байв. Нээлттэй эх сурвалжийн судалгаа, түүнчлэн үндэсний аюулгүй байдлын мэдээллийн дүн шинжилгээгээр тус АББ-ын хэд хэдэн захирал жагсаалтад орсон террорист байгууллагад тусламж үзүүлдэг гэж үздэг бусад гадны байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байсныг илтгэж байв. Эдгээр гадны байгууллагын нэг нь өөрөө терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад орсон байжээ.

Үндэсний хяналтын байгууллагаас тус АББ-ын хоёрдахь өргөдөлд хариу өгөхдөө тус АББ нь үндсэндээ гадаадын толгой байгууллагын хяналтад байдаг, улс төрийн шинж чанартай төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрт оролцсон, түүний үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл байхгүй байгааг мэдэгдсэн байна. Тус АББ-д эдгээр эргэлзээг арилгах боломжийг олгосон боловч хариу өгөөгүй байна. Үүний дараа тус АББ-ыг бүртгэхээс татгалзсан байна.

Кейс тохиолдол 59-Террорист байгууллагатай холбоотой байх

АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний хяналтын байгууллагад өөрийн үндсэн зорилгыг соёл, шашны үйл ажиллагаа гэж мэдүүлсэн АББ-аас бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Тус АББ-ын удирдах албан тушаалтны нэг нь террорист үйл ажиллагааг дэмждэг гэж үздэг өөр нэг байгууллагын удирдах албан тушаалтнаар нэгэн зэрэг ажиллаж байсан тул хяналтын байгууллагын анхааралд өртжээ. Түүнчлэн АББ-ын үйл ажиллагааг хянадаг байгууллага олон нийтийн зүгээс тус АББ-ын ашигладаг хэд хэдэн сэжигтэй тайлангийн ажиллагааны талаар сэжүүр мэдээлэл авчээ. Эдгээрт удирдан зохион байгуулах хоёр багц баримт бичгийг хөтөлдөг болох (нэгийг нь хяналтын байгууллагад танилцуулдаг, нөгөөхийг нь олон нийтэд танилцуулдаг),

цөөн хэдэн бүлэг хүнээс бусад хүнийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болохыг хориглодог, уулзалтын тэмдэглэлийг хөтөлдөггүй зэрэг асуудлууд багтаж байв.

Үндэсний хяналтын байгууллагаас эдгээр асуудлыг тус АББ-д мэдэгдэж, эдгээр асуудлыг бүртгэлээс өмнө шийдвэрлэх шаардлагатай байгааг дурдаад тус АББ-д эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжийг олгожээ. Гэвч тус АББ-аас хариу өгөөгүй бөгөөд үндсэндээ бүртгүүлэх хүсэлтээ буцаажээ.

Кейс тохиолдол 60 – Террорист байгууллагатай холбоотой байх (Дөрөвдүгээр бүлэгт иш татсан)

Үндэсний (орон нутгийн) АББ зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын АББ-аас их хэмжээний мөнгө хүлээн авчээ. Тус орон нутгийн АББ-ын удирдах албан тушаалтан уг мөнгөний ихэнхи хэсгийг бэлнээр авах гэж оролджээ. Банкнаас түүнд үүний эсрэг зөвлөсний дараа тэрбээр уг мөнгөний тодорхой хэсгийг бэлэн мөнгөний автомат машинаас гаргаж авсан байв. Түүнчлэн тус АББ-д хамааралгүй өөр нэг этгээд их хэмжээний бэлэн мөнгө авсан байв.

Үүнтэй холбогдуулан тус орон нутгийн ашгийн бус байгууллагын данс нээлгэсэн банкнаас СМА-нд сэжигтэй гүйлгээний мэдээллийг явуулжээ. Үндэсний СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар уг гадаадын АББ нь террорист байгууллагын жагсаалтад орсон байгууллагатай холбоотой байсныг илрүүлжээ. Түүнчлэн тус орон нутгийн АББ-ын удирдах гишүүдийн нэг нь мөн гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой гадны зэвсэгт бүлэглэлийн нэрт зүтгэлтэн байсныг тогтоожээ.

Кейс тохиолдол 61 – Террорист байгууллагатай холбоотой байх

Үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргасан АББ үйл ажиллагааныхаа үндсэн зорилтыг гадаадын зөрчил мөргөлдөөнд нэрвэгдсэн хүмүүст хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, зөрчил мөргөлдөөнөөс дүрвэгсдийг дотоод орчиндоо нэгтгэхэд дэмжлэг үзүүлэх гэж мэдэгджээ. Хяналтын байгууллагаас тус АББ-ын өргөдөлийг нягталж үзэх явцад түүний үйл ажиллагааны зарим төрөл, зорилго нь хэтэрхий ойлгомжгүй бөгөөд буяны зорилгод нийцэхгүй байсан тул анхааралдаа авчээ. Тус АББ-аас мэдээлэхдээ түүний үйл ажиллагаа, зорилго нь өмнө нь бүртгүүлсэн охин байгууллагатай нь адилхан байсан гэжээ. Тус АББ үйл ажиллагааныхаа зорилго, зорилтыг өөрчилж, бүртгүүлсэн хэдий ч хяналтын байгууллагас тус байгууллагыг үргэлжлүүлэн хянаж байв.

Дээр дурдсан гадаадын зөрчил мөргөлдөөнөөс үүдэлтэй террорист үйл ажиллагаанд нийтээрээ түгшиж байсан тул хяналтын байгууллагаас уг зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг байсан хэд хэдэн өндөр эрсдэлтэй байгууллагын үйл ажиллагааг шалгаж эхэлжээ. Тус АББ-ын заавал илтгэх тайланд дүн шинжилгээ хийхэд үнэндээ тус АББ нь охин байгууллагын хамт нэг газарт байрлаж байсан бөгөөд дор хаяж хоёр удирдах албан тушаалтан нь хамтран ажилладаг байсныг тогтоожээ. Үндэсний аюулгүй байдлын байгууллагын

тайланд уг охин байгууллага нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутгийн гадна үйл ажиллагаа явуулдаг гадаадын террорист бүлэглэлийн халхавч байгууллага гэж үздэг болохыг илтгэсэн байв. Түүнчлэн үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийн дагуу тэдгээрийн хамтран удирддаг удирдах албан тушаалтны нэг нь гадаадын террорист бүлгийн орон нутгийн удирдагч гэж үздэг болохыг тогтоосон.

Хяналтын байгууллагаас тус АББ-д аудитын шалгалт хийхэд хэд хэдэн чиглэлд хянан нийцүүлэлтийн шаардлагыг хангаагүй болох нь тогтоогдсон. Тус АББ нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт байдаг, түүний хөрөнгийн хууль ёсны хүлээн авагчид бус гадаадын байгууллага, хувь хүнд 20,000 ам.долларыг шилжүүлсэн байв. Түүнчлэн тус АББ-ын данснаас зарцуулсан 10,000 ам.долларыг тайланд тусгаагүй байсан бөгөөд уг хөрөнгийн эцсийн хүлээн авагчийн асуудал нээлттэй хэвээр үлдсэн. Түүнчлэн тус АББ нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтөлдөггүй байсан нь тус АББ-ын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлын талаар асуулт үүсгэж байв.

Тус АББ-аас зарим захиргааны ажил хэргийн шинэчлэлийг эхлүүлж, хэд хэдэн удирдах албан тушаалтныг сольсон байсан тул бүртгэлээ цуцлуулахаас зайлсхийж чадсан ч хяналтын байгууллагатай хянан нийцүүлэлтийн гэрээ байгуулж хянан магадлагааны нийцүүлэлт, хариуцлагын хэм хэмжээг хатуу чанд сахин мөрдөх шаардлагатай болсон.

Кейс тохиолдол 62 – Террорист байгууллагатай холбоотой байх (Дөрөвдүгээр бүлэгт иш татсан)

Гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт олон улсын хүмүүнлэгийн ажил хийдэг ашгийн бус байгууллага үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Хяналтын байгууллага тус АББ-ын өргөдлийг нягталж үзэхэд тус АББ-ын зорилго, үйл ажиллагааны зарим төрөл нь хуулийн хүрээнд хамаарахгүй байсан нь анхаарал татжээ. Түүнчлэн тус АББ-ын гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт түншилдэг байсан гадны байгууллагууд нь түүний хууль ёсны дэмжлэгийг хүлээн авагчид нь биш байв.

Хяналтын байгууллага тус АББ-ын өргөдлийг нягталж үзэж байхдаа үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг олж авчээ. Энэхүү мэдээллийн дагуу тус АББ нь гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг жагсаалтад орсон террорист бүлэглэлийн орон нутгийн халхавч байгууллага болохыг илтгэж байв. Тус АББ нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн байгууллагад хууль ёсны аргаар хөрөнгө шилжүүлдэг байсныг тогтоосон. Эдгээр гадны байгууллагын зарим нь өөрсдөө жагсаалтад орсон террорист бүлгийн дэд бүтцийн нэг хэсэг гэж тодорхойлсон байв.

Гадаадын түнш хоёр байгууллагаас мөн мэдээлэл өгсөн бөгөөд хяналтын байгууллага түүнийг нь өргөдлийг шалгах явцдаа ашиглажээ. Гадаадын нэг түнш

нь тус улсад террорист үйл ажиллагаатай холбогдуулан уг АББ-тай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа явагдсаныг мэдээлсэн байв.

Хяналтын байгууллагаас тус АББ-д эдгээр асуудлын талаар мэдэгджээ. АББ-аас хяналтын байгууллагын зүгээс тавьсан зарим асуудлыг шийдвэрлэх гэж оролдсон. Тодруулбал гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт албан газрынхаа салбарыг нээсэн бөгөөд үүгээрээ хөрөнгийн хуваарилалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд илүү сайн хяналт тавьж байгаа гэдгээ харуулахыг хичээсэн. Гэхдээ хяналтын байгууллагаас явуулсан нэмэлт шалгалтаар үндсэн эрсдэлийг арилгаагүй байсныг тогтоосон тул энэ талаар тус АББ-д мэдэгджээ.

Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаа, захиргааны арга хэмжээний үр дүнд тус АББ бүртгүүлэх хүсэлтээ буцааж авчээ. Хяналтын байгууллагын судалгаа дүн шинжилгээний үр дүн, мэдээллийг үндэсний аюулгүй байдлын байгууллагуудын мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор шилжүүлсэн.

Кейс тохиолдол 63 – Террорист байгууллагатай холбоотой байх

АББ үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргахдаа дотоодын болон гадаадын хамтын нийгэмлэгт хүмүүнлэгийн үйлчилгээ үзүүлэх зорилготой гэж мэдэгдсэн байв. Тус АББ-ын нэр нь хэд хэдэн идэвхтэй террорист бүлэглэлтэй гадаадын зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг томоохон байгууллагын нэртэй адилхан байжээ. Тус АББ нь тухайн зөрчил мөргөлдөөнтэй бүс нутаг дахь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх зорилгоор уг гадны байгууллагатай үйл ажиллагааны гэрээ байгуулсан байв. Тус АББ өмнө нь бүртгэлтэй байсан бөгөөд хэдэн жилийн турш үйл ажиллагаа явуулсан байжээ. Гэхдээ тус АББ-д аудитын шалгалтад орсны дараа түүний бүртгэлийг захиргааны шалтгаанаар хүчингүй болгосон байв. Тодруулбал тус байгууллага үндэсний хяналтын байгууллагад заавал илтгэх тайлангаа бүрдүүлж өгөөгүй байжээ.

Тус АББ-аас дахин бүртгүүлэх хүсэлт гаргасан бөгөөд өмнөх бүртгэлийг нь цуцалсан байсан тул хяналтын байгууллага өргөдлийг дахин сайтар нягталж үзсэн байна. Тус АББ-ын өргөдөлд үйл ажиллагааны төрөл, ялангуяа түүний гадаадын томоохон түнштэйгээ хамтран хэрэгжүүлдэг үйл ажиллагааны талаар тодорхой заагаагүй байснаас гадна тус АББ-ын гадаад руу явуулсан хөрөнгөндөө зохих хяналт тавиагүй байсан тул хяналтын байгууллагын анхаарлыг татжээ. Хяналтын байгууллага тус АББ-аас тодруулга хүсч, АББ-аас дээрх хоёр асуудлаар дэлгэрэнгүй мэдээллийг авсан.

Энэ хооронд хяналтын байгууллага тус АББ-ын санхүүгийн үйл ажиллагаа болон түүний гол гурван удирдлагын талаар үндэсний СМА-аас мэдээлэл хүлээн авчээ. Санхүүгийн тагнуулын мэдээллээр тус АББ нь гадаадын террорист байгууллагыг дэмждэг гэдэгт сэжиглэгддэг үндэсний байгууллагуудтай холбоотой болохыг нь тогтоожээ. Гэхдээ хяналтын байгууллагын гол эргэлзэж байсан асуудал буюу тус АББ нь өөрийн гадаад руу явуулсан хөрөнгөнд зохих хяналт тавьсан эсэхийг илтгэж

чадаагүй асуудал хэвээр байсаар байв. Энэ шалтгааны улмаас тус АББ-ыг бүртгэхээс татгалзсан.

Кейс тохиолдол 64 – Террорист байгууллагатай холбоотой байх

Хууль сахиулах байгууллагын мэдээллээр орон нутгийн АББ-тай холбоотой хүмүүс эх нутагтаа террорист ажиллагаа явуулахаар хуйвалдсан байв. Мэдээллийн дагуу хуйвалдагчдын ойр дотны хүний нэг нь энэхүү АББ-ын үүсгэн байгуулагч нь байсан бөгөөд тус АББ-ыг хууль бус зорилгоор ашигласан байж болзошгүй гэж сэжиглэгдсэн байжээ.

Үндэсний хяналтын байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд тус АББ-ын дотоодын банкны дансыг царцаасан байна. Хяналтын байгууллагаас тус АББ-ын удирдлагад байгууллагын гадаад дахь хөрөнгийн талаар мэдээлэл ирүүлэхийг мөн хүсэлт болгожээ.

Хэдийгээр үндэсний тагнуул, аюулгүй байдлын байгууллагын мэдээлэл тус АББ-ын хөрөнгийг хууль бус зорилгод ашиглахаар гадаад руу шилжүүлсэн байж болзошгүй гэдгийг зөвлөж байсан хэдий ч хяналтын байгууллага тус АББ-ын удирдах албан тушаалтнууд байгууллагын хөрөнгийг хууль бус эсхүл буяны бус зорилгод зарцуулсан гэдгийг шууд нотлох баримтыг илрүүлж чадаагүй байна. Гэхдээ хяналтын байгууллага тус АББ-ын удирдах албан тушаалтнууд гадаадын хоёр улсад шилжүүлсэн хөрөнгийг зохих удирдлагаар хангаж, хянах чадвартай байсан гэдгээ нотолж чадаагүй гэдэг дүгнэлтэд хүрсэн байв. Ерөнхийдөө тус АББ-аас маш хязгаарлагдмал хэмжээнд хяналт тавьдаг байжээ. Ихэнхдээ түүний удирдах албан тушаалтнууд нь гадаадад байдаг гуравдагч талын, тэр дундаа хөрөнгийг хүлээн авдаг хүвь хүмүүсийн хариу үйлдлээс ихээхэн хамааралтай байдаг байв.

Эцсийн дүнд тус АББ-ын удирдлага гадаадын улс руу шилжүүлсэн хөрөнгийг хуульд заасны дагуу хууль ёсоор болон АББ-ын зорилгын дагуу ашиглаж байсан гэдгээ зохих ёсоор нотлож чадаагүй болно.

Кейс тохиолдол 65 – Террорист байгууллагатай холбоотой байх

АНУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны 8 дугаар сард гаргасан 13224 тоот захирамжийн дагуу АНУ-ын Сангийн яам Жамиа Талем-Ул-Коран-Валь-Хадис (Jamia Taleem-Ul-Quran-Wal-Hadith Madrassa) буюу Ганж (Ganj Madrassa) гэгддэг муслим шашинтны сургуулийг Аль-Каида болон бусад жагсаалтад орсон террорист байгууллагын хяналтад байсан, тэдний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулсан, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн гэдэг шалтгаанаар терроризмыг дэмждэг байгууллагын жагсаалтад оруулсан. Ганж медрес буюу муслим шашинтны сургууль нь Пакистан Улсын Пешавар хотод байрладаг сургууль бөгөөд сургалт боловсролын төв гэж байгуулагдаж “Аль-Каида”, “Лашкар-и Тайба”, “Талибан” зэрэг НҮБ, АНУ-ын холбогдох жагсаалтад орсон террорист байгууллагуудыг санхүүжүүлэхэд дэмжлэг

үзүүлдэг байжээ. Ганж медресийн үйл ажиллагаа нь “Аль-Каида”, “Лашкар-и Тайба”, “Талибан” зэрэг террорист бүлэглэлүүд шашны сургууль зэрэг хууль ёсны байгууллагыг хэрхэн гажуудуулж, боловсролд зориулж цуглуулсан буяны хандивыг террористуудыг бэлтгэх, хүчирхийлэл үйлдэхэд зарцуулдаг болохыг харуулсан жишээ юм. Энэхүү арга хэмжээ нь бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, дэлхийн олон бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг бүх шашны сургуулиудад чиглэгдээгүй болно; терроризм, терроризмыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн зөвхөн энэ тодорхой шашны сургуулийг олж тогтоосон юм.

Ганж медрес нь Шейх Аминулла (Shaykh Aminullah) гэгддэг Фазил-а-Тул Шейх Абу Мохаммед Амин аль-Пешавари (Fazeel-A-Tul Shaykh Abu Mohammed Ameen Al-Peshawari) нэртэй НҮБ-ын жагсаалтад орсон “Аль-Каида” бүлэглэлийн удирдагын нэг юм. АНУ-ын Ерөнхийлөгчийн 13224 тоот захирамжийн дагуу Шейх Аминуллаг жагсаалтад орсон террорист байгууллагын хяналтад байсан, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулсан, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн гэдэг шалтгаанаар АНУ-д терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулсан. Мөн 2009 онд НҮБ-аас түүнийг “Ал-Каида” болон “Талибан”-чуудад материаллаг дэмжлэг үзүүлсэн гэдэг шалтгаанаар терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулсан.

Ганж медрес нь террористуудын сургалтын төвийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тэнд шашны боловсрол нэрээр оюутнуудыг террорист болон босогчдын ажиллагаанд сургадаг байв. Зарим тохиолдолд оюутнуудад тэсрэх бөмбөг хийх, амиа золиослогчдыг бэлтгэх сургалт явуулдаг байжээ. Шейх Аминулла нь тус сургуульд зориулагдсан хандивыг Афганистанд үргэлжилж буй хүчирхийллийг санхүүжүүлэхэд хөрөнгийг зарцуулдаг байсан Талибан зэрэг террорист бүлэгт шилжүүлдэг байсан.

Кейс тохиолдол 66 – Террорист байгууллагатай холбоотой байх

Орон нутгийн АББ-ын дансанд гадаад улсад төвтэй олон улсын АББ-аас их хэмжээний бэлэн мөнгөний орлого, цахим мөнгөний шилжүүлгийг тогтмол хийдэг байжээ. Үүний дараа мөнгийг тэр даруй гадаад улсад байрладаг бусад АББ-ын дансанд шилжүүлдэг байв.

Гадаадын эрх бүхий байгууллагаас үндэсний СМА-нд өгсөн мэдээллээр орон нутгийн АББ болон олон улсын АББ, мөн тэдгээр байгууллагын нийтлэг үүсгэн байгуулагч нь гадаад улсын хууль сахиулах байгууллагаас явуулсан терроризмтой холбоотой мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой байжээ. Түүнчлэн олон улсын АББ-ын дансыг царцаасан байв.

СМА-гаас хийсэн судалгаа дүн шинжилгээгээр олон улсын АББ нь орон нутгийн АББ-аар дамжуулан тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг байсныг илтгэсэн байна. СМА-аас уг хэргийг прокурорт шилжүүлсэн. Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд

дээрх хоёр АББ-ыг терроризмыг дэмждэг хувь хүн, байгууллагын жагсаалтад оруулсан.

Кейс тохиолдол 67 – Террорист байгууллагатай холбоотой байх

Дотооддоо төв байр нь байрладаг олон улсын ашгийн бус байгууллага нийгмийн үйлчилгээ үзүүлэх нэрээр халхавчлан террорист байгууллагад хөрөнгө босгож, материаллаг хөрөнгө нөөцөөр хангадаг байжээ. Тус АББ нь цөөн хэдэн төрлийн нийгмийн үйлчилгээгээр хязгаарлагдаж ихэнхи хүчин чармайлтаа терроризмыг дэмжихэд чиглүүлсэн байв.

Терроризмын үйл ажиллагааг дэмжих зорилгоор босгосон хөрөнгийг террорист байгууллагын гишүүдийн үйл ажиллагааны хэрэгцээнд зориулан хуваарилж, мөн цалин, зээлд зарцуулсан байв. Терроризмын үйл ажиллагааг дэмжих зорилгоор худалдаж авсан материаллаг хөрөнгө нөөцөд “газар-тэнгэр” ангилалын пуужин, автомат буу, нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон), шумбагч онгоц болон байлдааны хөлөг онгоцны зураг төслийн програм хангамж, GPS навигацийн төхөөрөмж, радио болон хиймэл дагуулын тоног төхөөрөмж, шөнийн дураг зэрэг цэргийн тоног төхөөрөмж, харилцаа холбооны хэрэгслүүд багтаж байв.

Дотооддоо болон олон улсад хөрөнгө босгохын тулд тус АББ нь сайн дурын болон албадан цуглуулсан хандивыг ашиглах, хөрөнгө босгох арга хэмжээ зохион байгуулах, гар утасны карт зэрэг төрөл бүрийн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг байжээ. Босгосон хөрөнгөнийн багахан хувийг л нийгмийн үйлчилгээнд зарцуулдаг байсан. Мөнгөний ихэнхи хэсгийг терроризмыг санхүүжүүлэхэд зарцуулсан байжээ.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд, үүнд санхүүгийн тагнуулын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг оролцуулан тус АББ болон түүний олон улсын салбарууд нь террорист үйл ажиллагааг дэмжих зорилгоор чек, албан бус мөнгөний үйлчилгээ эрхэлдэг байгууллага, хувийн болон бизнесийн дансны сүлжээ, мөн бэлэн мөнгийг хөрөнгө шилжүүлэхэд ашиглаж байсныг тогтоосон. Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд тус АББ-ын банкн дахь дансыг царцааж, тус АББ-ын тухайн улс дахь бүртгэлийг цуцалсан.

Кейс тохиолдол 68 - Террорист байгууллагатай холбоотой байх (Зургадугаар бүлэгт иш татсан)

2005 оны 6 дугаар сард Хойд Америкийн Исламын нийгэмлэгийн хөгжлийн сан (IDF) нь буяны байгууллагуудын үйл ажиллагааг хянадаг үндэсний байгууллага болох Канад Улсын татварын алба (CRA)-нд буяны байгууллага нэрээр бүртгэгджээ. Уг бүртгүүлсэн сангийн (IDF) гол зорилго нь Канад Улсад шашны байгууллага байгуулах, тэдгээрий үйл ажиллагааг удирдах замаар шашныг дэлгэрүүлэх, мөн

Канад Улсад тусламж хэрэгтэй хүмүүст санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн ядуу давхаргад туслах явдал байв.

2011 оны 1 дүгээр сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр IDF-ийн толгой байгууллага болох Хойд Америкийн Исламын Нийгэмлэг (ISNA)-т хийсэн хараат бус, дотоодын аудитын үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлсэн. Шалгалтын үр дүнгээр ISNA нь хөрөнгө нөөцийг хууль бусаар ашигласан, ялангуяа зохимжгүй хүлээн авагчдад мөнгө шилжүүлсэн, хандивын хөрөнгийг хууль бус баримтаар олгосон, бүртгэгдсэн буяны байгууллагын удирдлагын талаарх Канад Улсыг хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний хөрөнгө хуваарилсантай холбоотой ноцтой асуудлуудыг илрүүлсэн байна. Түүнчлэн их хэмжээний хөрөнгө нөөцийг Канад Улсын өөр нэг АББ болох Канад Улс дахь Кашмирт тусламж үзүүлэх сан (KFPC)-д, Кашмирт үйл ажиллагаа явуулах нэрээр шилжүүлсэн байв.

2011 оны 12 дугаар сард Канад Улсын татварын албанаас IDF-ийн үйл ажиллагаанд шалгалт хийжээ. Шалгалтаар IFC нь KFPC болон түүний харьяа байгууллага болох Кашмир-Канадын Зөвлөл (KCC)-тэй санхүүжилтийн гэрээ байгуулж, цуглуулсан хөрөнгөө Кашмирын мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (ROKM) гэж нэрлэгддэг Пакистаны ашгийн бус байгууллагад явуулах зорилготой байсан. Энэхүү гэрээний дагуу KCC/KRFC нь Кашмирт "туслах" зорилгоор хөрөнгө босгосон бөгөөд IDF нь донор хандивлагчдад хандив хүлээж авсан тухай албан ёсны бичгийг өгч, цуглуулсан 250,000 гаруй ам.долларын хандивыг Кашмирийн мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (ROKM)-д шууд буюу KSS/KRFC-ээр дамжуулан олгосон байв. Хойд Америкийн Исламын нийгэмлэгийн хөгжлийн сан (IDF)-д хийсэн шалгалтаар түүний удирдлага ROKM болон/эсхүл санхүүжилтэд шилжүүлсэн хөрөнгийг чиглүүлэх үйл ажиллагааны талаар тодорхой ямар нэг зүйлийг огт мэдэхгүй гэж мэдүүлсэн байна. Нэмж дурдахад дээр дурдсан хандив цуглуулсан баримт олгох тохиролцоог Канад Улсын хууль тогтоомжийн дагуу хориглосон байдаг. Түүнээс гадна IDF нь шилжүүлсэн хөрөнгөө удирдлагаар хангаж, хянах чадваргүй байсан бөгөөд түүний хөрөнгө нөөцийг хуваарилж, чиглүүлсэн хөтөлбөрийн мөн чанарыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй байна.

IDF-ийн цахим баримт бичгүүдэд хийсэн дүн шинжилгээ нь Канад Улсын татварын албанд IDF-ийн Кашмир дахь хөтөлбөр төслийг хянаж, удирдлагаар хангаж байгааг батлах баримт бичиг нь хуурамч байсныг олж тогтоох боломжийг олгосон. Тухайлбал, Канад Улсын Засгийн газраас Хойд Америкийн Исламын нийгэмлэгийн хөгжлийн сан (IDF)-ийн Кашмир дахь үйл ажиллагааг удирдлага, хяналтаар хангаж байгааг харуулсан гэрэл зурагт шүүх эмнэлгийн дүн шинжилгээ хийхэд эдгээр зургуудыг дижитал технологи ашиглан хуурамчаар үйлдэж IDF-ийн нэр бүхий тэмдэглэгээтэй дарцгийг нэмж оруулсан байв.

Канад Улсын татварын албаны судалгаа дүн шинжилгээ нь Кашмирын мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (ROKM) нь Жамаат-и-Ислами хөдөлгөөний буяны халхавч байгууллага байсныг илтгэсэн. Тус байгууллага нь өөрийн цэргийн жигүүр болох Хизбул Мужахидин байгууллагын дэмжлэгтэйгээр мөн Энэтхэгийн Жамму, Кашмир мужууд дахь эрх мэдлийг сулруулах зорилготой улс

төрийн байгууллага байв. Хизбул Мужахидин нь Европын Холбооны Зөвлөлөөс террорист байгууллагуудын жагсаалтад багтсан бөгөөд Энэтхэг Улсын Дотоод хэргийн яамны 1967 оны Хууль бус үйлдлийн (урьдчилан сэргийлэх) тухай хуульд заасны дагуу хориг тавьсан террорист байгууллагаар зарлагдсан байв.

РОКМ болон Жамаат-и-Исламигийн удирдлагын ижил төстэй байдал, эдгээр хүмүүсийн Хизбул Мужахидин байгууллагыг байгуулахад оролцсон, түүний үйл ажиллагааг дээд түвшинд хянадаг байсан, мөн эдгээр хүмүүсийн олонхи нь Кашмир дахь зэвсэгт хөдөлгөөнийг дэмжиж олон нийтэд мэдэгдэл гаргаж байсныг харгалзан CRA нь IDF-ийн хөрөнгө нөөцийг Жамаат-и-Ислами байгууллага болон/эсхүл түүний цэргийн жигүүр болох Хизбул Мужахидиний улс төрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигласан байж болзошгүй гэж үзэж анхаарлаа хандуулжээ.

Аудитын шалгалтын дүнд үндэслэн 2013 оны 9 дүгээр сард Хойд Америкийн исламын нийгэмлэгийн хөгжлийн сангийн (IDF) бүртгэлийг цуцалсан. Уг АББ-ын бүртгэлийг цуцалсан хэрэг нь Канад, АНУ, Энэтхэг зэрэг улсын олон хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол сэдэв болж гарсан. Үүний дараагаар мөн Кашмирын мусульманчуудад тусламж үзүүлэх байгууллага (РОКМ)-ын цахим хуудсыг хаасан.

Тэмдэглэл:

Энэхүү шинжлэн судалсан кейс тохиолдлыг зөвхөн олон нийтэд нээлттэй эх сурвалжийн баримт бичгээс боловсруулсан бөгөөд кейс тохиолдлын судалгаанд оролцсон аливаа нэг улсын мэдээллийг ашиглаагүй болно. Канад Улсын татварын албанаас 2013 оны 5 дугаар сарын 28-ны өдөр IDF-т явуулсан байгууллагын зохих менежментийг хангах шаардлагын тухай захидлыг үзнэ үү.

www.thestar.com/news/canada/2013/07/25/star_investigation_federal_audit_raises_concern_that_canadian_charity_funded_terror.html.

Кейс тохиолдол 69 – Террорист байгууллагатай холбоотой байх

Гадаадын хэдэн иргэн бүс нутгийн хоёр хувийн компани, нэг орон нутгийн АББ-ын нэрийн өмнөөс банканд данс нээлгэжээ. Эдгээр компани болон АББ нь кино үйлдвэр, харилцаа холбооны салбартай холбоотой байв. Дээрх хүмүүс нь эдгээр гурван байгууллагын менежер болон ажилтнууд гэж бүртгүүлсэн байжээ.

Тус хоёр компани, орон нутгийн АББ нь гадаадын иргэдээс хэдэн сая ам.доллар хүртэлх хэмжээтэй их хэмжээний мөнгөн орлогыг хүлээн авчээ. Эдгээр мөнгөний тодорхой хэсгийг олон улсын шилжүүлгээр кино үйлдвэрлэл эрхэлдэг бусад байгууллагаас шилжүүлсэн байв.

Хууль сахиулах байгууллагаас өгсөн мэдээлэлд дээрх хүмүүсийн зарим нь террорист үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай холбоотой байжээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар АББ болон хувийн компанийг санхүүжүүлэхэд ашигласан хөрөнгө нь террорист үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас гарсан байж болзошгүй гэдгийг тогтоосон.

Уг хэрэгт үргэлжлүүлэн мөрдөн шалгалт явуулахаар шүүхийн байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 70 – Террорист байгууллагатай холбоотой байх

АББ-ын үйл ажиллагаанд хяналт тавьдаг үндэсний хяналтын байгууллага орон нутгийн АББ террорист байгууллагатай холбоотой гэсэн мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсны дараа мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ. Орон нутгийн АББ-ыг террорист байгууллага үйл ажиллагаа явуулдаг бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын АББ-д хөрөнгө шилжүүлсэн гэдэгт буруутгасан байв. Эдгээр гадаадын АББ-ууд нь террорист байгууллага болон түүний улс төрийн жигүүрийн нэг хэсэг нь байсан бөгөөд терроризмтой холбоотой үйл ажиллагааг, түүний дотор хүүхдийг үзэл сурталд автуулах, хүчирхийллийн хэт даврах үзэл суртлыг ухуулан сурталчлах үйл ажиллагааг дэмждэг байв. Түүнчлэн, эдгээр гадаадын АББ-ууд нь хөрөнгийг буяны үйлсэд зориулж хуваарилах бус харин амиа золиослогчдын ар гэрийнхэнд хуваарилдаг байсан байж болзошгүй гэж үзэж байв.

Өөр нэгэн мэдээлэлд дурдсанаар орон нутгийн АББ-ын нэг удирдлах албан тушаалтан нь дээрх террорист байгууллагын улс төрийн жигүүрийн уулзалтад оролцож, хүчирхийллийн хэт даврах үзлийг дэмжиж олон нийтэд мэдэгдэл хийсэн гэсэн байв. Түүнчлэн орон нутгийн АББ нь хоёр дахь орон нутгийн АББ-тай холбоотой байсан бөгөөд түүний ерөнхийлөгч нь амиа золиослогчдын үйлддэг террорист ажиллагааг дэмжиж үг хэлсэн байж болзошгүй гэж үзэж байв.

Орон нутгийн АББ-ын тухайд өмнө нь хяналтын байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байжээ. Энэхүү өмнөх мөрдөн шалгах ажиллагаа нь орон нутгийн АББ террорист байгууллагыг санхүүжүүлдэг байсан бөгөөд террорист байгууллагын улс төрийн жигүүр гэдэг байсан улс төрийн намтай холбоотой хэд хэдэн урьдын дайчидтай холбоотой байсан гэдэг мэдээлэлд үндэслэсэн байв. Гэхдээ уг мөрдөн шалгах ажиллагааны явцад АББ-д зориулсан хандивыг террорист болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигласан гэдгийг нотлох баримтыг олоогүй байна.

Үүний нэгэн адил хяналтын байгууллагаас түүний дараа хийсэн мөрдөн шалгах ажиллагаагаар орон нутгийн АББ-ыг терроризмтой холбосон хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллийн үнэн зөв болохыг нотлох хангалттай баримтыг олж чадаагүй байна. Гэхдээ мөрдөн шалгах ажиллагааны явцад орон нутгийн АББ-ын удирдлага өөрийн гадаад түншүүддээ зохих хяналт тавьж, хяналтын дүрэм журмыг хангуулах үүрэг хариуцлагаа зохих ёсоор биелүүлээгүй болох нь тогтоогдсон.

Хяналтын байгууллага орон нутгийн АББ-аас олж илрүүлсэн дутагдлыг арилгахад буяны хөрөнгийн хүлээн авагчдыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон заалтыг боловсруулах, гадаад түнш байгууллагууд нь эдгээр шалгуурыг хатуу чанд мөрдөж байгаа эсэхэд баталгаа өгөх арга хэмжээ авахыг даалгажээ. Эцэст нь орон нутгийн АББ-ыг хоёр дахь АББ болон жагсаалтад орсон байгууллага хоорондын харилцаа холбооны улмаас уг хоёр дахь орон нутгийн АББ-аас салахыг шаардлага болгосон.

Кейс тохиолдол 71 – Террорист байгууллагатай холбоотой байх

АББ үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргаж үйл ажиллагаагаа зөрчил мөргөлдөөнтэй бүс нутгаас дүрвэгсдэд тусламж үзүүлэх гэж мэдэгдсэн байв. Хяналтын байгууллага тус АББ-ын өргөдлийн нягталж үзэж байхдаа үндэсний аюулгүй байдлын мэдээллийг хүлээж авчээ. Энэхүү мэдээллийн дагуу тус АББ-ын хэд хэдэн удирдах албан тушаалтан нь жагсаалтад орсон гадаадын террорист байгууллагатай холбоотой гэдгийг илтгэсэн байв. Эдгээр мэдээллийн үндсэн дээр тус АББ нь өнөөх террорист байгууллагыг хөрөнгө нөөцөөр хангадаг байсан, үйл ажиллагаагаа зогсоосон байгууллагатай нэг ижил удирдлагатай байж, нэг газар байрладаг байсныг нь тогтоосон байна.

Түүнчлэн хяналтын байгууллагаас тус АББ-ын өргөдлийг нягталж үзэх явцад өөр хэд хэдэн асуудлыг илрүүлжээ, тухайлбал төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны тодорхой бус байдал, түүнчлэн тус АББ-ын бусад байгууллагатай харилцах харилцааны талаархи зөрчилтэй эсхүл алдаатай мэдээлэл өгсөн байв. Тус АББ-ын өргөдөлд хийсэн дүн шинжилгээ болон түүнээс үүдэлтэй асуудалд үндэслэн хяналтын байгууллага тус АББ-ыг бүртгэхээс татгалзсан.

Кейс тохиолдол 72 – Террорист байгууллагатай холбоотой байх

АББ үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргахдаа гадаад дахь иргэний дайнаас зугтаж тухайн улсад ирсэн болон уг зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үлдсэн дүрвэгсдэд тусламж үзүүлэх зорилготой гэж мэдэгджээ.

Хяналтын байгууллага өргөдлийг хянаж үзэх явцад тус АББ нь үйл ажиллагааны чиглэлээ тодорхой заагаагүй, ялангуяа гадаад дахь үйл ажиллагаагаа тодорхой заагаагүй байсан нь анхаарал татсан байна. Хяналтын байгууллагаас хэд хэдэн удаа тус АББ-т зорилт, үйл ажиллагааны чиглэлийнхээ талаар нэмэлт мэдээлэл ирүүлэхийг хүсэлт болгожээ. Гэвч тус АББ нь үйл ажиллагааныхаа талаар маш бага мэдээлэл өгч, хэд хэдэн удаа үйл ажиллагааныхаа зорилтыг өөрчилсөн байна. Хэдийгээр тус АББ үйл ажиллагааныхаа зорилтыг байнга өөрчилж байсан ч тэр болгонд зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулах чиглэл нь хэвээр байжээ. Үүнтэй холбогдуулан хяналтын байгууллага тус АББ-ын үндсэн зорилго нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулах юм байна гэж үзэхэд хүргэсэн байна. Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар түүнтэй холбоотой байгууллагад хийсэн шалгалтаар тус АББ-аас зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын террорист байгууллагын салбарт мөнгө шилжүүлсэн болохыг илтгэх баримтуудыг илрүүлсэн байна.

Үүнтэй зэрэгцэн үндэсний аюулгүй байдлын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын террорист байгууллагын халхавчаар ажиллаж байсныг тогтоосон байна. Түүнчлэн тус АББ-ын тэргүүн нь уг террорист байгууллагын орон нутгийн төлөөлөгч нь байсныг тогтоожээ. Нэмж дурдахад, үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд тус АББ нь гадаадад үйл ажиллагаа явуулдаг өөр хоёр террорист байгууллагын холбогчоор ажилладаг байсныг илтгэсэн байв. Үндэсний аюулгүй байдлын энэхүү мэдээллийг хяналтын байгууллагад өгчээ. Гэхдээ уг

мэдээллээс өмнө хяналтын байгууллага тус АББ нь бүртгүүлэх шаардлагыг хангаагүй гэдэг дүгнэлтэд хүрсэн байв.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд үндэслэн хяналтын байгууллагаас тус АББ-д байгууллагынхаа зорилгыг үндсээр нь өөрчилж, үйл ажиллагааныхаа талаар нэмэлт мэдээлэл өгөөгүй тохиолдолд бүртгэх боломжгүй гэж мэдэгджээ. Үүний дараа тус АББ бүртгүүлэх хүсэлтээ буцаасан байна.

Кейс тохиолдол 73 – Террорист байгууллагатай холбоотой байх

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагын үүсгэн байгуулагч мөн жижиг аж ахуйн нэгжийн эзэн байжээ. Тэрбээр тухайн аж ахуйн нэгжийг удирдаж, “А” банкинд өөрийн хувийн данстай байв. Компанийн дансан дахь үлдэгдэл мөнгийг дээрх хүний хувийн дансанд шилжүүлж, бэлэн мөнгөөр авсан байна. Энэ нь “А” банкнаас сэжигтэй гүйлгээний мэдээллийг үндэсний СМА-нд илгээх шалтгаан болжээ.

Тухайн улсад амьдардаг гадаадын нэгэн иргэн дээрх жижиг аж ахуйн нэгжтэй холбоотой байсан бөгөөд “Б” банкинд хувийн данстай байв. Тэрбээр өөрийн дансанд бэлэн мөнгөний орлого хийж, дараагаар нь зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт байрладаг өөр байгууллага руу цахим банкны шилжүүлгээр шилжүүлжээ. Эдгээр мөнгөн гуйвуулгын тодорхойгүй зорилготой тайлбар, үндэслэл нь “Б” банкнаас сэжигтэй гүйлгээний мэдээллийг үндэсний СМА-нд илгээхэд хүргэжээ.

Уг жижиг аж ахуйн нэгжийн дансанд СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар дээрх гадаадын иргэний хувийн дансанд хэд хэдэн удаа мөнгөн шилжүүлэг хийж, улмаар мөнгийг хүлээн авсны дараа бэлэн мөнгөөр авсныг тогтоосон. СМА-ийн хийсэн дүн шинжилгээгээр жижиг аж ахуйн нэгжийн данснаас авсан мөнгө нь гадаадын иргэний дансанд орлого хийсэн цаг хугацаа, мөнгөн дүнтэй давхцаж байсныг илрүүлсэн.

Хууль сахиулах байгууллагын мэдээллээр тус АББ-ын үүсгэн байгуулагч, жижиг аж ахуйн нэгжийн эзэн нь террорист байгууллагын идэвхтэй гишүүн байсныг илтгэсэн. Түүнчлэн хууль сахиулах байгууллага жижиг аж ахуйн нэгж нь хуурамч баримт бичиг үйлдсэн хэргийн мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой гэх мэдээллийг нотолжээ. Мөрдөгчид гадаадын иргэний дансаар дамжуулан жижиг аж ахуйн нэгжийн данснаас зөрчил мөргөлдөөнтэй бүс нутаг руу явуулдаг байсан мөнгө нь хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого байсан бөгөөд эцсийн дүнд гадаадын террорист байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулсан байж болзошгүй гэдэг дүгнэлтэд хүрчээ.

Кейс тохиолдол 74 – Террорист байгууллагатай холбоотой байх

АББ тухайн улсдаа хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах нэрээр үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Хяналтын байгууллага өргөдлийг хянаж үзэх явцдаа тус АББ-ын зорилго, үйл ажиллагаа нь ихээхэн бүрхэг

байсан нь тус байгууллагад буяны бус үйл ажиллагаа эрхлэх боломжийг өгч байсныг анхааралдаа авчээ. Түүнчлэн тус АББ зөвхөн гадны зөрчил мөргөлдөөнтэй бүс нутгаас цагаачилж ирсэн үндэсний цөөнхийн дунд ажиллах зорилготой байсан нь хяналтын байгууллагын анхаарлыг татжээ. Үүнээс гадна нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд тус АББ-ыг террорист байгууллагыг дэмждэг хүмүүстэй харилцаа холбоотой болохыг илтгэсэн байв.

Хяналтын байгууллагын хүлээж авсан үндэсний аюулгүй байдлын мэдээллээр тус АББ-ын дор хаяж хоёр удирдах албан тушаалтан өнөөх зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг жагсаалтад орсон террорист байгууллагын нэр бүхий дэмжигчид байжээ. Тус АББ-ын нэг удирдах албан тушаалтан нь уг террорист байгууллагын улс төрийн жигүүрийн ахмад гишүүний хамаатан байсныг тогтоосон байна. Түүнчлэн уг удирдах албан тушаалтан нь терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хүмүүстэй холбоотой байсныг тогтоожээ. Хоёрдахь удирдах албан тушаалтан нь өнөөх жагсаалтад орсон террорист байгууллагыг дэмждэг гэж үздэг байсан бусад хэд хэдэн байгууллагатай холбоотой байжээ.

Хяналтын байгууллагаас тус АББ-ын хүсэлтэд хариу өгөхдээ түүний заасан зорилтууд нь тодорхой бус эсхүл хэт өргөн хүрээтэй байгаа нь түүнд улс төрийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байна гэдгийг мэдэгджээ. Тус АББ-д эдгээр асуудлыг тодруулж өгөх боломжийг олгосон боловч хариу ирүүлээгүй байна. Үүний үр дүнд тус АББ-ыг бүртгээгүй болно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ

Кейс тохиолдол 75 – Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Орон нутгийн АББ өөрийн цахим хуудсандаа террорист амиа золиослогчдын үйлдлийг зөвтгөсөн байж болзошгүй үйлдэлтэй холбогдуулан түүний талаар сөрөг мэдээллэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарчээ.

АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний эрх бүхий байгууллагаас тус АББ-ын цахим хуудсанд дүн шинжилгээ хийхэд тус АББ нь хэд хэдэн террорист амиа золиослогчдын нэр бүхий “амиа золиослогчдын” жагсаалтыг нийтэлсэн болохыг илрүүлжээ. Хяналтын байгууллагын оролцоотойгоор уг зохисгүй агуулга бүхий мэдээллийг цахим хуудаснаас нь устгуулсан байна.

Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ-ын удирдлагын хяналтын тогтолцоо хангалтгүй, эрсдлийн менежментийн тогтолцоо үр дүнгүй байсан гэж дүгнэжээ. Тус АББ-д учирч болзошгүй эрсдлийг илүү үр дүнтэй бууруулахын тулд удирдлагын тогтолцоогоо нягталж харахыг чиглэл болгожээ.

Кейс тохиолдол 76 – Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах

Боловсрол, шашин, соёлын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагыг байгуулжээ. Гэхдээ хяналтын байгууллага тус АББ-ын бүртгүүлэх хүсэлтийг нягталж үзэх явцдаа тус АББ-ын мэдэгдээгүй нэг зорилго нь гадаадын террорист хөдөлгөөнийг дэмжих тухай байсныг нуусан гэж сэжиглэжээ. Эцсийн дүнд тус АББ-ыг бүртгэсэн хэдий ч үйл ажиллагааг нь хяналтандаа авсан байв.

Дараагийн хяналт шалгалтаар тус АББ нь хэд хэдэн тохиолдолд өөрийн хөрөнгө нөөцийн гарал үүсэл, эцсийн зарцуулалтыг тайлбарлаж чадахгүй байсныг нь тогтоожээ. Нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд судалгаа дүн шинжилгээ хийхэд тус АББ нь гадаадын террорист бүлэглэлийг дэмжих зорилготой улс төрийн үйл ажиллагаа явуулдаг байсан гэж үзэх нэмэлт сэжиг гарчээ. Хууль сахиулах байгууллагын мэдээллээр тус АББ нь террорист хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байсныг илтгэсэн бол үндэсний аюулгүй байдлын мэдээллээр тус АББ-ын хэд хэдэн захирал нь гадаадын террорист бүлэглэлтэй холбоотой байсныг илтгэсэн байна.

Эдгээр баримтыг үндэслэн тус АББ-ын бүртгэлийг цуцалж, үндэсний хяналтын байгууллага энэ хэргийн материалыг хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлын байгууллагуудын мөрдөн шалгах ажиллагаанд зориулан хүргүүлжээ.

Кейс тохиолдол 77 – Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах

АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний эрх бүхий байгууллага боловсрол, соён гэгээрүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагыг хүчирхийлэх хэт даврах үзлийг сурталчилдаг бүлэглэлийн ахмад гишүүд, идэвхтнүүд удирддаг гэсэн мэдээлэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсны дараа мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ. Мэдээллийн дагуу эдгээр хүмүүс нь АББ-ын сургуулийг хүчирхийлэлд хүргэдэг хэт даврах үзлийг дэлгэрүүлэн сурталчлах, заах зорилгоор ашигладаг байсан байна.

Хяналтын байгууллага олон янзын эх сурвалжийн мэдээллийг хүлээн авч, нягталж үзжээ. Үүнд өөрсдийн мэдээллийг нотлох зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс ирүүлсэн баримт мэдээлэл, ашгийн бус байгууллагын өөрийнх нь өгсөн мэдээлэл, боловсролын зөвлөлөөс өгсөн материалууд багтсан болно.

Хяналтын байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ-ын нэг удирдах албан тушаалтан өмнө нь хүчирхийлэлд турхирах радикал үзлийг сурталчилдаг байгууллагын гишүүн байсныг нь илрүүлсэн байна. Гэвч тус АББ-ын дээрх удирдлага энэ үйл явдал болохоос хэдэн жилийн өмнө тус байгууллагаас гарсан байсан бөгөөд тэрбээр уг радикал байгууллагын улс төрийн зарим үзэл санааг хуваалцахаа больсон байв.

Хяналтын байгууллага мөн тус АББ-ын удирдах албан тушаалтны нэг нь уг радикал байгууллагын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгч байсан

эмэгтэйтэй гэрлэсэн байсныг нь илрүүлсэн байна. Гэхдээ холбогдох материалыг хэвлэлд нийтлэснээс хойш энэхүү харилцаа нь мөн дуусгавар болсон байв.

Кейс тохиолдол 78 – Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Ашгийн бус байгууллага зөвхөн дотоддоо шашны болон боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байсан бөгөөд гадаадад ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй байжээ. Гэхдээ үндэсний СМА-аас өгсөн мэдээлэлд тус АББ нь гадаадын террорист бүлэглэлд дэмжлэг үзүүлдэг гадаадын байгууллагаас 13,000 гаруй ам.доллар хүлээн авсныг илтгэсэн байв.

Үүний дараа нээлттэй эх сурвалжийн мэдээллийг судалж үзэхэд тус АББ-ын боловсролын төсөл хөтөлбөрүүд нь гадаадын хэд хэдэн террорист бүлэглэлийн баримталдаг үзэл суртлыг дэмждэг болохыг илтгэсэн байна. Үүнтэй холбогдуулан уг үзэл суртлыг террорист байгууллагын шинэ гишүүд, дэмжигчдийг элсүүлэх зорилгоор ашигладаг гэж үзэх сэжиг, болгоомжлол төржээ. Хожим нь тус АББ-ын сургуулийн төгсөгчдийн нэг нь өөр улсад терроризмын гэмт хэрэгт буруутгагдаж байсныг илрүүлсэн байна. Энэхүү хуучин сурагч нь мөн терроризмын гэмт хэрэгт буруутгагдсан өөр хэд хэдэн хүнтэй уулзсан байжээ.

Үндэсний хяналтын байгууллагаас тус АББ-ын үйл ажиллагаанд аудитын шалгалт хийхэд тус АББ нь ихэнхи орлого, зарлагынхаа гарал үүслийн талаар тайлагнаагүй болох нь тогтоогджээ. Шалгалтын үр дүнд тус АББ-ын бүртгэлийг цуцалсан байна.

Кейс тохиолдол 79 – Үйл ажиллагааны хөтөлбөрийг хууль бусаар ашиглах

АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний байгууллагад хууль сахиулах байгууллагаас өгсөн мэдээлэлд үндэсний (орон нутгийн) АББ-ын цахим хуудсанд хүчирхийллийг сурталчлахад ашиглаж болох радикал шинжтэй мэдээллийг оруулсныг илтгэсэн байв.

Хууль сахиулах байгууллага тус АББ-д шууд шалгалт явуулах боломжгүй байв. Гэхдээ хяналтын байгууллагын тус байгууллагатай тогтоосон харицлаа холбоо, үйл ажиллагааны ачаар тус АББ нь өөрийн цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээллийн агуулгад хангалттай хяналт тавьдаггүй байсныг тогтоосон байна. Хяналтын байгууллагаас өгсөн зааварчилгааны дагуу тус АББ нь сэжигтэй мэдээллийг өөрийн цахим хуудаснаас устгасан байна.

ЭЛСҮҮЛЭХ АЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Кейс тохиолдол 80 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх (Гуравдугаар бүлэгт иш татсан)

АНУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 13224 тоот захирамжийн дагуу “Аль Рехмат Траст” (Пакистан Улсад үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага)-ыг терроризмыг дэмждэг байгууллагын жагсаалтад оруулсан байна. Шалтгаан нь тус АББ “Аль Каида” болон түүнтэй холбоотой бусад байгууллагуудын хяналтад байсан, тэдгээрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, жагсаалтад орсон террорист байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн явдал байв.

“Аль Рехмат Траст” сан нь НҮБ-ын террорист байгууллагын жагсаалтад орсон “Жаиш-и-Мохаммед” байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хөрөнгө босгох зорилгоор байгуулагдсан халхавч байгууллага байсан. “Жаиш-и-Мохаммед” (Пакистан Улсад байрладаг, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 тоот тогтоолын дагуу террорист байгууллагын жагсаалтад орсон террорист бүлэглэл)-ыг 2002 онд Пакистан Улсад хориглосны дараа тэрбээр үйл ажиллагаагаа халхавчлах зорилгоор “Аль Рехмат Траст” санг ашиглаж эхэлсэн байна. “Аль Рехмат Траст” сан нь Афганистан, Пакистан дахь цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг байсан бөгөөд мөн хоёр улсад байлдаж байсан гадаадын дайчдад санхүүгийн болон зохион байгуулалтын туслалцаа, дэмжлэг үзүүлдэг байжээ. 2009 оны эхээр “Аль Рехмат Траст” сангийн хэд хэдэн нөлөө бүхий гишүүд Афганистан Улсад террорист ажиллагаа явуулах зорилгоор оюутнуудыг элсүүлсэн байв. Түүнчлэн, “Аль Рехмат Траст” сан нь өөрийн сүм, хийдэд дайчдыг сургах, үзэл сурталд автуулах зэрэг ажилд зориулж “Жаиш-и-Мохаммед” бүлэглэлд хөрөнгө босгодог байсан. 2009 оны эхээр “Аль Рехмат Траст” сан нь алагдсан эсхүл баривчлагдсан дайчдын ар гэрийнхнийг дэмжих зорилгоор Пакистан Улсад хандивын төсөл хөтөлбөрийг эхлүүлсэн. Мөн 2007 оны эхээр “Аль Рехмат Траст” сан нь “Худам-ул-Ислам” (“Жаиш-и-Мохаммед” бүлэглэлийн өөр нэр) байгууллагын нэрийн өмнөөс хөрөнгө босгож байсан.

“Аль Рехмат Траст” сан нь Афганистан Улсаас ирсэн шархадсан Талибанчуудын дайчдад санхүүгийн тусламж үзүүлэх зэргээр “Талибан” хөдөлгөөнд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлдэг байсан.

Кейс тохиолдол 81 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага хүчирхийллийн хэт даврах үзлийг сурталчлан таниулдгаараа нэртэй илтгэгчид оролцдог арга хэмжээ, уулзалтыг зохион байгуулж, орон байраар хангаж байсныг илрүүлсэн байна. Эдгээр арга хэмжээг үзэгчдийн тоо олон зууд хүрдэг байсан бөгөөд уулзалт, арга хэмжээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлдэг байжээ.

Тухайн улсын төрийн хэд хэдэн байгууллагын хүчээр зөрчилдөөнтэй нөхцөл байдлыг шийдвэрлэсний дараа АББ-ын үйл ажиллагааг хянадаг үндэсний эрх бүхий байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ нь уригдаж буй илтгэгчид болон арга хэмжээг зохион байгуулагчдыг тохирох эсэхийг зохих ёсоор үнэлж, тодорхойлох тогтолцоо хангалтгүй байсан гэж дүгнэсэн. Хяналтын байгууллага тус АББ-тай холбогдож ажилласны дараа тус АББ

нь дээрх үйл ажиллагаагаа зогсоосон бөгөөд түүний удирдлага дотоод удирдлагын дүрэм, журмыг бүхэлд нь нарийвчлан нягталж үзэхээр болсон байна.

Тус АББ-ын үйл ажиллагааг түр зогсоож, хяналтын байгууллага хяналтандаа авсан байгаа болно.

Кейс тохиолдол 82 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Соёл, шашны болон боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага арга хэмжээ, уулзалт зохион байгуулж, орон байраар хангадаг байжээ. Тус байгууллага үндэсний хяналтын байгууллагаас шаардсаны дагуу үйл ажиллагааныхаа шинэчилсэн зорилгын талаар ирүүлсэн мэдээлэл нь хяналтын байгууллагын анхаарлыг татжээ. Хяналтын байгууллага тус АББ-ын шинэ зорилго нь нилээд бүрхэг, тодорхой бус заасныг тэмдэглэсэн байна.

Түүнчлэн нээлттэй эх сурвалжийн мэдээллийг судалж үзэхэд тус АББ-ын ерөнхий захирал нь хүчирхийллийг дэмжихээс гадна хүчирхийлэл үйлдэх зорилгоор дэмжигчдийг элсүүлэх, бусад үндэстэн угсаатан болон шашны бүлгийг доромжилсон мэдэгдэл, илтгэл тавьж байсныг тогтоожээ. Мөн тус АББ нь дээр дурдсан утга, агуулгатай ижил төстэй илтгэл, мэдэгдэл хийснээс болж бусад арга хэмжээнд оролцохыг хориглосон илтгэгчийг урьсан байв. Эдгээр анхаарал татсан асуудлын талаар мэдэгдэл авсны дараа тус байгууллага үйл ажиллагааныхаа зорилтыг шинэчилж, дээр дурдсан ерөнхий захирал, илтгэгчтэй харилцаагаа зогсоосон гэдгээ мэдэгджээ.

Үүнтэй холбогдуулан хяналтын байгууллага тус АББ-д хяналт шалгалт хийж, түүний үйл ажиллагаанд илүү хатуу хариуцлага тавих, тайлагнах журмыг мөрдүүлэх хянан магадлагааны нийцүүлэлтийн гэрээг байгуулсан.

Кейс тохиолдол 83 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Дотоддоо болон гадаадад хүмүүнлэг, соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Хяналтын байгууллага тус АББ-ын хүсэлтийг нягталж үзэх явцдаа тус АББ-ын зорилго, үйл ажиллагааг ихээхэн бүрхэг, тодорхой бус тайлбарласан байсан нь түүнд шаардлагад нийцээгүй үйл ажиллагааг эрхлэх боломжийг олгож байсныг тэмдэглэжээ. Тус АББ эдгээр асуудлыг шийдвэрлэж чадаагүй тул түүнийг бүртгэхээс татгалзсан байна.

Үүнээс гадна үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд тус АББ-ын барилга байгууламжийг жагсаалтад орсон террорист байгууллагын дэмжигчдийн уулзалтыг зохион байгуулахад ашигладаг байжээ. АББ-ын урилгаар оролцсон тус АББ-ын ТУЗ-ийн гишүүн асан нь хүчирхийлэлд дэмжигчдийг элсүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оролцсон гэдгээрээ нэртэй нэгэн байжээ.

Хэсэг хугацааны дараа хяналтын байгууллагад өөр нэг АББ-аас бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авсан бөгөөд түүний нэр нь эхний байгууллагын нэртэй давхцаж байжээ. Шинэ АББ нь өмнөх байгууллагатай адилхан үйл ажиллагаа явуулах гэж байсан бөгөөд мөн л үйл ажиллагаагаа ихээхэн бүрхэг, тодорхой бус байдлаар заасан байв. Хяналтын байгууллагаас явуулсан судалгаа, дүн шинжилгээгээр хүсэлт ирүүлсэн шинэ АББ нь үнэндээ эхний АББ-ын хуулбар байсныг нь тогтоожээ. Эдгээр хоёр байгууллага нь хоёулаа нэг ижил хаяг, утасны дугаар, банкны данстай байсан бөгөөд АББ-ын үйл ажиллагаатай холбоотой баримт бичигт тус байгууллагын хуучин, шинэ нэрийг аль алиныг нь ашигласан байв.

Хяналтын байгууллага эдгээр асуудлын талаар АББ-д мэдэгдэж, алдаа дутагдлаа залруулах боломжийг олгожээ. Тус АББ хяналтын багууллагаас хүсэлт болгосон зүйлийг шийдвэрлээгүй тул түүнийг бүртгэхээс татгалзсан байна.

Кейс тохиолдол 84 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Гадаадын иргэн гадаадын банкин дахь хувийн данснаасаа үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагын дансанд мөнгө шилжүүлэхийг захиалга өгчээ. Тэрбээр мөнгө шилжүүлэх үндэслэлээ нэгэн хувь хүнийг ивээн тэтгэдэг болох, тодруулбал уг этгээдийн амьжиргааны зардалд зориулсан байв.

Үндэсний СМА-аас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар уг ивээн тэтгүүлэх хүн нь террористуудын жагсаалтад орсон байсныг тогтоожээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар мөн дээрх ашгийн бус байгууллага нь террорист үйл ажиллагааг санхүүжүүлдэг хувь хүн, аж ахуйн нэгжийн сүлжээтэй нягт холбоотой байсныг илрүүлсэн байна.

Кейс тохиолдол 85 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Шинээр байгуулагдсан үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага хүчирхийллийн хэт даврагч үзлийг сурталчлан таниулдаг илтгэгчид, суртал ухуулагчид оролцдог лекцийг зохион байгуулах/эсхүл зохион байгуулах орон байраар хангах үйл ажиллагаа эрхэлдэг байсныг илрүүлжээ.

Дотоодын хэд хэдэн төр засгийн байгууллагын оролцоотойгоор зөрчилдөөнтэй нөхцөл байдлыг арилгасны дараа АББ-ын үйл ажиллагаанд хяналт тавьдаг үндэсний эрх бүхий байгууллагын мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлжээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар тус ашгийн бус байгууллага нь эдгээр арга хэмжээг зохион байгуулаагүй хэдий ч эдгээр арга хэмжээг зохион байгуулсан буяны бус боловсролын байгууллагатай нягт холбоотой байсан гэдэг дүгнэлтэд хүрсэн байна.

Түүнчлэн хяналтын байгууллага тус ашгийн бус байгууллагын удирдах албан тушаалтнууд нь дээрх боловсролын байгууллагын захирлын үүргийг нэгэн зэрэг гүйцэтгэж байсныг тогтоожээ. Энэ нь хяналтын байгууллагын хувьд байж боломгүй ашиг сонирхолын зөрчил байсан.

Кейс тохиолдол 86 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Үндэсний олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагыг террорист халдлага үйлдсэн гэмт этгээдүүдтэй холбоотой гэж олон нийтэд мэдээлжээ. Халдлагын үеэр амиа золиослогч хоёр этгээд нь тус АББ-ын удирдлагаар ажиллаж байсан гэж мэдээлсэн байв. Түүнчлэн тус АББ-ын байрнаас хэт даврагч үзлийн материал олдсон байв.

Үүнээс гадна тус АББ-ын өмнөх хоёр удирдлагыг терроризмтой холбоотой хэрэгт буруутгаж шийтгэсэн байжээ. Тэдний нэгийг террорист ажиллагаа явуулах эсхүл бэлтгэхэд ашиглаж болох мэдээллийг агуулсан баримт бичиг хадгалсан хэргээр, нөгөөхийг нь террористуудыг бэлтгэдэг газар очих гэж оролдсон хэргээр ялласан байв.

Хяналтын байгууллагын мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ-ыг террорист, хүчирхийлэлд уриалсан хэд даврах үзэл эсхүл бусад хууль бус үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашиглаж байсан эсэхийг олж тогтоохоор ажилласан байна. Мөрдөн шалгах ажиллагаагаар мөн тус АББ-ын хөрөнгийг террорист халдлагад дэмжлэг үзүүлэх зорилгоор ашигласан эсэх, тус АББ-ын байранд хүчирхийлэлд уриалсан хэт даврах үзлийн материал байсан эсэх болон тус АББ-ын байрыг террорист ажиллагааг төлөвлөх төв байр болгон ашиглаж байсан эсэхийг тогтоохоор ажиллажээ. Хяналтын байгууллага түүнд олгогдсон эрх мэдлийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа дуусахаас өмнө, хэргийн бүх нөхцөл байдлыг тодруулах хүртэл тус АББ-ын банкин дахь дансыг царцаасан байна.

Хяналтын байгууллага мөрдөн шалгах ажиллагааны явцад цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах ажиллагааны явцад тус АББ-ын байрнаас хураан авсан материал, баримт бичгийг шалгасан байна. Хэдийгээр ихэнхи материал нь эргэлзээ төрүүлээгүй боловч хураан авсан баримт бичгийн тавны нэг нь улс төрийн, ялгаварласан, суртал ухуулга эсхүл тус АББ-ын үйл ажиллагаанд зохимжгүй байсан гэж үзжээ. Тус АББ-ын байрнаас авсан баримт бичигт үндэслэн түүнд эрүүгийн хариуцлага ноогдуулаагүй байна.

Ерөнхийдөө мөрдөн шалгах ажиллагаагаар тус ашгийн бус байгууллага болон түүний байрыг террорист, хэт даврах үзэл болон бусад хууль бус үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэхэд ямар нэгэн үүрэгтэй байсан эсэхийг тогтоож чадаагүй байна. Гэхдээ террорист халдлагын дараа тус АББ-ыг татан буулгасан байна.

Кейс тохиолдол 87 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Ашгийн бус байгууллага үнийн 80 хувийг урьдчилгаа төлбөрөөр төлж үл хөдлөх хөрөнгө худалдаж авчээ. Үлдсэн 20 хувийг орон нутгийн банкин дахь данснаасаа шилжүүлсэн байна. Тус банкнаас үл хөдлөх хөрөнгө худалдаж авахтай холбоотой энэхүү сэжигтэй гүйлгээний талаар үндэсний санхүүгийн мэдээллийн албанд мэдэгджээ.

СМА-гийн мөрдөн шалгах ажиллагаагаар уг төлбөрийн үлдэгдэл мөнгөний гүйлгээг тус АББ-ын нэг удирдах албан тушаалтны хувийн данснаас шилжүүлсэн болохыг тогтоожээ. Уг мөнгийг шилжүүлэхээс өмнө тус удирдах албан тушаалтны дансанд их хэмжээний бэлэн мөнгөний орлого орсон байсан нь энэхүү хөрөнгийн эх үүсвэрийг тогтооход хүндрэл учруулсан байна.

Дээрх удирдах албан тушаалтан нь өөр нэг АББ-д мөн ижил албан тушаалыг хашиж байсан бөгөөд хууль сахиулах байгууллагын мэдээлснээр түүнийг террорист байгууллагыг дэмждэг гэдэгт сэжиглэсэн байжээ. Түүнчлэн уг удирдах албан тушаалтныг террорист байгууллагад байлдагчид элсүүлэхэд оролцсон гэж үздэг байсан бөгөөд тэрбээр уг террорист байгууллагын идэвхтэй гишүүнтэй нягт холбоотой байсан.

Түүнчлэн тус АББ-ын өөр нэг удирдах албан тушаалтан террорист үйл ажиллагааг дэмждэг байгууллагын үйл ажиллагаанд оролцсон нь тогтоогдсон байна.

Кейс тохиолдол 88 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Үндэсний (орон нутгийн) ашгийн төлөө бус байгууллага АББ-ын үйл ажиллагааг зохицуулах үндэсний эрх бүхий байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргахдаа орон нутгийн цагаач иргэдийн нийгэмлэгт зориулж шашин, соёлын төвийг нээх зорилготой гэж мэдэгджээ. Тус АББ-аас бүртгүүлэх хүсэлт ирүүлэхийн өмнөхөн хяналтын байгууллага үндэсний аюулгүй байдлын байгууллагаас тус АББ-ыг нэр бүхий террорист байгууллагатай холбоотой этгээдийн хяналтад байж болзошгүй гэдэг мэдээллийг хүлээж авсан байв.

Хяналтын байгууллага тус АББ-ын зорилго, үйл ажиллагаа нь бүрхэг, тодорхой бус байгааг дурдаж, тус АББ-ын удирдлага, үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсчээ. Хяналтын байгууллага нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсний дараа тус АББ нь хэд хэдэн нэр бүхий террорист байгууллагын баримталдаг улс төрийн үзэл бодлыг ухуулан сурталчилж байсныг илрүүлжээ. Тус АББ-ын төлөөлөгчид дээрх террорист байгууллагаас орон нутгийн цагаач иргэдийн нийгэмлэгт өөрсдийн үзэл бодлыг сурталчлан таниулах зорилгоор ашигладаг илтгэл, амь үрэгдсэн террористуудын гэрэл зураг бүхий хэвлэмэл материалтай төстэй илтгэл тавьж, зурагт материал тараасан байв. Түүнчлэн тус АББ нь дээр дурдсан террорист байгууллагын баримталдаг улс төрийн үзэл бодол, үзэл суртлыг ухуулан сурталчилдагаараа танигдсан гадаадын байгууллагаас зохион байгуулж, ивээн тэтгэсэн арга хэмжээнд зориулан өөрийн орон байрыг гаргаж өгснийг тогтоожээ.

Хяналтын байгууллага дээрх АББ-ыг хүчирхийллийн үйл ажиллагааг дэмжигчдийг элсүүлэх ажилд ашиглаж байна гэж үзэх өндөр эрсдэлтэй гэж үзэж, тус АББ-ыг бүртгэхээс татгалзсан байна.

Кейс тохиолдол 89 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Засгийн газрын нэгэн байгууллагаас үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага жагсаалтад орсон террорист байгууллагад дэмжлэг үзүүлдэг байж болзошгүй гэж АББ-ын хяналтын байгууллагад мэдэгджээ. Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл энэхүү мэдээллийг нотолсон байна.

Хяналтын байгууллага энэхүү АББ-тай ажилласны дүнд тус АББ-ын ойролцоо жагсаалтад орсон байгууллагын дэмжигчид оролцдог жагсаал, цуглааныг зохион байгуулдаг байсныг тогтоожээ. Тус АББ-ын байранд хийсэн үзлэг шалгалтаар жагсаалтад орсон байгууллагын гишүүдийн олон тооны гэрэл зураг, улс төрийн эд зүйлсийг хананд өлгөсөн байсныг илрүүлсэн байна.

Тус АББ-ын удирдлагуудад эдгээр бүх зураг, эд зүйлсийг хурааж авах, жагсаалтад орсон байгууллагатай тогтоосон бүх харилцаа холбоогоо таслах, тус АББ-ын байр, үйл ажиллагаанд илүү хатуу хяналт тавихыг үүрэг болгожээ.

Кейс тохиолдол 90 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Соёл, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага үндэсний хяналтын байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргажээ. Үүнээс гадна тус АББ нь шашны байгууллагын үйл ажиллагааг удирдаж, олон илтгэгчид уригдаж оролцдог лекц сургалтыг зохион байгуулдаг байв.

Хяналтын байгууллага тус АББ-ын өргөдлийг нягталж үзэх явцдаа нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн байна. Хяналтын байгууллагын эргэлзээ нь тус АББ-ын урьж оролцуулсан зарим лектор, илтгэгч нь террорист байгууллагын гишүүн, дэмжигчдийг элсүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд оролцсон байж болзошгүй гэж үзсэнтэй холбоотой байв. Нээлттэй эх сурвалжаас авсан нэмэлт мэдээлэлд тус АББ-ын үйл ажиллагаанд ихээхэн нөлөө бүхий нэгэн этгээд (гэхдээ бүртгүүлэх хүсэлтэд түүнийг удирдах албан тушаалтан гэж мэдэгдээгүй байсан) жагсаалтад орсон террорист байгууллагатай холбоотой гэж үзсэн байв.

Төр засгийн бусад байгууллагаас өгсөн үндэсний аюулгүй байдлын мэдээлэлд тус АББ-ын үйл ажиллагаагаа явуулна гэж байсан орон нутгийн цагаач иргэдийн нийгэмлэг нь дээр дурдсан террорист байгууллагын дэмжигчид болон дагалдагчдаа элсүүлэх ихээхэн эмзэг зорилтот бүлэг байсан.

Эдгээр баримтуудыг үндэслэн хяналтын байгууллага тус АББ-ыг бүртгэж авахаас татгалзсан байна.

Кейс тохиолдол 91 – Элсүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

Хэвлэлийн компанийн эзний гэрт тэсрэх бөмбөг хаясантай холбогдуулан үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагын удирдах албан тушаалтныг баривчилж, улмаар уг халдлагад буруутгажээ. Энэхүү хэвлэлийн компани нь зарим хүний үзэж

буйгаар тодорхой нэг шашиныг дайрч доромжилсон утгатай номыг хэвлэлтэд гаргахаар бэлтгэж байжээ.

Тэсрэх бөмбөг дэлбэрсэн халдлагын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл нийтлэгдсэний дараа АББ-ын үндэсний хяналтын байгууллага халдлагыг үйлдэгч этгээд нь үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллагын тэргүүн байсныг тогтоосон байна. Хяналтын байгууллага тус АББ-ын бусад удирдах албан тушаалтнуудыг шалгажээ. Тус АББ-ын төлөөлөгчид тус АББ-ын ТУЗ-өөс цагдаагийн мөрдөн шалгах ажиллагаа дуусахаас өмнө халдлага үйлдэгчтэй харилцаагаа зогсоох шийдвэр гаргасан тухай хяналтын байгууллагад мэдэгджээ. Удалгүй тус АББ-ын ТУЗ-өөс уг этгээдийг АББ-ын тэргүүний албан тушаалаас халах санал тавьжээ.

Халдлага үйлдсэн этгээдийг эд хөрөнгө сүйтгэж, хүний амь насыг санаатайгаар хөнөөх үйлдэлд гэм буруутайг нь тогтоожээ. Ял шийтгүүлсний дараагаар уг этгээд дээрх АББ-ын ТУЗ-ийн гишүүнээс сайн дураараа огцорчээ. Хэрвээ тэрбээр сайн дураараа огцроогүй байсан бол хяналтын байгууллагаас огцрохыг шаардах байсан.

ТӨӨРӨГДҮҮЛЭХ ТӨЛӨӨЛӨЛ, ХУУРАМЧ АББ

Кейс тохиолдол 92 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ

Хоёр этгээд тэдгээрийн эх нутагт үйл ажиллагаа явуулдаг жагсаалтад орсон террорист байгууллагыг дэмжих зорилгоор орон нутагтаа хөрөнгө босгох үйл ажиллагаа явуулдаг байв. Тэд өөрсдийн нутгийн цагаач иргэдийн нийгэмлэгт хандаж хандив үзүүлэхийг биечлэн хүсэлт болгож, мөн телеконференц зохион байгуулж, энэ үеэр уригдсан суртал ухуулагчид оршин суугчдыг жагсаалтад орсон террорист байгууллагыг дэмжиж хандив үзүүлэхийг ятгадаг байжээ. Эдгээр хүмүүсийн нэг нь хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд гэдэг хуурамч нэрийдлээр мөнгө цуглуулсан байв. Дээр дурдсан этгээдүүд цуглуулсан хөрөнгийг, эдгээр хөрөнгийг хүлээн авагчдын хувийн мэдээллийг нуух зорилгоор хуурамч нэр ашиглан мөнгө шилжүүлэх үйлчилгээ үзүүлдэг янз бүрийн компаниар дамжуулан террорист байгууллагад шилжүүлсэн байв.

Хууль зүйн яамнаас эдгээр хүмүүст эрүүгийн хэргээр ял оногдуулж, тэднийг 10, 20 жилийн хорих ялаар шийтгэсэн.

Кейс тохиолдол 93 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ (Дөрөвдүгээр бүлэгт иш татсан)

Залуучуудын соёлын нийгэмлэг нэрээр байгуулагдсан үндэсний (орон нутгийн) ашгийн бус байгууллага Засгийн газрын хэд хэдэн буцалтгүй тусламжийг авчээ.

Хууль сахиулах байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагаагаар тус АББ нь террорист бүлэглэлийн халхавчаар ажиллаж байсан хуурамч байгууллага байсныг олж тогтоожээ. Тус АББ-ын бодит үйл ажиллагаа нь террорист бүлэглэлийн ашиг

сонирхолд хөрөнгө босгох, хөрөнгийн зарцуулалтыг удирдах болон тус бүлэглэлийн хэт даврах үзэл суртлыг цахим сүлжээгээр түгээх явдал байв.

Хэдийгээр тус АББ нь албан ёсны удирдан зохион байгуулах зөвлөлтэй байсан ч бодит байдалд түүнийг нь террорист бүлэглэлийн гишүүд үүсгэн байгуулж, удирддаг байжээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар гол холбоотой этгээдүүдийг баривчилж, тус АББ болон түүний цахим хуудсыг хаасан байна.

Кейс тохиолдол 94 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр бүртгэлтэй ашгийн бус байгууллага терроризмыг дэмжигч улсын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, түүнийг дээрх улсын ашиг сонирхлыг дэмжих үүднээс бусад орон нутгийн байгууллагад мөнгө шилжүүлэхэд ашиглаж байсан гэж мэдээлжээ.

Үндэсний хяналтын байгууллага тус АББ-ын заавал илтгэх тайланг шалгахад тус байгууллага нь ямар нэгэн илт харагдахуйц үйл ажиллагаа эрхэлдэггүй байсан бөгөөд зөвхөн гадны байгууллагаас их хэмжээний мөнгө хүлээн авч, энэхүү мөнгийг тухайн гадны улсад таатай ханддаг орон нутгийн байгууллагуудад хуваарилдаг басйныг тогтоожээ. Нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр дээрх гадны байгууллага нь терроризмыг дэмжигч улсын салбар нь байсан бөгөөд түүнийг террорист үйл ажиллагааг дэмжих, тагнуулын мэдээлэл цуглуулах, улс төрийн нөлөөлөл үзүүлэх зорилгоор ашигладаг байжээ. Үндэсний хяналтын байгууллага тус АББ-д аудитын шалгалт хийхэд түүний хүлээж авсан бүх санхүүжилт, зааварчилгаа нь дээр дурдсан гадны байгууллагаас ирдэг байсныг тогтоосон байна. Тус АББ-ын төлөөлөгчид түүний санхүүжилтийн үйл явцыг хянадаггүй гболохоо хүлээн зөвшөөрчээ.

Эдгээр баримтыг үндэслэж үндэсний хяналтын байгууллага тус АББ-ын бүртгэлийг цуцалж, холбогдох материалыг орон нутгийн үндэсний аюулгүй байдлын байгууллагад шилжүүлсэн.

Кейс тохиолдол 95 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ

Үндэсний (орон нутгийн) хууль сахиулах байгууллага тус улсын террорист үйл ажиллагаа идэвхжсэн бүс нутгаас нэгэн этгээдийг баривчилжээ. Баривчлагдсан этгээд түүний гишүүн байсан орон нутгийн террорист байгууллага нутгийн хүн ардаас хандив цуглуулдаг байсныг мэдээлсэн байна. Энэ зорилгоор хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настнуудыг хандив цуглуулах “буяны” халхавчаар ашигладаг байжээ. Цуглуулсан хандивыг уг террорист байгууллагын үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэхэд зориулдаг байсан.

Кейс тохиолдол 96 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Бүртгэлгүй АББ-аар үйл ажиллагаа явуулж байсан дотуур байртай шашны сургуульд тэсрэх бөмбөг дэлбэрчээ. Үүнтэй холбогдох мөрдөн шалгах ажиллагаагаар тус сургуулийг террорист бүлэглэлийн гишүүд орон нутгийн цагдаагийн албан хаагчид, прокурор, шүүгчдийн эсрэг халдлага үйлдэх, мөн гар хийцийн тэсрэх бөмбөг үйлдвэрлэхэд оюутан сурагчдыг элсүүлэхэд ашиглаж байсныг тогтоосон байна.

Сургуулийн захирлыг терроризмтой холбоотой гэмт хэрэгт буруутгаж шийтгэсэн.

Кейс тохиолдол 97 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ (Гуравдугаар бүлэгт иш татсан)

Хоёр этгээд жагсаалтад орсон террорист байгууллагад нэгдэж гадны улсад байлдаж байсан гэр бүлийн гишүүндээ зориулж орон нутагтаа хандив цуглуулж байжээ. Эдгээр этгээдүүд өөрсдийгөө хүмүүнлэгийн тусламжийн нэр бүхий орон нутгийн ашгийн бус байгууллагын төлөөлөгчид хэмээн мэдэгдэж, олон нийтийн газар гудамж талбайд хандив цуглуулах замаар хөрөнгө босгосон байна. Хөрөнгө босгох энэ арга нь дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл байв.

Дээрх хоёр этгээд нь түүний нэрийн өмнөөс хандив цуглуулна гэж орон нутгийн АББ-аас зөвшөөрөл аваагүй байсан бөгөөд цуглуулсан хандивыг уг ашгийн бус байгууллагад шилжүүлдэггүй байжээ. Нилээд их хэмжээний мөнгө цуглуулсны дараа мөнгийг цахим шилжүүлгээр гадаад дахь гэр бүлийн гишүүндээ явуулсан байна.

СМА, АББ-ын хяналтын байгууллага, хууль сахиулах байгууллагын хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд дээрх хоёр этгээдийг баривчилж, терроризмыг дэмжих зорилгоор хөрөнгө босгосон хэргээр хорих ялаар шийтгэсэн.

Кейс тохиолдол 98 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ

Үндэсний (орон нутгийн) хууль сахиулах байгууллага тус улсын террорист үйл ажиллагаа идэвхтэй явагддаг бүс нутгаас нэгэн этгээдийг баривчилжээ. Хожим нь өөрийгөө террорист байгууллагын хөрөнгийн сангийн эрхлэгч гэдгээ хүлээн зөвшөөрсөн уг баривчлагдсан этгээд террорист байгууллагын гишүүдийн заавал өгөх хандив, мөн хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зорилгоор олон нийтээс цуглуулсан сайн дурын хандивыг хадгалдаг байжээ. Гэхдээ цуглуулсан бүх хөрөнгийг уг террорист байгууллагын үйл ажиллагааг дэмжихэд зарцуулдаг байв.

Кейс тохиолдол 99 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ

Боловсрол, шашин, соёлын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэх нэрийдлээр ашгийн бус байгууллагыг байгуулжээ. Гэхдээ бодит байдалд тус АББ нь гадаадын террорист бүлэглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, тус бүлэглэлийн

зорилгыг дэмжихэд шинэ гишүүд, дэмжигчдийг элсүүлэх замаар тусгайлан байгуулагдсан хэд хэдэн байгууллагын нэг байв.

Дээрх террорист бүлэглэлийн үйл ажиллагааг мөрдөн шалгах явцад олж авсан үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийн дагуу тус АББ нь терроризмын хэрэгт сэжиглэгдэн эрэн сурвалжлагдаж байсан этгээдийг өөрийн байранд орогнуулсан байжээ. Түүнчлэн тус АББ нь гэмт хэргээр яллагдсан террористын гэр бүлд санхүүгийн туслалцаа үзүүлсэн байв. Мөн нээлттэй эх сурвалж, хууль сахиулах байгууллагын мэдээллээр тус АББ-ын захирал нь террорист халдлагын мөрдөн шалгах ажиллагааны сэжигтнээр татагдсан байжээ.

Үндэсний хяналтын байгууллагаас тус ашгийн бус байгууллагад хэд хэдэн удаа хяналт шалгалт явуулахад тухай бүрт нь АББ-ын төлөөлөгчид санхүүжилтийнхээ нийлээд хэсгийн гарал үүсэл, зарцуулах зорилгыг тайлагнаж чадахгүй байжээ. Түүнчлэн нэг шалгалтын үеэр хяналтын байгууллагад өгсөн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн байх шинж тэмдгүүд илэрсэн байна. Шалгалтаар тус АББ нь террорист бүлэглэлийн халхавчаар ажилладаг нэр бүхий буяны байгууллагад мөнгө шилжүүлснийг тогтоожээ. Мөн тус АББ-ын хэрэгжүүлж байсан боловсрол, соёлын хөтөлбөр нь уг гадаадын террорист бүлэглэлийн зорилгыг сурталчилж байсныг илрүүлжээ.

Тус ашгийн бус байгууллагын бүртгэлийг цуцалж, холбогдох мэдээллийг хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлын байгууллагын холбогдох мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор шилжүүлсэн байна.

Кейс тохиолдол 100 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ (Зургадугаар бүлэгт иш татсан)

Өнчин хүүхдэд тусламж үзүүлдэг ашгийн бус байгууллагын хаягийг байрлуулсан байшинд гар хийцийн тэсрэх төхөөрөмж дэлбэрчээ. Мөрдөн шалгах ажиллагаагаар бодит байдалд ямар нэгэн АББ байдаггүй байсныг илрүүлж, террорист бүлэглэл өөрсдийн тэсрэх төхөөрөмж хийдэг үйлдвэрээ ашгийн бус байгууллагын албан байр мэт харагдахаар нуун дарагдуулсныг илрүүлжээ.

Хууль сахиулах байгууллагаас тэсрэх төхөөрөмж, зэвсэг үйлдвэрлэх зориулалттай их хэмжээний эд зүйлсийг хураан авчээ. Уг террорист бүлэглэлийн нэг гишүүнийг терроризмтой холбоотой гэмт хэрэгт буруутгаж, ял шийтгэл оногдуулсан.

Кейс тохиолдол 101 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ

Хэсэг бүлэг этгээд биеийн тамирын цамц борлуулах замаар хөрөнгө босгодог ашгийн бус байгууллагыг байгуулсан бөгөөд үүнээс олсон орлогыг гадаадын хоёр террорист байгууллагад явуулдаг байжээ. Тус АББ нь мөн гадаадын хоёр террорист байгууллагын гишүүд нь үнэндээ террористууд биш бөгөөд харин хууль ёсны "эрх чөлөөний төлөө тэмцэгчид" болохыг ухуулан сурталчлах гэж оролджээ. Биеийн

тамирын цамц худалдаалах тухай мэдээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргажээ.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дээрх мэдээлэл гарсны дараа хууль сахиулах байгууллагаас явуулсан мөрдөн шалгах ажиллагааны дүнд тус АББ-ын гол зохион байгуулагчдыг терроризмыг санхүүжүүлсэн хэргээр буруутгаж хорих ялаар шийтгэсэн.

Кейс тохиолдол 102 – Төөрөгдүүлэх төлөөлөл, хуурамч АББ

Үндэсний хууль сахиулах байгууллага орон нутгийн террорист байгууллагын гишүүн гэдэг нь мэдэгдэх нэгэн этгээдийг баривчилжээ. Тэрбээр хүмүүнлэгийн тусламж үзүүлэх нэрээр хандив цуглуулах ажлыг зохион байгуулдаг байснаа хүлээн зөвшөөрснөөс гадна уг этгээд террорист байгууллага нууц яриа хэлэлцээ, айлган сүрдүүлэх замаар засгийн газрын албан тушаалтнуудаас "хамгаалалт"-ад авсны төлбөрийг нэхэж авдаг байсан гэж мэдэгджээ. Хэдийгээр төр засгийн нэг түшмэл түүнийг мөнгө төлөхийг албадсан гэдгийг үгүйсгэсэн ч өөр нэг түшмэл дээрх террорист байгууллагад хувиасаа хандив өгсөн гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна. Уг баривчлагдсан этгээдийн банкин дахь дансны гүйлгээ нь уг дансанд сар бүр мөнгө ордог байсныг, дараа нь мөнгийг дээрх террорист байгууллагын үйл ажиллагааг дэмжихэд ашигладаг байсныг илтгэсэн байна.